

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 хүрэх үр дүнг 95 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлттэйгээр баталсан.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт шинжилгээ хийх журам”-ын 6.4-т заасныг баримтлан бодлогын баримт бичигт тусгагдсан 9 зорилгын үр дүнг батлагдсан шалгуур үзүүлэлтээр тооцож, үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үр дүнг илэрхийлэх нэмэлт 96 статистик үзүүлэлтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас үнэлгээнд ашигласан байна.

Хэрэгжилтийн үнэлгээний дүнгээс үзэхэд, 95 шалгуур үзүүлэлтээс 34 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 85.0 дээш хувь буюу “үр дүн гарсан”, 53 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 85.0-аас бага хувь буюу “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн. 8 шалгуур үзүүлэлт судалгааны дүн гарах хугацаа болоогүй, тухайн чиглэлээр тодорхой судалгаа хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас үнэлэгдээгүй байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилгын үр дүнг шалгуур үзүүлэлтээр харуулав. Үүнд:

- ✓ Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын 6 шалгуур үзүүлэлтээс 50.0 хувь нь үр дүн гарсан;
- ✓ Хүний хөгжлийн бодлогын 31 шалгуур үзүүлэлтийн 35.5 хувь нь үр дүн гарсан;
- ✓ Амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын 11 шалгуур үзүүлэлтийн 45.5 хувь нь үр дүн гарсан, 2 шалгуур үзүүлэлтийг тооцох боломжгүй;
- ✓ Эдийн засгийн бодлогын 14 шалгуур үзүүлэлтийн 42.9 хувь нь үр дүн гарсан;
- ✓ Засаглалын бодлогын 6 шалгуур үзүүлэлтийн 16.7 хувь нь үр дүн гарсан;
- ✓ Ногоон хөгжил бодлогын 13 шалгуур үзүүлэлтийн 15.4 хувь нь үр дүн гарсан, 3 шалгуур үзүүлэлтийг тооцох боломжгүй;
- ✓ Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын 3 шалгуур үзүүлэлтийн 66.7 хувь нь үр дүн гарсан;
- ✓ Бүс, орон нутгийн хөгжил бодлогын 8 шалгуур үзүүлэлтийн 50.0 хувь нь үр дүн гарсан;
- ✓ Улаанбаатар ба дагуул хот бодлогын 3 шалгуур үзүүлэлт үр дүнгүй хэмээн тус тус үнэлэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан 336 төсөл, арга хэмжээнээс 176 буюу 52 хувь нь бүрэн хэрэгжсэн, 59 буюу 18 хувь нь хэрэгжиж байгаа, 101 буюу 30 хувь нь хэрэгжиж эхлээгүй байна.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдсан зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, хэрэгжилт удааширсан шалтгаан нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлгүй арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн болон шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалтад баталсан, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт батлагдаагүй, мөн 2020-2022 онд үргэлжилсэн цар тахлын нөлөөлөл болон түүнийг дагасан эдийн

засгийн хүндрэл, бараа материалын ханган нийлүүлэлтийн доголдолтой холбоотой гэж дүгнэжээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 25.2 хувийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Хүснэгт 1. Бодлогын баримт бичиг хоорондын уялдаа

дд	Бодлогын чиглэл	Алсын хараа 2050 (2021-2030)		Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл			Үндсэн чиглэлд тусгасан хувь
		Зорилт	Үйл ажиллагаа	Зорилго	Зорилт	Хүрэх үр дүн	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	64	1	5	17	26.6
2	Хүний хөгжил	7	161	1	7	49	30.4
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	89	1	6	27	30.3
4	Эдийн засаг	6	165	1	6	35	21.2
5	Засаглал	6	99	1	6	25	25.3
6	Ногоон хөгжил	4	64	1	4	18	28.1
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	116	1	5	23	19.8
8	Бүс, орон нутгийн хөгжил	3	57	1	3	28	49.1
9	Улаанбаатар ба дагуул хот	5	150	1	5	21	14.0
ДҮН		47	965	9	47	243	25.2

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг тодорхойлохдоо нийт 95 шалгуур үзүүлэлтээс 82 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг жилд 1 удаа, 5 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 5 жилд нэг удаа, 4 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 2 жилд 1 удаа, 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг улирал бүр байхаар тус тус баталсан бөгөөд 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг тодорхойлоогүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлтийн 30.5 хувь буюу 29 нь үндэсний үр дүнг тодорхойлох ерөнхий үзүүлэлтүүд байгаа бол 69.5 хувь буюу 66 нь салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн хүрээний үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой үзүүлэлтүүд байна. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг Хөгжлийн бодлогын дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах хүрээнд тусгасан талаар:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг дунд, богино хугацааны бодлогын төлөвлөлтийн үе шатанд тодорхой авч үзэж бодлогын уялдааг хангаж төлөвлөж хэрэгжүүлэх;

“Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ын гуравдугаар хавсралтад Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, арга зам, хариуцагчийн хүснэгтийн 2 дугаар баганад бодлогын үндэслэл хэсгийг тусгаж баталсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, ... улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр

дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг” гэж заасны дагуу бодлогын үндэслэл хэсэгт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан заалтыг тусгаж боловсруулсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар дунд хугацааны буюу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, богино хугацааны буюу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ байхаар заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын уялдааг ханган төлөвлөж байна.

Мөн орон нутгийн түвшинд “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд суурилсан, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулсан, “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан байхаар хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын уялдааг хангаж байна.

2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа урт, дунд, богино хугацааны ялгаа заагийг харгалзан бодлогын үр дүнгийн хүрэх түвшнийг суурь судалгаа, бодит нөхцөл байдалд тулгуурлан үе шаттайгаар оновчтой тодорхойлж төлөвлөх;

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/13 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ын 2-т заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн чиг үүргийн хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээг аргачлалын 2 дугаар хавсралтын дагуу хийсэн. Уг шинжилгээг боловсруулахдаа хамрах хүрээ, үр шим хүртэгч ба зорилтот бүлэг, хэрэгцээ, асуудал, асуудлыг шийдвэрлэх арга зам, асуудлыг хэмжих үзүүлэлт, тархалтын хурд, асуудалд шууд холбогдогч талуудын мэдээллийг тусгасан. Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ салбарын түвшин, төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшин, хөтөлбөрийн түвшний тулгамдсан хэрэгцээ, асуудлыг тодорхойлж уг хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэж үр дүнд хүрсэн байхаар төлөвлөсөн.

3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа таван жилийн дараа хүрэх үр дүнг зорилго, зорилт хэлбэрээр тодорхойлж, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг он тус бүрээр тогтоох;

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 10 зорилт, 2 дугаар хавсралтад “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн үзүүлэлт”-д бодлогын үндэслэл, салбар, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн нэр, үр дүн, арга зам, үндсэн хариуцагч, хамтран хариуцагчийг тусгаж батлах бол 3 дугаар хавсралтад “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг салбар, ТЕЗ, хөтөлбөрийн нэр, үр дүн, шалгуур үзүүлэлт,

Тогтвортой хөгжлийн зорилтын уялдаа, хэмжих нэгж, суурь түвшин, зорилтот түвшний мэдээллийг 2026-2030 оныг хүртэл он тус бүрээр, мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах арга зүй, давтамж, хариуцах байгууллагыг тусгаж төлөвлөсөн.

4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй холбоотой албан ёсны статистик мэдээлэл болон бусад салбарын статистик мэдээллийг тогтмол хугацааны давтамжтайгаар гаргадаг болох, мэдээллийн эх сурвалж, мэдээллийн давтамжийг бодитой тооцож төлөвлөх;

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой албан ёсны статистик мэдээлэл болон бусад салбарын статистик мэдээллийг тогтмол хугацаанд гаргадаг болох талаар Үндэсний статистикийн хороо болон холбогдох яамд, байгууллагатай санал солилцон ажиллаж байна. Мэдээллийн эх сурвалж, мэдээллийн давтамжийг хөгжлийн бодлогын баримт бичиг хэрэгжих хугацаатай уялдуулж бодитой тооцож төлөвлөсөн.

5. Хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн явцад урьдчилсан үнэлгээ хийж, хөгжлийн бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг өнөөгийн бодит нөхцөл байдалд тулгуурлан оновчтой төлөвлөж байгаа эсэх, дунд, богино хугацаанд улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд бодлогын төлөвлөлт харилцан уялдаатай байгаа эсэх, бодлогын хэрэгжилт, үр дүнг тодорхойлох шалгуур үзүүлэлт оновчтой эсэхийг тодорхойлж, төлөвлөлтийн алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллах;

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулахдаа бодлогыг оновчтой тодорхойлох зорилгоор хүн, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хөгжлийн түвшин, засаглалын нөхцөл байдлын ерөнхий мэдээлэлд үндэслэж үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйн дагуу үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг он тус бүрээр тоогоор илэрхийлж үр дүн гарсан байхаар боловсруулсан. Түүнчлэн Үндэсний хөгжлийн хүрээлэнтэй хамтран нөхцөл байдлын дүн шинжилгээг боловсруулж, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаачдын саналыг тусгасан бөгөөд тус академийн Их, Бага чуулганаар хэлэлцүүлэв.

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан байх, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан байхаар хуульчилсан байдаг ба дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдаатай боловсруулагддаг. Хуулийн 9.10.1-т зааснаар Аймаг, нийслэлийн Засаг дарга Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг тус тус боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх хуулийн зохицуулалттай тул Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлагдсаны дараа аймаг, нийслэлийн түвшинд таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулна.

6. Хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дагавар, үр нөлөөг үндэсний, салбарын, орон нутгийн түвшинд тодорхойлох үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн сан бий болгож, төлөвлөлт болон хяналт, шинжилгээ, үнэлгээнд ашиглах шаардлагатай байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.22-т "шалгуур үзүүлэлт" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг;" гэж заасан бөгөөд тус яамнаас өнгөрсөн хугацаанд боловсруулж батлуулсан 2023-2026 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулах хүрээнд ашигласан шалгуур үзүүлэлтийн санг бүрдүүлж, төлөвлөлтөд ашиглаж байна.

7. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд салбарын байгууллагын тооцоо, судалгаа, бодит нөхцөл байдалд үндэслэн гаргасан төслийн саналыг эцэслэн хэлэлцэж, Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад өөрчлөлт оруулах тохиолдолд салбарын, мэргэжлийн байгууллагын оролцоог хангаж, шийдвэрлэж байхаар зохицуулалт хийх.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан салбарын яамд, байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэж боловсруулсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх явцад өөрчлөлт оруулах тохиолдолд их гардаг. Аливаа төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх явцад салбарын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг Улсын Их Хурлаас байгуулдаг бөгөөд тухайн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах явцад холбогдох яамд, байгууллагуудаас мэргэжил арга зүйн дэмжлэг авдаг.

2.2. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт 336 төсөл, арга хэмжээ батлагдсанаас санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл тус тус батлагдсан.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 9 бодлогын хүрээнд санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас хэрэгжсэн 72 буюу 48.0 хувь, хэрэгжиж байгаа 56 буюу 37.3 хувь, хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 22 буюу 14.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Батлагдсан 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилт

дд	Бодлогын хэрэгжилт	Хэрэгжсэн	Хэрэгжиж байгаа	Хэрэгжээгүй	Нийт
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	4	1	1	6
2	Хүний хөгжил	8	6	5	19
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	7	1	14
4	Эдийн засаг	26	19	11	56
5	Засаглал	8	1	-	9
6	Ногоон хөгжил	2	3	1	6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	6	5	-	11
8	Бүс, орон нутгийн хөгжил	9	7	2	18
9	Улаанбаатар ба дагуул хот	3	7	1	11
	Нийт	72	56	22	150

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээнээс Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдсанаас хойш

2025 оны эхний хагас жилд 63 төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулсан. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил нь эхэлсэн 3 төсөл, арга хэмжээ байгаа бол хэрэгжиж эхлээгүй 32 төсөл, арга хэмжээ байна.

Хэрэгжээгүй нийт 32 төсөл, арга хэмжээг шалтгаанаар нь ангилбал санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүй 22 төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон 1 төсөл, арга хэмжээ, Концессын тухай хууль хүчингүй болсонтой холбоотой 1 төсөл, арга хэмжээ, газрын асуудал шийдэгдээгүй 2 төсөл, арга хэмжээ, холбогдох дээд шатны шийдвэрээр хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээ, хэрэгжээгүй шалтгааныг тайлагнаагүй 3 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 88 төсөл, арга хэмжээ батлагдсан. 2021-2025 оны эхний хагас жилд 41 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах явцад анхаарч, хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээ бүр нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн аль заалтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгааг тодорхой зааж тусгах;

2.Төсөл, арга хэмжээ бүрийн гарцын шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшинг тодорхой тусгаж, хэмжүүртэй болгох;

3. Хяналт-шинжилгээний шалгуур боловсруулахдаа Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн аль заалтын үр дүнгийн шалгуур үзүүлэлт болохыг хамтад нь тодорхой заах;

4.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ, болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ бүрийн хариуцагч төсвийн ерөнхийлөн захирагчийг тодорхой заах;

5.Техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл боловсруулсан төсөл, арга хэмжээг “санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д нэмж тусгадаг байх зохицуулалтыг шийдвэрийн төсөлд тусгах;

6.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад “санхүүжилт шийдвэрлэгдээгүй” төсөл, арга хэмжээг тусгахгүй байх;

7.Төсөл, арга хэмжээг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэрээр бус, хэрэгжих бүтээн байгуулалтын арга хэмжээгээр нэрлэх;

8.Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлгүй арга хэмжээг “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн болон шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ”-нд тусгахгүй байх.

2.3. Макро эдийн засгийн нөхцөл байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2025 оны эхний хагас жилд 40.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 15.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар тус тус өслөө. Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдааны салбарууд буурч, өсөлтийг сааруулав.

Уул уурхайн салбар дахь зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаар өсөлтийн эрчим өнгөрсөн оноос саарч, 1.1 хувиар хязгаарлагдлаа.

Тухайлбал, нүүрс олборлолт 43.8 сая тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар, төмрийн хүдэр, баяжмал үйлдвэрлэл 4.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар тус тус буурлаа. Түүнчлэн 2025 оны эхний хагас жилд газрын тос олборлолт 1.9 сая баррель, алтны олборлолт 4.5 тонн болж буурсан байна. Харин Оюу толгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр зэсийн баяжмалын нийт үйлдвэрлэл 29.0 хувиар өсөж 970.0 мянган тоннд хүрч, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжлээ.

Уул уурхайн бус салбарын өсөлт 2025 оны эхний хагас жилд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн нөлөөгөөр эрчимжиж, 6.3 хувьд хүрлээ. Мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд төлийн тоо толгой 20.8 саяд хүрч (төл бойжилт 98.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 189.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсан голлох нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар 36 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 3.6 нэгж хувийг бүрдүүллээ. Барилгын салбар 2025 оны эхний хагас жилд орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшгийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын үр дүнд 25 хувиар өсөж, өсөлтийг 0.4 нэгж хувиар нэмэгдүүллээ. Мөн шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-дын үйлдвэрлэлийн нөлөөгөөр цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 4.8 тэрбум кВт цагт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9 хувиар, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 9.5 сая.Гкал-д хүрч 7.7 хувиар өссөнөөр эрчим хүчний салбарын үйлдвэрлэл 8.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 0.3 хувиар дэмжлээ. Харин авто тээврийн орлогын бууралтын голлох нөлөөгөөр тээврийн салбар 2025 оны эхний хагас жилд 12.5 хувиар багасаж, эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар сааруулав. Мөн бөөний болон жижиглэн худалдааны салбар 5.7 хувиар буурлаа.

Нийт эрэлтийн талаас авч үзвэл эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд үндсэн хөрөнгийн хуримтлал, өрхийн хэрэглээний өсөлтийн голлох нөлөөгөөр 5.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийн ойролцоо байлаа. Хаврын цаг агаарын таатай байдалтай уялдан том малын зүй бус хорогдол бага, төлийн хорогдол бага байсны үр дүнд биологийн өсөж үрждэг хөрөнгө нэмэгдсэний голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтийг 6.5 нэгж хувиар нэмэгдүүлэв. Мөн орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг орон сууцны бус барилгын бүтээн байгуулалтын ажил үндсэн хөрөнгийн хуримтлалыг дэмжсэн байна. Өрхийн хэрэглээ 2025 оны эхний хагас жилд 9.9 хувиар өсөж, нийт өсөлтийг 7.8 нэгж хувиар өрхийн бодит орлого өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар, хэрэглээний зээл 19.6 хувиар тус тус өссөн нь өрхийн хэрэглээний өсөлтийг голлон дэмжсэн байна. Харин зэсээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан ч барааны импортын өсөлт саарсан нь эдийн засгийн өсөлтөд үзүүлэх цэвэр экспортын сөрөг нөлөөг бууруулсан байна.

Инфляц: Инфляц 2025 оны 9 дүгээр сард 9.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар, өмнөх сараас 0.2 нэгж хувиар өслөө. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд мах, хүнсний ногоо, цахилгааны төлбөр, орон сууцны түрээс болон тээврийн бүлгийн үнийн өсөлт голчлон нөлөөлжээ.

Импортын барааны үнэ 2025 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өсөж, нийт инфляцын 2.4 нэгж хувь буюу 26.4 хувийг бүрдүүлсэн байна. Импортын барааны үнийн өсөлтийн дийлэнхийг хүнсний бус бараа бүрдүүлж байна.

Дотоодын бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өсөж, нийт инфляцын 6.6 нэгж хувь буюу 73.6 хувийг бүрдүүллээ. Хүнсний барааны үнэ 2025 оны 9 дүгээр сард 10.6 хувиар өссөн нь нийт инфляцын 2.8 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний үнийн өсөлтийн дийлэнх буюу 85 орчим хувийг хүнсний ногоо, талх, нарийн боов, сүү, мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байна.

Хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсөж, нийт инфляцын 6.2 нэгж хувийг эзэлж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар, өрхийн цахилгааны төлбөр 65 хувиар, автобусны билетийн үнэ 100 хувиар, орон сууцны түрээс 36.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Эрэлтийн (суурь¹) инфляц 2025 оны 9 дүгээр сард 7.8 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар эрчимжсэн хэдий ч сүүлийн 6 сар дараалан буурах хандлагатай байна. Эрэлтийн инфляц саарахад эдийн засгийн дотоод идэвхжил суларсан нь нөлөөллөө. Эрэлтийн шалтгаантай инфляц нийт инфляцын дийлэнх буюу 53 орчим хувийг тайлбарлаж байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 9 дүгээр сард 11.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.7 нэгж хувиар эрчимжив. Үүнд хүнсний үнийн өсөлт эрчимжсэн нь голлон нөлөөллөө.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 44.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эх үүсвэр талаас төгрөг ба гадаад валютын хадгаламж нийлбэр дүнгээр 14.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн бол төгрөг ба гадаад валютын харилцах нийлбэр дүнгээр өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буурч, өсөлтийг сааруулжээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 9 дүгээр сард 42.7 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 22.1 хувьд хүрсэн байна. Зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдааны зээл 5.4 нэгж хувийг, цалин, тэтгэвэр 4.4 нэгж хувийг, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 3.2 нэгж хувийг, барилга 2.3 нэгж хувийг, хөдөө аж ахуйн салбар 1.4 нэгж хувийг, уул уурхай, олборлолт 0.9 нэгж хувийг, бусад салбарын зээл 4.5 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Төсөв: Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2025 оны эхний 9 сарын байдлаар түүхий эдийн үнийн уналттай холбоотойгоор экспортын орлого буурснаар 22,244.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 611.3 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар буурч, улмаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,335.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн орлого буурахад ААНОАТ өмнөх оны мөн үеэс 917.4 тэрбум төгрөг буюу 19.2 хувиар, АМНАТ-ийн нийт орлого 949.6 тэрбум төгрөг буюу 25.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 оны эхний 9 сарын байдлаар 22,058.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, өмнөх оны мөн үеэс 2,236.6 тэрбум төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Тус өсөлтөд Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сараас эхлэн нийт төрийн албан хаагчдын цалинг дунджаар 6.0 хувиар, мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримтлах итгэлцүүрийг 2025 онд шинэчилснээр тэтгэврийн зөрүүг бууруулж, тэтгэврийн зөрүүг бууруулсан сууриас тэтгэврийг 6 хувь тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хөдөлмөр эрхлэлт: Ажиллагчдын тоо 2025 оны эхний хагасын байдлаар өмнөх оны мөн үеэс 43 мянгаар нэмэгдэж 1 сая 390 мянгад хүрсэн байна. Энэхүү өсөлтөд нийт ажиллагчдын дөрөвний нэгийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын тоо салбарын өсөлтийн нөлөөгөөр нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 45 мянгаар буюу 14 хувиар өссөн нь голчлон нөлөөллөө. Мөн барилгын салбарт 15 мянга, уул уурхай, боловсруулах салбарт тус бүр 11 мянган ажилчин нэмэгдсэн нь өсөлтийг дэмжлээ. Харин үйлчилгээний салбарын ажилчид 27 мянгаар, худалдааны салбар 19 мянгаар буурсан нь өсөлтийн хурдыг сааруулжээ.

¹ Суурь инфляцыг нийт инфляцаас нийлүүлэлтийн хэлбэлзэл өндөртэй буюу хүнс, шатахуун, хатуу түлш болон эрчим хүчийг хасаж тооцсон.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 16 мянган хүнээр буюу 20 хувиар буурч 66 мянга боллоо. Ингэснээр ажилгүйдлийн түвшин 1.2 нэгж хувиар буурч 4.5 хувьд хүрэв. Энэхүү бууралт нь ажиллах хүчний өсөлтийг сааруулснаар ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч 61.9 хувь болсон байна.

Төлбөрийн тэнцэл: Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 12 хувиар буюу 1.0 тэрбум ам.доллараар буурснаар төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 6 сард 462.0 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Мөн бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 1 хувиар буюу 91.0 сая ам.доллараар, шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 41 хувиар буюу 0.6 тэрбум ам.доллараар тус тус бага байна. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 07 дугаар сарын эцсийн байдлаар 5,380.0 сая ам.доллар байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 7 сард 14.2 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарав. Экспорт 2025 оны эхний 7 сард 7.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар буурлаа. Экспортын бууралтад нүүрсний экспортын биет хэмжээ 44.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар, нүүрсний хилийн үнэ тонн тутамдаа 70 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 40.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

БНХАУ-ын нүүрсний уурхайнуудын олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор нүүрсний нийлүүлэлт нэмэгдэж, үнэ буурсан байна. Харин Оюу толгойн далд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тогтворжсон, дэлхийн зах зээлд цэвэр зэсийн эрэлт өндөр түвшинд хадгалагдсан зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспорт 1,243 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өсжээ. Мөн төмрийн хүдрийн экспорт 4,681 мянган тоннд хүрч, 10.0 хувиар нэмэгдсэн байна.

Уул уурхайн бус экспортын хувьд 2025 оны эхний 7 сард ноолуурын экспорт 78 хувиар буурсан байна. Түүнчлэн, боловсруулах үйлдвэрлэлийн идэвх сул байсан нь мах болон арьс, ширний экспорт буурахад нөлөөлсөн байна.

Нийт импорт 2025 оны эхний 7 сарын байдлаар 6.5 тэрбум ам.долларт хүрч, жилийн өсөлтийн хурд 1.1 хувьд хүрч саарлаа. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн бол аж үйлдвэрийн орцын импорт 10 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 3 хувиар тус тус буурсан байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний импорт голлох нөлөөг үзүүллээ. Тухайлбал, суудлын автомашины импорт 2025 оны эхний 7 сард 753.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 33 хувь буюу 187.0 сая ам.доллараар, хүнсний бүтээгдэхүүний импорт 682.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувь буюу 55.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. САЛБАРУУДЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

3.1. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүний хөгжил гэдэг нь хүмүүсийн сонголтыг өргөжүүлж, сайн сайхан байдлыг дээшлүүлэх явдал юм.² Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хүний хөгжлийг эрүүл саруул байж, урт удаан наслах, эрдэм мэдлэг эзэмших, амьжиргааны аятай нөхцөлд аж төрөх гэсэн гурван хэмжигдэхүүнээр хэмждэг байна. Хүний амьдрах хугацааг дундаж наслалтаар, боловсролын байдлыг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт болон бүх шатны боловсролд хамрагдалтын түвшнээр, амьжиргааны зохистой түвшнийг нэг хүнд ногдох ДНБ-ээр илэрхийлэн тооцоолдог. Монгол Улсын Хүний

² НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний хөгжлийн үндэсний баримт бичиг, 2024.

хөгжлийн индексийг дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох орлогын үзүүлэлт тус бүрээр авч үзвэл (Хүснэгт 3-т харуулав) дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Хүний хөгжлийн индекс (2020-2024)

Он	Хүний хөгжлийн индекс	Хүн амын дундаж наслалтын индекс	Хүн амын боловсролын түвшний индекс	Нэг хүнд ногдох ҮНӨ-ын индекс
2020	0.747	0.780	0.761	0.702
2021	0.745	0.785	0.761	0.693
2022	0.749	0.789	0.754	0.707
2023	0.753	0.792	0.755	0.714
2024	0.756	0.796	0.755	0.718

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улс хүний хөгжлийн индексээр 193 улсаас 104 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Хүний хөгжлийн индекс сүүлийн 5 жилийн хугацаанд өсөлт удаан байгаа нь боловсролын индексийн түвшин бууч байгаатай холбоотой.

Дэлхийд хүний хөгжлөөр Исланд, Норвеги, Швейцар, Дани, Герман, Швед зэрэг улс тэргүүлж, дунджаар 0.965 үнэлгээ авсан байна. Харин Өмнөд Судан, Сомали, Чад, Нигер, Мали зэрэг улс хүний хөгжлөөр хамгийн сул буюу дунджаар 0.410 оноо авчээ. Мөн Хүний хөгжлийн индекс ЭЗХАХБ-ын улс орнуудад 0.916, хөгжиж буй улс орнуудад дунджаар 0.712, хөгжил буурай орнуудад 0.560 байна.

Цаашид хүний хөгжлийн индексийг 2030 он гэхэд 0.054-өөр нэмэгдүүлж 0.810 болгохоор зорьж байна.

1.1.1. Боловсрол


Хүний хөгжлийн индексийн нэг хэмжигдэхүүн болох эрдэм мэдлэг эзэмших түвшнийг тодорхойлох үзүүлэлт нь боловсролын индекс бөгөөд тус индексийг тооцоход сургуульд суралцсан болон суралцах хугацааны индексийг ашигладаг байна.

Боловсролын статистик үзүүлэлт тооцох аргачлалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас баталсан гарын авлагад үндэслэн боловсруулсан байдаг бөгөөд уг аргачлал нь 4 бүлгийн 41 үзүүлэлтээс бүрдэнэ. Үүнд:

1. Боловсролын хүртээмжийн үзүүлэлт-10
2. Боловсролын дотоод үр ашгийн үзүүлэлт-8
3. Боловсролын үр дүнгийн үзүүлэлт-13
4. Боловсролын салбарын зардал, хүний нөөцийн үзүүлэлт-10

Хүний хөгжлийн индекс 2024 оны байдлаар 0.755 байгаа нь боловсрол, эрүүл мэнд, орлогын түвшнээс хамаарч байна. Энэ хүрээнд сүүлийн 5 жилийн хугацаанд боловсролын индекс 2020-2021 онд харьцангуй өндөр түвшинд байсан боловч 2022 оноос буурах хандлагатай болж, 2023-2024 онд тогтмол түвшинд хадгалагдаж байна (график 1-д харуулав). Энэ нь хүн амын боловсролын чанар, хөдөө орон нутаг дахь боловсролын хүртээмж, дээд боловсролын ялгаа зэрэг асуудалтай холбоотой байна.

График 1. Хүн амын боловсролын түвшний индекс (2020-2024)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Боловсролын индексийн түвшин 2024 оны байдлаар 0.756 байгаа нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон дээд боловсролын чанар, хүртээмжийн түвшнээс хамаарч байна.

Сургуулийн өмнөх боловсролын түвшинд бага насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал хангалтгүй байгаа нь суурь боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлж байна. Ерөнхий боловсролын түвшинд сурагчдын суурь мэдлэг, ур чадварын ялгаа болон сургалтын чанарын зөрүү их байгаа нь индексийн өсөлтийг сааруулж байна. Харин мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, тэргүүлэх чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг дээшлүүлэх хэрэгцээ нь боловсролын индексийг ахиулах чухал хүчин зүйл болж байна.

Сургуулийн өмнөх боловсрол: Монгол Улсын 3.5 сая хүн амын 8.3 хувийг 2-5 насны хүүхэд эзэлж байна. 2-5 насны нийт 292,359 хүүхдийн 150,209 (51.4%) нь орон нутагт, 142,150 (48.6%) нь нийслэлд амьдарч байна.

Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 1,407 цэцэрлэгт 264,818 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, 35,339 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 9,945 (28.1%) нь үндсэн багш байна. Өмнөх онтой харьцуулахад цэцэрлэгийн тоо 0.06 хувь буюу 3 цэцэрлэгээр буурсан байна. (Хүснэгт 4-т харуулав)

Хүснэгт 4. Сургуулийн өмнөх боловсролын статистик (2020-2025)

Үзүүлэлт		Хичээлийн жил				
		2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Цэцэрлэгийн тоо		1,454	1,453	1,413	1,410	1,407
Өмчийн хэлбэр	Төрийн	948	972	985	1,010	1,024
	Хувийн	506	481	428	400	383
Байршил	Хот	684	677	649	659	655
	Хөдөө	770	776	764	751	752
Нийт Бүлгийн тоо		8,499	7,877	8,871	9,034	9,226
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид		247,040	190,991	266,024	274,236	264,818
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид	Цэцэрлэгт	229,899	178,444	250,457	260,271	253,158
	Хувилбарт сургалтад	17,141	12,547	15,567	13,965	11,660
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид	Халамжид буй хүүхэд	3,096	2,837	3,460	3,794	3,779
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	1,156	1,065	1,498	1,977	2,150
	Малчдын хүүхэд	31,860	25,814	33,657	34,888	32,282
Нийт багш, ажиллагчид		30,668	30,996	32,509	33,999	35,339
Үндсэн багшийн тоо		8,827	8,824	9,450	9,733	9,945
Үндсэн багшийн хангалт		94.3	97.2	93.3	92.0	92.0
Туслах багшийн тоо		7,819	7,788	8,277	8,592	8,743

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нь суралцагчдын зан байдал, анхаарал, тууштай байдал, сургалтын үйл ажиллагааны оролцоог дэмжиж сайжруулдаг (Берлински, Галиана ба Гертлер, 2009). Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам” батлагдаж, эрх зүйн орчин бүрдсэнээр сүүлийн гурван жилийн хугацаанд сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ хийж байна. Тус журмын 1.5.2-д “Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээ” гэж хүүхэд сургуульд элсэн суралцахад шаардлагатай чадвар, дадал, хандлага эзэмшсэн байдлыг тогтоож, цаашид суралцахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлийг тодорхойлох үнэлгээг ойлгоно.”, 1.6-д “Хүүхдийн хөгжлийн үнэлгээг цэцэрлэг, сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээг сургууль тус тус зохион байгуулна.” гэж заасан.


2023-2024 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэн суралцаж байгаа суралцагчдын “Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний улсын дундаж 70.2 хувьтай бөгөөд бүс нутгаар харьцуулбал:

- ✓ Цэцэрлэг: Орон нутагт 36,371 хүүхэд хамрагдаж, гүйцэтгэлийн дундаж 69.8 хувь, Улаанбаатарт 31,444 хүүхэд хамрагдаж, 71.1 хувийн гүйцэтгэлийн дундажтай байна.
- ✓ Сургууль: Орон нутагт 36,949 хүүхэд хамрагдаж, 69.6 хувийн дундажтай, Улаанбаатарт 34,875 хүүхэд хамрагдаж, 70.8 хувийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлттэй үнэлэгдсэн байна.³

Үүнээс үзэхэд Улаанбаатар хотын цэцэрлэг, сургуульд хамрагдсан хүүхдүүдийн гүйцэтгэлийн дундаж улсын дундаж болон орон нутгийн үр дүнгээс өндөр байгаа нь цэцэрлэгт тогтмол хамрагддаг хүүхдийн хувь өндөр байгаатай холбоотой. Учир нь сургуулийн өмнөх боловсролын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик мэдээнээс үзвэл 266,024 хүүхдийн 15,567 нь хувилбарт сургалтад⁴ хамрагдсан байна.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж 2-5 настай хүүхдийн хамран сургалт 2024-2025 онд 90.6 хувьд хүрсэн (График 2-т харуулав).

График 2. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /2-5 нас/




Сургуулийн өмнөх боловсролын 2024-2025 оны хичээлийн жилд нийт таван настай 78,627 хүүхэд байгаагаас 74,027 нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж,

³ Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний үр дүнд суурилсан зөвлөмж, Улаанбаатар хот, 2024.

⁴ Хувилбарт сургалт гэж оршин суудаг газар болон хөгжлийн бэрхшээлийн улмаас цэцэрлэгийн үндсэн бүлгийн сургалтад тогтмол хамрагдах боломжгүй сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг ойлгоно.

хамран сургалт 94.1 хувьтай гарсан байна. Энэ нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 0.7 хувиар буурсан үзүүлэлт юм. (График 3-т харуулав)

График 3. Таван настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин



Эх сурвалж: Боловсролын яам

Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчин өрхийн болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна. Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд байгууллагын дэргэдэх цэцэрлэг байгуулахад төрөөс мэргэжлийн удирдлага, нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, хүүхдийн хоолны зардал, мэргэжлийн багшаар хангах, багшийн мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2024 оны байдлаар нэг үндсэн багшид 28.2 хүүхэд ногдож байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалтын түвшин 2024 онд 93.5 хувь байгаа бөгөөд энэ нь 2020 онтой харьцуулахад 0.8 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. (График 4-т харуулав)

График 4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт, хувь



Эх сурвалж: Боловсролын яам

Боловсролын салбарын 2025 оны статистик мэдээгээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 1,147 багш, ажилтны орон тоо сул байгаагаас 339 нь бүлгийн багшийн орон тоо байна. Үүнээс нийслэлд 685 багш дутагдалтай байна. Мөн сургалтын байгууллагын орчин хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжсэн, хэрэгцээ, сонирхолд нийцсэн, эрүүл аюулгүй байх нь нэн тэргүүнд анхаарах асуудлын нэг юм. Боловсролын салбарын 2023 оны статистик мэдээгээр стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг нийт цэцэрлэгийн 66.0 хувийг эзэлж байна. Мөн стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн эзлэх хувь Улаанбаатар хотод ердөө 76.5 хувь байна.

Асуудлыг шийдэх үүднээс сургуулийн өмнөх боловсролын түвшинд мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулах шаардлагатай байна. Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан цэцэрлэгийн эзлэх хувь 2024 оны байдлаар ердөө 23.6 хувь байгаа нь сургалтын чанар, хүүхдийн хөгжил, төлөвшилд сөргөөр нөлөөлж байна. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 2024 оны байдлаар 88.6 хувь байгаа нь чанарын хувьд сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Цаашид эцэг, эхийн оролцоог дэмжих замаар бага насны хүүхдийн суралцах идэвх, суурь ур чадварын хөгжилд эерэг нөлөө үзүүлж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулахаар зорьж байна. Ингэснээр хүүхдийн цаашдын суралцах амжилт дээшилж, боловсролын чанар сайжирна. Мэргэжлийн багшийн хангалт, хүртээмжийг дээшлүүлэхийн тулд багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулж мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан цэцэрлэгийн эзлэх хувь 2024 онд 23.6 хувь байгааг 2030 онд 95.5 хувь хүргэж, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 88.6 хувь байгааг 2030 онд 91.0 хувьд хүргэнэ.

Мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж стандартын шаардлага хангасан орчин бүхий цэцэрлэгийн эзлэх хувийг 2030 онд 73.0 хувьд, цэцэрлэгийн хүүхдийн хоолны илчлэг, шим тэжээлийн хангалтын хувь 2024 онд 76.0 хувь байгааг 2030 он гэхэд 100.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн.

Ерөнхий боловсрол: Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд 885 ерөнхий боловсролын сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 14-өөр буюу 1.5 хувиар өссөн байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийн 79.7 хувь нь төрийн өмчийн, 20.3 хувь нь хувийн сургууль байна. Ерөнхий боловсролын сургуульд нийт 797.9 мянган суралцагч суралцаж, 37.7 мянган үндсэн багш ажиллаж байна. Суралцагчийн тоо өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 26.2 (3.4%) мянгаар нэмэгдсэн байна. (Хүснэгт 5-д харуулав)

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын статистик (2020-2025)

Үзүүлэлт		Хичээлийн жил				
		2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Сургууль		839	848	859	871	885
Өмчийн хэлбэр	Төрийн	672	682	688	695	705
	Хувийн	167	166	171	176	180
Байршил	Хот	562	563	562	565	513
	Хөдөө	277	285	297	306	372
Бүлэг		22,979	23,835	24,750	25,471	26,228
3 ээлжтэй сургуулийн тоо		8	13	34	64	56
Суралцагч /өдөр/		680,837	712,353	746,405	771,722	797,905
Нийт суралцагчид	Нэгдүгээр ангид суралцагч	78,219	75,518	78,728	73,403	75,917
	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	5,628	5,606	5,673	6,283	6,273
	Малчдын хүүхэд	124,444	128,228	13,2635	135,917	136,730
Төрийн өмчийн сургууль		632,499	658,634	683,708	701,065	721,758
Хувийн сургууль		48,338	53,719	62,697	70,657	76,147
Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч		5,340	4,963	4,981	5,095	4,422
Дотуур байр		540	548	532	528	526
Дотуур байранд амьдарч буй хүүхэд		35,000	32,576	35,077	36,029	35,486
Нийт багш, ажиллагчид		54,498	56,228	57,737	59,455	61,016
Үндсэн багш		34,073	35,110	36,118	36,993	37,770

Эх сурвалж: Боловсролын яам

Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 885 ерөнхий боловсролын сургуулийн 26,228 бүлэгт 797.9 мянган суралцагч (өдрөөр) суралцаж, нийт 61.0 мянган багш, ажиллагчид ажиллаж байна. Ерөнхий боловсролын нийт сургуулийн 60.3 хувь нь мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан. Нийт багш нарын 32.7 (86.7%) мянга нь төрийн, 5.0 (13.3%) мянга нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. Багшийн тоо өмнөх хичээлийн жилээс 2.1 хувь буюу 777-оор нэмэгдсэн байна. (График 5-д харуулав)

График 5. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, өмчийн хэлбэрээр



Эх сурвалж: Боловсролын яам

Ерөнхий боловсролын сургуулиудад нийт 3,324 багшийн сул орон тоо байгаагаас 1,590 нь нийслэлд байна. Энэхүү нөхцөл байдал нь боловсролын хүртээмж, тэгш бус байдал гэх зэрэг асуудлыг үүсгэж байна.

2024-2025 оны хичээлийн жилд 885 сургуулийн 376 (42.5%) нь 1 ээлжээр, 509 (57.5%) нь 2 ээлжээр хичээллэж байна. 2024-2025 оны хичээлийн жилд нийт 8 сургуулийн 56 бүлгийн 2,120 суралцагчдад 3 ээлжээр хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 тоот тушаалаар анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй, дунд, ахлах ангид 32-35 хүүхэдтэй байх нормативыг баталсан. Төрийн өмчийн ЕБС-ийн ээлжийн коэффициент ба бүлэг дүүргэлтийн харьцуулалтыг (Хүснэгт 6) харуулав.

Хүснэгт 6. Төрийн өмчийн ЕБС-ийн ээлжийн коэффициент ⁵ ба бүлэг дүүргэлтийн харьцуулалт, 2024-2025

Ээлжийн коэффициент	Бүлэг дүүргэлтийн дундаж ба сургуулийн тоо				Нийт сургуулийн тоо
	30 хүртэлх	30-40 хүртэлх	40-50 хүртэлх	50+	
0-0.5 хүртэлх	41	-	-	-	41
0.5-1 хүртэлх	170	5	-	-	175
1-1.5 хүртэлх	183	38	3	-	224
1.5-2 хүртэлх	59	62	5	-	126
2+	27	84	27	1	139
Бүгд	480	189	35	1	705

Эх сурвалж: Боловсролын яам

Цаашид стандартын шаардлага хангасан орчин бүхий ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн эзлэх хувь 2024 оны байдлаар нийслэлд 76.5 хувь, аймагт 97.0 хувь байгаа нь бүс нутгийн ялгаатай байдлыг харуулж байна.

PISA⁶ (Олон улсын суралцагчдын үнэлгээ) нь гурван жил тутам зохион байгуулагддаг бөгөөд 2022 онд дэлхийн 81 улс орон хамрагдаж, Монгол Улс анх удаа


⁵ Боловсролын ээлжийн коэффициент нь сургуулийн хичээлийн танхимд нэг өдөрт явагдаж буй хичээлийн ээлжийн тоог илэрхийлсэн харьцаа бөгөөд тухайн сургуулийн орчны ачааллыг тодорхойлох үзүүлэлт юм.

⁶ PISA нь суурь боловсрол эзэмшсэн 15 настай суралцагчид танхимаар олж авсан мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямар хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын олон улсын үнэлгээ юм.

оролцсон. 2022 оны үнэлгээнд ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын математикийн чиглэлээр дундаж оноо 472, Азийн орнуудын дундаж 451 оноо байсан нь Монгол Улс дундаж гүйцэтгэл 425 оноогоор 81 орноос 47 дугаарт жагсаад байна. Математикийн энэ үзүүлэлт нь PISA-аас тухайн улсын орлогод суурилж таамагласан хүлээлтээс өндөр гарсан юм. Унших чадварын хувьд ЭЗХАХБ-ын орнуудын дундаж 476 оноо, Азийн орнуудын дундаж 427 оноогоос Монгол Улсынх 378 оноо, байгалийн ухааны ЭЗХАХБ-ын орнуудын дундаж 485 оноо, Азийн дундаж 449 оноо байсан бол манай орных 412 онооны гүйцэтгэл гарсан байна.

"PISA-2022" үнэлгээний Монгол Улсын үр дүнгээс харахад суурь боловсрол эзэмшсэн сурагчдын 38.0 хувь нь багш дутагдалтай сургуульд сурч байгаа бөгөөд эдгээр сургуулийн ихэнх нь хөдөө орон нутагт байна. Энэ нь сумын төвд суралцаж байгаа хүүхэд аймгийн төвийн үе тэнгийн хүүхдээс 1 жилээр, аймгийн төвийн хүүхэд нийслэлийн хүүхдээс 1.5-1.8 жилийн сурлагын хоцрогдол үүсэх нэг хүчин зүйл болж байна.⁷

Зураг 1. Суралцагчдын гүйцэтгэлийн ялгаа, байршлаар



Эх сурвалж: Боловсролын яам

Иймээс хот, хөдөөгийн боловсролын чанарын зөрүүг тогтвортой бууруулах нь тулгамдсан асуудлын нэг болж байна.

Дэлхийн банкны 2025 онд хийсэн "Монгол Улсын санхүү, төсвийн тойм" судалгаанд Монгол Улс боловсролын чанар нь нийгэм, эдийн засгийн ялгаатай байдлаас үүдэлтэй сорилттой тулгарч байгаа тухай дурдсан байна.

"Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" 2023-2024 оны хичээлийн жилд MNS7005:2023 стандартыг баталж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөл, хоолны чанар, аюулгүй байдлыг хангах боломж бүрдсэн.

2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн нийт 705 сургуулийн 585 (83.0%) нь хоолны газраа өөрсдөө ажиллуулдаг, 120 (17.0%) нь хоолны газраа түрээслэн үйл ажиллагаа явуулдаг байна.

Бүх түвшний сургалтын хөтөлбөрийг шинэчлэх замаар иргэдийн суурь чадваруудын түвшин нэмэгдэж, боловсролын чанар, хүртээмжийн ялгаа буурч, орон нутгийн сурагчдын суралцах явц сайжрах боломжтой.

Дээрх үр дүнг бий болгохын тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар стандартын шаардлага хангасан орчин бүхий ЕБС-ийн эзлэх хувийг нэмэгдүүлж 2024 онд нийслэлд 76.5 хувь байгааг 2030 он гэхэд 88.0 хувьд хүргэх, аймагт 2024 онд 97.0 хувь байгааг 2030 он гэхэд 99.9 хувьд хүргэхээр төлөвлөсөн. Мөн стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь 2024 онд 71.0 байгааг 2030 онд 90.0 хувьд, сургуулийн үдийн хоолны илчлэг, шим тэжээлийн хангалтын хувь 65.0 хувь байгааг 100.0 хувьд хүргэнэ.

⁷ Эх үүсвэр: Боловсролын яамны 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах замаар мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ЕБС-ийн эзлэх хувь 2024 онд 23.8 байгааг 2030 он гэхэд 96.0 хувьд, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 2024 онд 77.0 хувь байгааг 2030 он гэхэд 79.5 хувьд хүргэнэ.

Мэргэжлийн болон дээд боловсрол: Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын 69 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 41 буюу 58.6 хувь нь төрийн өмчийн, 29 буюу 41.4 хувь нь хувийн өмчийнх байна. (График 6-д харуулав)

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 34 буюу 48.6 хувь нь орон нутагт, 36 нь буюу 51.4 хувь нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна.

График 6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо




Эх сурвалж: Боловсролын яам

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас Боловсролын яаманд харьяалагддаг 38 (үүнээс бие даасан-26, төрийн өмчийн их сургуулийн харьяа-12), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалагддаг-1, ШШГЕГ-ын харьяа-1, "УБТЗ ХНН"-ийн харьяа-1, хувийн өмчийн-29 сургалтын байгууллага байна.

Магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувь 2024 оны байдлаар 67.1 хувь байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд нийт 40,906 суралцагч мэргэжил, ур чадвар эзэмшин суралцаж байна. Энэ нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 2,612 суралцагч буюу 6.8 хувиар өссөн байна. (График 7-д харуулав)

График 7. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн тоо



Эх сурвалж: Боловсролын яам

2024 оны 12 дугаар сарын байдлаар 2023 онд төгсөгчдийн 79.1 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа болон дараагийн шатны боловсролын түвшинд

суралцаж байна. Үүнээс 62.3 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж, 16.8 хувь нь дараагийн боловсролын түвшинд элсэн суралцсан байна.

Цаашид мэргэжлийн боловсролын түвшинд хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн болон техникийн боловсролтой төгсөгчдийг нэмэгдүүлэхийн тулд магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ нь сургалтын чанар, зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар эзэмшсэн төгсөгчдийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөрийн зах зээлийг эрчимжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Дээд боловсрол: Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд 65 дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 34 (52.3%) их сургууль, 29 (44.6%) дээд сургууль, 2 (3.1%) коллеж байх бөгөөд 17 (26.1%) төрийн өмчийн, 45 (69.2%) хувийн өмчийн, 3 (4.6%) олон нийтийн/шашны өмчийн сургалтын байгууллага байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын 60 (92.3%) нь Улаанбаатар хотод, 5 (7.7%) нь орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулж байна.⁸

Дээд боловсролын сургалтын байгууллагын 2024-2025 оны хичээлийн жилд суралцагчдын тоо 150,282 болж, өмнөх хичээлийн жилээс 4,937 буюу 3.4 хувиар нэмэгдсэн байна. (Хүснэгт 7-д харуулав.)


Хүснэгт 7. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид

Үзүүлэлт	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Бүх суралцагчид	147,293	148,954	145,267	145,345	150,282
Эмэгтэй	89,463	91,034	88,823	88,601	92,261
Эрэгтэй	57,830	57,920	56,444	56,744	58,021
Диплом	124	3,155	2,799	2,792	2,630
Бакалавр	119,108	117,037	112,451	113,322	117,344
Магистр	24,813	25,300	25,509	24,171	24,830
Доктор	3,248	3,462	4,508	5,060	5,488

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт суралцагчийг мэргэжлийн чиглэлээр авч үзвэл 2024-2025 оны хичээлийн жилд 39,561 буюу 26.3 хувийг бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн мэргэжлээр хамгийн олон суралцагч суралцаж байна. Мөн хамгийн цөөн тооны суралцагч буюу 2,127 буюу 1.4 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгийн салбарын мэргэжлийг сонгон суралцаж байна. (График 8-д харуулав)

График 8. Нийт суралцагчдын тоо, мэргэжлийн ерөнхий чиглэлээр (2024-2025 оны хичээлийн жилд)




Эх сурвалж: Боловсролын яам

Их, дээд сургуулийг 2023-2024 оны хичээлийн жилд 27,555 суралцагч төгсөж өмнөх оны хичээлийн жилээс 4,241 буюу 18.2 хувиар өссөн байна. Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2023-2024 оны хичээлийн жилд 20,906 буюу 75.9 хувь нь бакалавр, 5,421 буюу 19.7 хувь нь магистр, 1,087 буюу 3.9 хувь нь диплом, 141 буюу 0.5 хувь нь докторын зэрэг эзэмшсэн байна. (График 9-д харуулав)

⁸ Боловсрол яам, Боловсролын салбарын статистик мэдээлэл 2024-2025, 113-р хуудас, Улаанбаатар, 2025.

График 9. Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид, хүйсээр




Эх сурвалж: Боловсролын яам

Цаашид дээд боловсролын түвшинд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр төгсөгчийг нэмэгдүүлэх, ялангуяа инженерийн чиглэлээр төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ нь үндэсний хөгжлийн гол чиглэлд шаардлагатай мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчийг бий болгох, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Насан туршийн боловсрол: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.1 “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших, тэгш боломж, бүрдүүлж, боловсролын хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа тасралтгүй суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлсэн. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр⁹ суралцагчдын тоо 2024 онд өмнөх онтой харьцуулахад 673-аар буурсан байна. (График 10-т харуулав)

График 10. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр суралцагчдын тоо



Эх сурвалж: Боловсролын яам

Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр 2023-2024 оны хичээлийн жилд нийт 2,084 төгсөгчид байгаагаас бага боловсролд 172, суурь боловсролд 798, бүрэн дунд боловсролд 1,114 суралцагч суралцсан байна.

Иргэнд ажил, амьдралын орчинд суралцах, гэр бүлийн боловсрол олгох, хувь хүний хөгжлийг дэмжих, хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол олгох, цаг хугацаа орон зайнаас үл хамааран мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Насан туршийн суралцахуйн төв, 330 сумын албан бус боловсролын багшаар дамжуулан улсын хэмжээнд малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, залуу гэр бүл, ажилгүй иргэд, эрх нь хязгаарлагдсан нийт 252,843 иргэнд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.¹⁰

⁹ Иргэн бүрийн сурч боловсрох эрх, тэгш хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх албан бус сургалтын хэлбэрийг “Боловсрол нөхөн олгох сургалт” гэнэ.

¹⁰ Эх үүсвэр: Боловсролын яамны 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Цаашид насан туршийн суралцахуйн хүрээнд албан ба албан бус боловсрол эзэмшсэн, сургалтад оролцсон 18-аас дээш насны иргэдийн хувь, сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан 15-24 насны залуучуудын хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ нь иргэдийн ур чадварыг сайжруулж, ажиллах хүчний чанар, хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ур чадварын зөрүүг сургалтын хөтөлбөртэй уялдуулах замаар хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Ингэснээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай боловсон хүчин бэлтгэгдэж, залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдэж цаашлаад эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадвар нэмэгдэх боломжтой.

Дээрх үр дүнг бий болгохын тулд ажил олгогч, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн болон техникийн боловсролтой төгсөгчдийг нэмэгдүүлнэ. Үүний тулд магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувь 2024 онд 61.7 байгааг 2030 он гэхэд 100.0 хувьд хүргэнэ.

Сургалтын хөтөлбөрийг ажлын байрны ур чадвартай уялдуулах замаар эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр төгсөгчийг нэмэгдүүлнэ. Үүний тулд их, дээд сургуулийг байгалийн ухаан, инженерийн чиглэлээр төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь 2024 онд 24.2 байгааг 2030 он гэхэд 44.0 хувьд хүргэнэ.

Мөн цахим болон зайны сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх замаар албан ба албан бус боловсрол эзэмшсэн, сургалтад оролцсон иргэдийн хувийг нэмэгдүүлнэ. Үүний тулд албан ба албан бус боловсрол эзэмшсэн, сургалтад оролцсон 18-аас дээш насны иргэд 2024 онд 59.1 хувь байгааг 2030 он гэхэд 64.0 хувьд, сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан 15-24 насны залуучуудын хувь 2023 онд 73.7 байгааг 2030 он гэхэд 80.0 хувьд хүргэнэ.

Боловсролын бүх түвшинд дээрх асуудлуудыг шийдвэрлэхгүй байх нь боловсролын чанар болон хүртээмжийн ялгааг улам гүнзгийрүүлж, боловсролын индексийн өсөлтийг удаашруулах эрсдэлтэй байна. Сургуулийн өмнөх боловсролын түвшинд бага насны хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын хангалтгүй байдал нь цаашдын суралцах үр дүнд сөргөөр нөлөөлөх хандлагатай. Ерөнхий боловсролын түвшинд суурь ур чадварын ялгаа буурахгүй байх нь хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг сулруулах эрсдэлтэй. Харин мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцээгүй мэргэжлээр төгсөгчдийн тоо нэмэгдэх нь ажилгүйдэл өсөж, эдийн засгийн бүтээмж буурахад нөлөөлж болзошгүй байна. Мөн боловсролын үйлчилгээний ачаалал хот, хөдөөгийн ялгаатай байдал, боловсролын түвшний хүйсийн тэгш бус байдал, хүртээмжийн ялгааг улам гүнзгийрүүлж байна.

1.1.2. Эрүүл мэнд

Монгол Улсын хүн ам 2024 онд 3 сая 544.8 мянга болж, өмнөх оноос 40.1 мянган хүн буюу 1.2 хувиар өссөн. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2024 онд улсын хэмжээнд 71.8 болж сүүлийн 10 жилийн дунджаас 1.2 жил, өмнөх оноос 0.3 жилээр тус тус нэмэгдсэн байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.9 жил, эмэгтэйчүүдийнх 77.1 жил, зөрүү 9.2 жил байна. Манай орны дундаж наслалтын зөрүү 9.2 байгаа нь дэлхийн дунджаас 3.9 жилээр буюу 1.7 дахин өндөр байна.¹¹

¹¹ Монгол Улсын хүн ам 2024, 12-р хуудас, Улаанбаатар, 2025.

Эрүүл мэндийн үзүүлэлтээр хүн амын дундаж наслалт, халдварт болон халдварт бус өвчлөлийн байдал, биеийн тамир, спортын хүртээмж хангалтгүй байгаа нь хүний хөгжлийн индексийг бууруулахад нөлөөлж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд халдварт болон халдварт бус өвчлөл буураагүй байна. Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 30 гаруй төрлийн 37.3 мянган халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 10,000 хүн ам тутамд 109.1 продецимль байна. Нийт халдварт өвчний 41.7 хувийг амьсгалын замын халдварт өвчин, 32.6 хувийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 20.0 хувийг гэдэсний халдварт өвчин, 0.4 хувийг зоонозын халдварт өвчин, 5.3 хувийг бусад халдварт өвчин тус тус эзэлж байна.

Манай улсад 1990 оноос өмнө өвчлөлийн хувьд халдварт өвчин давамгайлж байсан бол өнөөгийн байдлаар хүний амьдралын хэв маягаас илүүтэй шалтгаалсан халдварт бус өвчин давамгайлж байна. Өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой өвчлөл дийлэнх хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд 2024 оны байдлаар амьсгалын тогтолцооны өвчнөөр 10,000 хүн тутмын 1,848.9, хоол боловсруулах тогтолцооны өвчнөөр 2,010.0, зүрх судасны өвчнөөр 1,340.9, шээс бэлгэсийн тогтолцооны өвчнөөр 1,088.9, гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад эмгэгээр 820.1 хүн байна.

Хүн амын нас баралтын хувьд зүрх судас, хавдар, гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт тэргүүлж байна. 2024 оны байдлаар 10,000 хүнд ногдох хорт хавдраар нас барсан хүний тоо 13.2, зүрх судасны өвчнөөр нас барсан хүний тоо 16.9, чихрийн шижингээр нас барсан хүний тоо 1.1, амьсгалын замын архаг өвчнөөр нас барсан хүний тоо 1.4, халдварт өвчний тохиолдлын тоо 109.1, сүрьеэгийн өвчлөлийн түвшин 6.53 байна. Хүснэгт 8-д халдварт болон халдварт бус өвчлөл, нас баралтын 2020-2024 оны үзүүлэлтийг харуулав.


Хүснэгт 8. Халдварт болон халдварт бус өвчлөл, нас баралтын үзүүлэлт

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Халдварт өвчний тохиолдлын тоо (10,000 хүнд ногдох)	104.6	1754.6	973.9	121.4	109.1
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100,000 хүнд ногдох тухайн жилд сүрьеэгээр өвчилсөн хүний тоо)	103.5	72.2	70.5	69.7	65.3
Амьсгалын замын архаг өвчнөөр нас барсан хүний тоо (10,000 хүнд ногдох)	0.9	1.1	1.3	1.3	1.4
Хорт хавдраар нас барсан хүний тоо, (10,000 хүнд ногдох)	12.8	12.8	12.8	12.8	13.2
Зүрх судасны өвчнөөр нас барсан хүний тоо (10,000 хүнд ногдох)	16.2	18.9	17.5	17.1	16.9
Чихрийн шижингээр нас барсан хүний тоо (10,000 хүнд ногдох)	0.8	1.1	1.0	0.8	1.1

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

Хүн амын нас баралт 2024 онд 18.1 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 875 (5.0%) хүнээр, өмнөх оноос 580 (3.4%) хүнээр нэмэгдсэн. Нас баралтын ерөнхий коэффициент 2024 онд 5.3 байгаа бөгөөд 1000 эрэгтэй хүн амд 6.8, эмэгтэй хүн амд 3.8 байна. Эрэгтэйчүүдийн зүрх судасны өвчнөөр нас барсан тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 3 дахин өндөр байна. Харин осол гэмтлээр нас барсан тохиолдол 3.6-5.4 дахин өндөр байгаагийн дийлэнх хувийг архины хордлого, амиа хорлолт, зам тээврийн осол эзэлж байна. Нас барсан эрэгтэйчүүдийн 50.2 хувь нь хөдөлмөрийн насных байна. (График 11-д харуулав)

График 11. Нас баралтын ерөнхий коэффициент, хүйсээр, 2015-2024 он



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

Халдварт болон халдварт бус өвчлөл нь өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа нь иргэдэд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх нэгдсэн тогтолцоо, хууль, эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой.

Эдгээр үзүүлэлт нь халдварт болон халдварт бус өвчний эрсдэл өндөр хэвээр байгааг харуулж байна. Иймээс өвчлөлийг бууруулахын тулд эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэдийн тоо, хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлэх нь чухал юм.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг: Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг гэдэг нь хүний бие, сэтгэл, оюун санааны эрүүл мэндийг дэмжих, урт удаан, чанартай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зан үйл, зуршлуудын цогц юм.

Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн биеийн жингийн эрсдэлийн үнэлгээг насны бүлгээр харьцуулан үнэлэхэд жингийн илүүдэл болон таргалалтын тархалт иргэдийн наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 40 ба түүнээс дээш насны 4 хүн тутмын 1 нь (22.0%-27.0%) таргалалттай байна. Мөн 20-39 насны иргэдийн дунд таргалалтын тархалт огцом нэмэгдэж, өмнөх насны бүлгийн насанд хүрэгчдийн үзүүлэлтээс 2 дахин ихсэж байна.

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 23.4 хувь нь тогтмол, 23.7 хувь нь долоо хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаагаар идэвхтэй хөдөлгөөн хийдэг эсвэл өдөр бүр 10,000 алхдаг байна. Долоо хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаанд идэвхтэй хөдөлгөөн хийдэг эрэгтэйчүүдийн үзүүлэлт эмэгтэйчүүдээс 4.1 хувиар илүү байна.

Нийгмийн эрүүл мэнд: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх зорилт тавьж "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай" бие даасан хууль баталж, эрх зүйн орчин бүрдүүлсэн. Хууль, эрх зүйн орчин бүрдсэнээр санхүүжилтийн хэмжээ нэмэгдэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд чанартай, хүртээмжтэй бие даасан бүтэц зохион байгуулалтын тогтолцоо бүрдэх юм.¹²

Энэ хүрээнд хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог 2022 оноос эхлэн орон даяар зохион байгуулж эхэлсэн. Эрт илрүүлэг нь зорилтот насны бүлэгт чиглэсэн, хувь хүний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийг үнэлэх, эмнэл зүйн үзлэг, багажийн болон лабораторийн шинжилгээнд үндэслэн дүгнэлт өгөх, зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад оношийг нь тодруулахаар илгээх, хянах цогц үйл ажиллагаа юм.

¹² Эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Эрт илрүүлэг үзлэгт 2024 оны байдлаар 1,593,838 хүнийг хамруулсан нь хамрагдвал зохих хүн амын 47.1 хувийг эзэлж байна. Үзлэгт хамрагдсан иргэдээс хавдрын сэжигтэй 5,797 хүн илэрч, 371 анх оношлогдсон хорт хавдар байна. Анх оношлогдсон 371 хорт хавдрын 37.7 хувь нь эрт (0-2 үе шат), 62.3 хувь нь хожуу (3-4 үе шат) оношлогджээ. Бүдүүн гэдэсний хавдрын эрт илрүүлэг болох өтгөнд далд цус алдалт 10 хүн тутмын 1-д илэрлээ. Судасны хатуурлын эрсдэл, сүрьеэгийн тохиолдол эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил, чихрийн шижин эрэгтэйчүүдэд, гепатитын В, С вирусийн хавсарсан халдвар эмэгтэйчүүдэд илүү тохиолдож байна.

Үзлэгт хамрагдсан насанд хүрсэн 10 хүн тутмын 7 нь халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй, дөнгөж 4.1 хувь нь ямар нэгэн эрсдэлгүй байна. Халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт Улаанбаатар хотын иргэдийн дунд өндөр буюу орон нутгийн түвшнээс 3.2 хувиар илүү байна. Халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй насанд хүрсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс 15.1 хувиар илүү байна.¹³

Нярайн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт: Нярай хүүхдийн өвчлөл 2024 онд 27,157 бүртгэгдсэн нь нийт амьд төрсөн хүүхдийн 47.0 хувийг эзэлж, өмнөх оноос 12.2 хувиар буурсан ч нярайн болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тогтвортой буурахгүй байна.

Перинаталь үед үүссэн зарим эмгэг дотор төрөхөд ураг бүтэх 1.9 хувь, нярайн шарлалт 48.6 хувийг эзэлж байна. Амбулаторид бүртгэгдсэн нэг хүртэлх насны хүүхдэд төрөлхийн гажгийн 8,693 тохиолдлоос зүрхний таславчийн төрөлхийн гажиг 38.5 хувь, түнхний төрөлхийн гажиг 36.3, сэтэрхий уруул ба тагнай 2.0 хувь, шээс ялгаруулах тогтолцооны төрөлхийн гажиг 7.5 хувь, цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг 3.7 хувьтай тэргүүлж байна.

Улсын хэмжээнд 2024 онд нярайн эндэгдлийн нийт 431 тохиолдол бүртгэгдсэний 281 буюу 65.2 хувь нь нярайн эрт үед (амьдралын эхний 0-6 хоногт), 150 буюу 34.8 хувь нь нярайн хожуу үед (амьдралын эхний 7-28 хоногт) эндсэн байна. Харин тав хүртэлх насандаа 877 хүүхэд эндсэн бөгөөд амьд төрсөн 1,000 хүүхдэд ногдох түвшин 15.2 байна. Өмнөх онтой харьцуулахад 84 тохиолдлоор буурч, амьд төрсөн 1,000 хүүхдэд ногдох эндэгдэл 0.3 тохиолдлоор ихэссэн үзүүлэлттэй байна.

Сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалт: Урьдчилсан сэргийлэх эрт илрүүлэгт хамрагдсан 0-17 насны 753,903 хүүхэд байгаагаас 6-17 насны хүүхдийн 5 хүүхэд тутмын 3 нь шүдний өвчтэй, 6.5 хувь нь илүүдэл жинтэй, 25.7 хувь нь илүүдэл жин, таргалалтад өртөх эрсдэлтэй байна.

Нийт 6 ба 14 насны эрт илрүүлэгт хамрагдсан хүүхдийн 72.6 хувь нь сэтгэл хөдлөл зан үйл нь хэвийн буюу насандаа тохирсон, 27.4 хувь нь сэтгэл хөдлөл зан үйлийн хувьд хэвийн бус сэжигтэй байна. Үүнээс 7.0 хувь нь сэтгэл хөдлөл, 30.3 хувь нь зан үйлийн хувьд хэвийн бус, 12.2 хувь анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг, 16.0 хувь нь үе тэнгийнхний харилцаандаа тулгамдсан асуудалтай, 34.5 хувь нь бусад өөрчлөлттэй байна.

Монгол Улсад 2024 онд 0-19 насанд 148 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэний 34 нь 0-4 нас, 74 нь 5-14 нас, 40 нь 15-19 насны хүүхэд байна. Нийт хүүхдийн хорт хавдрын шинэ өвчлөл 2020 онд 57, 2021 онд 115, 2022 онд 143, 2023 онд 125 бүртгэгдсэн. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкеми тэргүүлж байгаа ба тархи мэдрэлийн, яс мөгөөрсний, бөөр, Ходжкины бус лимфома хавдар мөн тэргүүлж байна.

Эмийн чанар: Манай улсын эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа 2007 оноос эхлэн

¹³ Эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ


бүхэлдээ хувийн хэвшилд шилжсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр 32, ханган нийлүүлэх байгууллага 466, эмийн сан 2,835 байна. Монгол Улсын эмийн бүртгэлд 55 улсын 707 үйлдвэрлэгчийн 3,785 эм бүртгэлтэй байна.

Улсын хэмжээнд 2024 онд эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх нийт 32 үйлдвэр үйл ажиллагаа явуулснаас Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан 9 үйлдвэр байна. Тус үйлдвэрүүдийг чиглэлээр нь авч үзвэл эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх 51 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсад 2024 оны жилийн эцсийн байдлаар 87 улсын 478 үйлдвэрлэгчийн (давхардсан тоогоор) 1,107 (худалдааны нэршлээр) нэр төрлийн эмд импортын мэдүүлэг олгосон байна. 2023 онтой харьцуулахад эм, эмийн түүхий эд, стандарт бодист олгосон импортын мэдүүлэг 981-ээр буурч, эмнэлгийн хэрэгсэл, эмийн туслах материал 202, оношлуур урвалж 391, төрийн хяналтын мэдүүлэг 121, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн импортын мэдүүлэг 12-оор тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Эмийн суурь үнийн дүнгээр 2024 онд 612.2 тэрбум төгрөгийн импорт хийсэн нь 2020 онтой харьцуулахад 243.3 тэрбум төгрөг буюу 66.0 хувиар өссөн байна. (График 12-т харуулав)

График 12. Эмийн импорт, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

2024 онд Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй 174 нэр төрлийн 11,393 ширхэг, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 289 нэр төрлийн 5,606 ширхэг, хаяг шошгын зөрчилтэй 2 нэр төрлийн 483 ширхэг, хадгалалтын горим алдагдсан 5 нэр төрлийн 53,024 ширхэг нийт 134.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий зөрчилтэй эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хяналт шалгалтаар илрүүлж холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэсэн.

Монголын уламжлалт анагаах ухаан: Улсын хэмжээнд 2024 онд уламжлалт анагаах ухааны тусгай зөвшөөрөл бүхий 6 уламжлалт эмийн үйлдвэр, 7 сургууль, 200 орчим эмнэлэг, амбулатори, 1,467 эмч, 490 сувилагч ажиллаж байна. Уламжлалт эмийн 2 үйлдвэр дотоодын “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын шаардлагыг хангасан бөгөөд уламжлалт анагаах ухааны 440 эм Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлтэй байна.

Орон нутгийн 7 аймагт Уламжлалт анагаах ухааны дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх аймгийн нэгдсэн эмнэлэг 16, сумын нэгдсэн 6 эмнэлэгт уламжлалт анагаах ухааны тасаг ажиллаж, 12 аймагт 43 сувилал, хувийн эмнэлэг үйл ажиллагаа эрхэлж байна. Улаанбаатар хотод Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн түвшинд ажиллаж байгаагаас гадна 80 гаруй уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлдэг төр, хувийн хэвшлийн эмнэлэг ажиллаж байна.

Монгол Улсад зонхилон хэрэглэгдэж байгаа уламжлалт эмийн үйлдвэрлэлд 350 гаруй түүхий эд ашиглаж байгаагаас эмт ургамал 74.0 хувь, эрдэс 15.0 хувь, амьтны

гаралтай түүхий эд 11.0 хувь байна. Түүнчлэн уламжлалт эмийн түүхий эдийн 50.0 хувийг гадаад улсаас импортолдог бөгөөд БНХАУ-аас 90.0 хувийг импортолж байна.

Монгол Улсаас 3 ханган нийлүүлэх байгууллага Бүгд Найрамдах Унгар Улс болон Бүгд найрамдах Польш Улс руу уламжлалт эмийг экспортолж байна. 2024 онд 881.7 сая төгрөгийн 146 (давхардсан тоогоор) нэр төрлийн уламжлалт эмд экспортын мэдүүлэг олгосон нь 2023 онтой харьцуулахад 39.1 хувиар буурсан ба тан эмийн экспорт 18.7 сая, талх эмийн экспорт 402.2 сая, үрэл эмийнх 145.6 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн даатгал: Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн чуулганаар Эрүүл мэндийн тухай багц хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сан гэсэн 2 эх үүсвэрээс санхүүжүүлж байсан тогтолцоог халж, санхүүжилтийг төвлөрүүлж, сангийн үйл ажиллагааг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл орц, хатуу хязгаарлалтад байсан санхүүжилтийн тогтолцоог гарц, үр дүн, үр ашигт суурилан шинэчилсэн.

Шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, иргэнийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлэн ажилласнаар нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмж 2 дахин нэмэгдэж 83.8 хувь болсон. Шинэчлэл хэрэгжихээс өмнө 2.0 сая төгрөгөөс дээш тусламж, үйлчилгээг санхүүжүүлдэггүй байсан бол 2024 оны байдлаар жилд 2.0 сая төгрөгөөс дээш тусламж, үйлчилгээ авсан иргэдийн тоо 142.0 мянга болж өссөн.

ДЭМБ гишүүн улс, орнууддаа эрүүл мэндийн салбарт зарцуулах санхүүжилтийг тухайн улсын ДНБ-ын 5.0-аас доошгүй хувь байхыг зөвлөмж болгодог. Манай улсын хувьд 2025 оны байдлаар 3.0 хувь байгаа нь зорилтот түвшин болон бүс нутаг, дэлхийн дунджаас доогуур үзүүлэлт юм.

Эрүүл мэндийн даатгалын сангийн жил бүрийн батлагдсан төсвөөс тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн тоо давж байгаа ба түүний үр дүнд даатгалын санд төсөвт тусгагдаагүй өр төлбөр үүсэж байна. Сангийн тэнцэл алдагдахад хүргэсэн гол шалтгаан нь Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээний 2024 оны гүйцэтгэлээр нийт зардал эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлсэн улсын төсвөөс олгох татаас санхүүжилтийн орлогоос 189.7 тэрбум төгрөгөөр давсан, улсын төсвөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэдийн шимтгэлийн орлого нь тухай иргэдийн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилттэй харьцуулахад 560.7 тэрбум төгрөг буюу 2.7 дахин бага байгаа, 2025 оны төсвийн тодотголоор 51.5 тэрбум төгрөгөөр бууруулсан, эрт илрүүлэг үзлэгийн үр дүнгээр өвчлөл нэмэгдэж байгаа зэрэг юм.

2021-2024 онд төрийн албан хаагчийн цалингийн өсөлт болон инфляцын нөлөөгөөр тусламж, үйлчилгээний тарифыг жил бүр 2.0-7.0 хувиар нэмэгдүүлсэн боловч бодит зардлын өсөлтийг хангаж чадахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны батлагдсан төсвөөс өмнөх оны хуримтлагдсан өр төлбөр 316.8 тэрбум төгрөгийг барагдуулсан бөгөөд үлдэж буй санхүүжилтэд хамгийн оновчтой, үр дүнтэй, даатгуулагчийн амь нас аврах чиглэлийн тусламж, үйлчилгээнд зарцуулж, тэнцлийг хангах бодлогыг баримталж байна. Хэдийгээр батлагдсан төсөвт багтааж тусламж, үйлчилгээг тоо хэмжээгээр хязгаарлах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллаж байгаа хэдий ч хүн амын өвчлөл бодитой, тусламж, үйлчилгээний хүртээмж хангалтгүй, нөөцийн дахин хуваарилалтыг хийж, санхүүжилтийн үр ашгийг сайжруулах хэрэгцээ байна. Эрүүл мэндийн даатгалын сан нь 2025 төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 279.3 тэрбум төгрөгийн өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан гаргахад 2024 оны байдлаар ажил олгогчийн орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь даатгалын сангийн орлогын 42.4 хувийг бүрдүүлж, сангийн зардлыг 7.9 хувийг хүртсэн байна. Гэтэл төр хариуцах иргэд нь даатгалын сангийн орлогын 16.8 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 41.9 хувийг хэрэглэж байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ: Эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэдэг нь хүний өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хордлого, биеийн үйл ажиллагааны алдагдлыг оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах зэрэг цогц үйл ажиллагааг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан үзүүлэхийг хэлнэ. Энэ нь хүний эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах, амь нас, амьдралын чанарыг хадгалах чухал үүрэгтэй. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь анхан шатны тусламж болох өрхийн эрүүл мэндийн үйлчилгээ, төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзүүлэх мэргэшсэн тусламж, жирэмсэн болон төрөх үеийн эх барихын тусламж, амь насанд аюултай нөхцөлд үзүүлэх яаралтай тусламж, газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлэх түргэн тусламж, өвчтөн асрах, сувилах, хөнгөвчлөх сувилахуйн тусламж, мөн биеийн үйл ажиллагааны алдагдлыг нөхөн сэргээх сэргээн засах зэрэг төрлүүдтэй.

2024 онд статистикийн тайлан ирүүлсэн 4,914 эрүүл мэндийн байгууллагаас хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 14, тусгай мэргэжлийн төв 3, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, дүүргийн эрүүл мэндийн төв 10, сумын нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 307, өрхийн эрүүл мэндийн төв 227, ортой хувийн эмнэлэг 229, хувийн клиник 1,588 байна. (Хүснэгт 9-д харуулав)

Хүснэгт 9. Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2024 он

Эрүүл мэндийн байгууллагууд		Аймгийн дүн	Улаанбаатар	Улсын дүн
Өрхийн эрүүл мэндийн төв		76	151	227
Тосгоны эрүүл мэндийн төв		16	4	20
Сумын эрүүл мэндийн төв	А зэрэглэл	53	-	53
	Б зэрэглэл	113	-	113
	В зэрэглэл	141	-	141
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг		6	-	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг		16	-	16
Дүүргийн нэгдсэн эмнэлэг		-	4	4
Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ		-	10	10
Бүсийн оношилгоо эмчилгээний төв		5	-	5
Тусгай мэргэжлийн төв		-	3	3
Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг		1	13	14
Амаржих газар		-	3	3
Түргэн тусламжийн төв		-	1	1
Клиник /хувийн/		508	1,080	1,588
Ортой хувийн эмнэлэг		103	126	229
Сувилал		47	44	91
Эм ханган нийлүүлэх байгууллага		82	60	142
Эмийн сан		967	1,150	2,117
Тусгай эмнэлэг		21	6	27
Бусад		76	28	104
Нийт		2,231	2,683	4,914

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

Улсын хэмжээнд 2024 онд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 30,117 эмнэлгийн ор ашигласан бөгөөд сүүлийн 10 жилийн дунджаас 3,047 ороор нэмэгдсэн байна. Үүнээс 72.8 хувь нь төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад, 27.2 хувь нь хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ашиглалтын хувь улсын дундаж 64.1, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт 78.9, аймгийн нэгдсэн эмнэлэгт 71.9, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 66.3, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэгт 70.2, сум тосгоны эрүүл мэндийн төвүүдэд 60.1, хувийн эмнэлгүүдэд 48.0, бусад эмнэлгүүдэд 70.1 хувь байна.

Эмнэлгийн бус нас баралт: Манай улсад түргэн тусламжийн дуудлагын тоо жил ирэх тутам нэмэгдэж, 2024 онд яаралтай тусламжийн 727,553 удаагийн тохиолдол бүртгэгдэж, 621,005 иргэн үйлчилгээ авч, 59.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт дуудлагын 76.2 хувь нь 20 минутаас дээш хугацаагаар хүлээлгэсэн ба орон нутагт 30 минутаас 2 цаг хүртэлх хугацаанд тусламж хүрэх тохиолдол элбэг байна. Нийслэлд өдөрт 40 орчим түргэн тусламжийн автомашин ажиллаж байгаа нь олон улсын жишгээс 3 дахин бага байна.

Нийт нас баралтаас эмнэлгийн бус нас баралтын эзлэх хувь 2020 онд 64.7, 2021 онд 65.9, 2022 онд 66.1, 2023 онд 68.0 хувь, 2024 онд 68.0 хувь байгаа нь жил бүр нэмэгдэх хандлагатай байна.

Манай улсад нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны суурь тусламж, үйлчилгээний хамрагдалт дөнгөж 19.6 хувь байгаа нь эрүүл мэндийн тогтолцооны үр нөлөө, хүртээмж хангалтгүй байгааг илтгэж байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо бүрэн бүрдээгүй, хүн амын дунд өвчнөөс урьдчилан сэргийлэх хандлага сул, ихэнх тохиолдолд өвдсөний дараа эмнэлэгт ханддаг байдал давамгайлж, эмийн хэрэглээ хяналтгүй, эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг дутмаг, эмийн бус эмчилгээ, уламжлалт анагаах ухааны аргыг төдийлөн ашигладаггүй нь амьдралын эрүүл дадал хэвшлийг төлөвшүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтыг нэмэгдүүлэх, эмийн чанарыг сайжруулах, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын дадал хэвшлийг төлөвшүүлэх нөхцөл бүрдэх юм.

Энэ хүрээнд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэхээр зорьж, хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувийг 2030 он гэхэд 25.0 хувьд хүргэх, нярайн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувийг 40.0 хувьд хүргэх, сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтын хувийг 25.0 хувьд хүргэх, үндэсний хөтөлбөрт тусгагдсан бүх төрлийн вакцинжуулалтад хамрагдсан зорилтот хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсад худалдаалагдаж байгаа стандартын шаардлага хангасан эмийн эзлэх хувь, эмийн найдвартай, аюулгүй байдал, эмийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хууль бус эмийн эзлэх хувь 2024 онд 18.0 байсныг 2030 онд 5.0 хувьд хүргэнэ.

Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний төрөл, чанарыг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь 2024 онд 65.0 байгааг 68.0 хувьд хүргэх, мөн хөдөө орон нутгаас төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт ирж тусламж, үйлчилгээ авсан иргэд 2024 онд 29.0 хувь байгааг 2030 он гэхэд 15.0 хувь болгож бууруулна. Үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх замаар уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж үйлчилгээний тоо 2024 онд 10,000 хүн амд 122.0 продецимиль байгааг 2030 он гэхэд 258.0 продецимильд хүргэнэ.

Мөн төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх замаар хувь хүний төлөх төлбөрийн хэмжээг 33.0 хувь байгааг

26.0 болгож бууруулах, яаралтай, түргэн тусламжийн сүлжээг шинэчлэх замаар сэргийлэх боломжтой эмнэлгийн бус нас баралтын нийт нас баралтад эзлэх хэмжээ 2024 онд 68.0 хувь байгааг 2030 он гэхэд 56.0 хувь болгож бууруулахаар төлөвлөсөн.

Хүн амын бие бялдрын хөгжил: Монгол хүний өдрийн дундаж алхалтын тоо 2,737 байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн 10,000 алхалтаас 73.0 хувиар бага байна.

Бие бялдрын түвшин тогтоох сорилын дүнгээр нийт хамрагдагсдын 23.4 хувь нь илүүдэл жинтэй байгаагийн 53.2 хувь нь эмэгтэй, 46.8 хувь нь эрэгтэй хүн байна.

Монгол Улсад биеийн тамир, спортын 33 төрийн захиргааны байгууллагад 861 албан хаагч ажиллаж, 1 ажилтанд биеийн тамир, спортоор хичээллэдэг 3,988 иргэн ногдож байна. Улсын хэмжээнд 2024 онд нийт 4,122 биеийн тамир, спортын арга хэмжээнд нийт 1,325,962 хүн хамрагдаж, улсын хэмжээнд 1,541 спортын заал, 1,950 спортын гадна талбай байна.

Биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд ашиглагдаж буй спортын заалны болон гадаад талбайн тоо, спортоор хичээллэх талбайн хэмжээг 6-64 насны хүн амд харьцуулсан үзүүлэлтээр хэмждэг. Спортоор хичээллэх талбайн хэмжээг 6-64 насны хүн амд харьцуулсан үзүүлэлт 2024 онд нэг хүнд ногдох спортын гадаа талбайн хувьд 2.64 м.кв, спортын заалны үзүүлэлт 2024 онд 0.176 м.кв байна.

Дасгал хөдөлгөөн хийх дадал хэвшил: Дасгал хөдөлгөөн нь амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэхэд онцгой ач холбогдолтой. Бие махбодын хувьд тогтмол хөдөлгөөн нь зүрх судасны эрүүл мэндийг дэмжиж, бодисын солилцоог идэвхжүүлэн, дархлааг сайжруулж, өвчлөх эрсдэлийг бууруулахад мөн тусалдаг.

Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон даяар зохион байгуулагдсан эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 23.4 хувь нь тогтмол, 23.7 хувь нь хаяа долоо хоногт 5-аас цөөнгүй өдөр 30 минутаас багагүй хугацаагаар эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэг эсвэл өдөр бүр 10,000 алхдаг гэж хариулжээ. Идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийх дадал аймаг орон нутаг (24.5%), Улаанбаатар хотын (23.4%) иргэдийн дунд харьцангуй ижил түвшинд байна.

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн биеийн жингийн индексийн дундаж хэмжээ 26.4 кг/м² байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30 ба түүнээс дээш насны 2 хүн тутмын 1-ээс илүү нь илүүдэл жин ба таргалалттай байв. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 56.0 хувь төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр байна.

Монгол Улсын хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин 2024 оны байдлаар 76.2 хувь, идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэх дадалтай хүн амын эзлэх хувь 37.0 хувь байгаа нь дасгал хөдөлгөөний ач холбогдлыг олон нийтэд таниулах үйл ажиллагаа хангалтгүй, дасгал хөдөлгөөний талаарх ойлголт, дадал харьцангуй сул, идэвхтэй хөдөлгөөнийг өдөр тутмын амьдралын хэв маягт нэвтрүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Цаашид эрүүл, зөв амьдралын хэв маягийг дэмжих замаар хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлэхээр зорьж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэх дадалтай хүн амыг 38.2 хувьд хүргэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар спортын барилга байгууламжаас 15 минутын зайд амьдарч буй хүн амын эзлэх хувийг 2030 он гэхэд 5.0 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

Мөн спортын сургалт, дасгалжуулалтын уялдааг сайжруулах, тамирчдын залгамж халааг бэлтгэх замаар олимп, дэлхийн амжилтыг хадгалж, Азийн наадмын

амжилтыг дээшлүүлнэ. Үүний тулд зуны олимп, параолимпын наадмын амжилтыг нэмэгдүүлэх, Ази тивийн зуны спортын наадамд улсын дүнгээр эзэлсэн амжилтыг урагшлуулахаар зорьж байна.


Эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлж, тэдний бие бялдрын хөгжлийн түвшнийг дээшлүүлэх нь зүрх судасны өвчлөл, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчин, нас баралтыг бууруулахад чухал ач холбогдолтой юм. Зонхилон тохиолдох өвчлөл нь амьдралын хэв маягтай шууд холбоотой тул урьдчилан сэргийлэх, эрүүл дадал хэвшлийг төлөвшүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах боломжтой байна. Энэ хүрээнд зүрх судасны өвчнөөр нас барсан хүний тоог (10,000 хүнд ногдох) 2024 онд 16.9 продецимиль байсныг 14.6-д хүргэх, халдварт өвчний тохиолдлын тоог (10,000 хүнд ногдох) 2024 онд 109.1 продецимиль байсныг 73.0 болгох, хорт хавдраар нас барсан хүний тоог (10,000 хүнд ногдох) 2024 онд 13.2 продецимиль байсныг 8.0-д хүргэж бууруулахаар тус тус төлөвлөв.

1.1.3. Дундаж давхарга

Орлогын түвшинд, ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр, дундаж орлого бага байгаа нь иргэдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, хүний хөгжлийн индексийн өсөлтийг удаашруулж байна. Үндэсний статистикийн хорооноос 2 жил тутамд ядуурлын түвшнийг тооцдог. Ядуурлын түвшин 2022 оны байдлаар 27.1 хувь байгаа бөгөөд энэ нь ядуурлын шугамыг шинэчлэн тооцсон дүн юм. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктай хамтран ядуурлын шугамыг 418 мянга 90 төгрөг болгож шинэчлэн тооцсон. Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 914.2 мянган хүн байгаа бөгөөд ядууралд өртөхөд ойрхон 346.4 мянган хүн ам байгаа нь ядуурал 10.3 хувиар нэмэгдэх эрсдэлтэй байна. Нийт ядуу хүн амын 57.0 хувь нь хот суурин газарт, 43.0 хувь нь хөдөө, орон нутагт байна. Үүнээс 37.0 хувь нь Улаанбаатар хотод, аймгийн төвд 19.0 хувь, сумын төвд 20.0 хувь, хөдөө 23.0 хувь нь амьдарч байна.

Жини коэффициент буюу тэгш бус байдлын үзүүлэлт болох нэг хүнд сард ногдох зардлын ялгаа 2024 оны байдлаар 0.29 болж буурсан эерэг үзүүлэлтэй байна. (График 13-т харуулав)

График 13. Ядуурлын түвшин болон Жини коэффициент¹⁴



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 20 жилийн хугацаанд тогтвортой өсөж, хөдөлмөрийн бүтээмж эдийн засгийн бүх салбарт дээшилж, хотжилт нэмэгдэж, ажил эрхлэлт хөдөө аж ахуйгаас аж үйлдвэр, ялангуяа үйлчилгээний салбарт шилжиж байна.¹⁵

¹⁴ Жини коэффициент хүн амын зардлын тэгш бус хуваарилалтыг илэрхийлсэн үзүүлэлт. 0>тусам ялгаа ихсэж, 0 руу ойртох тусам ялгаа бага байгааг илтгэнэ. Ядуурлын шугамыг 2022 оноос шинэчлэн 418,090 төгрөгөөр тогтоосон.

¹⁵ Улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ. ОУШХБ, Улаанбаатар хот, 2025.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2024 онд 15 ба түүнээс дээш насны хүн амын 1.4 (61.3%) сая ажиллах хүч, 911.7 (38.7%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.6 хувь болж, өмнөх оноос 1.3 нэгж хувиар өссөн байна. Ажилгүйдлийн түвшин 5.9 хувь болж өмнөх оноос 0.6 нэгж хувиар нэмэгдсэн байна. Ажиллагчдын 627.5 (46.3%) мянга нь Улаанбаатар хотод, 728.2 (53.7%) мянга нь хөдөө, орон нутагт байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл 2020-2024 оны хооронд Ковид-19 цар тахлын нөлөөнд өртөж, дараа нь үе шаттайгаар сэргэж эхэлсэн бөгөөд ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2021 онд огцом буурсан ч 2022 оноос эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, 2024 онд үндсэн үзүүлэлт эерэг чиглэлд шилжсэн. Тухайлбал, ажиллагчид 8.5 хувиар, хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин 3.9 нэгж хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гэвч ажилгүйдлийн түвшин 2024 онд 2021 онтой харьцуулахад буурсан боловч 2023 оноос 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь тогтворгүй байгааг илтгэж байна. (Хүснэгт 10-т харуулав)

Хүснэгт 10. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Ажиллах хүч	1,340,014	1,317,425	1,370,594	1,367,319	1,441,090
Ажиллагчид	1,249,643	1,207,991	1,283,128	1,294,746	1,355,666
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	4,897	6,754	8,376	6,505	4,314
Ажилгүй хүн	90,371	109,434	87,466	72,573	85,423
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	854,785	910,249	901,868	930,549	911,690
Боломжит ажиллах хүч	69,511	73,422	45,338	39,841	24,218
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	785,274	836,826	856,530	890,708	887,471
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	61.1	59.1	60.3	59.5	61.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	56.9	54.2	56.5	56.3	57.6
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, хувь	11.7	13.6	10.0	8.5	7.8
Ажилгүйдлийн түвшин, хувь	6.7	8.3	6.4	5.3	5.9
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, хувь	7.1	8.8	7.0	5.8	6.2
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, хувь	11.3	13.1	9.4	8.0	7.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл цар тахлын дараах сэргэлтийн мөчлөгт орж, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсөж, хөдөлмөрийн дутуу ашиглалт буурсан эерэг төлөвтэй байна. Гэвч ажиллах хүчнээс гадуурх хүн ам өндөр хэвээр байгаа нь зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого шаардлагатайг харуулж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд ажиллах хүчний нийт оролцооны түвшин тогтвортой өсөхгүй байна. Эрэгтэйчүүдийн оролцоо 69.7 хувьд хүрч 2020 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрсэн бол эмэгтэйчүүдийн оролцоо 2020 онтой харьцуулахад 0.6 нэгж хувиар буурч 53.5 хувьд хүрсэн байна. (Хүснэгт 11-д харуулав) Энэ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 11. Ажиллах хүчний оролцооны түвшин

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	Дэлхийн дундаж
Нийт	61.1	59.1	60.3	59.5	61.3	60.6
Эрэгтэй	68.7	67	68.1	67.9	69.7	72.9
Эмэгтэй	54.1	51.8	53.1	51.9	53.5	48.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүчний оролцооны түвшин 2024 оны байдлаар 61.3 хувь байгаа бөгөөд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь ажиллах хүчний аюулгүй

байдал, бүтээмжийг сайжруулж, ажиллах хүчний идэвхийг нэмэгдүүлэхэд шууд нөлөөлдөг. Мөн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол: Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2,125 тохиолдол бүртгэгдэж, 275 хүн нас барсан байна. Үйлдвэрлэлийг осол гэмтлийн давтамж манай улсад 2024 онд (100,000 ажиллагчдад) 59.7 байхад Казакстан 41.5, Узбекистан 10.0, Киргизстан 22.1 байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаант нас баралт (100,000 ажиллагчдад) Монгол Улсад 6.4 байхад Узбекистанд 3.6 байна.¹⁶ Ижил төстэй орнуудтай харьцуулахад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын давтамж өндөр үзүүлэлттэй байна.

Нийт хөдөлмөрийн насны хүн амын 61.3 хувь нь ажиллах хүч бөгөөд эдгээрийн 521.0 (22.1%) мянга нь эрсдэлтэй салбарт ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас 224.0 мянган хүн нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүд, эдийн засгийн өсөлтийн дүнд ажиллах хүчний эрэлт 2035 онд 19.1 хувиар, үүнээс эрсдэл өндөртэй уул уурхай, олборлолтын салбарт 32.5 мянга, боловсруулах үйлдвэрт 63.3 мянга, барилгын салбарт 55.9 мянган хүнээр нэмэгдэх төлөвтэй байгааг хөдөлмөрийн зах зээлийн таамаглалаар тодорхойлжээ.


Цаашид хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдалтын хувийг нэмэгдүүлж, аюулгүй, эрүүл орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Асуудлыг шийдэх үүднээс идэвхтэй урьдчилан сэргийлэлтийг дэмжих замаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг бууруулахыг зорьж байна. Ингэснээр ажиллах хүчний аюулгүй байдал сайжирч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.

Дээрх үр дүнг бий болгохын тулд бүх талын мэдлэгийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулж, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдалтыг 2030 он гэхэд 20.0 хувиар нэмэгдүүлнэ.

Ажилгүйдлийн түвшин: Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2024 онд 15 ба түүнээс дээш насны хүн амын 1.4 (61.3%) сая ажиллах хүч, 911.7 (38.7%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.6 хувь болж, өмнөх оноос 1.3 нэгж хувиар өссөн байна. Ажилгүйдлийн түвшин 5.9 хувь болж өмнөх оноос 0.6 нэгж хувиар нэмэгдсэн байна. (График 14-т харуулав)

График 14. Ажилгүйдлийн түвшин, хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Албан бус хөдөлмөр эрхлэлт: Нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо 2020 онд 555.2 мянга байсан бол 2024 онд 594.9 мянга болж 7.2 хувиар нэмэгдсэн нь албан бус

¹⁶ Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO).

хөдөлмөрийн хэмжээ өсөх чиг хандлагатай байгаа бөгөөд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувийн жин хөдөө аж ахуйн салбарт сүүлийн 5 жилд 44.4 хувиас 43.9 хувь болж буурсан боловч хөдөө аж ахуйн бус салбарт 23.3 хувиас 28.1 хувь болж нэмэгдсэн байна.

Сүүлийн таван жилийн хандлагыг харвал, хөдөө аж ахуй дахь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо 2020 онд 345.7 мянга байсан бол 2024 онд 299.6 мянга болж 13.0 хувиар буурсан байна. Харин бөөний болон жижиглэн худалдааны салбар дахь албан бус ажиллагчдын тоо 2020 онд 54.4 мянга байсан бол 2024 онд 112.9 мянга болж 2.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөө аж ахуйгаас дараагийн өндөр түвшинтэй салбарууд нь бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засварын үйлчилгээ 112.9 (19.0%) мянга, барилгын салбар 44.8 (7.5%) мянга, боловсруулах үйлдвэрлэл 40.2 (6.8%) мянга, тээвэр, агуулахын үйлчилгээ 38.8 (6.5%) мянга байна. (Хүснэгт 12-т харуулав)

Хүснэгт 12. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо, хувийн жин

Салбар		Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
ХАА-н орсон салбар	Албан бус хөдөлмөр эрхлэгчид		555,221	520,482	555,712	531,493	594,954
	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь		44.4	43.1	43.3	41.1	43.9
ХАА-н салбарт бус	Албан бус хөдөлмөр эрхлэгчид		209,474	180,348	215,186	194,451	295,374
	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь		23.3	20.9	23.1	20.8	28.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйн бус салбарын нийт ажиллагсдын 20.8 хувь нь 2023 оны байдлаар албан бус ажил эрхэлж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг бууруулж, нийгмийн хамгааллын хүртээмжийг хязгаарлаж байна. Иймд албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах шаардлагатай байна.

Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт: Зорилтот бүлгийн өрхийн хөдөлмөрийн насны нийт иргэдийн 33.4 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 66.6 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. Хүйсээр нийт хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 47.1 хувь нь эмэгтэй, 52.9 хувь нь эрэгтэй байна. Хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 62.7 хувь нь цалинтай ажил, 18.5 хувь нь мал аж ахуй, 11.0 хувь нь бусад, 3.5 хувь нь цалин хөлсгүй ажил, 2.6 хувь нь өрхийн бизнес, газар тариалан, ажил олгогч гэсэн ангилалд орж байна. Бүс нутгаар харвал Улаанбаатар хотод 81.6 хувь нь цалинтай ажил, баруун бүсэд 9.2 хувь нь мал аж ахуй эрхлэлт өндөр хувийг эзэлж байна.¹⁷

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 2024 оны байдлаар хамрагдсан иргэдээс байнгын ажлын байртай болсон хүний эзлэх хувь 25.1 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 16.0 хувь, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 53.5 хувь байгаа нь эдгээр зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт: Монгол Улсад 15-24 насны залуучуудын ажиллах хүчний оролцоо 2024 онд 29.8 хувь болж өмнөх оноос өссөн боловч дэлхийн дунджаас 12.0 нэгж хувиар доогуур үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 14.7 хувь байгаа бөгөөд 2020 онтой харьцуулахад 1.6 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Харин суралцаагүй, хөдөлмөр эрхлээгүй эсвэл сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь 2024 оны байдлаар 10.1 хувь байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад 10.3 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Иймд

¹⁷ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, Улаанбаатар, 2024.

залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургалтын болон хөгжлийн боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ур чадвар, мэргэжлийн сургалтыг дэмжих замаар зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. Үүний тулд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдагчдад байнгын ажлын байртай болсон хүний эзлэх хувь 2024 онд 25.1 байгааг 2030 он гэхэд 30.0 хувьд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2024 онд 16.0 хувь байгааг 19.0 хувьд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2024 онд 53.5 хувь байгааг 58.0 хувьд тус тус хүргэхээр төлөвлөсөн.

Гарааны бизнес, энтрепренершипыг дэмжих замаар залуучуудын идэвх, оролцоог нэмэгдүүлнэ. Үүний тулд 2024 онд 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 14.7 хувь байгааг 2030 он гэхэд 12.2 хувь, суралцаагүй, хөдөлмөр эрхлээгүй эсвэл сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь 2024 онд 10.1 хувь байгааг 2030 он гэхэд 7.8 хувь болгож бууруулна.

Хөдөлмөрийн үнэлэмж, дундаж цалин: Хөдөлмөрийн үнэлэмж нь зөвхөн цалингаас гадна бүтээмж, бодлогын зохицуулалт, нийгмийн хандлага, жендэрийн бүтэц, албан ёсны ажлын байрны баталгаа зэргээс хамаардаг нийгэм-эдийн засгийн нийлмэл үзүүлэлт юм. Хөдөлмөрийн үнэлэмжийн гол үзүүлэлт болох медиан цалин 2024 оны IV улирлын байдлаар 2,229.4 сая төгрөг (НДШ төлөгчдийн 50% түүнээс доош орлоготой), хамгийн бага цалин 792,000 төгрөг (2025 оны 04 дүгээр сарын 01-ээс) байна.

Улсын хэмжээнд нийт ажиллагчдын дундаж цалин хөлс 2,332.4 мянган төгрөг, хувийн хэвшлийн ажиллагчдын дундаж цалин хөлс 2024 оны жилийн эцсийн байдлаар 2,303.8 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,278.0 мянган төгрөг байна. (График 15-д харуулав)

График 15. Ажиллагчдын сарын дундаж, медиан цалин болон бодит цалингийн индекс (мянган төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цалинтай ажиллагчдын цагийн дундаж хөлс 2024 оны байдлаар 9.2 мянган төгрөг байгааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргаан: Олон улсад хөдөлмөрийн маргааныг түгээмэл байдлаар ганцаарчилсан болон хамтын маргаан, эрхийн болон сонирхлын маргаан гэсэн хэлбэрээр ерөнхий байдлаар хоёр ангилан авч үздэг.¹⁸ Шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн

¹⁸ Хөдөлмөрийн хууль, тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, дотоод журмыг хэрэгжүүлэх болон тайлбарлах явцад үүссэн саналын зөрүүг "Хөдөлмөрийн эрхийн маргаан" гэнэ. Хөдөлмөрийн хууль, тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, дотоод журмыг байгуулах, шинэчлэх, өөрчлөх үеийн саналын зөрүүг "Хөдөлмөрийн сонирхлын маргаан" гэнэ.

маргааныг хөдөлмөрийн эрхийн ба сонирхлын маргаан гэж ангилан, маргаан шийдвэрлэх зохицуулалтыг өөр хооронд нь ялгаатай байдлаар хуульчилсан байна.

Хэдийгээр хөдөлмөрийн эрхийн маргаан нь хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд заавал байх ёстой үзэгдэл биш боловч хөдөлмөрийн эрхлэлтийн харилцаанд оролцогч талуудын хооронд санал зөрөлдөөн үүсгэхэд нөлөөлөгч хүчин зүйлс олон байдаг. Хөдөлмөрийн эрхийн маргааныг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй тогтолцоо нь байгууллагын түвшинд маргаан шийдвэрлэх бие даасан бүтэц буюу “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс”-г байгуулан ажиллуулан, шүүхийн өмнөх шатанд маргалдагч талуудыг эвлэрүүлэх замаар тохиролцоонд хүрэх боломжийг бүрдүүлэх явдал юм. Хөдөлмөрийн маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэж чадаагүй бол хуулиар эрх олгосон, тусдаа бүтэц бүхий байгууллагын дэмжлэгтэйгээр тохиролцоонд хүрэх, маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу маргааныг эцэслэн шийдвэрлэх боломжтой.

Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргааны тоо 2024 оны байдлаар 770 байгаа бөгөөд цаашид хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааны тоог бууруулах шаардлагатай байна.

Асуудлыг шийдэх үүднээс гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог сайжруулах замаар хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний тулд төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дундаж цалинг нэмэгдүүлж, цалинтай ажиллагчдын цагийн дундаж хөлс 2024 онд 9.2 мянган төгрөг байгааг 2030 он гэхэд 1.9 дахин нэмэгдүүлж 17.4 мянган төгрөгт хүргэнэ.

Мөн Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх замаар хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч шүүхээр шийдвэрлүүлсэн маргааны тоо 2024 онд 770 байгааг 2030 он гэхэд 566 болгон бууруулна.

Жижиг, дунд үйлдвэрлэл: Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ нь дэлхийн хэмжээнд бизнес эрхлэгчдийн дийлэнх хувийг эзэлж ажлын байр бий болгох, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг. Монгол Улсад 2024 оны байдлаар 261,157 хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас 108,378 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс жижиг, дунд үйлдвэрийн салбарт 65,123 компани, 5,408 нөхөрлөл, 12,031 хоршоо буюу нийт 82,562 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээлснээр тус салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 6.2 хувийг, экспортын 1.7 хувийг эзэлж байна.¹⁹

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 2019 оноос хойш улсын төсвөөс эх үүсвэр хуваарилаагүй бөгөөд өмнө олгосон зээлийн эргэн төлөлт, орон нутгийн эх үүсвэр, төсөл, хөтөлбөрөөс 132.6 тэрбум төгрөгийг бүрдүүлсэн. Тус сангаас 2020-2024 онд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зээл олгоогүй бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрээс шалтгаалан бичил бизнес эрхлэгч 3,865 аж ахуйн нэгжээс 572.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүсэлт хүлээн авч, 960 аж ахуйн нэгжид 116.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Энэ нь нийт хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжийн 25.0 хувь, санхүүжилтийн 20.0 хувь болсон байна. (Хүснэгт 13-т харуулав)

Хүснэгт 13. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2020-2024 онд олгосон зээл

дд	Он	Нийт ирүүлсэн		Олгосон		Нийт ирсэн хүсэлтэд эзлэх хувь	
		Төсөл	Санхүүжилт (тэрбум төгрөг)	Төсөл	Санхүүжилт (тэрбум төгрөг)	Төсөл	Санхүүжилт
1	2020	1579	238.5	249	22.8	16	10
2	2021	16	1.2	12	0.8	75	67
3	2022	608	87.8	156	19.2	26	22

¹⁹ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

4	2023	820	120.8	265	35.4	32	29
5	2024	842	124.4	278	38.4	33	31
	НИЙТ	3865	572.7	960	116.6	25	20

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа тогтворжуулан, салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн дэмжлэг зайлшгүй чухал юм.

Цаашид жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна. 2024 оны байдлаар жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ногдох дундаж ажилтны тоо 3.3 хувь байгаа нь хангалтгүй тул нэмэгдүүлэх шаардлагатай.

Асуудлыг шийдэх үүднээс үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний тулд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнес эрхлэх орчин, ур чадварыг сайжруулах замаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тогтвортой байдлыг хангаж, бизнес эрхлэгчид ногдох дундаж ажилтны тоо 2024 онд 3.3 хувь байгааг 2030 он гэхэд 5.8 хувьд хүргэнэ.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам дорвитой буурахгүй, ажиллах хүчний оролцооны түвшин тогтвортой өсөхгүй байгаа бөгөөд үүнд зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого шаардлагатайг харуулж байна.

Асуудлыг шийдвэрлэх үүднээс үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Ингэснээр хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж, цалин, нийгмийн баталгаа сайжирснаар иргэдийн амьдралын чанар дээшилнэ.

Дээрх үр дүнг бий болгохын тулд нийгмийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх замаар албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулна. Хөдөө аж ахуйн бус салбарын нийт ажиллагсдад албан бус ажил эрхлэгчдийн эзлэх хувь 2023 онд 20.8 байгааг 2030 он гэхэд 13.4 хувь болгож бууруулна.

Ур чадвар болон мэргэжлийн сургалтыг дэмжих бодлогоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдагчдын байнгын ажлын байртай болох түвшнийг 2024 оны 25.1 хувиас 2030 онд 30.0 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг 2024 оны 16.0 хувиас 19.0 хувь, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог 2024 оны 53.5 хувиас 58.0 хувь хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Мөн гарааны бизнес, энтрепренершипыг дэмжих замаар залуучуудын идэвх, оролцоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Үүний үр дүнд 15–24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшнийг 2024 оны 14.7 хувиас 2030 онд 12.2 хувь болгон бууруулах, суралцаагүй, хөдөлмөр эрхлээгүй болон сургалтад хамрагдаагүй (NEET) залуучуудын эзлэх хувийг 2024 оны 10.1 хувиас 2030 онд 7.8 хувь болгон бууруулах зорилттой.

1.1.4. Нийгмийн хамгаалал

Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийгмийн халамжийн чиглэлийн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Ахмад настны тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай нийт 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Нийгмийн халамжийн сангийн 2024 онд зарцуулсан нийт зардлын 26.4 хувь буюу 620.5 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд олгох тэтгэвэр,

тэтгэмж, тусламжид зарцуулжээ. Нийгмийн халамжийн зорилтот хэсэгт 620.5 тэрбум төгрөг зарцуулснаас 531.2 тэрбум төгрөг буюу халамжийн зардлын 85.6 хувийг халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулсан байна.

Нийгмийн даатгал: Өнөөдрийн байдлаар 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 5 байгаа бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсөж, 2030 онд 7 тэтгэвэр авагч болохоор байна.²⁰

Нийгмийн даатгалын 34 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс 24 үйлчилгээг цахимжуулж, иргэдэд “Нийгмийн даатгал” гар утасны программ, portal.ndaatgal.mn болон И-монгол цахим системээр дамжуулан авах боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, 2024 онд И-монгол цахим системээр үзүүлж байгаа 17 үйлчилгээг давхардсан тоогоор 14.8 сая удаа авсан байна.

Нийгмийн даатгалын санд 2024 онд 5.6 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлж, давхардсан тоогоор 61.0 мянган ажил олгогчийн 1,136.9 мянган даатгуулагч албан журмаар, 140.2 мянган даатгуулагч сайн дураар хамрагдаж, нийгмийн даатгалын сангаас 781.2 мянган даатгуулагчид 5.1 их наяд төгрөгийн 26 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг олгосон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 26.5 хувиар өссөн байна. (Хүснэгт 14-т харуулав)

Хүснэгт 14. Нийгмийн даатгалын орлого, зарлага (мянган хүн, тэрбум төгрөг)

Он	Даатгалд хамрагдсан				Орлого	Зарлага	НДС-аас тэтгэвэр авагчдын тоо
	Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо					
		Албан журмаар	Сайн дураар	Нийт			
2020	49.3	826.1	187.1	1,013.2	1,878.2	2,451.8	441.4
2021	52.4	862.1	157.0	1,019.1	2,732.0	2,562.9	459.7
2022	55.1	913.1	156.5	1,069.6	3,512.5	3,415.7	478.7
2023	58.2	953.8	152.0	1,105.8	4,271.6	4,032.6	490.3
2024	61.0	996.8	140.2	1,136.9	5,610.0	5,107.2	531.8

Эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Тэтгэвэр: Монгол Улсын Засгийн газар хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2020, 2022, 2023, 2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, дундаж тэтгэврийн хэмжээ 2020 онд 416.1 мянган төгрөг байсныг 2024 онд 787.0 мянган төгрөгт хүргэж 1.9 дахин нэмэгдүүлсэн.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэхээр туссаны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг 6.0 хувиар нэмэгдүүлж дундаж тэтгэврийн хэмжээ 848.0 мянган төгрөгт хүрээд байна. (Хүснэгт 15-д харуулав)

Хүснэгт 15. Тэтгэврийн нэмэгдлийн хэмжээ

Он	Сарын нэмэгдлийн хэмжээ	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ (мян.төг)	Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ (мян.төг)	Дундаж тэтгэврийн хэмжээ (мян.төг)	Тэтгэврийн нэмэгдэлд тухайн жилд зарцуулсан хөрөнгө (тэрбум.төг)
2020	25,000₮-40,000₮	350.0	300.0	416.1	150.6
2022	15-43%	500.0	400.0	549.5	637.4
2023	10-22%	550.0	440.0	687.0	396.4
2024	100,000₮	650.0	540.0	787.0	449.3
2025	6%	689.0	572.4	848.0	297.0

Эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

²⁰ Эх үүсвэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа 2024 оны байдлаар 33.8 хувь байгаа нь өндөр настны нийгмийн баталгаа хангалтгүй байгааг илтгэж байгаа бөгөөд энэ харьцаа буурах эрсдэлтэй байна. 2030 онд өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг ажиллагчдын дундаж цалингийн 35 хувиас бууруулахгүй.

Тэтгэврийн нөөц сан: Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас болон бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг байгуулсан. Энэхүү сангийн хүрээнд 2024 оноос эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнээс ажил олгогчийн 1.0 хувь, даатгуулагчийн 1.0 хувь, нийт 2.0 хувийг, мөн сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн 2.0 хувийг мөнгөн хэлбэрээр тэтгэврийн нөөц санд байршуулсан ба 2024 оны байдлаар 1.3 сая даатгуулагчид 214.8 тэрбум төгрөгийн хуримтлал үүсээд байна.

Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)", Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдүүлэх, хуримтлалын нэгдсэн сан байгуулж иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэлийг хийсэн.

Эдгээр бодлогын баримт бичгүүдэд туссан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Нийгмийн даатгалын багц хууль 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийгмийн даатгалын харилцааг зөвхөн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулах, хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн төрлийг нарийвчлан тодорхойлох, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, нийгмийн даатгалын сангийн менежментийг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангаж байна.

Асуудлыг шийдэх үүднээс нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн хуримтлалын нэрийн дансны үлдэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2024 оны байдлаар нэг иргэний хуримтлалын нэрийн дансны дундаж үлдэгдлийн хэмжээ 138.9 мянган төгрөг байгаа нь иргэдийн санхүүгийн баталгаа хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн жилийн дундаж өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх замаар нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэхээр зорьж байна. Ингэснээр даатгуулагчийн тоо нэмэгдэж, нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдал болон иргэдийн нийгмийн хамгааллын баталгаа сайжирна. Үүний тулд:

Цахим үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх замаар нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулан иргэдийн сэтгэл ханамжийн хувийг 2030 он гэхэд 30.0 хувиар нэмэгдүүлж нийт даатгуулагчийн эзлэх хувь 79 хувь байгааг 2030 онд 86.2 хувьд хүргэнэ.

Тэтгэврийн тогтолцоог гурван тулгуурт загвар болгон шинэчлэх замаар нэг иргэний хуримтлалын нэрийн дансны дундаж үлдэгдлийн хэмжээ 2024 онд 138.9 мянган төгрөг байгааг 2030 он гэхэд 8.4 дахин нэмэгдүүлж 1,162.5 мянган төгрөгт хүргэнэ.

Мөн олон эх үүсвэрийг бий болгох замаар тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө оруулалтад оруулсан хөрөнгийн хувийг 2030 он гэхэд 40.0 хувьд хүргэж, тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн жилийн дундаж өгөөжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

Нийгмийн хамгааллын тогтолцоонд тулгарч буй гол асуудал нь халамжийн зардал өндөр, даатгуулагч ба тэтгэвэр авагчдын харьцаа муудаж, хуримтлалын хэмжээ хангалтгүй байгаа явдал юм. Энэ нь хүн амын насжилт, албан бус хөдөлмөр эрхлэлт, шимтгэл төлөлтийн бааз хязгаарлагдмал байдал зэрэг шалтгаантай.

Эдгээр сорилтыг шийдвэрлэхийн тулд тэтгэврийн тогтолцоог гурван тулгуурт загварт бүрэн шилжүүлж, тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн өгөөж болон олон эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Үр дүнд нь нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдал дээшилж, иргэдийн санхүүгийн баталгаа бэхжиж, хуримтлал төвтэй системд шилжих нөхцөл бүрдэнэ. 2030 онд өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг ажиллагчдын дундаж цалингийн 35 хувиас бууруулахгүй байснаар нийгмийн баталгааг хангах нөхцөл сайжирна.

3.2. НИЙГМИЙН ХӨГЖИЛ БА ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

3.2.1 Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Нийгмийн соён гэгээрэлд гэр бүл болон сургуулийн орчин, ёс заншил, өдөр тутмын амьдралын хэв маяг зэрэг нь нөлөөлдөг ба иргэдийн нас хүйс, орлогын түвшин, боловсрол, амьдарч буй орчин зэргээс үл хамааран иргэдийг бага наснаас нь эхлэн гэр бүл, сургуулийн орчинд өв уламжлал, түүх, соёл, ёс заншлын тухай мэдлэгийг өвлүүлэн үлдээх чухал нөлөөтэй байдаг.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл нь аливаа улс үндэстний дотоод мөн чанар, ижилсэл, ондоошилтой уялдаатай байдаг. Ард түмний оюун санаа, хүсэл эрмэлзэл, дотоод мөн чанарын нэгдлийг олох нь аливаа улс орны хувьд амин чухал асуудал байдаг бөгөөд энэ нь улс орны оршин тогтнох, хөгжин дэвшихүйн үндэс болдог.²¹

Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг үндэсний соёл-нэгдмэл зүйл, улс төрийн нэгдмэл байдал, нийгмийн нэгдмэл байдал, эдийн засгийн бодлогын нэгдмэл байдал гэсэн 4 үндсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогддог байна²². Монгол Улсын үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн индексийг 2021 онд тооцсон ба 49.0 хувьтай үнэлэгдсэн байна. Үүнийг үзүүлэлт бүрээр задалж үзвэл:

- ✓ Үндэсний соёл-нэгдмэл байдлын түвшин-64.0 хувь;
- ✓ Нийгмийн нэгдмэл байдлын түвшин-53.0 хувь;
- ✓ Эдийн засгийн бодлогын нэгдмэл байдлын түвшин-40.0 хувь;
- ✓ Улс төрийн нэгдмэл байдлын түвшин-38.0 хувь байна.

Үндэсний соёл-нэгдмэл байдлын түвшинд нийгмийн соён гэгээрлийн түвшин шууд нөлөөлж байгаа ба энэ нь тус индексийг тооцох хүрээнд хийгдсэн судалгаагаар батлагджээ. Нийгмийн соён гэгээрлийн түвшин нь 56.0 хувьтай буюу дундаж түвшинтэй тооцогджээ.

Соён гэгээрлийн үр дүнд урлаг, шинжлэх ухаан, шашин хөгжиж улс орны соёлыг бүтээдэг. Соён гэгээрэлд хамгийн чухал үндэс нь хүний сэтгэл судлалын шинжлэх ухаан юм. Хүний сэтгэл зүйн гажуудлыг түүхэн туршлагаас нь судалж, тодорхойлсон нийгэм болон сэтгэл судлалын шинжлэх ухааны үр дүнгээс хамаарч гүн ухаан болон шашин судлалын шинжлэх ухааны үнэт мэдлэгүүдийг нарийвчлан судалж, хөрвүүлэн шинэчилж, сайжруулалт хийж нийгмийн шинжлэх ухааны үр дүнг хөгжилд ашиглах нь дэлхий дахины нийгэмд тулгамдсан гажуудал, асуудлуудыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх юм.

²¹ Алсын хараа-2050, Үндэсний нэгдмэл үнэт зүйл

²² Үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийн арга зүйг тодорхойлж, олон нийтийн санаа бодлын судалгаа-2021

Ёс суртахуун гэдэг нийгмийн харилцааг тохируулдаг, зохицуулдаг нийгмийн институт. Ёс суртахуун хүний өөрийн мөн чанарыг тодорхойлдог хамгийн чухал нь оюун санааны үзэгдэл. Хүнд төрөлхийн байдаг зан чанарууд буюу сөрөг чанар буюу атаархал, уур хилэн, шунал өөрийгөө зөвтгөх гэх мэт тэдгээрийг засаж залруулдаг арга хэрэгсэл нь ёс суртахуун, түүний зарчим хэм хэмжээ юм.²³

Монгол Улсад 1990-ээд оноос эхэлсэн ардчилсан төрийн тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц өрнөсөнтэй холбоотойгоор "ардчилал, хүний эрх, эрх чөлөө" гэдэг нэр томъёоллыг ашиглаж, монгол уламжлал, соёл, ёс зүйг ихээхэн гажуудалд оруулж, ард иргэдийн ёс зүйн төлөвшил алдагдсаны нөлөөгөөр эрх мэдэл, албан тушаалын төлөө ичгүүргүй тэмцэх, эд хөрөнгөтэй болох гэж эх орон, ард түмний эрх ашгаас урвах, хүмүүнлэг ёс зүй, нинжин сэтгэлгүй, үг үйлдэл зөрөх, хуурч мэхлэх, бусдыг гутаан доромжлох хандлага бий болсон. Сүүлийн үед хүний санаанд оромгүй аймшигт гэмт хэргүүд олноор гарах болсон нь хүний ёс суртахуун, ёс зүй уналтад орсныг харуулж байна.

Соёл гэдэг ухагдахуун нь хүн төрөлхтний соён гэгээрлийн хөгжлийн үр дүнд бүтээгдсээр ирсэн үнэт зүйл юм. Соён гэгээрлийн үр дүнд нийгмийн биет ба биет бус соёл бүтээгддэг.

Дэлхий дээр 20 орчим соёл иргэншил байдаг. Тэдгээр нь институт, өв уламжлалаа даган хуваагддаг²⁴. Монголчуудын хувьд нүүдлийн соёл иргэншлийн сонгодог мөн чанарыг орчин цагт уламжлан тээж ирсэн гэдгээрээ онцлогтой.

Нүүдлийн соёл иргэншил нь олон хүчин зүйлсээр тодорхойлогддог. Тэдгээрээс малчин ард түмний бэлчээр даган нүүдэллэх амьдралын хэмнэл нь цөм нь болдог. Уламжлалт нүүдэл нь хангай, говь, тал хээрийн ялгаа, ургамлын гарц, газар нутаг, бэлчээрийн даац, малын тоо, ус унд, хужир давс зэргээс уялдан бүрддэг.

"Үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийн арга зүйг тодорхойлж, олон нийтийн санаа бодлын судалгаа"-аар нүүдлийн ахуй, соёлыг хойч үедээ өвлүүлж, таниулах нь насны бүлэг буурах тусам багасаж байна. Мөн тус судалгаагаар орлогын түвшин нэмэгдэх, гадаадад амьдарч байсан иргэдийн хувьд уламжлалт нүүдлийн ахуй, соёлыг өвлүүлж, хадгалж буй байдал доогуур байна гэж дүгнэгджээ. Нүүдлийн соёл иргэншлийн индекс 70.0 хувьтай байгаа ба индексийг ахиулахын тулд залуу хойч үедээ нүүдлийн ахуй, соёлын уламжлалыг таниулан түгээх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.²⁵

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд "Ард түмний билэг авьяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараах оюуны соёлын үнэт зүйлийг соёлын биет бус өвд хамааруулна." гэж заасан байдаг. Монгол Улсын Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд 2024 оны байдлаар соёлын биет бус өвийн 362 төрөл зүйл, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 10,924 хүн, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын үндэсний жагсаалтад бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч, 9,341 дурсгалт газрын 82,514 түүх, соёлын үл хөдлөх дурсгал, улс, аймгийн музейд нийт 141,289 дэсийн 333,047 ширхэг дурсгал бүртгэлтэй байна.²⁶

"Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл"-д соёлын биет бус өвийн 7 ай савын 279 өв, "Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл"-д 7 ай савын 83 өв, нийт 362 өв бүртгэлтэй байна. ЮНЕСКО-ийн

²³ МУИС-ийн философи шашин судлалын тэнхимийн доктор (Ph.D), профессор Р.Дарьхүү, ярилцлага

²⁴ Алсын хараа-2050, Үндэсний нэгдмэл үнэт зүйл-36 дугаар тал

²⁵ Үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийн арга зүйг тодорхойлж, олон нийтийн санаа бодлын судалгаа-2021

²⁶ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад 2024 онд “Монголын нүүдлийн зан үйл”, “Наурыз” баяр өвийг бүртгүүлж, Монголын түүх, соёлын 645 мэдээлэл, музейн виртуал үзүүлэн “Google Arts&Culture”-д орсноор дэлхий нийтэд түгээж эхэлсэн байна.

Үндэсний соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, хөгжүүлэлт сул, үндэсний агуулгатай уран бүтээлийн тоо харьцангуй цөөн байна.²⁷ Тухайлбал, үл хөдлөх өвийн 45.0 хувь нь гэмтэлтэй, хөдлөх өвийн 600 гаруй ширхэг дурсгалыг сэргээн засварлах шаардлагатай байна.

Бүртгэн баримтжуулалт, судалгаа шинжилгээнд хамрагдсан өв 2024 онд 15 байгаа нь соёлын өвийн хамгаалалт, зохистой ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Үндэстэн оршин тогтнох, тусгаар байх хамгийн чухал суурь нь хэл юм. Аливаа түүх соёл, өв уламжлал, ёс заншил хэлээр дамжин түгдэг. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 1.3-т “Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл хэсэг болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.” гэж заасан байдаг.

Монгол Улсын насанд хүрсэн нийт хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан байгаа бол Монгол хэл, бичгийн унших, бичих боловсролын чадамж харьцангуй доогуур буюу Монгол хэл, бичгийн индекс 56.0 хувьтай байна. Монгол бичгийн чадамж гадаадад амьдарч буй иргэд, эрэгтэйчүүд болон иргэдийн нас ахих тусам буурч²⁸ байгаа нь үндэсний хэл, бичгийн боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Хүнээ хөгжүүлсэн улс хөгждөг тул “Хүн төвтэй” хөгжлийн үзэл санааны хүрээнд шинэчлэл уламжлалыг хослуулж, соёлын өвийг түгээн дэлгэрүүлсэн, даяаршлын тавцанд оюун санааны ондоошлоороо түүчээлсэн, хүмүүжил, ёс суртахуунтай XXI зууны шинэ үеийн иргэдийг бэлтгэхэд олон нийтийг соён гэгээрүүлэх зорилтот ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн соён гэгээрлийг нэмэгдүүлэхийн тулд иргэдийн соёлын оролцоо, соёлын боловсролын түвшнийг нэмэгдүүлж, үндэсний агуулгатай уран бүтээлийн тоог нэмэгдүүлэх замаар үнэт зүйлсийг төлөвшүүлэхээр зорьж байна.

Энэ хүрээнд иргэдийн соёл, ёс заншил, бахархал эв нэгдлийг бэхжүүлэн өв уламжлалаа хадгалж хойч үедээ өвлүүлэх, хадгалах замаар үндэсний нэгдмэл үнэт зүйлийн индексийг 2030 онд 55 хувьд хүргэх, “Эх хэл, эх түүх, өв соёл”-ын бүтээлч хэрэглээг дэмжих замаар үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийг 70.0 хувьд хүргэж үндэсний соёлын дархлааг бэхжүүлнэ. Үүний тулд ёс суртахуун, хариуцлагын соёлыг төлөвшүүлж, нийгмийн соён гэгээрлийн түвшин 2021 онд 56.0 хувь байгааг 2030 онд 63.0 хувьд хүргэж, Монгол үндэстний соёлын мөн чанарыг таниулан түгээн дэлгэрүүлэх замаар нүүдлийн соёл иргэншлийн үнэ цэнийг нэмэгдүүлж, нүүдлийн соёл иргэншлийн индексийг 74.0 хувьд хүргэнэ.

Орон нутгийн болон олон талт оролцоог нэмэгдүүлэх замаар бүртгэн баримтжуулалт, судалгаа шинжилгээнд хамрагдсан өвийн тоог 85-аар нэмэгдүүлж 100-д хүргэж, соёлын өвийн бүртгэн баримтжуулалт, судалгаа шинжилгээнд инновац, өндөр технологи нэвтрүүлэх замаар соёлын биет бус өв өвлөн уламжлагч 2024 онд 10,924 байгааг 2030 онд 11,244 хүргэж нэмэгдүүлэхээр тус тус төлөвлөсөн.

²⁷ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

²⁸ Үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийн арга зүйг тодорхойлж, олон нийтийн санаа бодлын судалгаа-2021

3.2.3. Нийгмийн сайн сайхан байдал

Нийгмийн хөгжил дэвшил нь иргэд, айл өрх сайн сайхан байдлыг дээшлүүлэх явдал юм. Ийм ахиц дэвшлийг үнэлэхийн тулд эдийн засгийн нөхцөл байдал болон хүмүүсийн янз бүрийн туршлага, амьдралын нөхцөл байдлыг хамааруулдаг. Нийгмийн хөгжлийг хэмжих үүднээс Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага сайн сайхан байдал, хөгжил дэвшлийг хэмжих хүрээг боловсруулсан бөгөөд энэхүү хүрээ нь одоогийн сайн сайхан байдал, сайн сайхан байдлын үр дүнгийн тэгш бус байдал, ирээдүйн сайн сайхан байдлын нөөц гэсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг ба сайн сайхан байдалд орлого, ажил, эрүүл мэнд, мэдлэг ур чадвар, байгаль орчин, аюулгүй байдал, нийгмийн харилцаа, иргэний оролцоог хамааруулдаг байна.²⁹ Эдгээрийг нийгмийн сайн сайхан байдал гэж тодорхойлж, Сайн сайхан байдлын индекс болон Ядуурлын хамралтын хүрээгээр хэмжих боломжтой юм.

Сайн сайхан байдлыг олон улсад Wellbeing index ашиглан тооцдог бөгөөд манай улсын хувьд аргачлал ашиглан тооцох шаардлагатай байна.

Ядуурал нь ажилгүйдэл, нийгмийн гадуурхал, гамшиг осол өвчлөл зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй ба хүн амын дунд тэгш бус байдал ихсэх нь хүний үнэ цэнэ, сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх, урт хугацаандаа улс орны нийгмийн болон эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг байна.³⁰

Ядуурлын хамрагдалтын хүрээг авч үзвэл 2022 онд 27.1 хувь болж 2014 оноос 5.5 нэгж хувиар өссөн бол 2020 оноос 0.7 нэгж хувиар буурсан ч ядуурал өндөр хэвээр байна. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктэй хамтран ядуурлын шугамыг 418 мянга 90 төгрөг болгож шинэчлэн тооцсон. Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 914.2 мянган хүн байгаа бөгөөд ядууралд өртөхөд ойрхон 346.4 мянган хүн ам байгаа нь ядуурал 10.3 хувиар нэмэгдэх эрсдэлтэй байгааг харуулж байна.

Нийт ядуу хүн амын 57.0 хувь нь хот суурин газарт, 43.0 хувь нь хөдөө, орон нутагт байна. Үүнээс 37.0 хувь нь Улаанбаатар хотод, сумын төвд 20.0 хувь, аймгийн төвд 19.0 хувь, хөдөө 23.0 хувь нь амьдарч байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын 5 хүн тутмын хоёр нь ядуурлын шугамаас бага хэрэглээтэй байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын дагуу Монгол Улс 2030 он гэхэд ядуурлыг 2 дахин бууруулах зорилготой. Гэвч ядуурлыг бууруулах зорилгын хэрэгжилт ухралттай үнэлэгдсэн бөгөөд ийнхүү үнэлэгдэхэд ядуурлын олон улсын болон үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь 2018 онтой харьцуулахад өссөн нь голлон нөлөөлсөн болохыг Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд дурдсан.

Монгол Улсын олон хэмжээст ядуурлын хамралт харьцангуй бага байгаа нь туйлын ядуурал бараг тэг, хүний капиталын хөгжил өндөр байгааг харуулж байна. Гэхдээ таван хүн тутмын нэг нь олон хэмжээсний дор хаяж нэг үзүүлэлтээр нь гачигдалтай байна. Олон хэмжээст ядууралд газарзүйн ялгаа их байна. Улаанбаатар хотын хүн амын 95.0 хувь нь ямар нэгэн гачигдалгүй байхад, хөдөөд дөрвөн хүн тутмын гурав нь дор хаяж нэг үзүүлэлтээр гачигдалтай байна. Хөдөөд хэд хэдэн үзүүлэлтээр зэрэг гачигдалтай байх нь түгээмэл бөгөөд хөдөөгийн хүн амын 42.0 хувь нь 2-оос дээш үзүүлэлтээр гачигдалтай байна³¹.

Ядуурлын шугамаас доогуур амьдарч буй иргэд амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах, зайлшгүй шаардлагатай хүнс болон хүнсний бус хэрэглээний зүйлсээ худалдан авах чадваргүй байгаагаас үүдэн урт хугацаандаа улс орны

²⁹ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD).

³⁰ ҮСХ-Ядуурлын дүр төрх судалгаа 2020.

³¹ ҮСХ, 2022. “Ядуурлын дүр төрх 2020: Ядуурлыг бууруулахад ахиц дэвшил гаргасан, зогсонги байдалд орсон 10 жил”.

нийгмийн болон эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөх талтай байдаг.³² Өөрөөр хэлбэл эдийн засгийн суурь нөхцөл бүрэлдэж байж хүн гэр бүл зохиох, үр хүүхэдтэй болох боломжтой бөгөөд амьжиргааны баталгаатай орчин нь хүн амын зохистой өсөлтөд шууд нөлөөлдөг.

3.2.4. Хүн амын өсөлт

Монгол Улсын хүн ам 2024 оны байдлаар 3,544,835 болж сүүлийн 10 жилийн хугацаанд 600.0 орчим мянгаар нэмэгдсэн байна. Хүн амын өсөлтийн хувь 2.0 байхад хүн ам өсөж байгаа хэмээн тооцдог бөгөөд Монгол Улсын хүн амын өсөлт 2024 оны байдлаар 1.14 хувь болж буурсан нь сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн бага хэмжээнд хүрсэн үзүүлэлт болж байна.³³

График 16. Хүн амын тоо, өсөлтийн хувь, сүүлийн 10 жилд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүн амын өсөлт саарахад 2019 онд 79,580 байсан төрөлт 2024 онд 59,644 болж 19,936-аар буюу 25.0 хувиар буурсан байна.

Хүн амын өсөлт нь улс орны хөгжил, ирээдүйн тогтвортой байдалд чухал нөлөөтэй бөгөөд үүнд эх, хүүхдийн эрүүл мэнд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг. Эхийн эрүүл мэндийг хамгаалах нь эхийн нас баралтыг бууруулах, хүүхдийн эндэгдлийг багасгах, улмаар хүн амын өсөлтийг тогтвортой байлгах үндэс болдог.

Эхийн эрүүл мэнд: Эхийн эрүүл мэнд нь жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн эрсдэлээс хамгаалагдаж, эрүүл хүүхэд төрөх үндэс суурийг бүрдүүлдэг.

Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 57,050 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд 93.1 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа, 6.3 хувь нь 4-6 сартайдаа, 0.7 хувь нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ. Жирэмсний эрт үеийн хяналт Улаанбаатарт 92.6 хувь, орон нутагт 93.6 хувь байна. Өмнөх онтой харьцуулахад Улаанбаатарт 1.0 хувиар буурч, орон нутагт 0.6 хувиар өссөн байна. Шинээр хяналтад хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.7 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдсанаас 4.0 хувь нь цус багадалттай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2024 онд 57,319 эх амаржсан нь өмнөх онтой харьцуулахад 6,596 тохиолдлоор буюу 10.3 хувиар буурсан байна. Төрөлт Улаанбаатар болон бусад аймгуудад 24-269 тохиолдлоор жигд буурсан байна.

Нийт төрөлтийн 99.9 хувийг эмнэлгийн мэргэжилтэн удирдан явуулсан ба төрсөн насны хувьд 3.4 хувь нь 20 хүртэлх насны, 24.3 хувь нь 35-аас дээш насны төрөлт эзэлж байна. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход 2024 онд нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 71.2 нь хүүхэд төрүүлсэн байна.

³² ҮСХ-Ядуурлын дүр төрх 2020

³³ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Гэрийн төрөлтийн 154 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 41 тохиолдлоор буюу 21.0 хувиар буурсан байна. Гэрийн төрөлтийн 57.8 хувь нь Улаанбаатарт бүртгэгдсэн ба өмнөх оноос 4.2 хувиар буурсан байна. Эмнэлгийн тусламжгүй төрөлт 39 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор буюу 15.2 хувиар буурсан байна. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд орон нутгийн харьяат 5,939 эх амаржсан нь өмнөх оноос 30 тохиолдлоор буурсан ба Улаанбаатарт бүртгэгдсэн төрөлтийн 19.1 хувийг эзэлж байна

Эхийн эндэгдэл 2024 онд 13 тохиолдол бүртгэгдэж, 100,000 амьд төрөлтөд 22.5 байна. Өмнөх оноос 4 тохиолдлоор, 100,000 амьд төрөлт тутамд 3.9-оор буурсан байна. Эхийн эндэгдлийн 84.6 хувь нь эмнэлэгт, 15.4 хувь нь гэртээ эндсэн байна. 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшнийг 2015 онтой харьцуулахад 2024 онд 3.6-оор буурсан байна.

Хүүхдийн эрүүл мэнд: Хүүхдийн эрүүл мэнд нь зөвхөн тухайн гэр бүлийн сайн сайхан байдалд бус, ирээдүйн хөдөлмөрийн чадвартай, боловсролтой иргэдийг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй. Хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөж торних үндэс болдог.

Улсын хэмжээнд 57,756 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 6,550 хүүхдээр буюу 10.2 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.6 хувь нь 2,500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдийн 1,402 нь хоёр ихэр, 18 нь гурван ихэр хүүхэд байна. Амьгүй төрөлтийн 290 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 нийт төрөлтөд 5.0 байгаа ба өмнөх онтой харьцуулахад 54 тохиолдлоор буюу 15.7 хувиар буурсан байна.

Нярай хүүхдийн өвчлөлийн 27,157 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь амьд төрсөн хүүхдийн 47.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оноос өвчлөл 12.2 хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд 2024 онд нялхсын эндэгдэл 702 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.2 болж байгаа нь өмнөх оноос 0.1-оор буурсан байна. Нялхсын эндэгдлийн 61.4 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 7.5 байна.

Харин тав хүртэлх насандаа 877 хүүхэд эндсэн бөгөөд амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох түвшин 15.2 байна. Өмнөх онтой харьцуулахад 84 тохиолдлоор буурч, амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох эндэгдэл 0.3 тохиолдлоор ихэссэн үзүүлэлттэй байна.

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөж торних үндэс болдог.

Улсын хэмжээнд 57,756 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 6,550 хүүхдээр буюу 10.2 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.6 хувь нь 2,500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдийн 1,402 нь хоёр ихэр, 18 нь гурван ихэр хүүхэд байна. Амьгүй төрөлтийн 290 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 нийт төрөлтөд 5.0 байгаа ба өмнөх онтой харьцуулахад 54 тохиолдлоор буюу 15.7 хувиар буурсан байна.

Нярай хүүхдийн өвчлөлийн 27,157 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь амьд төрсөн хүүхдийн 47.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оноос өвчлөл 12.2 хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд 2024 онд нялхсын эндэгдэл 702 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.2 болж байгаа нь өмнөх оноос 0.1-оор буурсан байна. Нялхсын эндэгдлийн 61.4 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 7.5 байна.

Харин тав хүртэлх насандаа 877 хүүхэд эндсэн бөгөөд амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох түвшин 15.2 байна. Өмнөх онтой харьцуулахад 84 тохиолдлоор буурч, амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох эндэгдэл 0.3 тохиолдлоор ихэссэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсад эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжирч байгаа ч төрөлт буурах хандлага, эхийн эндэгдэл, нялхсын эндэгдэл тогтвортой өндөр түвшинд байна. Жирэмсний эрт үеийн хяналт сайн боловч цус багадалттай эхчүүдийн хувь нэмэгдэж, эрүүл мэндийн эрсдэл даамжирч байна. Хүүхдийн амьд төрөлт буурч, бага жинтэй төрөх тохиолдол, нярай өвчлөл өндөр байгаа нь эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Иймд тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах мөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, жирэмсний хяналтад хамрагдалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гэр бүл: Манай улсад 2024 оны байдлаар нийт 997,023 өрх байгаагаас өрх толгойлсон эх 54,863, өрх толгойлсон эцэг 11,950 байгаа нь нийт өрхийн 6.7 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд 2024 онд 4,463 гэр бүл цуцалсан нь өмнөх оноос буурсан боловч 10 ба түүнээс дээш жил амьдарсан хосуудын гэр бүл цуцлалт 63.7 хувийг эзэлж байна. Гэр бүл цуцлалтыг авч үзвэл 1000 хүн тутамд ногдох гэр бүл цуцалт 2020 онд 1.6 промилль байсан бол 2024 онд 2.1 промилль буюу сүүлийн 5 жилийн хугацаанд 31.2 хувиар нэмэгдсэн нь гэр бүлийн тогтворгүй байдал нэмэгдэж байгааг харуулж байна. (Хүснэгт 16-д харуулав.)

Хүснэгт 16. Гэр бүл цуцлалт /1000 хүн тутамд ногдох/

Он	2020	2021	2022	2023	2024
Гэр бүл цуцлалт	1.6	1.6	2.2	2.2	2.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдийн 76 хувь нь таарамжгүй харилцаа, 12 хувь нь архидалт, 8 хувь нь тусдаа амьдарч байгаа, 2 хувь нь гэр бүлээс гадуурх харилцаа, 2 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс тус тус шалтгаалсан байна.³⁴ 2019-2023 оны дунджаас харахад гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн тэтгэлгийн 60 гаруй хувь огт төлөгдөхгүй байгаа нь эцэг, эхийн ухамсар, үүргээ хэрэгжүүлэхгүй хариуцлагагүй байдал, ажилгүйдэл, ядуурал, төлбөрийн чадваргүй байдалтай холбоотой байна.

Гэр бүлийн харилцааны өнөөгийн хэв маяг, хөгжил, өөрчлөлт, цаашдын чиг хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилготойгоор 2010, 2019 онд “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгааг тус тус хийсэн байдаг. Судалгаанаас үзэхэд ойрын 5-10 жилд манай оронд өрх гэр бүлийн харилцааны асуудал улам нарийсан төвөгтэй болж, шийдвэрлэх асуудлууд гарч ирэх хандлага ажиглагдаж буйг дурджээ. Мөн архидалт, ядуурал, үнийн хөөргөдөл, мөнгөний ханшны уналт, шилжих хөдөлгөөн, гадаадад гарч ажиллах, даяаршил зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс гэр бүлийн зөрчилд нөлөөлдөг гэж үзсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018 онд хийсэн “Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” 20 судалгаагаар гэр бүлийн тулгамдсан асуудлыг тодорхойлсон байдаг. Уг судалгаагаар гурван гэр бүл тутмын нэг нь санхүүгийн асуудалтай, таван гэр бүл тутмын нэг нь орон байрны асуудалтай гарсан байна. Гэр бүлийн уламжлалт угийн бичгийг гэр бүлийн 11.5 хувь нь хөтөлдөг байна.

³⁴ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 134-р тал

Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгааныг судлахад 55.3 хувь нь санхүү, өр зээлийн асуудлаас, 15.7 хувь нь согтууруулах ундааны хэрэглээнээс, 15.3 хувь хүүхэдтэй холбоотой асуудлаас, 11 хувь нь үзэл бодлын зөрчлөөс болж байна гэж үзжээ. Гэр бүлийн асуудал, хүчирхийлэл, салалт зэрэг нэмэгдэхийн хэрээр хүүхэд, эмэгтэйчүүд хохирч сөрөг үр дагаврууд нэмэгдэж байна.

Төрөөс гэр бүлд ямар дэмжлэг хүсэж байгааг тодруулахад 57.57 хувь хөдөлмөр эрхлэх боломжийг өсгөж өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, 55.4 хувь өрхийн орлогоо нэмэгдүүлэхийг, 18.6 хувь гэр бүлийн боловсрол олгохыг, 17.7 хувь гэр бүлийн харилцаа, сэтгэл заслын зөвлөгөө хүссэн байна. Залуу гэр бүлийн 50.8 хувь нь ажлын байраар хангах дэмжлэг, 22.5 хувь орон сууц, 16.3 хувь орлого нэмэгдүүлэхийг хүсэж байсан бол дунд нас (35-49)-ны гэр бүлд санхүү, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн асуудлыг чухалчилсан байна.

Гэр бүлийн ээлтэй, тогтвортой байдал нь гэр бүлийн боловсрол буюу зөв дадал, зан үйл хэвшээгүйгээс үүдэлтэй. Мөн ажил амьдралын тэнцвэр алдсанаас үүдэлтэй байдаг. Долоо хоногт 48 цагаас дээш цагаар ажиллагчид 2024 оны байдлаар 32.3 хувийг эзэлж байна.

Монгол Улсад гэр бүлийн тогтворгүй байдал нэмэгдэж, энэ нь хүн амын өсөлт, хүний хөгжлийн чанарт сөргөөр нөлөөлж байна. 2024 онд гэр бүл цуцлалт сүүлийн 5 жилд 31.2 хувиар өсөж, 1000 хүн тутамд 2.1 промилд хүрсэн бөгөөд салалтын 63.7 хувь нь 10 ба түүнээс дээш жил хамт амьдарсан хосуудад тохиож байна. Нийт өрхийн 6.7 хувь нь өрх толгойлсон байна.

Гэр бүлийн зөрчил, салалтын гол шалтгаан нь санхүүгийн бэрхшээл архидалт, орон байр, хүүхэдтэй холбоотой асуудлууд байна. Долоо хоногт 48 цагаас дээш ажиллагчид 32.3 хувьтай байгаа нь ажил амьдралын тэнцвэр алдагдахад нөлөөлж байна.

Дээрх байдлаас харахад гэр бүлд тэдний амьжиргааг дэмжих дэмжлэг үзүүлэх, орчныг сайжруулах, нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн боловсрол олгох, нийгмийн үйлчилгээ үзүүлэх зэргээр төрөл бүрийн дэмжлэг хэрэгтэй нь харагдаж байна. Санхүү, орон сууц, сэтгэлзүй, хүчирхийллээс хамгаалах үйлчилгээ, гэр бүлийн боловсролыг сайжруулах нь нэн тэргүүний зорилт болж байна.

Нийгмийн халамж: Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.³⁵

Нийгмийн халамжийн сангаас 2024 онд нийт 2.3 их наяд төгрөг зарцуулснаас 1.5 их наяд төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан байна. Зарцуулсан нийт зардлын 26.4 хувь буюу 600.9 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжид зарцуулжээ.

Харин 1,704.1 тэрбум төгрөг буюу нийт зардлын 73.6 хувийг цалинтай ээж, одонтой эх, хүүхдийн мөнгө, насны хишиг, жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг олгож байгаа хөтөлбөрт зарцуулсан.

Нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл нь улс төрийн шийдвэрээр 2005 оноос эхлэн олгосон зорилтот бүлэгт бус нийт хүн амд чиглэсэн нийтлэг мөнгөн тэтгэмж, тусламжийн хөтөлбөрүүдийн зардал юм.

³⁵ Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.1 дэх хэсэг

Алдар цолтон ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хамгийн зорилтот бүлэгт чиглэгдээгүй хөтөлбөр бөгөөд нийт зардлын 65 хувь нь хүн амын амьжиргааны түвшин хамгийн өндөртэй 20 хувьд хуваарилагдаж байна.

Иймээс халамжийн үйлчилгээг оновчлох, хүн амын өсөлт, гэр бүлийг дэмжсэн дэмжлэгийг халамжийн зорилтот бүлэгт чиглэсэн зардлаас зааглах хэрэгцээ шаардлага байна. Халамжийг хөдөлмөр эрхлэх боломжгүй амьжиргаа багатай зорилтот бүлэгт чиглүүлэх, үүнээс ялгаатай нь хүүхдийн хөгжлийг дэмжих, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх, хөгжлийн цогц үйлчилгээг үзүүлэх замаар гэр бүлийн тогтвортой байдал, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогын ялгааг онцлох юм.

Тогтвортой хөгжлийн зорилт 1.3-т Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулахаар зорьж байгаа бөгөөд 1.3.1 дэх хэсэг буюу нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан хүн амын эзлэх хувь (ядуу хүн ам) 2016 онд 56.0 байсан бол 2024 онд 78.6 хувь буюу 1.4 дахин нэмэгдсэн байна. (Хүснэгт 17-д харуулав.)

Хүснэгт 17. Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан хүн амын эзлэх хувь (ядуу хүн ам)

Он	2016	2018	2020	2022	2024
Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан хүн ам	56.0	59.2	61.7	74.0	78.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн халамжийн нийт зардалд зорилтот бүлэгт чиглэсэн зардал 26.4 хувийг эзэлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулж, оновчлох мөн ахмад настанд чиглэсэн цогц тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж асаргааны хувилбарт үйлчилгээ болон эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг бий болгох шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн анхны хууль батлагдсанаас хойш 2000, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 1998, 2005, 2012 онд шинэчлэн найруулж байсан.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийгмийн халамжийн чиглэлийн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай (2010 он), Нийгмийн халамжийн тухай (2012 он), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (2016 он), Ахмад настны тухай (2017 он), Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай (2017 он), Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай (2017 он) 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн зорилтот бүлэгт чиглэсэн байдлыг 2018 оны тоон мэдээлэлд үндэслэн судалсан бөгөөд судалгаагаар хүнсний эрхийн бичгийн хөтөлбөр зорилтот бүлэгт хамгийн их чиглэсэн хөтөлбөр бөгөөд нийт зардлын 99 хувь нь хүн амын амьжиргааны түвшин хамгийн бага 20 хувьд хуваарилагдаж байна. Харин эсрэгээр Алдар цолтон ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хамгийн зорилтот бүлэгт чиглэгдээгүй хөтөлбөр бөгөөд нийт зардлын 65 хувь нь хүн амын амьжиргааны түвшин хамгийн өндөртэй 20 хувьд хуваарилагдаж байна.

Бусад хөтөлбөрүүдийн хувьд орлого багатай иргэдэд хуваарилагдаж буй зардлын хэмжээ нь харьцангуй өндөр орлоготой иргэдэд хуваарилагдаж буй зардлаас бага зэрэг өндөр боловч хангалттай хэмжээнд зорилтот бүлэгт чиглэгдэж чадаагүй байна.

Нийгмийн халамжийн зардлын 73.6 хувь нь нийтлэг мөнгөн тэтгэмжийн олголтод зарцуулагдаж, бодит хэрэгцээтэй зорилтот бүлэгт чиглэсэн дэмжлэг ердөө 26.4 хувьтай байгаа нь үр ашиггүй хуваарилалтыг бий болгож байна. Үүнээс үүдэж бодит

дэмжлэг хэрэгтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эцэг эх зэрэг бүлэгт хүртээмж хангалтгүй хэвээр байна.

Үүнд зорилтот бүлгийг тодорхойлох үнэлгээ сул, халамжийн үйлчилгээний, бие даан амьдрахад нь туслах үйлчилгээний нэр төрөл цөөн байгаа нь нөлөөлж байна. Халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, гэр бүл, хүн амын өсөлтийг дэмжсэн дэмжлэгээс зааглах, эмзэг бүлгийн иргэдийн хамгааллыг сайжруулж, ажиллах чадвартай иргэдийн орлого нэмэгдэх бодлогоор дэмжвэл халамжийн үр ашиг өсөж, ядуурал буурахад нөлөөлнө.

Өрхийн орлого: Өрхийн нийт орлогыг өрхийн мөнгөн орлого, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог. Өрхийн мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрддэг.³⁶

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2024 оны 4 дүгээр улирлын дүнгээр 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 98.7 (5.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн бол өмнөх улирлаас 26.3 (1.5%) мянган төгрөгөөр буурсан байна. Өрхийн сарын дундаж бодит мөнгөн орлого 1.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 95.7 (6.1%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 17.6 (1.0%) мянган төгрөгөөр буурчээ.

Бодит орлогын өсөлтийг төрлөөр задалж үзвэл, өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 23.5 (15.6%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 8.0 (9.2%) мянган төгрөгөөр буурсан нь сөргөөр нөлөөлсөн ч цалин хөлсний орлого 91.3 (10.7%) мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 24.3 (6.8%) мянган төгрөгөөр, бусад орлого 11.7 (10.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бодит нийт орлого 5.9 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна. (Хүснэгт 18-д Нэг өрхийн сарын дундаж бодит орлого, орлогын өөрчлөлт, 2020 оны зэрэгцүүлэх үнээр харуулав.)

Хүснэгт 18. Нэг өрхийн сарын дундаж бодит орлого, орлогын өөрчлөлт, 2020 оны зэрэгцүүлэх үнээр, улсын дунджаар, мянган төгрөгөөр

Орлогын төрөл	2023	2024	Өөрчлөлт, мян.төг	Өсөлт
			Өмнөх оноос	Өмнөх оноос
Нийт орлого	1,663.5	1,762.2	98.7	5.9
Мөнгөн орлого	1,563.0	1,658.7	95.7	6.1
Цалин хөлс	857.7	949.0	91.3	10.7
Тэтгэвэр, тэтгэмж	358.5	382.8	24.3	6.8
ХАА-н үйлдвэрийн орлого	151.1	127.6	-23.5	-15.6
Үйлчилгээний орлого	87.4	79.4	-8.0	-9.2
Бусад орлого	108.3	120.0	11.7	10.8
Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	35.7	41.4	5.7	16.0
Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	64.8	62.1	-2.7	-4.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нэг өрхийн сарын дундаж нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 0.3 нэгж хувиар нэмэгдэж, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 0.4 нэгж хувиар буурсан байна.

Өрхийн сарын дундаж орлогыг хот, хөдөөгөөр нь авч үзвэл, хотын өрхүүдийн сарын дундаж нийт орлого 2.9 сая төгрөг, хөдөөгийнх 2.1 сая төгрөг байна. Хотын өрхүүдийн сарын дундаж нийт орлого хөдөөгийн өрхүүдээс 765.5 (36.0%) мянган

³⁶ ҮСХ-Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2024 оны танилцуулга

төгрөгөөр их байна. Бүсээр харвал, өрхийн сарын дундаж нийт орлого 2.0-2.4 сая төгрөг байна.

Улсын хэмжээнд 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар сард 700.0 мянган төгрөг хүртэлх орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 75.2 хувийг, 700.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 54.9 хувийг, 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 52.9 хувийг тус тус тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд өрхийн мөнгөн орлогын хэмжээ нэмэгдэхийн хэрээр тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь буурч байна. Нөгөөтэйгөөр, өрхийн мөнгөн орлогын хэмжээ нэмэгдэхийн хэрээр цалин хөлсний орлогын эзлэх хувь хэмжээ өсөж байна. Тухайлбал, сард 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 38.4 хувийг, 2.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 66.2 хувийг цалин хөлсний орлого бүрдүүлж байна.

Хүн ам зүйн ачаалал нэмэгдэхийн хэрээр өрхийн орлого буурах хандлагатай байдаг, учир нь ажиллах насны хүн амын эзлэх хувь багасаж, тэтгэвэр болон хүүхдийн насны иргэдийн арчилгаа, халамжийн зардал нэмэгддэг. Энэ нь өрхийн нийт орлогын зарцуулалтад дарамт үүсгэж, амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлдөг. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15 хүртэлх, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн ам зүйн ачааллаар харуулдаг.³⁷ (Хүснэгт 19-д харуулав.)

Хүснэгт 19. Хүн ам зүйн ачаалал (Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо)

Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Хүн амын тоо	58.6	59.5	59.7	60.0	59.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх хүснэгтээс үзэхэд хүн амын зүйн ачаалал 2020 онд 58.6 байсан бол 2024 онд 59.0 болж өссөн байна.

Монгол Улсад хүн ам зүйн ачаалал нэмэгдэж, тэтгэврийн насны хүн амын эзлэх хувь өсөж байгаа нь ажиллах хүчний насны хүн амд ногдох тэжээлгэгчийн тоог бууруулж, нийгмийн даатгалын тогтолцоонд дарамт үүсгэх, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж байна. Мөн өрхийн орлогын бүтэц тэнцвэргүй байгаагаас шалтгаалан бага орлоготой өрхүүдийн амьжиргаа тэтгэвэр, тэтгэмжийн хамаарлыг нэмэгдүүлж байгаа нь орлогын тогтвортой эх үүсвэр дутмаг, хөдөлмөр эрхлэлтийн боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна.

Цаашид өмчийн эрхийн баталгааг сайжруулах замаар өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Мөн иргэдийн ур чадварыг нэмэгдүүлж, хүн ам зүйн ачааллыг бууруулна.

Баялгийн сан: Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх замаар тэгш, шударга хүртээхэд чиглэсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 179 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс Монгол” ХХК нь 2024 онд Хуримтлалын санд нийт 499.5 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүрэг хүлээснээс 495.6 тэрбум төгрөгийн орлогыг шилжүүлсэн буюу нэгдлийн бүрэлдэхүүн компаниудаас “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ 273.0 тэрбум төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК 200.0 тэрбум төгрөг, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК 13.6 тэрбум төгрөг, “Монголросцветмет” ТӨҮГ 8.7 тэрбум төгрөг, “Эрдэнэс Оюутолгой” ХХК 342.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн. (Хүснэгт 20-д хуримтлалын санд 2024 онд төвлөрүүлсэн дүнг харуулав.)

³⁷УСХ- Хүн амын статистикийн мэдээ, ойлголт хэрэглээ тайлан, 8 дугаар тал

Хүснэгт 20. Хуримтлалын санд 2024 онд төвлөрүүлсэн дүн, төгрөгөөр

дд	Компаниуд	2024 онд Хуримтлалын санд төвлөрүүлэх орлогын хэмжээ	2024.12.31-ний өдрийн байдлаар төвлөрүүлсэн дүн
1	Эрдэнэс Тавантолгой ХК	200,000,000,000	200,000,000,000
2	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	273,031,625,042	273,031,625,042
3	Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК	13,614,960,515	13,614,960,515
4	Монголросцветмет ТӨҮГ	8,657,239,244	8,657,239,244
5	Цемент Шохой ХХК	3,826,764,558	-*
6	Эрдэнэс Оюу Толгой ХХК	342,865,122	342,865,122
	Нийт	499,473,454,481	495,646,689,923

*-"Цемент шохой" ХХК-аас 3.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийг санхүүгийн нөхцөл байдал, мөнгөн хөрөнгийн дутагдалтай байдлаас шалтгаалан төвлөрүүлж амжаагүй болно.

Хуульд заасны дагуу Монголбанкнаас хуримтлалын сангийн үлдэгдэлд 9.9 тэрбум төгрөгийн хүү тооцсоноор хуримтлалын сангийн нийт үлдэгдэл 505.5 тэрбум төгрөгт хүрээд байна.

Үндэсний баялгийн сангийн хуримтлал 2024 онд 1,308.4 сая ам.долларт хүрсэн байна. Үүний 88.8 хувь буюу 1,162.1 сая ам.долларыг Ирээдүйн өв сан бүрдүүлсэн бол үлдсэн хэсгийг хуримтлалын сан бүрдүүлсэн байна. (Хүснэгт 21-д Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг харуулав.)

Хүснэгт 21. Үндэсний баялгийн сангийн хуримтлал

Төрөлжсөн сан	2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Тэрбум төгрөг	Сая ам.доллар
Ирээдүйн өв сан	3,974.5	1,162.1
Хуримтлалын сан	500.5	146.4
Нийт	4,475.1	1,308.4

Эх сурвалж: Сангийн яам

Үндэсний баялгийн сангийн хараат бус, бие даасан, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, мөн баялгийн сангийн хөрөнгийн ашиглалтын хяналтын механизм бий болгох шаардлагатай байна.

Цаашид Үндэсний баялгийн сангийн хараат бус, бие даасан, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх замаар Үндэсний баялгийн сангийн иргэдэд хүрэх өгөөжийг нэмэгдүүлэх мөн Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн ашиглалтын хяналтын механизм бий болгож, хөгжлийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлнэ.

Иргэдийн орлого, ажил, эрүүл мэнд, мэдлэг ур чадвар, аюулгүй байдал, нийгмийн харилцаа, иргэний оролцоог нэмэгдүүлж нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ. Ингэснээр ядуурлын хамрагдалтын хүрээ 2022 онд 27.1 хувь байгаа бол 2030 онд 15.0 хувьд хүрч буурна.

Монгол Улсын хүн амын өсөлт 2024 онд 1.14 хувь болж саарсан нь төрөлт 25 хувь буурсан, эх хүүхдийн эндэгдэл тогтвортой өндөр, гэр бүлийн тогтворгүй байдал нэмэгдсэнтэй шууд холбоотой. Нийгмийн халамж зорилтот бус зохицуулалттай, өрхийн орлогын тэгш бус байдал их, хүн ам зүйн ачаалал өсөж байна.

Эдийн засгийн дарамт, ажил-амьдралын тэнцвэргүй байдал, гэр бүлийн зөрчил, эхийн эрүүл мэндийн эрсдэл, үйлчилгээний хүртээмж ба чанарын ялгаа, халамжийн оновчгүй тогтолцоо эдгээр асуудлыг үүсгэж байна.

Нөхөн үржихүйн болон хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулах, гэр бүлийн бодлогыг орлого-орон сууц-асаргаатай уялдуулах, ажил амьдралын уян зохицуулалт нэвтрүүлэх, халамжийн үйлчилгээг оновчлох шаардлагатай байна. Ингэснээр төрөлтийн бууралтыг зогсоож хүн амын өсөлтийг тогтворжуулах, эх нялхсын эндэгдлийг мэдэгдэхүйц бууруулах, өрхийн орлогын тогтвортой байдлыг сайжруулах боломж бүрдэнэ.

Гэр бүлийн бодлогыг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг 1.1 хувьд тогтмол барихаар зорьж байна.

Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж эх хүүхдийн эндэгдлийг бууруулна. Ингэснээр эхийн эндэгдлийн харьцаа (100,000 амьд төрөлтөд ногдох) 2024 онд 22.5 байгаа бол 2030 онд 15 болж буурна. Нярайн эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлтөд ногдох) 2.5 бууруулан 5-д хүргэж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлтөд, хүйсээр) 2024 онд 15.2 байгааг 2030 онд 12.1 болгоно.

Ингэхийн тулд үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалтын хувийг 1.9 дахин бууруулж 2.1 хувьд хүргэнэ. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, өсвөр насны охидын төрөлтийн түвшин 2024 онд 15.5 хувь байгааг 2030 онд 12.5 хувьд хүргэж, үр хөндөлтийн харьцаа (1,000 амьд төрөлтөд ногдох) 2024 онд 219.0 байгааг 2030 онд 190.0-д хүргэнэ.

Бүх нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах замаар гэр бүлийн ээлтэй, тогтвортой байдлыг хангаж, 1,000 хүн тутамд ногдох гэр бүл цуцлалтыг 1.3 дахин бууруулж 1.6 хүргэнэ. Мөн зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх замаар нийт хүн амын гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлнэ. Ажлын цагийг уян хатан зохицуулах замаар ажил амьдралын тэнцвэрийг хангаж, долоо хоногт 48 цагаас дээш цагаар ажиллагчдын хувь 2024 онд 32.3 хувь байгааг 2030 онд 15.0 хувьд хүргэнэ.

Халамжийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан хүн амын эзлэх хувь (ядуу хүн ам)-ийг 1.2 дахин өсгөж 39.0 хувьд, “Нийгмийн суурь үйлчилгээний загвар”-ыг нэвтрүүлэх замаар нийгмийн халамжийн нийт зардалд зорилтот бүлэгт чиглэсэн зардлын эзлэх хувийг 10.4 нэгж хувиар нэмэгдүүлж 36.8 хувьд хүргэхээр зорьж байна. Мөн олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар ахмад настанд чиглэсэн цогц тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Өмчийн эрхийн баталгааг сайжруулж өрхийн бодит орлогын өсөлтийг 5.0 хувьд, иргэдийн ур чадварыг нэмэгдүүлж хүн ам зүйн ачааллыг бууруулна. Мөн Үндэсний баялгийн сангийн хараат бус, бие даасан, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж баялгийн сангийн иргэдэд хүрэх өгөөжийг нэмэгдүүлэх, хөгжлийн сангийн хуримтлалыг 200.0 тэрбум төгрөгт хүргэнэ.

3.2.5. Хүний эрхийн баталгаа

Монгол Улс 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, “хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх”-ийг эрхэм зорилгоо болгон тунхагласан билээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хүний эрхийг “яс үндэс, оршин сууж буй газар, хүйс, үндэсний болон угсаатны угсаа гарал, арьсны өнгө, шашин, хэл, аливаа бусад байдлаас үл хамааран бүх хүний угаас салшгүй хэсэг” гэжээ. Эдгээр эрх нь биднийг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, шударга бус харьцаа хандлагаас хамгаалж, үг хэлэх эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх зэрэг иргэний болон улс төрийн, эрүүл мэнд, боловсролын зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын, эрхүүд багтдаг. Хүний эрх нь шударга шүүхээр шүүлгэх гэх мэт хувийн, мөн эмэгтэйчүүд, хүүхдийн гэх мэт бүлгийн эрх байж болно. Хүний эрхийг хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцоор хамгаалдаг.

Хүний эрх нь боолчлол, хүний наймаанаас ангид байх, амьд байх, хувийн халдашгүй байдал хэмээн үргэлжилсэн өргөн хүрээг хамарсан ойлголт билээ.

Дэлхийн банкнаас гаргадаг Засаглалын үзүүлэлтийн дэд үзүүлэлт болох “Иргэдийн дуу хоолой ба хариуцлага” үзүүлэлт нь тухайн улсын иргэд төрийн үйл ажиллагаанд хэрхэн оролцож чадаж байгаа, төрөөс иргэддээ хэр хариуцлагатай,

нээлттэй байгааг илэрхийлдэг.³⁸ Энэ нь дараах үндсэн хэмжүүрийг нэгтгэн тооцдог нийлмэл үзүүлэлт юм.

- ✓ Иргэд сонгуулиар төрийн эрх баригчдаа сонгох эрх, оролцооны түвшин;
- ✓ Үг хэлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, иргэд болон сэтгүүлчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж;
- ✓ Иргэний нийгмийн байгууллагын оролцоо, төрийн бодлогод нөлөөлөх чадамж;
- ✓ Хариуцлагын механизм, төрийн шийдвэр, бодлого, үйл ажиллагаанд иргэд хяналт тавих боломж.

Эдгээр үзүүлэлтийг олон улсын судалгааны байгууллага, судалгааны баг, бизнесийн холбоо, ТББ-ууд болон экспертүүдийн үнэлгээнд үндэслэн тооцдог. Тус үзүүлэлтээр манай улс 2024 онд 98-д эрэмбэлэгдэж байна.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс 2001-2005 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх нийт 24 удаагийн илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн, хүний эрхийг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой 474 саналыг танилцуулж, УИХ-ын 8, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 9 тогтоолыг гаргуулж ирсэн.

Итгэлд хүүхдийн эрх, хөдөлмөрлөх эрх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх, сурч боловсрох эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, жендэрийн эрх тэгш байдал, эрүү шүүлт ба хүний эрх, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх, гэр бүлийн хүчирхийллийн талаар, ахмад настны эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, хүний эрхийн боловсрол, халдашгүй чөлөөтэй байх эрх, өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх эрх, хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх, үндэстний цөөнх, аж ахуй эрхлэх эрх, амьд явах эрх, сонгох, сонгогдох эрх, зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн хүрээнд гарч буй хүний эрхийн зөрчлийг арилгах талаар илтгэлд тусгагдсан.³⁹

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хүрээнд гарсан УИХ-ын тогтоолын хэрэгжилт 2024 онд 50.0 хувьтай байгаа нь зарим асуудал шийдэгдээгүй, хэрэгжилт удаашралтай байгааг харуулж байна.

Хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай гомдол шийдвэрлэлт 75.0 хувьтай байгааг нэмэгдүүлэх, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад учирч буй эрсдэлийн үнэлгээ 3.25 оноотой байгааг бууруулах шаардлагатай байна.

Дэлхийн банк, Жендэрийн үндэсний хорооны Ажлын албатай хамтран “Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ” тайланг танилцуулсан. Тус тайланд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсролыг сайжруулах чиглэлд томоохон үр дүнд хүрч, амжилтаа хадгалж байгааг онцолсон. Түүнчлэн дээд боловсрол болон эрүүл мэндийн салбарт жендэрийн ялгаа нэмэгдэж, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, дуу хоолой, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэгт жендэрийн ялгаа байсаар байгааг анхаарууллаа.

Жендэрийн тэгш бус байдлын индекс 2024 онд 0.218 болсон бөгөөд нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсрол, шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл гэсэн гурван хэмжүүрээр тооцдог.

Тус индексийн дэд индекс болох боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлт тогтвортой, ахиц дэвшлээ хадгалж байгаа бол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо 120 дугаар байрнаас

³⁸ Дэлхийн банк (2023). Иргэдийн дуу хоолой ба хариуцлага: Тооцоолол. Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд

³⁹ Хүний Эрхийн Үндэсний Комисс, нөхцөл байдлын дүн шинжилгээ

99 хүртэл, ажиллах хүчний оролцоо 43-р байрнаас 20 хүртэл ахисан “ахиц дэвшилттэй” үнэлэгдсэн байна.

Эмэгтэйчүүд төрийн захиргаанд олноор ажилладаг ч улс төрийн болон бодлого боловсруулах үйл явцад дуу хоолойгоо хангалттай хүргэж чадахгүй байна. Эмэгтэйчүүд дунд шатны удирдах албан тушаалтны дөнгөж 30 хувийг, дээд түвшний удирдах албан тушаалтны 15 хувийг эзэлж байгааг тус тайланд онцолсон байна.

Жендэрийн ялгаатай байдал нь ажиллах хүчинд бий болсон тэгш бус байдалд тод илэрч байна. Тухайлбал, их, дээд сургууль төгссөн хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд эрчүүдээс илүү байгаа ч эрчүүдтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэх нь 15 хувиар бага, дунджаар 25 хувь бага цалин авч байгааг Дэлхийн Банк Жендэрийн үндэсний хорооны Ажлын албатай хамтран “Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ” тайланд дурджээ.

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцоо эрэгтэйчүүдээс 16.2 хувиар бага байгаа ба 2020 онд 14.6 байсан бол 2024 онд 16.2 буюу өмнөх 5 жилээс 1.6 хувиар өссөн, оролцоо нь 0.6 хувиар буурсан байна.

Эмэгтэйчүүд төрийн захиргаанд олноор ажилладаг ч улс төрийн болон бодлого боловсруулах үйл явцад дуу хоолойгоо хангалттай хүргэж чадахгүй байна. Эмэгтэйчүүд дунд шатны удирдах албан тушаалтны дөнгөж 30 хувийг, дээд түвшний удирдах албан тушаалтны 15 хувийг эзэлж байгааг тус тайланд онцолсон.

Хүн амын дундаж наслалтын тоо баримтаас харахад Монгол эрчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 2024 онд 9.18 жилээр бага байгаа бөгөөд энэ нь 2020 онтой харьцуулахад эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү 0.33 пунктээр буурсан байна. (Хүснэгт 22-т жендэрийн тулгамдаж буй асуудлыг харуулав.)

Хүснэгт 22. Жендэрийн тулгамдаж буй асуудлын харьцуулалт

д/д	Жендэрийн асуудал	2024 он	
		Эрэгтэй	Эмэгтэй
1	Дундаж наслалт (жилээр)	67.92	77.1
2	Ажиллах хүчний оролцоо (хувиар)	69.7	53.5
3	Дундаж цалин (мянган төгрөгөөр)	2,576.9	2,077.1
4	Эхийн эндэгдэл (100,000 амьд төрөлтөд)	23	

Эх сурвалж: Жендэрийн үндэсний хороо

Тус индексийг бууруулахын тулд удирдах албан тушаалд ажиллагчдад эмэгтэйчүүд 2024 онд 41.3 хувь байгааг өсгөх, 15 түүнээс дээш насны хүм амын дундах эрэгтэйчүүдийн (15-49 нас) тамхи таталтын тархалт 59.3 хувь, эрэгтэйчүүдийн амиа хорлолтын түвшин (10,000 эрэгтэй хүнд ногдох амиа хорлосон хүний тоо) 27.3 байгааг бууруулах шаардлагатай байна.

Монгол Улсад хүний эрхийн хууль эрх зүйн орчин тогтворжиж, олон улсын стандартын дагуу хамгаалах тогтолцоо бий болсон ч хэрэгжилт удаашралтай, 2024 онд УИХ-ын тогтоолын биелэлт 50.0 хувьтай байна. Иргэдийн дуу хоолой, хариуцлагын үзүүлэлтээр улс 98-р байранд эрэмбэлэгдсэн нь төрийн нээлттэй байдал, иргэний оролцоо хангалтгүй байгааг илтгэж байна. Жендэрийн ялгаа хөдөлмөрийн зах зээл, улс төрийн оролцоо, удирдах түвшинд өндөр хэвээр, эмэгтэйчүүдийн дундаж цалин эрчүүдээс 25.0 хувиар бага, ажиллах хүчний оролцоо 16.2 хувиар доогуур байна. Иймд хүний эрхийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах, иргэний оролцоог нэмэгдүүлэх бодлого, хяналтын механизмыг сайжруулах шаардлагатай байна.

Залуучууд: Залуучууд нь нийгмийн хөгжлийн гол тулгуур багана ба нийгэм дэх идэвхтэй оролцоо, шийдвэр, шийдэл нь хүний эрхийн зэрэг өөрчлөлтийг бий болгодог.

Монгол Улсад 15-34 насны иргэн 1,080.1 мянга байгаа нь нийт хүн амын 34.6 хувь, 15 ба түүнээс дээш насны хүн амын 66.1 хувийг эзэлж байна. Залуучууд болон залуу гэр бүлийн хувьд хамгийн тулгамдаж буй асуудал бол ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, хүүхдээ асруулах асуудал юм. Тухайлбал, улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 10.0 хувьтай байгаагаас залуучуудын ажилгүйдлийн түвшнийг авч үзвэл, улсын дунджаас 2 дахин өндөр байна. Тухайн үед хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 34.4 мянган ажилгүй иргэн бүртгэлтэй байгаагийн 57.1 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

“The Commonwealth of Nations” байгууллагаас эрхлэн гаргадаг “Залуучуудын хөгжлийн индекс (YDI)”-ийн үзүүлэлтээр 2020 оны байдлаар 0.758 үзүүлэлтээр 58-т эрэмбэлэгдэж “сайн” ангилалд орсон бол 2023 онд 0.770 үзүүлэлтээр 61-т буюу 3 байраар ухарсан байна.

Монгол Улсын ажилгүй иргэдийн тал хувийг залуучууд эзэлдэг. Тэгвэл тэдгээр залуучуудын 90.0 хувь нь ажилгүй байх хугацаандаа өрхийн бусад гишүүдээр тэжээлгэдэг тул өрхийн хүн ам зүйн ачаалалд дарамт болж, амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байна. Сүүлийн 12 сарын хугацаанд хөдөлмөр эрхэлж байгаад ажилгүй болсон залуучуудаас хөдөлмөр эрхлэхэд тулгардаг, хүндрэлтэй байдаг шалтгааныг тодруулсан. Мэргэжил эзэмшсэн залуучуудын хувьд нэгдүгээрт, ажлын туршлагагүй байдал (26.2%), хоёрдугаарт, ар гэрийн асуудал (20.0%), гуравдугаарт, тухайн ажлыг хийх мэдлэг, чадвар хүрэхгүй байх (19.5%) шалтгаанууд зонхилдог байна.

Харин мэргэжил огт эзэмшээгүй залуучуудын дунд нэгдүгээрт, тухайн ажлыг хийх мэдлэг, чадвар хүрэхгүй байх (41.6%), хоёрдугаарт, боловсролын түвшин (35.5%), гуравдугаарт, ажлын туршлагагүй нь (22.9%) хүндрэлтэй байдаг гэж хариулсан юм. Мөн аж ахуйн нэгж, байгууллагуудын цалингийн хэмжээ бага, цалингаа хугацаанд нь, эсвэл огт өгдөггүй, ажил горилогчийг туршилтын хугацаагаар ажиллуулж, цалин олгохгүй байх, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулахгүй байх, хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй байх зэрэг шалтгааны улмаас олон залуучууд ажилгүй болох, улмаар ажил хийх, хайхаас шантрах тохиолдол гарсаар байна. Тиймээс шинэ ажиллагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Залуучууд хангалттай ажлын байр байхгүй байгаа нь хамгийн том бэрхшээл гэсэн ойлголттой байна. Харин нээлттэй ажлын байранд шалгуулахад ажил олгогчийн тавьсан шаардлагад ажлын туршлага, хэлний мэдлэг зэрэг нь хамгийн том бэрхшээл болж байна. Судалгаанд оролцогч залуучуудын 97.0 хувь нь хөдөлмөр эрхлэх хүсэл тэмүүлэлтэй байгаа нь тэдэнд шаардлагатай ажлын байрыг бэлдэх, өөрөө өөрсдөдөө ажлын байраа бэлдэж хувийн аж ахуй эрхлэх боломжтой, сонирхолтой залуучуудыг дэмжих хэрэгтэйг харуулж байна.²

Залуучуудын хөгжлийн индексийн эрэмбийг урагшлуулахын тулд залуучуудын ур чадвар болон оролцооны түвшнийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсад залуучууд нийт хүн амын 34.6 хувийг эзэлж байгаа ч ажилгүйдлийн түвшин улсын дунджаас хоёр дахин өндөр, хөдөлмөр эрхлэхэд ажлын туршлага, ур чадвар, хэлний мэдлэгийн дутагдал, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт сул байгаа нь томоохон асуудал хэвээр байна. Залуучуудын хөгжлийн индекс 2023 онд 61-р байранд орж, 3 байраар ухарсан нь ур чадвар, оролцооны түвшнийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүүхдийн эрх: Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүүхэд бүр ялгаварлан гадуурхалгүйгээр бүрэн эрхээ эдлэх эрхтэй гэж заасан байдаг.

Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц, Нидерландын Хүүхдийн эрхийн сангаас гаргадаг хүүхдийн эрхийн индексээр манай улс 2020 онд 0.702 оноо авч

байсан бол 2024 онд 0.855 оноо авсан байна. Тус индекс амьд явах эрх, эрүүл мэнд, боловсрол, хамгаалалт, хүүхдэд ээлтэй орчин гэсэн 5 шалгуур үзүүлэлтээр тооцдог. (Хүснэгт 23-т харуулав.)

Хүснэгт 23. Хүүхдийн эрхийн индексийн үзүүлэлт

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
Амьд явах эрх	0.69	0.7	0.702	0.705
Эрүүл мэнд	0.66	0.67	0.68	0.685
Боловсрол	0.73	0.735	0.74	0.745
Хамгаалалт	0.67	0.675	0.68	0.685
Хүүхдэд ээлтэй орчин	0.61	0.62	0.625	0.63

Эх сурвалж: Хүүхдийн эрхийн сан

Манай улс хүүхэд хамгаалал, хүүхдэд ээлтэй орчны үзүүлэлт муу байгаа ба энэ нь хүүхэд амьдрах аюулгүй ээлтэй орчин бүрдээгүй байгааг илтгэж байна.

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт хүн амын 37.1 хувийг хүүхдүүд эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийллээс болж хохирсон хүүхдийн тоо 2020 онд 91 байсан бол 2024 онд 131 болж 44.0 хувиар нэмэгдсэн.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 2019 оноос хойш 38.3 хувиар буурч, аюулгүй байдлын хамгаалалт, түр хамгаалах байрны үйлчилгээ авсан хүүхдийн тоо (түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв) тогтмол 2,100-3,000 орчимд хэлбэлзэж байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 13,219 хүүхдээс 2,456 хүүхэд тусламж авсан байна. ⁴⁰ (Хүснэгт 24-т харуулав.)

Хүснэгт 24. Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024
Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд	21,417	22,754	20,724	14,207	15,905	13,219
Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхэд /нийт үйлчлүүлэгчдийн 70-80% хүүхэд байна/	2,097	3,755	2,916	3,226	3,308	2,456
Асрамж, халамжийн төвд амьдарч буй хүүхэд	1,067	1,069	1,031	1,031	924	888

Эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувь 2018 онд 16.7 хувь байсан бол 2023 онд 11.7 хувь болж 30.0 хувиар буурсан байна. Энэ нь хүүхдийн эрхийн баталгаа хангах, эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж хүүхдийн хүчирхийллийн тоог бууруулахад чиглэсэн арга хэмжээг улам бүр сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Хүүхдийн эрхийн индекс сайжирч байгаа ч хүүхэд хамгаалалт, хүүхдэд ээлтэй орчны үзүүлэлт сул, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 44 хувиар өссөн нь хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатайг илтгэж байна. Мөн хүүхэд хамгааллын тогтолцоог эрчимтэй сайжруулж, эрсдэлийн эрт илрүүлэлт, хамгааллын үйлчилгээний салбар хоорондын уялдааг бэхжүүлэх шаардлагатай. Гэр бүлийн боловсрол, сэтгэлзүйн дэмжлэг, хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдэд ээлтэй гэр бүл болон нийгмийн орчныг бодитоор бүрдүүлэх чиглэлд үр дүнг тодорхойллоо.

Гэмт хэрэг, зөрчил: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй.” гэж заасан байдаг.

⁴⁰ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Гэмт хэрэгт хохирох эрсдэл гэдэг нь хувь хүн эсвэл бүлэг хүмүүс тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч болох магадлалыг илэрхийлдэг бөгөөд эрсдэл нь тухайн хүний амьдралын хэв маяг, амьдрах орчин, эдийн засгийн нөхцөл байдал, нас, хүйс, боловсрол, ажил мэргэжил зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Улсын хэмжээнд 2024 онд 44,673 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 32,123 (71.9%), орон нутагт 12,540 (28.1%), бусад газар (хилийн чанадад)-т 10 (0.02%) үйлдэгдсэн байна. Гэмт хэргийн тоог 2020 онтой харьцуулахад нийт гэмт хэрэг 21,609 буюу 1.9 дахин, нийслэлд 17,490 буюу 2.2 дахин нэмэгдэж, орон нутагт 4,120 буюу 48.9 хувиар өссөн бол бусад газар үйлдэгдсэн гэмт хэрэг 1 буюу 9.0 хувиар буурчээ. (График 17-д харуулав)

График 17. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 25. Бүртгэгдсэн гэмт хэрэг 16, түүнээс дээш насны /10,000 хүнд ногдох/

Он	2020	2021	2022	2023	2024
Бүртгэгдсэн гэмт хэрэг	108	117	159	160	198


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх (Хүснэгт 25) хүснэгт дэх 16, түүнээс дээш насны 10,000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо сүүлийн 5 жилд тасралтгүй өсөж, 1.8 дахин нэмэгдэн 2024 онд 198 болсон байна. Энэ нь дараагийн 5 жилийн хугацаанд шийдвэрлэхгүй бол дахин нэмэгдэх хандлагатай байна.

Иргэн, хуулийн этгээдээс 2024 онд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 323,607 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос 14,547 гомдол, мэдээллээр буюу 4.7 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо жил тутам өсөж, 2024 онд 2020 оноос 47.9 хувиар өссөн байна.⁴¹ (График 18-д харуулав.)

График 18. Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирол 2020 онд 254,937.3 сая төгрөг байсан бол 2024 онд 2.7 дахин нэмэгдэж 697,077.4 сая төгрөгт хүрсэн байна. Нийт

⁴¹ Үндэсний статистикийн хороо, статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2024 оны гэмт хэргийн тоо

хохиролд эзлэх хохирол нөхөн төлөлт 2020 онд 82,079.4 сая төгрөг буюу 32.2 хувь байсан бол 2024 онд 306,256.4 сая төгрөг буюу 43.9 хувь болж 11.7 нэгж хувиар өсжээ. (Хүснэгт 26-д харуулав.)

Хүснэгт 26. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлөлт, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Учирсан нийт хохирол	254,937.3	180,339.3	347,900.1	449,155.2	697,077.4
Үүнээс: Төрийн өмчид учирсан хохирол	6,537.6	8,767.3	7,751.7	10,071.6	31,572.5
Орон нутгийн өмчид учирсан хохирол	2,395.1	3,307.9	9,797.8	2,809.6	3,605.2
Хувийн өмчид учирсан хохирол	246,004.7	168,264.2	330,350.6	436,274.0	661,899.7
Хохирол нөхөн төлөлт	82,079.4	90,376.7	183,243.9	211,535.8	306,256.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 52.7 хувь, 2022 онд 54.2 хувь, 2024 онд 51.9 хувь буюу 2020 оноос 0.8 нэгж хувиар буурсан байна.

Гэмт хэргийн гаралт өсөхөд архидалт, ажилгүйдэл, ядуурал голлох шалтгаан болж байгаа бол амьдрах орчны аюулгүй байдал хувь хүний амьдралын чанарт шууд нөлөөлдөг гол хүчин зүйл болж байна. Нийслэл хотын авто замын түгжрэл иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг хамгийн том хүчин зүйл байсаар байна.⁴² Цаашид гэмт хэргээс хохирох эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Цаашид хүний эрхийн боловсролыг дэмжих замаар хүний эрхийн баталгааг хангаж, иргэдийн дуу хоолой ба хариуцлагын эрэмбийг 18 байраар ахиулж 80-д хүргэнэ. Үүнд хүрэхийн тулд хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хүрээнд гарсан УИХ-ын тогтоолын хэрэгжилт 2024 онд 50.0 хувь байгааг 2030 онд 95.0 хувьд, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай гомдол шийдвэрлэлтийг 85.0 хувьд, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад учирч буй эрсдэлийн үнэлгээг 2.5-д хүргэнэ.

Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар жендэрийн тэгш бус байдлын индексийг 0.053-р бууруулж 0.165-д, УИХ, орон нутгийн эрх барих хуралд суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 30.0-д, удирдах албан тушаалд ажиллагчдад эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 43.8-д хүргэнэ.

Мөн жендэрийн хэвшмэл буруу ойлголтыг арилгах замаар 15 түүнээс дээш насны хүм амын дундах эрэгтэйчүүдийн (15-49 нас) тамхи таталтын тархалтыг 52.5 хувь буюу 6.8 нэгж хувиар бууруулна. Эрэгтэйчүүдийн амиа хорлолтын түвшин (10,000 эрэгтэй хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)-ийг 2030 онд 17.6 продецимль буюу 1.6 дахин багасгана. Илүүдэл жинтэй эрэгтэйчүүд 2023 онд 39.1 хувь байгааг 2030 онд 34.0-д, санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (100,000 хүнд ногдох)-ийг 2030 онд 18.4 продецимль буюу 1.8 дахин бууруулна.

Залуучуудын нийгмийн идэвх, санаачилга, хамтын ажиллагааг дэмжих замаар залуучуудын хөгжлийн индексээр 59-д эрэмбэлэгдэнэ. Эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах дадал, зан үйлийг хэвшүүлэх замаар залуучуудын амьдрах ур чадварыг дээшлүүлнэ. Нийгмийн хөгжлийн төлөөх шийдвэр гаргах түвшинд оролцох боломжийг нэмэгдүүлж залуучуудын нийгмийн оролцоо, манлайллыг дэмжиж залуучуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхээр зорьж байна.

Эцэг, эх, олон нийтийг хариуцлагажуулж, оролцоог нэмэгдүүлэхээр зорьж байна. Ингэснээр хүүхдийн эрх хамгаалагдаж улмаар хүүхдийн эрхийн индекс 2024 онд 0.855 байгааг 2030 онд 0.905-д хүрнэ. Урьдчилан сэргийлэлт, илрүүлэлтийг сайжруулах замаар гэр бүлийн хүчирхийллээс болж хохирсон хүүхдийн тоог 70 болгож

⁴² Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа-2023 он

1.9 дахин бууруулна. Мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь 2024 онд 34.1 байгааг 2030 онд 95 хувьд хүргэнэ.

Хүүхдийн авьяас, сонирхлыг тасралтгүй хөгжүүлэх замаар тэднийг хөгжлийн үйл ажиллагаанд тогтмол хамруулах орчныг бүрдүүлж, идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд 6-18 насны хүүхдүүдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах түвшнийг нэмэгдүүлж, нийт хүүхдийн 40 хувьд хүргэх зорилт тавина.

Мөн өсөлтийн хоцролттой 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувийг 2024 онд 8.8 хувь байгааг 7.0 хувьд хүргэж бууруулна. Үүнтэй зэрэгцэн хоол тэжээлийн дутагдалтай, туранхай хүүхдийн эзлэх хэмжээг 2.1 хувьд хүргэхээр төлөвлөж байна. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн тэгш боломжийг хангах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд бүрийн авьяас, чадварыг дэмжих ба хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тухайн насны хүүхдийн эзлэх хувийг 9.3 хувьд хүргэнэ. 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтэл (100,000 хүн амд ногдох) 2024 онд 1,268 байгааг 2030 онд 1,089 болгож 179-өөр бууруулна.

Иргэдийн ёс суртахуун, хүмүүжлийг сайжруулах замаар гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ба 16, түүнээс дээш насны 10,000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийг 127 болгож 68-аар багасгахаар зорьж байна. Ингэснээр суурьшлын бүсүүдэд теле хяналтын сүлжээг бүрэн нэвтрүүлж гэмт хэргийн илрүүлэлт 2030 онд 55.0 хувь болж нэмэгдэнэ. Цагдаагийн ёс зүй, ур чадварыг нэмэгдүүлж цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа 2023 онд 80.0 хувь байгааг 2030 онд 83.0 хувьд хүргэнэ. Суурьшлын бүсэд нэвтрүүлсэн камерын хяналтын төв, дэд төвийн эзлэх хувийг 82.0 хувьд хүргэнэ. Мөн шүүх шинжилгээний байгууллагын иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж шүүх шинжилгээний 100 дүгнэлтэд ногдох гомдлын тоо 2024 онд 34 байгааг 2030 онд 29-д хүргэж 14.7 хувиар бууруулна.

3.2.6. Хүнсний аюулгүй байдал

Хүн амын амьжиргааны байдал нь дан ганц ядуурлын үзүүлэлтээр хэмжигдэхгүй өргөн цар хүрээтэй асуудал бөгөөд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” хэмээн баталгаажуулсан байдаг.

Хүнс бол хүн амын суурь хэрэглээ байдаг билээ. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогын асуудал нь дэлхийн улс орон бүрийн хувьд ач холбогдолтой байдаг.

Манай улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хангамжийн түвшин 2024 онд 77.3 хувьтай байна. Үүнээс малын гаралтай бүтээгдэхүүнийг дотооддоо хангах чадварын харьцаа 100.0 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг дотооддоо хангах чадварын харьцаа 71.0 хувь байна. Дотоодын үйлдвэрлэлд малын гаралтай бүтээгдэхүүн 30.5 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүн 69.5 хувийг эзэлж байна.

Хүнсний хангамжийн түвшнийг өмнөх онтой харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн 171.2 мян.тн буюу 27.6 хувь, сүү 12.8 мян.тн буюу 8.0 хувь, гурил 39.9 мян.тн буюу 30.0 хувь, жимс, жимсгэнэ 0.4 мян.тн буюу 15.4 хувь, өндөг 1.5 мян.тн буюу хүнсний ногоо 73.9 мян.тн буюу буурцагт ургамал 0.3 нэгж хувиар, гурилан бүтээгдэхүүн 1.9 нэгж хувиар, цөцгийн тос 3.7 нэгж хувиар, сүү 9.5 нэгж хувиар, төрөл бүрийн будаа 18.1 нэгж хувиар, өндөг 1.5 мян.тн буюу 11.3 хувь, ургамлын тос 1.0 мян.тн буюу 66.6 хувь, цөцгийн тос 0.3 мян.тн буюу 33.3 хувиар буурсан. Харин төмс 71.8 мян.тн буюу 39.3 хувь, хүнсний ногоо 73.9 мян.тн буюу 35.5 хувиар өссөн байна. Дотоодын үйлдвэрлэлээр мах, махан бүтээгдэхүүн, сүү, төмсний хэрэгцээг 90.0-ээс

дээш хувиар хангаж байгаа бол өндөгний хэрэгцээг 70.6 хувь, хүнсний ногооны 66.3 хувь, гурил, гурилан бүтээгдэхүүний 59.1 хувийг дотоодоос хангасан байна. Төрөл бүрийн будаа 100.0 хувь импортын хараат байгаа бол ургамлын тосны 98.1 хувь, цөцгийн тосны 97.2 хувь, жимс, жимсгэнэ 97.1 хувийг импортоор авчээ. (Хүснэгт 27-д харуулав.)

Хүснэгт 27. Хүнсний хангамжийн түвшин (2023-2024)

Бүтээгдэхүүн	2023 он			2024 он		
	Дотоодын үйлдвэрлэл (мян.тн)	Дотоодоос хангасан хувь	Импортоор хангасан хувь	Дотоодын үйлдвэрлэл (мян.тн)	Дотоодоос хангасан хувь	Импортоор хангасан хувь
Мах, махан бүтээгдэхүүн	621.4	94.1	5.9	450.2	90.4	9.6
Сүү	160.0	99.8	0.2	147.2	99.8	0.2
Гурил, гурилан бүтээгдэхүүн	191.6	82.1	17.9	144.7	59.1	40.9
Гурил	132.6	91.2	8.8	92.7	58.3	41.7
Төрөл бүрийн будаа	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0
Төмс	182.7	95.9	4.1	254.5	95.9	4.1
Хүнсний ногоо	208.4	63.3	36.7	282.3	66.3	33.7
Жимс, жимсгэнэ	2.6	3.7	96.3	2.2	2.9	97.1
Өндөг	13.3	59.2	40.8	11.8	70.6	29.4
Ургамлын тос	1.5	5.2	94.8	0.5	1.9	98.1
Цөцгийн тос	0.3	3.3	96.7	0.2	2.8	97.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүнсний холбогдолтой үндэсний стандартын тоо 2024 оны байдлаар 660 байгаагаас 258 буюу 39.1 хувь нь олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн, 402 буюу 60.9 хувь нь уялдуулсан стандарт байна. (График 19-д харуулав.)

График 19. Хүнсний холбогдолтой нийт болон олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн стандартын тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг нийт баталсан аюулгүйн үзүүлэлтэд эзлэх хувиар тооцдог ба улсын хэмжээнд 2024 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавх 77.0 хувьтай байна.

Олон улсын стандарт, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн 35 ААНБ байгаагаас 15 ААНБ хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг, 20 ААНБ эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн байна. (Хүснэгт 28-д харуулав)

Хүснэгт 28. Олон улсын стандарт, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн хүнсний үйлдвэрийн тоо

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Нийт үйлдвэрийн тоо	22	17	27	33	35
Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн	12	12	16	17	15
Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (HACCP) нэвтрүүлсэн	10	5	11	16	20

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын хэмжээнд 2024 оны байдлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүнсний үйлдвэрлэлд хэрэглэж буй хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох лаборатори 27 нэр төрлийн хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлж байгаа боловч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд транс тосыг шинжлэн тодорхойлох чадамжтай лаборатори бүртгэгдээгүй байна⁴³.

Нийт өрхийн 65.0 хувь хүнсний баталгаат байдал нь ямар нэг хэмжээгээр алдагдсан, тэдний 14.0 хувь “өрхийн хүнс хүрэлцэхгүй нь” гэж санаа зовнидог буюу хүнсний баталгаат байдал нь “бага” түвшинд алдагдсан, 28.0 хувь идэхийг хүссэн хоол хүнсээ хэрэглэж чаддаггүй буюу хүнсний баталгаат байдал “дунд” зэрэг түвшинд алдагдсан, 23.0 хувь нь шаардлагатай хэмжээний хоол хүнс байхгүй буюу баталгаат байдал нь “ноцтой” алдагдсан байна.⁴⁴

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас хүнсний хангамжийн тогтвортой байдалд эрсдэл бий болж байна. Тухайлбал, тээвэр, логистикийн хүндрэлээс шалтгаалан дэлхий нийтэд хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардал 40.0-60.0 хувиар, өнгөрсөн оны байдлаар хүнсний үнэ дунджаар 28.1 хувиар өсөж, импортын гол нэрийн хүнсний татан авалт 2-3 дахин буурч, зарим түүхий эдийн нийлүүлэлт тасалдаж, хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 13.4 хувиар өссөн байна.

Хүнсний салбарт гол тулгамдсан асуудал нь дотоодын хангамж хангалтгүй, олон улсын стандарт шаардлага хангасан үйлдвэрлэл сул, малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт доогуур байгаагаас гадна хүнсний аюулгүй байдлын эрсдэл өндөр хэвээр байна. 2024 онд нийт өрхийн 65 хувь нь хүнсний баталгаат байдал алдагдсан, үүнээс 23 хувь нь ноцтой түвшинд хүнсний хомсдолд орсон нь хүнсний хүртээмж, чанарын асуудлыг илтгэж байна. Мөн хүнсний нэмэлт, транс тосыг шинжлэх чадамжтай лаборатори байхгүй байгаа нь чанарын хяналтын тогтолцооны сул тал бөгөөд олон улсын стандартын шаардлагыг хангах боломжийг хязгаарлаж байна. Иймд дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах лабораторийн чадавхыг сайжруулах, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хүнс үйлдвэрлэл, үйлчилгээний бүх шатанд мөшгөх тогтолцоо, зохистой дадлыг нэвтрүүлэх замаар хүнсний аюулгүй байдлыг сайжруулахаар зорьж байна. Хүнсний аюулгүй байдлын индекс 2021 оны байдлаар 53.5 хувьтай байгаа бол хүнсний аюулгүй байдлыг сайжруулж 80.25 хувьд хүргэнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновац нэвтрүүлэлтийг дэмжиж хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хангамжийн түвшин 2024 онд 77.3 хувь байгааг 2030 онд 79.8 хувьд хүргэхээр зорьж байна. Үүний тулд тээвэрлэлт, хадгалалтын сүлжээг өргөжүүлэх замаар олон улсын стандарт, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн үйлдвэрийн тоог 2030 онд 58 буюу 25-р нэмэгдүүлнэ. Мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон санаачилгыг дэмжиж малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг 70.0 хувьд буюу 3.5 дахин нэмэгдүүлнэ.

⁴³ ҮСХ, Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд, 2024

⁴⁴ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Импортын хүнсний бүтээгдэхүүний баримт бичгийн бүрдэл, шошгололт, тээвэрлэлтийн хяналтыг сайжруулж чанар, аюулгүйн баталгаатай импортын хүнсний бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлнэ. Хэрэглэгчийн хяналтыг дэмжих замаар импортын хүнсний шошгололтын шаардлага хангалтыг нэмэгдүүлнэ. Мөн мэдээллийн ил тод байдал, цахим хяналтыг дэмжиж импортын гол нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн шаардлага хангалтыг нэмэгдүүлэхээр зорьж байна.

3.2.7. Орчны эрсдэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан байдаг.

Орчны эрсдэлийн түвшнийг тогтвортой хөгжлийн 16 дугаар зорилтын шалгуур үзүүлэлтийн нэг болох амьдардаг орчиндоо шөнийн цагаар ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь (15, түүнээс дээш насны хүн ам)-аар хэмждэг бөгөөд тус үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр авч үзвэл 2020 онд 64.0 хувь байсан бол 2024 онд 61.2 хувь буюу 2.8 нэгж хувиар буурсан байна. Энэ нь гэмт хэрэг, хүчирхийлэл, нийгмийн тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлс нэмэгдэж байгааг илтгэж байна. (Хүснэгт 29-д харуулав.)

Хүснэгт 29. Амьдардаг орчиндоо шөнийн цагаар ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь (15, түүнээс дээш насны хүн ам)

Он	2020	2021	2022	2023	2024
Амьдардаг орчиндоо шөнийн цагаар ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн ам	64.0	66.3	70.6	58.9	61.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Амьдардаг орчиндоо шөнийн цагаар ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь 2020 онд 64.0 байсан бол 2024 онд 61.2 болж 2.8 хувиар буурсан байна. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн тайлангаар Монгол Улсын хүн амын гуравны нэг орчим нь, голдуу 15-аас дээш насныхан шөнийн цагаар амьдардаг орчиндоо ганцаар алхаж явахдаа аюулгүй байдлыг мэдэрдэггүй гэж үзсэн.⁴⁵ Олон нийтийн газар өөрийгөө аюулгүй гэж мэдэрдэггүй байх нь хүний сайн сайхан аж байдлын мэдрэмжийг үндсэнд нь доройтуулж, итгэлцэл, олон нийтийн оролцоог бууруулж, хөгжилд саад болдог.

Инженерийн дэд бүтэцтэй сууц: Сүүлийн хорин жилийн хугацаанд Монгол Улсад хотжилт эрчимтэй явагдаж, ялангуяа Улаанбаатар болон томоохон хотуудад орон сууцжих үйл явц идэвхэжсэн байна. Энэ өсөлтийн хажуугаар гэр хороолол тэлж, одоогийн байдлаар нийт хот, суурин газарт амьдарч буй хүн амын 50.0 орчим хувийг хамарч байна. Эдгээр гэр хорооллууд нь хөдөөгөөс хот руу шилжин суурьшигчдын үндсэн суурьшлын хэлбэр болдог хэдий ч ядуурлын түвшин өндөр, чанаргүй барилга, дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг олон асуудлыг дагуулж, улмаар агаар, хөрсний бохирдол, амьдралын чанар муу байх зэрэг сөрөг үр дүнд хүргэж байна.⁴⁶

Монгол Улсын хэмжээнд 2025 оны хагас жилийн байдлаар нийт 11,414 айлын орон сууц ашиглалтад орсноос 7,964 буюу 69.8 хувь нь нийслэл хотод ашиглалтад орсон байна.

Инженерийн дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байгаа нь иргэдийн амьдрах орчны чанар, эрүүл ахуйн эрсдэл, халдварт болон халдварт бус өвчин, аюулгүй байдал, нийгмийн үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлдөг байна. Нийтийн аж ахуйн салбар нь хэрэглэгчдийг баталгаат ундны усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэршүүлэн байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, иргэдийн

⁴⁵ Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн тайлан

⁴⁶ Дэлхийн банк. 2024. Монголын гэр хорооллыг дахин төсөөлөх нь: Ногоон, гамшигт тэсвэртэй, орлогод нийцсэн орон сууцны загвар.

ая тухтай амьдралын нөхцөлийг бүрдүүлэх нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатай Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурь салбарын нэг юм.

Тус салбарт нийт 223 байгууллага, аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нийтийн орон сууцны зориулалттай 7,000 гаруй барилгын ашиглалтын үйл ажиллагааг хариуцаж, жилдээ 176.5 сая.м³ ус олборлон 3,773 км урттай шугамаар түгээж, хэрэглээнээс гарсан бохир усыг 1,875 км урттай шугамаар татан зайлуулж, цэвэршүүлэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд гэр хорооллын хүн амыг ундны усаар хангадаг ус түгээх 1,546 байртай ба үүнээс 111 буюу 7.2 хувь нь гүний усаар, 662 буюу 42.8 хувь нь зөөврийн, 773 буюу 50.0 хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдон байна. Орон сууцны ашиглалт, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөл эзэмшигчид 713.2 мянган хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байгаагаас 678.8 (95.2%) мянга нь айл өрх, 34.4 (4.8%) мянга нь аж ахуйн нэгж, байгууллага байна.⁴⁷

Гэр хорооллын хүн амын ундны усыг улсын хэмжээнд 1,525 ус түгээх байраар хангаж байгаа бөгөөд үүнээс 767 буюу 50.3 хувь нь ус хангамжийн төвлөрсөн шугамд холбогдсон, 657 буюу 43.1 хувь нь зөөврийн, 101 буюу 6.6 хувь нь гүний худагтай байна.

Ундны усны хүртээмж, бохир усны цэвэрлэгээ, инженерийн шугам сүлжээний шинэчлэлт хангалтгүй байгаагаас үүдэн иргэдийн эрүүл ахуй, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Орлогод нийцсэн орон сууц: Орлогод нийцсэн орон сууц гэдэг нь маш багаас дунд хүртэлх түвшний орлоготой өрхүүдийн хэрэгцээ шаардлагад тохирсон орон сууцаар хангах тогтолцоо бөгөөд үнийн хувьд өрхүүд бусад суурь хэрэгцээгээ хангах боломжийг олгохуйц үнэтэй (хөнгөлөлттэй) байхыг хэлдэг.⁴⁸

Манай улсын нийт 996,911 өрхийн 40 орчим хувь буюу 398.8 өрх нь инженерийн дэд бүтцийн шаардлага хангасан орон сууцанд амьдардаг бол 21.7 хувь буюу 216,2 өрх нь инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжгүй байшин хороололд, 38.2 хувь буюу 380.8 нь гэр сууцанд тус тус амьдарч байна.

Монгол Улсын хэмжээнд 2020-2024 онд нийт 95,304 айлын орон сууц ашиглалтад орсон бол үүний 75,661 (79.3%) айлын орон сууц нийслэл хотод, 19,643 (20.7%) нь орон нутагт ашиглалтад орсон байна.

Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл болон Засгийн газрын 2013 оны 135 дугаар тогтоолын хүрээнд 2013 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг Засгийн газар, Монголбанктай байгуулж, иргэдийг орон сууц худалдаж авахад зориулан олгох орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлж эхлүүлсэн байна. Хөтөлбөр эхэлснээс хойш 2024 оны байдлаар Засгийн газар, Монголбанк, арилжааны банкнуудын эх үүсвэрээр 10.1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийг нийт 139.0 мянган иргэнд олгосон бөгөөд хөтөлбөр хэрэгжих хугацаанд ипотекийн зээлийн санхүүжилтийн хэмжээтэй шууд хамааралтайгаар ашиглалтад орсон орон сууцны тоо нэмэгдэх эерэг хандлагаас гадна эрэлтээс хамаарсан орон сууцны үнийн өсөлтийг үзүүлсээр ирсэн байна. (График 20-д харуулав)

⁴⁷ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

⁴⁸ Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл-2018

График 20. Ипотекийн зээл



Эх сурвалж: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын байдлаар 794.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 6,274 зээлдэгчид олгосон. Хөдөө, орон нутагт олгох 3.0 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөр 2023 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл нийт 4,424 иргэний 477.0 тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлээд байна. Тус үйл ажиллагааны хүрээнд 2020 онд 5,594, 2021 онд 13,292 иргэн, 2022 онд 7,847 иргэн, 2023 онд 8,889, 2024 онд 12,150 өрхийг тус тус хамааруулсан.⁴⁹

Орон сууцны банкны тогтолцоо гэдэг нь банк нь өөрийн эх үүсвэр дээр үндэслэн зээл олгож, зээлээ барьцаалан үнэт цаас гаргах замаар нэмэлт эх үүсвэр татдаг.⁵⁰

Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар орон сууцны санхүүжилтийн тусгайлсан банк байгуулах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон сууцны урт хугацааны санхүүжилтийн тогтолцоог бий болгох, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулсан. Уг банкныг төр, хувийн хэвшил хамтарч байгуулах бөгөөд олон улсын санхүүгийн байгууллагыг оролцуулахаар төлөвлөж байна. Орон сууцны төрөлжсөн банк байгуулснаар орон сууцны санхүүжилтийн дэд бүтэц бүрдэж, арилжааны банкнаас энэ төрлийн зээлд олгогдох хүү буурах ач холбогдолтой юм.

Иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах, үр бүтээмжтэй ажиллаж, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь орон сууцжуулах, өрхийн орлого, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, хөдөө, орон нутагт шилжихэд анхаарах шаардлагатай байна.

Гэр хорооллын өрхүүд орлогын түвшин, эрхэлдэг ажил, сууцны хэрэгцээ ялгаатай учраас орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн зах зээлд үүсэж буй орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг тооцох тогтолцоо дутагдалтай байна.

Барилгын материал: Барилгын материалын үйлдвэрлэл нь барилга угсралтын хурд, хэрэгцээ шаардлагаас хоцорч байгаагаас нийт хэрэгцээнийхээ 62.8 хувийг импортоор авч, импортын материал, тоног төхөөрөмжид олон сая доллар зарцуулж байгаа тул бүтээн байгуулалтын үндэс суурийг бэхжүүлж, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг зөв зохистой дэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж 2021 онд 5.1 их наяд, 2022 онд 6.8 их наяд, 2023 онд 8.0 их наяд, 2024 онд 9.2 их наяд төгрөгийн ажил хийгдсэн бол 2025 оны хагас жилийн байдлаар 5.0 их наяд төгрөгийн барилга угсралтын ажил хийгдсэн байна.

⁴⁹ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

⁵⁰ Монголбанк, Орон сууцны зээлийн тогтолцоо судалгааны ажил, 2017

Барилга байгууламжийн нийт төсөвт өртгийн 45.0-55.0 орчим хувь нь барилгын материалын зардал эзэлдэг бөгөөд энэ нь жилд ойролцоогоор 4.0-5.1 их наяд төгрөгийн барилгын материал Монгол Улсын барилгын зах зээл дээр ашиглагдсан байна.⁵¹

Импортоор орж ирж буй гол нэр төрөл (21 төрөл)-ийн барилгын материалын судалгаанаас үзэхэд 2019 онд 1.1 их наяд төгрөгийн барилгын материал импортолж байсан бол 2024 онд 2.3 их наяд төгрөгийн үндсэн нэрийн барилгын материалыг импортоор авсан байна.

Жил бүрийн өсөн нэмэгдэж буй барилга, орон сууцны өсөлттэй харьцуулан судалж үзэхэд 2025 онд гол нэрийн импортын барилгын материалын хэрэглээ 2.6 их наяд төгрөгт хүрч өсөхөөр байна.⁵²

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хөгжиж байгаа барилгын материалын үйлдвэрлэлд эрчим хүч, дулаан, цахилгааны үнэ өндөр, түүхий эдийн зардал их байгаагийн зэрэгцээ татвар, тариф, зээлийн хүү, төгрөгийн ханшны уналтаас шалтгаалан техник, технологийн шинэчлэл хийж чадахгүй байгаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Нийтийн эзэмшлийн талбай: Хотын төвийн бүсэд газар ашиглалт эрчимтэй явагдаж, орон сууцны хорооллын талбай тэлэхийн хэрээр ногоон бүсүүд шахагдах, буурах хандлага ажиглагдаж байна. Хэрэв энэ чиг хандлага үргэлжилбэл 2030 он гэхэд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 4-5 м² хүртэл буурах эрсдэлтэй байна. Энэ нь НҮБ-ын “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн (2016-2036 он) хүрээнд тогтоосон 10-15 м²/хүн-ээр тогтоосон олон улсын жишгээс үлэмж доогуур түвшин юм. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 2024 оны байдлаар 5.1 м² байна. “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний суурь судалгаанд дурдсанаар Нийслэлийн төвийн зургаан дүүргийн нягтрал өндөр буюу нийт хүн амын 95.0 хувь нь төвлөрч байна. Хотын дэд бүтцийн даац хэтэрч, ногоон бүсийн 30.0 хувьд зориулалт өөрчлөгдөж, барилгажилт явагджээ⁵³.

Хотжилт, хүн амын төвлөрөл, барилгажилт болон ногоон байгууламжийн төлөвлөлт, хамгаалалтын хууль, эрх зүйн хэрэгжилт сул, санхүүжилт ба дэмжлэгийн тогтолцоо дутмаг, хувийн хэвшлийн оролцоо хангалтгүйгээс шалтгаалан нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ олон улсын жишгийн доод түвшнээс 2-3 дахин бага байна. Газар ашиглалтын төлөвлөлт хангалтгүй, орон нутгийн түвшинд хөрөнгө оруулалт ба хяналтын механизм сул, агаар, хөрсний бохирдол, усны хомсдол зэрэг байгаль орчны хүчин зүйлс ногоон байгууламжийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Үерийн эрсдэл: Үер бол хүний амь нас, эд хөрөнгөнд хамгийн их хохирол учруулдаг байгалийн гамшиг. Аадар борооны үер гэнэтийн бөгөөд хүчтэйгээр үүсэж иргэдийн амь нас, эд хөрөнгөд хамгийн аюул, хохирол учруулдаг. Цасны хайлалтаас үүсэх шар усны үер харьцангуй удаан үүсдэг ч их хэмжээний цас хурдан хайлснаар гол мөрөн, дэд бүтцийг даван гарч, ноцтой хохирол учруулж болдог.⁵⁴ Үргэлжлэн удаан хугацаанд орсон борооны үер нь гол мөрөн халих үед үүсдэг ба томоохон талбайг хамарч, хор хохирол ихтэй байдаг. Эдгээр үер нь өөр өөр шинж чанартай боловч урьдчилан сэрэмжлүүлэг, хамгаалалт бэлтгэлгүй тохиолдолд хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой эрсдэл учруулах эрсдэлтэй юм.

“Инженерийн бэлтгэл ажил”-ыг төлөвлөхдөө холбогдох барилгын норм, нормативын баримт бичигт заасан судалгаа, тооцооллыг хийж төлөвлөдөг бөгөөд

⁵¹ Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Барилга угсралт, их засварын ажил”-ын статистик мэдээллээс улсын хэмжээнд гүйцэтгэсэн барилгын ажлын хэмжээг авч, тооцоолсон. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

⁵² Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

⁵³ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

⁵⁴ Уур амьсгалын үйлчилгээний систем

үерийн хамгаалалтын барилга байгууламжийг хот, суурины төлөвлөлтийн баримт бичигт нарийвчлан тусгадаг. Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хүрээнд 2021-2024 онд 21 аймагт нийт 10 байршилд 37,817м², нийслэлд 5 байршилд 6,143 м² үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлыг бүрэн дуусаж ашиглалтад орсон. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 36,9 км үерийн барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна. Нийт улсын хэмжээнд 2024 оны байдлаар 519.4 км урт үерийн хамгаалалтын барилга байгууламж байна.

Үерийн хамгаалалтын барилга байгууламж нь бусад барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн адил тодорхой ашиг өгдөггүй мэт боловч хот сууриныг гамшигт тэсвэртэй байх, хүн амыг аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг, гамшгийн улмаас үүсэх хохирол, зардлыг багасгаж ашиг өгдөг онцгой төрлийн барилга байгууламж юм.

Барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг төлөвлөх, тухайн барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа үерийн аюулын зураглал, үерийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх, экспертийн дүгнэлт гаргуулдаггүйгээс үүдэн тухайн хот, суурин газар нь үерт автах, тухайн барилга байгууламжийг барьж байгуулахаас хэд дахин илүү зардал гарах мөн хүний амь нас эрсдэх, эд хөрөнгийн хохирол зэрэг асуудлууд үүсдэг тул шар ус, уруйн болон голын үерээс үүдэлтэй хохирлыг бууруулах, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гамшгийн эрсдэл: Гамшгийн төрөл, давтамж, түүнээс учрах хохирлын хэмжээ, өртөж буй хүн ам, нийгэм эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө жилээс жилд нэмэгдсээр байгаа нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэхийг шаардаж байна. (Хүснэгт 30-д харуулав)

Хүснэгт 30. Гамшгийн улмаас учирсан хохирол

Үзүүлэлт	2020	2021	2021	2022	2023	2024
100,000 хүнд ногдох гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон, гамшигт шууд нэрвэгдсэн хүний тоо	79.2	79.2	129.2	174.9	269.10	193.2
Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь	0.08	0.08	0.06	0.07	0.08	0.05

Эх сурвалж: ШСАА (Бүсчилсэн хөгжлийн асуудал хариуцсан)

Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь 2020 онд 0.08 байсан бол 2024 онд 0.05 болж буурсан байна. Харин 100,000 хүнд ногдох гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон, гамшигт шууд нэрвэгдсэн хүний тоо 2020 онд 79.2 байсан бол 2024 онд 193.2 буюу 2.4 дахин нэмэгдсэн байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүсчилсэн хэлбэрээр, 21 аймаг, нийслэл, сум, дүүрэгт Онцгой байдлын байгууллагын салбар нэгжтэйгээр зохион байгуулж байна. Гамшгаас хамгаалах чиглэлээр бүх салбарын бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах, гамшгаас хамгаалах тогтолцооны илүү сайн бэхэжсэн, үр дүнтэй байдлыг хангахын тулд орон нутгийн түвшинд санал санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

Жил бүр ой, түймэр, үер усны аюул, ган, зуд, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн аюулт үзэгдлээс шалтгаалан жилд дунджаар 200 гаруй хүн амь насаа алдаж, улсад 40.9 тэрбум төгрөгийн хохирол учирч байна. (Хүснэгт 31-д харуулав)

Хүснэгт 31. Улсын хэмжээнд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Гамшигт нэрвэгдсэн хүн	0	151,689	285,840	12,466	8,777
Сураггүй болсон хүн	0	10	9	12	8

Нас барсан хүн	248	1,980	401	321	336
Учирсан хохирол, сая.төгрөг	31,317.5	25,990.7	33,233.9	52,058.8	40,881.1

Эх сурвалж: ОБЕГ-ын статистик

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн доройтол, хүн амын хэт төвлөрөл зэргээс шалтгаалан гамшгийн аюул, учруулах хохирол жилээс жилд нэмэгдэж байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавх бэхжээгүй байна. Эрт сэрэмжлүүлэх мэдээлэл дамжуулах чадамж 2024 онд 30.0 хувьтай байна. Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангалт мөн хангалтгүй буюу техник хангамж 2024 онд 54.0 хувьтай байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн идэвх оролцоо сул, мэдлэг бага, нийслэл, аймаг, сум, дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн чадавх харилцан адилгүй байгаа нь томоохон хэмжээний гамшиг тохиолдсон үед хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэхээр байна.⁵⁵

Зам тээврийн осол: Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 97.2 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс, 2.5 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 0.4 хувь нь замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан гэж бүртгэгджээ.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол өмнөх оноос 22.5 хувь, явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 32.0 хувь, замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол 13.2 хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт 32-т харуулав.)

Хүснэгт 32. Зам тээврийн ослын хэлбэр

дд	Ослын хэлбэр	Тоо	Хувь
1	Онхолдох	1,123	3.6
2	Мөргөлдөх	25,468	82.2
3	Явган зорчигч мөргөх	2,297	7.4
4	Дугуйтай зорчигч мөргөх	228	0.7
5	Үл хөдлөх зүйл мөргөх	1,367	4.4
6	Зорчигч унагах	55	0.2
7	Мал, амьтан мөргөх	344	1.1
8	Бусад	95	0.3

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн алба, статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2024

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар хөдөлгөөнд оролцохдоо анхаарал, болгоомжгүй, гарц, гарамтай хэсгээр зам хөндлөн гарах, асран хамгаалагчгүй оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн хөндлөн гүйх, замын хөдөлгөөний мэдлэг дутмаг, жолоочийн хариуцлагагүй үйлдлийн улмаас шалтгаалан осолд ихээр өртөж байна.

Хүснэгт 33. Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)

Хэмжих нэгж	2020	2021	2021	2022	2023	2024
Просантимиль	15.1	14.3	13.8	15.1	14.3	15.4

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн алба, статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2024

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)-ийг авч үзвэл 2020 онд 15.1 байсан бол 2024 онд 15.4 болж өссөн байна. (Хүснэгт 33-д харуулав)

Зам тээврийн осол, гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэндээр хохирсон 4,493 тохиолдол бүртгэгджээ. Улсын хэмжээнд 2024 онд зам тээврийн 548 ослын улмаас 631 хүний амь нас хохирсны 500 буюу 79.2 хувь нь орон нутгийн замд, 131 буюу 20.8 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна. Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон хүний тоон үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад улсын хэмжээнд 14.5 хувиар,

⁵⁵ Онцгой байдлын алба 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

орон нутагт 11.1 хувиар, нийслэлд 29.7 хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт 34-т харуулав)

Хүснэгт 34. Зам тээврийн осол, гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэндээр хохирсон тохиолдол

Өртсөн хүн			Амь насаа алдсан хүн		Гэмтэж бэртсэн хүн			
Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг
4,493	2,946	1,547	631	131	500	3,862	2,815	1,047

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн алба, статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2024

Хүүхэд өртсөн зам тээврийн ослын үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад улсын хэмжээнд 45.4 хувиар, нийслэлд 78.0 хувиар, орон нутагт 4.0 хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт 35-д харуулав)

Хүснэгт 35. Осол, нас баралт

Хүүхэд өртсөн зам тээврийн осол	Нийт хохирсон хүүхэд	Үүнээс	
		Амь нас хохирсон хүүхэд	Гэмтэж бэртсэн хүүхэд
Улсын хэмжээнд			
1,230	1,377	69	1,308
Нийслэлд			
842	927	11	916
Орон нутаг			
388	450	58	392

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн алба, статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2024

Улсын хэмжээнд 30,977 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өсжээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт зам тээврийн ослын 27,264 буюу 88. хувь нь эд материалын хохиролтой, 371 буюу 12.0 хувь нь хүн гэмтсэн осол байна. Хүн гэмтсэн зам тээврийн осол өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар, эд материалын хохиролтой зам тээврийн осол 26.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.⁵⁶

Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл 25,488 буюу 82.3 хувь нь суудлын, 2,923 буюу 9.4 хувь нь ачааны, 992 буюу 3.2 хувь нь автобус, 39 буюу 0.1 хувь нь механизм, 598 буюу 1.9 хувь нь мотоцикл, 174 буюу 0.6 хувь нь унадаг дугуй, 445 буюу 1.4 хувь нь микро автобус, 64 буюу 0.2 хувь нь скүтер, 159 буюу 0.5 хувь нь суррон, 95 буюу 0.3 хувийг тусгай дуут дохиот тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Мөн зам тээврийн осолд холбогдсон 29,982 автомашины 22,313 буюу 74.4 хувь нь баруун (буруу) 7,669 буюу 25.6 хувь нь зүүн (зөв) талдаа жолооны хүрдтэй автомашин эзэлж байгаа бол 74.5 хувь нь үйлдвэрлэгдсэнээс хойш 11-ээс дээш жил буюу ашиглалт өндөр автомашин эзэлж байна. (Хүснэгт 36-д харуулав)

Хүснэгт 36. Зам тээврийн осолд холбогдсон автомашины ашиглалтын хугацаа

Дд	Ашиглалтын хугацаа	Үйлдвэрлэсэн он	Тоо	Хувь
1	0-5 жил	2019-2024	2,096	7
2	6-10 жил	2014-2018	5,549	18.5
3	11-15 жил	2009-2013	13,893	46.3
4	16-20 жил	2004-2008	6,222	20.8
5	21-ээс дээш жил	2003-с дээш	2,222	7.4

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн алба, статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2024

Зам тээврийн осол нь иргэдийн анхаарал болгоомжгүй байдал, замын хөдөлгөөний мэдлэг дутмаг, бага насны хүүхдүүд асран хамгаалагчгүйгээр хөдөлгөөнд оролцох, жолоочийн хариуцлагагүй үйлдэл, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, замын тэмдэг тэмдэглэгээ дутмаг, шөнийн гэрэлтүүлэг хангалтгүй, замын хөдөлгөөний

⁵⁶ Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэргэ, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2024

зохион байгуулалт сул зэрэг олон хүчин зүйлсийн улмаас осол нэмэгдэж, зам тээврийн ослын шалтгаант нас баралт буурахгүй байна.

Орчны эрсдэл өндөр байгаагийн гол шалтгаан нь инженерийн дэд бүтцийн хүртээмж хангалтгүй, үер усны гамшигт өртөх эрсдэлтэй бүс нутагт олон өрх амьдарч байгаатай холбоотой байна. 2024 онд нийт өрхийн ердөө 38.6 хувь нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байгаа нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Үүнээс гадна шар ус, голын үер, уруйн гамшиг, зам тээврийн ослын шалтгаант нас баралт буурахгүй байгаа нь орчны аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Иймд дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр бодлого, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Цаашид эрсдэлийн менежментийг сайжруулах замаар орчны эрсдэлийн түвшнийг бууруулж, амьдардаг орчиндоо шөнийн цагаар ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь (15, түүнээс дээш насны хүн ам)-ийг 2030 онд 73 хувьд хүргэхээр зорьж байна. Үүний тулд нэгдсэн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлж инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийг 40.4 хувьд хүргэнэ. Мөн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 69.6 байгаа бол 2030 онд 75 хувь буюу 5.4 нэгж хувиар нэмэгдүүлнэ. Орлогод нийцсэн хөтөлбөрт хамрагдсан өрх 2024 онд 12,150 байгаа бол 2030 онд 68,650 болгож нэмэгдүүлнэ.

Түгээмэл загвар гэх ойлголт нь өргөн хүрээг хамардаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хөгжлийн бэрхшээлгүй иргэнд зориулж ямар нэгэн зүйлийг тусад нь хийх бус аль алиных нь хэрэгцээ шаардлагад нийцсэн нэгдмэл байдлаар хийхийг хэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.4-т "түгээмэл загвар" гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;" гэж тодорхойлсон байдаг. Иймд түгээмэл загварыг ашиглах замаар орчны саадыг бууруулна. Барилгын материалын үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж импортыг орлох барилгын материалын үйлдвэрийг нэмэгдүүлнэ. Мөн нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламжид 20 минутын дотор хүрэх боломжийг нэмэгдүүлэх замаар нийтийн эзэмшлийн талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Инженерийн байгууламж, зохистой төлөвлөлт, эрт сэрэмжлүүлэг, иргэдийн оролцоог хослуулан хэрэгжүүлж үерийн эрсдэлийн түвшин (маш их, их эрсдэлтэй сумдын түвшин)-ийг 0.9 хувьд хүргэж бууруулна. Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн уртыг 50.0 км-ээр нэмэгдүүлж 569.4 км-т хүргэхээр зорьж байна.

Олон талт оролцоог хангаж гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувийг 2030 онд 0.038 хувь болгож бууруулна. Мөн 100,000 хүнд ногдох гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон, гамшигт шууд нэрвэгдсэн хүний тоог 119.2 хүргэнэ. Эрт сэрэмжлүүлэх мэдээлэл дамжуулах чадамжийг 45.0 хувиар өсгөж 75.0 хувьд, техник хангамжийн хувийг 81.0 хувьд тус тус хүргэнэ.

Аюулгүй тайван амьдрах орчныг бий болгоход замын осол ихээхэн нөлөөтэй байдаг. Замын хөдөлгөөний дүрэм, хяналтыг сайжруулах замаар зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)-ийг 2030 онд 8.3 буюу 1.8 дахин бууруулна. Хариуцлагыг сайжруулах замаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулна. Ингэснээр бүртгэгдсэн зам, тээврийн ослын тоо 2024 онд 30,997 байгаа бол 2030 онд 23,740 болгож буурна.

3.3. ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” хэмээн заасан байдаг.

Монгол Улсын нийт эдийн засгийн 93.0 хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг. Уул уурхай дотроо нүүрс дангаараа 60.0 хувийг эзэлж байгаа ба уул уурхайн салбараас хэт хамааралтай тул дэлхийн зах зээлийн түүхий эдийн хэлбэлзлээс өндөр хамаарч, макро тогтворгүй байдал өндөр байна.

Эдийн засгийн өсөлт цар тахлын улмаас 2020 онд 4.4 хувиар агшаад байсан бол 2021 онд ердөө 1.4 хувиар л өсөж сэргэсэн бол 2024 онд 5.1 хувьд хүрч өссөн байна. Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулсан байна.

Уул уурхайн салбар дахь зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаар эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны мөн үеэс саарч 1.1 хувьд хязгаарлагдлаа. Тухайлбал, нүүрс олборлолт 43.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 11 хувиар, төмрийн хүдэр, баяжмал үйлдвэрлэл 4.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар тус тус буурлаа. (Хүснэгт 37-д ДНБ-ний өсөлтийн бүтцийг салбаруудаар харуулав.)

Хүснэгт 37. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь)

Салбар	2021	2022	2023	2024
ДНБ	1.6	5.0	7.4	5.1
ХАА	-0.8	1.7	-1.3	-3.6
Үйлдвэрлэл	-0.6	-1.2	3.2	1.6
Уул уурхай	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах	-0.1	0.5	0.4	-0.3
Цахилгаан, ус	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.9	0.2	0.1	0.4
Үйлчилгээ	1.8	3.2	4.7	5.4
Худалдаа	0.6	1.1	0.8	1.4
Тээвэр	-0.3	0.4	1.8	1.0
Бусад	1.5	1.7	2.1	2.5
Цэвэр татвар	1.3	1.4	0.8	1.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 80 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар, бодит дүнгээр 32 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.9 хувиар тус тус өслөө.

Нэг хүнд ногдох ДНБ-ийг авч үзвэл 2020 онд 4,128.0 ам доллар байсан 2024 онд 6,898.0 ам доллар буюу 1.7 дахин нэмэгдсэн байна. (Хүснэгт 38-д нэг хүнд ногдох ДНБ-ийг харуулав.)

Хүснэгт 38. Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)

Он	2020	2021	2022	2023	2024
Ам.доллар	4,128.0	4,657.0	5,126.0	6,008.0	6,898.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн бус салбарын өсөлт 2025 оны эхний хагас жилд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн голлох нөлөөгөөр эрчимжиж, 6.3 хувьд хүрлээ. Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн тоо толгой 20.8 саяд хүрч (төл бойжилт 98.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 189 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсан голлох нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар 36 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 3.6 нэгж хувийг бүрдүүллээ.

Эдгээр нь эдийн засгийг төрөлжүүлж, уул уурхайгаас хамаарал багатай, тогтвортой өсөлттэй бүтэц рүү шилжих шаардлагатайг харуулж байна.

Эдийн засгийн төрөлжилтөд боловсруулах үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, санхүү, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон инновацыг дэмжих замаар дотоод нөөц бололцоог өргөжүүлэх нь нэн чухал юм.

3.3.1. Боловсруулах үйлдвэрлэл

Манай улсын эдийн засаг дах уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдэж байгаа ч боловсруулах үйлдвэрлэлийн хувь хэмжээ алгуур буурч байгаа нь эдийн засгийн төрөлжилт сул байгааг илэрхийлж байна. Иймд боловсруулах салбарт төрөлжилтийг нэмэгдүүлэх чиглэлд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хөрөнгө оруулалт, технологийн таатай орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай тулгараад байна.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2024 оны дунджаар 4.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 74 хувиар, 2015 оны үнээр засварласан дүнгээр 2.3 их наяд төгрөгт хүрч, 21 хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт 39-д боловсруулах салбарын эдийн засгийн үзүүлэлтийг харуулав.)

Хүснэгт 39. Боловсруулах салбарын үзүүлэлт

Эдийн засгийн үзүүлэлт		2006-2010	2011-2015	2016-2020	2021-2024
ДНБ-д эзлэх хувь		8.1	9.5	8.6	7.8
Салбарын ДНБ	Нэрлэсэн ДНБ, их наяд төгрөг	0.41	1.48	2.28	3.97
	Дундаж өсөлт	7.9%	6.8%	7.2%	1.5%
Аж ахуй нэгжид эзлэх хувь	Нийт ААН-д эзлэх хувь	-	7.9%	7.7%	7.5%
	Компани	-	87.4%	90.3%	93.5%
	Нөхөрлөл	-	4.1%	3.1%	1.4%
	Төрийн бус байгууллага	-	0.3%	0.2%	0.1%
	Төсвийн байгууллага	-	0.1%	0.0%	0.0%
	ТӨҮГ, ОНӨҮГ	-	0.4%	0.4%	0.3%
	Хоршоо	-	7.7%	6.0%	4.8%
	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	-	0.0%	0.0%	0.0%
	Бусад	-	0.0%	0.0%	0.0%
Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	ХО-ын дүн	61.7	299.8	557.7	650.7
	Нийт ХО-д эзлэх хувь	2.7	3.4	4.2	2.7
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг	Мөнгөн дүн	335	1,023	1,386	1,858
	Эзлэх хувь	14.2	10.8	8.9	7.0

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Тус салбарын 55 орчим хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ундаа үйлдвэрлэл, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бүрдүүлж байна. Үүнд, тус салбарын 30 орчим хувийг бүрдүүлдэг мах, махан бүтээгдэхүүний 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2024 онд жилд дунджаар 794 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дундаж үйлдвэрлэлээс 20 хувиар тэлж, боловсруулах салбарын өсөлтийг дэмжлээ. Засгийн газар 2023 оны 2 дугаар сард махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалж, 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс "Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-ийг нэвтрүүлснээр махны экспорт эрчимжин түүхэн дээд хэмжээнд хүрч, мах боловсруулах үйлдвэрлэлийн өсөлтөд томоохон нөлөө үзүүллээ. Боловсруулсан малын мах 2021-2024 онд жилд дунджаар 38.7 мянган тонн хүрч, өмнөх таван жилийн дунджаас 1.4 дахин нэмэгдсэн байна. Боловсруулах салбарын 15 орчим хувийг бүрдүүлдэг ундааны (согтууруулах болон согтууруулах бус ундаа) 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэл 2021-2024 онд жилд дунджаар 370 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дундаж үйлдвэрлэлээс 29 хувиар тэлж,

салбарын өсөлтийг дэмжлээ. Мөн цэвэр ус, амтат ус, ундаа, жүүсний 2021-2025 оны жилийн дундаж үйлдвэрлэл 416 сая литр хүрч, өмнөх таван жилийн дунджаас 1.4 дахин, шар айргийн үйлдвэрлэл 97 сая литр хүрч, 1.1 дахин, архи үйлдвэрлэл 27.6 сая литр хүрч 1.1 дахин тус тус өссөн байна. Түүнчлэн, тус салбарын 10 орчим хувийг бүрдүүлдэг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний (цемент, тоосго, шохой, гипс, чулуун тавилга үйлдвэрлэх үйл ажиллагаа зэрэг) 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2024 онд жилд дунджаар 311 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дунджаас 101 хувиар тэлсэн байна. Харин боловсруулах салбарын 5 орчим хувийг бүрдүүлж буй сүү, сүүн бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх таван жилийн дунджаас 0.6 хувиар, 2 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурил, цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2 хувиар, 3 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн үйлдвэрлэл 0.9 хувиар тус тус буурч, өсөлтийг хязгаарлав. Мөн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг эрс нэмэгдүүлэх зорилгоор “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолын хүрээнд “Цагаан алт” хөдөлгөөнийг хэрэгжүүлж, 2024 оны байдлаар нийт 46 аж ахуйн нэгжид 228 тэрбум төгрөгийн эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл олгож, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүний үр дүнд самнасан ноолуурын хэмжээ 2025 оны эхний 9 сард 2.2 мянган тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 4.5 дахин өссөн боловч ноолуурын экспорт 2025 оны эхний 9 сард 199 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурсан байна.

Боловсруулах салбар 2025 оны эхний хагас жилд өмнөх оноос 5.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжлээ. Үүнд барилга угсралт, их засварын ажлын өсөлтийг даган тэлж буй төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл болон зэсийн баяжмал зэрэг металлын хүдэр олборлох үйл ажиллагааны идэвхийг дагасан тэсэрч, дэлбэрэх химийн бодисын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөлөв.

Хөнгөн үйлдвэр: Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын экспортын голлох бүтээгдэхүүнүүд нь ноос, ноолуур, арьс ширэн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн бөгөөд экспортын дийлэнх хувийг нэхмэл, сүлжмэл үйлдвэрлэлийн бэлэн бүтээгдэхүүн болон хагас боловсруулсан түүхий эд эзэлж байгаа бол модон эдлэл, хэвлэл, цаас, картонон бүтээгдэхүүний экспорт маш бага хувийг эзэлж, харин эдгээр нь импортын дийлэнх хувийг эзэлж байна.

Угаасан ноолуурын экспорт 2024 онд 4,775.8 мянган тонн (256.7 сая. ам.доллар) болж өмнөх оноос 12.3 хувиар, самнасан ноолуурын экспорт 707.3 мянган тонн (69.8 сая. ам.доллар) болж өмнөх оноос 29.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь ямааны ноолуурын боловсруулалт, худалдааны явцад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх, техникийн зохицуулалтын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхээс хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор баталсан техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулсан шийдвэрийн нөлөөлжээ.

Арьс, ширний экспортыг авч үзвэл; боловсруулаагүй арьс, шир 2023 онд 1,032.6 мянган ширхэг (2,354.1 сая. ам.доллар) болж өмнөх оноос тоо хэмжээний хувьд 359.4 хувиар, үнийн дүнгийн хувьд 55.1 хувиар өслөө. Харин боловсруулсан арьс, шир 2023 онд 109.5 сая ширхэг (2,758.4 сая. ам.доллар) болж өмнөх оноос тоо хэмжээний хувьд 36.6 хувиар, үнийн дүнгийн хувьд 29.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.(Хүснэгт 40-д хөнгөн үйлдвэрийн салбарын экспорт, импортыг харуулав.)

Хүснэгт 40. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын нийт экспорт, импорт

Барааны төрөл	Экспорт (сая ам.доллар)					Импорт (сая ам.доллар)				
	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН	2024 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН	2024 ОН
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	279.5	370.7	489.7	451.2	404.1	85.8	103.7	133.8	150.7	139.4
Арьс ширэн түүхий эд болон эдгээрээр хийсэн эдлэл	7.4	6.4	5.2	4.7	3.3	5	6.4	9.3	9.5	9.8
Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	1.8	2.2	2.1	3.2	2.4	17.8	24.6	35.1	36.2	39.4
Мод, модон эдлэл	0.3	0.1	0.3	0.3	0.1	43.4	67.3	81.7	79.5	113.1
Цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.04	0.03	0.3	0.1	0.06	58.1	64.3	98.1	78.4	86.4
Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	1.6	1.2	10.2	21.8	13.9	226.8	260.2	345.2	359.6	396.8
Нийт	290.6	380.6	507.8	481.3	423.9	436.9	526.5	703.2	713.9	784.9

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Монгол Улс жилдээ 45.0 мянган тонн орчим хонь, тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр зэрэг малын гаралтай ширхэгт түүхий эд бэлтгэж байгаа ба үүнээс ямааны ноолуур 8.5 мянган тонн орчим. Дэлхийд жилдээ 110 гаран сая тонн химийн болон органик гаралтай бүх текстилийн ширхэгт материалаар хувцас үйлдвэрлэн хэрэглэж байна. Үүний 1.6 хувь нь малын гаралтай ширхэгт материалын бүтээгдэхүүн эзэлж байгаагаас ноолуур 0.017 хувийг л эзэлж байна.

Боловсруулах салбар 2021-2024 онуудад дунджаар 1.5 хувиар өссөн байгаа бөгөөд салбарын 55.0 орчим хувийг 3 нэр төрлийн үйлдвэрлэл бүрдүүлж байна.

Тухайлбал, боловсруулах салбарын 30 орчим хувийг бүрдүүлдэг мах, махан бүтээгдэхүүний 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэл 2021-2024 онд жилд дунджаар 794 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дундаж үйлдвэрлэлээс 6.9 хувиар нэмэгдэж, боловсруулах салбарын өсөлтийг голлон дэмжлээ. Уг өсөлтөд “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны техникийн зохицуулалт” болон импортлогч орноос тавьдаг экспортлох малын махыг үйлдвэрийн аргаар боловсруулах шаардлагын дагуу 2023 оны 02 дугаар сард Засгийн газар махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалсан ба мөн 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэвтрүүлсэн “Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем” нөлөөлөв. Энэхүү систем нь мах экспортлоход шаардагддаг байсан 26 нэр төрлийн 50 гаруй давхардсан баримт бичгийг 15 болгож, зарцуулах хугацаа 316 цаг буюу 13 хоног байсны 96 цаг буюу 4 хоног хүртэл багассанаар мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдийн экспортын гэрчилгээ авахад бүрдүүлдэг баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгаж, цахимаар шийдэх боломжийг бүрдүүллээ.

Эдгээр бодлого, зохицуулалтын нөлөөгөөр боловсруулсан махны үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2024 онуудад жилд дунджаар 38.7 мянган тонн хүрч, өмнөх таван жилийн дунджаас 41 хувиар, махан нөөш 548 тонн хүрч, 125 хувиар, хиаман төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 9.8 мянган тонн хүрч, 79 хувиар тус тус өссөн байна. Харин 2023, 2024 оны зудын нөхцөл байдлаас үүдэн хүнсэнд хэрэглэх малын махны нийлүүлэлт буурч, махны үнэ өсөх эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 01-нийг хүртэл үхрийн махны экспортыг хориглосон.

Манай улс дэлхийн түүхий ноолуурын 40 гаран хувийг бэлтгэх нөөцтэй хэдий ч нэмүү өртөг бүтээх, өндөр ашиг шим хүртэх стратегийн бүтээгдэхүүнээсээ олох боломжит орлогоо алдсаар байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд байгуулсан ноос, ноолуур экспортлох үеийн мал эмнэлэг, ариун цэвэр хорио цээрийн протоколын хүрээнд манай улсаас тус улсад түүхий бус угаасан ноос, ноолуур экспортлох

болсноор манай улс жилд дунджаар 1.2 сая м3 цэвэр усыг ашиглаж, төдий хэмжээний бохир усыг байгаль орчинд гаргаж, дорвитой нэмүү өртөг шингээж чадахгүйгээр нийт түүхий эдийнхээ 70 гаруй хувийг зөвхөн угаагаад тус улсад экспортолсоор байна.

Ноос, ноолуурын боловсруулалтын түвшин харилцан адилгүй байна. Үүнд:

- ✓ Ямааны ноолуурын 70.0 гаруй хувь нь угаасан, 10 орчим хувь нь самнасан, 20 орчим хувь нь бэлэн бүтээгдэхүүн,
- ✓ Тэмээний ноосны 70.0 хувь нь угаасан, 20.0 хувь нь самнасан, 10.0 хувь нь бэлэн бүтээгдэхүүн,
- ✓ Хонины ноосны 75.0 нь хувь угаасан, 25.0 хувь нь бэлэн бүтээгдэхүүн;
- ✓ Сарлагийн хөөвөр 100.0 хувь бэлэн бүтээгдэхүүн болж байна.

Арьс ширэн түүхий эд бэлтгэлийн хувьд манай улс жилдээ 18 сая ширхэг арьс, шир бэлтгэх нөөцтэй хэдий ч өнөөгийн байдлаар арьс ширний нөөцийн 30 хүрэхгүй хувийг үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэж байна. Тухайлбал жилд 3.4 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 1.2 сая ширхэг арьс ширэн гүн боловсруулалт, нийт 4.6 сая ширхэг нь боловсруулагдаж, 13.4 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадахгүй байна. Үүний шалтгаан нь арьс ширэн түүхий эдийн нядалгаа, амьдын үеийн гэмтэл их байхаас гадна анхан шатны боловсруулалт хийдэг жижиг, дунд үйлдвэрүүдийн хүрэлцээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал хангалтгүйд оршиж байна. Түүнчлэн тээвэр логистикийн зардал өндөр, бүтээгдэхүүн тээвэрлэх нөхцөл муу байгаа нь түүхий эдийн үнэлгээг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах зорилгоор хонь, тэмээний ноос, арьс, ширэн түүхий эд бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгож эхлээд 10 гаруй жил болж байгаа хэдий ч түүхий эдийн чанар сайжирч, үнэ цэнэ нь өсөхгүй байгаад дүгнэлт хийж, урамшууллын бодлогыг зөв, оновчтой зүйлд чиглүүлэхээс гадна эрс, тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуйгаа хадгалан үлдсэн манай улсын хувьд өөрийн орны онцлог соёл, монгол малчдын байгаль орчин, мал ахуйгаа хайрлан хамгаалж, уламжлан ирсэн өвөрмөц арга ажиллагааг орчин цагийн органик үйлдвэрлэл, мал, амьтны эрх чөлөөний нийтлэг зарчимтай уялдуулан тэдний шаардлагад нийцсэн үнэ цэнтэй, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлээ тэлэх шаардлагатай байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээ сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал үйлдвэрлэлийн хэмжээ суурь он 2024 онд 2023 оноос 19.0 хувиар буурсан бол 2025 онд 13.0 хувиар буурах урьдчилсан тооцоо гараад байна. Экспортын хэмжээ 2022-оос 2023 онд 5.0 хувь, 2023-аас 2024 онд 13.0 хувиар тус тус буурсан бөгөөд 2025 оны 07 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар буурсан дүнтэй байна.

Хүнд үйлдвэр: Катодын зэсийн үйлдвэрлэлийн биет хэмжээний өсөлтийг авч үзвэл 2020 онд 9,488.3 мянган тонн байсан бол 2024 онд 6,976.3 мянган тонн болж -26.7 хувиар буурсан байна. Энэ нь үйлдвэрлэлийн салбар эдийн засагт эзлэх байр суурь суларч байгааг илтгэж байна. (Хүснэгт 41-д катодын зэсийн үйлдвэрлэлийн хэмжээг харуулав.)

Хүснэгт 41. Катодын зэсийн үйлдвэрлэл

дд	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
1. Боловсруулах үйлдвэр							
1.1. Хүнд үйлдвэр							
	Катодын зэс	мян.тн	9,488.3	9,689.9	9,736.0	9,661.3	6,976.3

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Монголын эдийн засаг уул уурхайд хэт төвлөрсөн, харин боловсруулах үйлдвэрлэл ДНБ-д эзлэх байр сууриа алдсаар байна. Энэ нөхцөл байдал нь эдийн

засгийн төрөлжилтийг хязгаарлаж, гадаад зах зээлээс хамааралтай болгож байна. Мөн боловсруулах хүнд үйлдвэрлэлийн түүхий эдийн хангалт тогтворгүй байна.

Боловсруулах хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж боловсруулах хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж катодын зэсийн үйлдвэрлэлийн биет хэмжээний өсөлт 2024 онд 27.8 хувь байгаа бол 2030 онд 23.3 хувьд хүргэнэ. Мөн түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээг оновчтой болгох замаар боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ. Ингэснээр түүхий эдийн хангалт 4.71 хувь буюу 6 дахин нэмэгдэнэ.

Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд ирэх 5 жил дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ. Ингэснээр салбарын үйлдвэрлэлийн хэмжээг 3,250.0 тэрбум төгрөг хүрнэ. Нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөж малын гаралтай түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, малын гаралтай түүхий эд боловсруулалтын технологийн түвшний өсөлт 55.0 хувь буюу 15.0 нэгж хувиар нэмэгдүүлнэ. Мөн менежментийг сайжруулах замаар хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ. Ингэснээр арьс ширний гүн боловсруулалтыг 3,100 мянган ширхэг, ноолуурын ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг 3,150 тонн, ноолуурын ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 3,150 тонн, ноосны үйлдвэрийн хялгас ялгах хүчин чадал 5,500 тонн, ээрэх үйлдвэр 2,100 тонн мөн сүлжих үйлдвэр 7.7 сая ширхэг, нэхэх үйлдвэр 2.8 сая метрт хүрч нэмэгдэнэ.

3.3.2. Уул уурхай

Уул уурхайн салбар нь эдийн засгийн 93.0 хувийг дангаараа бүрдүүлдэг. Уул уурхайн салбар 2021-2024 онд 26.4 хувьд хүрч, эдийн засгийн бүтцэд эзлэх хэмжээ жил ирэх бүр нэмэгдсээр байна. Уул уурхайн салбар 2025 оны 2 дугаар улиралд 1.1 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 0.1 нэгж хувиар дэмжлээ. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвхжил 2025 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас сайжирсан ч өмнөх оны мөн үеэс доогуур хэвээр байна. Төмрийн хүдрийн үйлдвэрлэл 2025 оны 2 дугаар улирлаас сэргэж, 3.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар өслөө. Оюу толгойн гүний уурхайн олборлолт 2025 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 32 хувиар өсөж, уул уурхайн салбарын өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байна. Харин нүүрс олборлолт 2025 оны эхний хагас жилд 43.7 сая тоннд болж, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буурсан бол газрын тос олборлолт 1.9 сая тонн болж 6 улирал дараалан, алтны олборлолт 4.5 тонн болж 10 улирал дараалан буурч, уул уурхайн салбарын өсөлтийг сааруулав.

Уул уурхайн салбар сүүлийн 20 жилд ДНБ-д эзлэх хувиар тэргүүлж буй бөгөөд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг уул уурхайн салбарт төвлөрч, экспортын орлогын дийлэнхийг бүрдүүлж байна. Салбарын үйлдвэрлэлийн дийлэнх хэсгийг нүүрс, зэс, төмөр болон бусад хүдрийн олборлолт бүрдүүлдэг. Түүнчлэн салбарын нийт үйлдвэрлэлийн 40 орчим хувийг зэсийн баяжмал олборлолт дангаар бүрдүүлдэг бөгөөд Оюутолгой, Эрдэнэт гэсэн хоёрхон том үйлдвэр тус баяжмалыг олборлодог. Уул уурхайн салбар нь 2006-2010 онд ДНБ-ий 23.7 хувийг бүрдүүлж байсан бол 2016-2020 онд 24.6 хувь болж өсөж, 2021-2024 онд 26.4 хувьд хүрч, эдийн засгийн бүтцэд эзлэх хэмжээ жил ирэх бүр нэмэгдсээр байна. 2021-2024 онд ийнхүү нэмэгдэхэд "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд гааль, татварын автомат бүрдүүлэлтийн системийг нэвтрүүлж, ашигт малтмалын гэрээг бүртгэлжүүлж, хил холболт, тээвэр, логистикийн зохион байгуулалт сайжирснаар, экспортын хүчин чадал тэлж, уул уурхай, тээврийн салбарын өсөлтийг голлон дэмжсэн байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ⁵⁷ 2021-2024 оны дунджаар 16.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 110 хувиар өсөж, 2015 үнээр засварласан дүнгээр 3.7 их наяд төгрөг болж, өмнөх таван жилээс 5.8 хувиар буурсан байна. “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд гааль, татварын автомат бүрдүүлэлтийн системийг нэвтрүүлж, ашигт малтмалын гэрээг бүртгэлжүүлж, хил холболт, тээвэр, логистикийн зохион байгуулалт сайжирснаар, экспортын хүчин чадал тэлж, уул уурхай, тээврийн салбарын өсөлтийг голлон дэмжлээ. Нүүрс олборлолтын хэмжээ 2023 онд 85.3 сая тонн хүрч өмнөх оноос 2.3 дахин нэмэгдсэн бол нүүрсний экспортын орлого 8.9 тэрбум ам долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өсөж, нийт экспортын 58 хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Түүнчлэн тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2022 онд төмөр замын тарифт өөрчлөлт оруулж, салбарыг үе шаттай либералчлах замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээ. Жишээлбэл, УБТЗ ХНН-ийн дотоодын ачаа тээврийн 16, зорчигч тээврийн 2 бүлгийн үнэ, тарифыг өөрчилж, БНХАУ-ОХУ чиглэлийн чингэлэг тээвэрлэлтэд олгож буй дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн нэгдсэн нэвтрэх тарифын хөнгөлөлтийг 61 хувиас 51 хувь болгон бууруулав. (Хүснэгт 42-т уул уурхайн салбарын эдийн засгийн үзүүлэлтийг харуулав.)

Хүснэгт 42. Уул уурхайн салбарын эдийн засгийн үзүүлэлт

Эдийн засгийн үзүүлэлт		2006-2010	2011-2015	2016-2020	2021-2024
ДНБ-д эзлэх хувь		23.7	18.2	24.6	26.4
Салбарын ДНБ	Нэрлэсэн ДНБ, их наяд төгрөг	1.44	3.19	7.70	16.24
	Дундаж өсөлт	2.8%	13.6%	-2.3%	4.9%
Аж ахуй нэгжид эзлэх хувь	Нийт ААН-д эзлэх хувь	-	1.4	1.6	1.3
	Компани	-	98.3%	94.5%	95.3%
	Нөхөрлөл	-	0.4%	4.9%	4.5%
	Төрийн бус байгууллага	-	0.6%	0.1%	0.0%
	Төсвийн байгууллага	-	0.0%	0.0%	0.0%
	ТӨҮГ, ОНӨҮГ	-	0.1%	0.1%	0.2%
	Хоршоо	-	0.5%	0.3%	0.0%
	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	-	0.0%	0.0%	0.0%
	Бусад	-	0.1%	0.0%	0.0%
Ажиллагчид	Салбарын ажиллагчид, мянган хүн	34.5	45.1	53.5	70.3
	Нийт ажиллагчдад эзлэх хувь	3.4	4.1	4.4	5.5
Бүтээмж, сая төгрөг	Салбарын нэг ажиллагчид ногдох бодит үйлдвэрлэл	62.56	71.58	78.33	55.52
	Улсын дундаж бүтээмжтэй харьцах харьцаа	4.68	3.83	3.69	2.39
Цалин, мянган төгрөг	Салбарын дундаж цалин	334.7	1,282.4	2,359.5	4,030.7
	Улсын дундаж цалинтай харьцах харьцаа	1.38	1.91	2.29	2.30
Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	ХО-ын дүн	762.5	4,540.6	6,026.1	11,868.1
	Нийт ХО-д эзлэх хувь	33.8	50.8	45.2	48.4
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг	Мөнгөн дүн	226	1,018	1,260	1,734
	Эзлэх хувь	9.6	10.8	8.1	6.5

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Нийт аж ахуйн нэгжид эзлэх уул уурхайн салбарын хувь 2021-2024 онд 1.3 хувь болж бага багаар буурсан трендтэй байгаа нь салбар их хэмжээний капитал, зах зээлд


⁵⁷ Уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний хагас жилд 10.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 8 хувиар буурсан байна.

нэвтрэхэд өндөр босготой буюу шинэ жижиг оролцогчид нэвтрэхэд хүнд болохыг харуулж байна. Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг төрлөөр нь авч үзвэл 95 буюу дийлэнх хувийг компанийн зохион байгуулалттай байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт зэсийн баяжмал металл агуулгаараа, баяжуулсан нүүрс, чулуун нүүрс, төмрийн хүдэр, хүрэн нүүрс, цайрын баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдрийн баяжмалын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 12.0-50.6 хувиар өсөж, харин мөнгөний баяжмал, газрын тос, цэвэршүүлээгүй алт, хайлуур жоншны баяжмал 5.0-32.5 хувиар буурсан байна. Энэ нь уул уурхайн нийт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд баяжуулсан бүтээгдэхүүний экспорт тэр дундаа ашигт малтмалын нөөц, баялгийг нэмэгдүүлэх нь чухал болохыг илтгэж байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээтэй шууд хамааралтай байдаг бөгөөд Монгол улсын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг сүүлийн 10 жилд 14.0 сая.га-аас 7.0 сая.га хүртэл 2 дахин буураад байна. (График 21-д ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг харуулав.)

График 21. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ (сая.га)



Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 2005 онд 69.7 сая га хүрч, 2005-2010 онд олгогдсон тусгай зөвшөөрлүүд нь өнөөгийн уул уурхайн салбарын хөгжил, эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлох суурь болсон байна. Энэ нь тухайн үед эрчимтэй хийгдсэн хайгуул, судалгааны ажлууд шинэ орд газруудыг илрүүлэх нөхцөлийг бүрдүүлснийг харуулж байна.

Нөгөө талаас, Монгол Улс эрдэс бүтээгдэхүүний импортын хувьд газрын тосны бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай хэвээр байна. Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2024 онд 2,162.0 сая ам.долларт хүрч, өмнөх оноос биет хэмжээгээр 18.2 хувь, үнийн дүнгээр 15.7 хувиар өссөн нь дотоодын шатахуун үйлдвэрлэлийн хязгаарлагдмал байдлыг илтгэж байна. Импортын дийлэнх буюу 89.6 хувийг автобензин, дизель түлш бүрдүүлж байгаа нь импортын хэт хамааралтай байгааг харуулж байна. (Хүснэгт 43-т харуулав)

Хүснэгт 43. Бүх төрлийн шатахууны импорт, (тонн)

дд	Огноо	Автобензин	Дизель түлш	Нийт
1	2020 он	585,239	1,027,538	1,612,777
2	2021 он	577,389	988,506	1,565,895
3	2022 он	681,991	987,873	1,669,865
4	2023 он	728,952	1,341,693	2,070,645
5	2024 он	904,295	1,639,969	2,626,708

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Уул уурхайн хайгуул, ашиглалтын идэвхжил эдийн засгийн өсөлтийн чухал хөшүүрэг болсон хэдий ч, шатахууны импортын өсөлт нь эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэл дагуулж байна.

Салбар дотор төрөлжилтийг авч үзвэл 2024 оны экспортын нийт бүтээгдэхүүний 80.0 хувийг зэс (22.0 хувь), нүүрс (58.0 хувь) гэсэн хоёр бүтээгдэхүүн дангаар эзэлж байгаа нь уул уурхайн салбарыг дэлхийн зах зээл дээрх үнэ, эрэлтээс шууд хамааралтай болгон, савлагаа үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөн геологи хайгуул, судалгааны ажил явуулах талбайн хэмжээ багасаж өнгөрсөн 20 жилийн хугацаанд 10 дахин буурсан, хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо өнгөрсөн 10 жилд 2 дахин буурснаас үүдэн бодит үйлдвэрлэл явуулах, цаашид судалгаа хийн нөөц тогтоох боломжит талбайн хэмжээ багасаад байна.

Уул уурхайн салбар нь экспортын бүтэц, геологи хайгуулын боломж, үйлдвэрлэлийн хэмжээ зэрэгт хэт төвлөрсөн байдал, нөөцийн хязгаарлалт, зах зээлийн савлагаа зэрэг эрсдэлүүдээр хязгаарлагдаж, эдийн засгийн тогтвортой өсөлт, төрөлжилтөд сөргөөр нөлөөлж байна.

Уул уурхайн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах замаар салбарын нийт үйлдвэрлэлийг нэмэгдүүлж бодит өсөлт 2024 онд 10.8 хувь байгааг 2030 онд 4.3 хувьд хүргэхээр зорьж байна. Үүний тулд дэвшилтэт технологи нэвтрүүлж баяжуулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж экспортын биет хэмжээний өсөлтийг 19.6 хувьд хүргэнэ.

Мөн геологийн зураглал, хайгуул судалгааны ажлыг нэмэгдүүлэх замаар ашигт малтмалын нөөц, баялгийг нэмэгдүүлнэ. Ингэснээр геологийн 1:50 000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн судалгаанд хамруулсан талбайн нийт нутаг дэвсгэрт эзлэх хэмжээ 2024 онд 46.8 хувь байгаа бол 2030 онд 52.0 хувьд хүрч хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хэмжээ 2030 онд 5.0 хувьд хүрнэ. Ашиглагдаж байгаа ордуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, нөөц нь тогтоогдсон ордуудыг ашиглалтад оруулах замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж газрын тосны олборлолтын хэмжээг 600.0 мянган тонн, олборлох салбарын орлогын хэмжээг 57.3 их наяд төгрөгт хүрч нэмэгдэнэ.

3.3.3. Хөдөө аж ахуй

ДНБ-ний 7.3 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онд 5,881.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын нийт экспорт 2024 оны гүйцэтгэлээр 786.3 сая ам долларт хүрч, 2022 онтой харьцуулахад 13.9 хувиар өссөн байна. Салбарын экспортын бүтцийг авч үзвэл экспортын барааны нийт дүнд нэхмэл, хувцас үйлдвэрлэл, мах, махан бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт дийлэнх хувийг эзэлж байна. 2024 оны дүнгээр нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүний экспорт 451.2 сая ам.доллар мах, махан бүтээгдэхүүний экспорт 285.4 сая.ам.доллар болсон.

Хөдөө аж ахуйн салбар нь экспортын өсөлт, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаа ч нөөцийн үр ашиггүй ашиглалт, боловсруулах үйлдвэрлэлийн сул хөгжил, зах зээлийн хязгаарлалт зэрэг тулгамдсан асуудлаас шалтгаалан эдийн засгийн төрөлжилт, тогтвортой өсөлтөд бүрэн хувь нэмэр оруулж чадахгүй байна.

Мал аж ахуй: Манай улс нэг хүнд ногдох малын тоогоор дэлхийд тэргүүлдэг хэдий ч малын түүхий эд, хүнсний экспортоор муу байгаа ба хөдөө аж ахуйн экспортын ердөө 36.3 хувийг мал аж ахуйн салбар бүрдүүлж байна. Мал гаралтай бүтээгдэхүүний экспортод малын чанар, эрүүл мэнд, ялангуяа халдварт өвчний тархалт ихээхэн нөлөөлдөг.

Монгол Улсад малын тоо толгой их боловч нэг малаас авах ашиг шим (сүү, мах, ноос, арьс ширний гарц, чанар) олон улсын дунджаас доогуур байна. Жишээлбэл сүүний гарц монгол үхрийн жилийн дундаж саам 500-600 литр орчим байдаг бол дэлхийн дундаж 2,500-3,000 литр, өндөр үржлийн үнээ 6,000-8,000 литр хүрдэг. Нэг бог малаас авах махны дундаж 16-20 кг бол, өндөр ашиг шимтэй үүлдрээс 30-40 кг хүртэл мах авдаг. Ийм үзүүлэлт нь малын үүлдэрлэг байдлын доройтол, селекцийн сул хөгжил, тэжээллэгийн дутагдалтай шууд холбоотой.

Мөн малын эрүүл мэндийн тогтолцоо сул, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж жигд бус байна. Үндсэн асуудлууд нь халдварт өвчин (шүлхий, мялзан, цэцэг гэх мэт) үе үе дэгддэг. Хорио цээрийн дэглэм, вакцинжуулалтын чанар, хяналт сул.

Малын шим тэжээлийн дутагдал, дархлаа сулрах, өвчинд өртөмтгий болох. Энэ нь зөвхөн малын ашиг шимд нөлөөлөөд зогсохгүй, мах, сүүний аюулгүй байдал, экспортын боломжид шууд нөлөөлдөг.

Мал, амьтныг олноор нь өвчлүүлж, улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг, олон улсын худалдааны хорио цээрт 15 өвчнийг ДМАЭМБ-аас гоц халдварт өвчин гэсэн ангилалд багтаадаг.

Монгол Улсад 2024 онд мал, амьтны гоц халдварт бог малын мялзан, хонины цэцэг, гахайн мялзан, ямааны годрон зэрэг 4 төрлийн өвчний дэгдэлт бүртгэгдсэн. Хонины цэцэг өвчин 12 аймгийн 71 суманд 91 голомтод 401 өрхийн нийт 11,951 толгой мал, бог малын мялзан өвчнөөр 564 толгой мал өвчилж, 129 толгой мал устгасан бол ямааны годрон өвчнөөр 14,914 толгой ямаа өвчилсөн байна.

Монгол Улсад мал, амьтны 17 нэр төрлийн зооноз, халдварт өвчин оношлогдсон байна. Халдварт өвчнөөр нийт тохиолдлын 11 аймагт нь дотрын халдварт хордлого (642) 29.5 хувь, цусан халдварт 12 аймагт (525) толгой мал 24.1 хувь, Маеди висна өвчин 2 аймагт (491) толгой мал 22 хувь, зооноз халдварт галзуу өвчин 17 аймагт (121) 5.5 хувь толгой мал, амьтан халдвар авч өвчилсөн. Нийт 17 нэр төрлийн өвчнөөр 2,170 толгой мал өвчилж үүнээс 1,195 толгой мал, амьтан буюу 55.0 хувь нь халдварт өвчнөөр үхсэн байна.

Эдгээр малын халдварт, гоц халдварт өвчин нь зөвхөн малын ашиг шимд нөлөөлөөд зогсохгүй, мах, сүүний аюулгүй байдал, экспортыг сааруулж эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөр байна.

Малчид малын чанар биш тоонд суурилж байгаа нь чанар ба бүтээмжийг орхигдуулсан бодлогын үр дагавар бөгөөд энэ нь малчдын орлого, амьжиргааны түвшин муу байгаад нөлөөлж байна.

Газар тариалан: Газар тариалангийн салбарын гол хүндрэл нь байгаль цаг уураас шууд хамааралтай байдаг бөгөөд үүнээс үүдэн нэгжээс авах ургацын хэмжээ бага, хүн амын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс бүрэн хангаж чадахгүй байгаа юм.

Ургац хураалтын хувьд 2024 оны байдлаар 336.1 мянган га талбайгаас 430.0 мянган тонн үр тариа, үүнээс 386.4 мянган тонн улаан буудай, 18.6 мянган га-аас 250.8 мянган тонн төмс, 17.2 мянган га-аас 267.3 мянган тонн хүнсний ногоо, 96.1 мянган га-аас 246.9 мянган тонн тэжээлийн ургамал, 115.2 мянган га-аас 53.3 мянган тонн тосны ургамал тус тус хураан авсан бөгөөд хураасан ургацын хэмжээг өмнөх онтой харьцуулахад улаан буудай 13.1 хувь, тосны ургамал 3.7 хувиар буурсан бол төмс 37.0 хувь, хүнсний ногоо 20.0 хувиар тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Нэг га-аас авах ургацын хэмжээ өмнөх онтой харьцуулбал (2022/2023) улаан буудай 11-ээс 13 цн, арвай 10-аас 13 цн, хүнсний ногоо 105-аас 132 цн, таримал тэжээл 23-аас 24 цн болж тус тус өссөн боловч хүн амын эрэлтийг ханган дэлхийн дундаж хэмжээнд хүрч чадаагүй байна.

Салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, тариалсан талбайн хэмжээ өсөж байгаа хэдий ч газар тариалангийн салбар нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул, байгалийн эрсдэл, эмзэг байдлын түвшин өндөр хэвээр байсаар байна. Мөн таримал ургамлын үр сортын тогтолцоо алдагдсан, таримлын үрийн чанар, үр үйлдвэрлэл, хуваарилалтын тогтолцоо бүрдээгүй, нутагшсан сортын үрийн хүрэлцээ хангамж муу зэрэг асуудлууд үүсэж буй учраас газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой бус байна.

Газар тариалангийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт муугаас сэлгээн дэх таримлын нэр төрөл цөөн бөгөөд таримлын зохистой сэлгээ нэвтрээгүй, хөрөнгө санхүүтэй холбоотойгоор бордох технологийн горимыг мөрдөхгүй байгаа зэргээс шалтгаалан тариалангийн салбарын үндсэн баялаг болсон хөрсний үржил шим

доройтож байна. 2024 оны судалгаагаар тариалангийн талбайн 61.6 хувь хүчтэй элэгдсэн, 47.7 хувь нь маш бага үржил шимтэй болж эрсдэлийн байдалд хүрсэн.

Мөн тариалангийн салбарт санхүүгийн дэмжлэг, техник технологийн иж бүрэн шинэчлэл амжилттай нэвтэрч тариалах талбай, хураан авах ургацын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч энэхүү нь тогтвортой биш, байгаль цаг уурын эрсдэлд хэт өртөмтгий байна.

Тариалангийн салбарыг тогтворжуулах, байгалийн эрсдэлээс ангид, бие даасан байдлыг хангах зорилгоор таримлын зохистой сэлгээ, үр сорт, ургамал хамгааллын салбарын тогтолцоог бүрдүүлэх, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, бордоо, ургамал хамгааллын бодисын хэрэглээг төлөвшүүлэх, хөрсний үржил шимийг хамгаалах, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, худалдааны оновчтой байдлыг хангах цогц бодлогыг төлөвлөн хэрэгжилтийг зохион байгуулах шаардлагатай байна.

Тухайн салбарын тогтвортой хөгжлийн хүрээнд эхний ээлжид хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс бүрэн хангах, цаашлаад экспортын чиг баримжаатай хөгжүүлэх шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах замаар стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний тулд дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж салбарын нийт үйлдвэрлэл 2024 онд 5,881.1 тэрбум төгрөг байгааг 2030 онд 16,700.0 тэрбум төгрөгт хүргэнэ.

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын стратегийг хэрэгжүүлж малын халдварт, гоц халдварт, архаг халдварт болон зооноз халдварт өвчний гаралтыг бууруулна. Ингэснээр архаг халдварт, зооноз халдварт өвчний гаралтын тоог 192-оор буюу 600-д хүргэж, малын бруцеллёз өвчингүй аймаг, сум 2024 онд 15 байгааг 51 болгож нэмэгдэнэ. Мөн олон улсын худалдааны хоригтой мал, амьтны гоц халдварт өвчний гаралтын тоо 100 байгааг 0-д, олон улсын худалдааны хоригтой үхрийн цээж, үхрийн тархи сархиатах, үхрийн сүрьеэ, лейкоз, адууны африк мялзан, хонины скрепи өвчний гаралт бүртгүүлэхгүй байхаар зорьж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд селекц, үржил, генетикийн хяналтыг сайжруулах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх замаар малын чанарыг сайжруулж нийт малын тоонд өндөр ашиг шимт малын эзлэх хэмжээг 11.0 хувьд хүргэнэ.

Мөн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангана. Ингэснээр тариалсан талбайгаас хураасан үр тариа 14.5 ц/га, төмс 140 ц/га, хүнсний ногоо 135 ц/га-д хүрнэ.

3.3.4. Аялал жуулчлал

Аялал жуулчлалын салбар нь эдийн засаг, бүс нутгийн хөгжил, эдийн засгийн өрсөлдөх чадварт чухал ач холбогдолтой. Аялал жуулчлал нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, ажлын байрыг шинээр бий болгох, гадаад валютын орлогыг өсгөх, гадаад валютын нөөцийг арвижуулах, дотоодын эрэлтийг дэмжихэд эерэг нөлөөлөл үзүүлж байна.

Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл (WTTC) нь “Аливаа улсын аялал жуулчлалын салбар бол олон сая ажлын байрыг бий болгож, тухайн улс, бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмждэг чухал салбар юм” гэж тайландаа онцолжээ (WEF, 2024). Нийгэм, эдийн засаг, байгаль орчны үйл ажиллагаа хосолж явагддаг утгаараа аялал жуулчлалын салбар нь онцлогтой юм.

Дэлхийн эдийн засгийн форумас 2 жил тутамд гаргадаг аялал жуулчлалын индексээр манай улс 2019 онд 140 орноос 93-р байр, 2021 онд 117 орноос 84-р байр, 2024 онд 119 орноос 85-р байрт тус тус орсон байна.

Сүүлийн таван жилийн хугацаанд Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн индексийн эрэмбэ тогтмол дунд түвшинд хадгалагдаж, дэлхийн 120 орчим улсаас 80-90 дугаар байрны хооронд хэлбэлзэж байна. Энэ нь аялал жуулчлалын салбар дэд бүтэц, үйлчилгээний чанар, аяллын хүртээмжийн хувьд тодорхой ахиц гаргасан ч, олон улсын өрсөлдөх чадварын хувьд харьцангуй сул байгааг харуулж байна.

Аялал жуулчлалын салбарт олон өөр салбарын үйл ажиллагаа хамаардаг тул тусгайлсан салбарын тоог тооцоход хүндрэлтэй байдаг. Гэсэн хэдий ч Монголбанкны төлбөрийн тэнцлийн статистик мэдээлэлд тулгуурлан салбарын орлогыг тооцож үзэхэд өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт ДНБ-ий 3.0 орчим хувийг бүрдүүлж байна. Салбарын орлого өнгөрсөн хугацаанд нэмэгдсээр байсан ч ДНБ-д эзлэх хувь хэмжээ жил бүр буурсаар байна. (Хүснэгт 44-т аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үзүүлэлтийг харуулав.)

Хүснэгт 44. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үзүүлэлт⁵⁸

Эдийн засгийн үзүүлэлт		2006-2010	2011-2015	2016-2020	2021-2024
ДНБ-д эзлэх хувь		5.4	1.7	2.7	1.4
Салбарын орлого	Салбарын орлого, их наяд төгрөг	0.3	0.3	0.8	1.0
	Дундаж өсөлт	8.4%	2.4%	-2.5%	305.7%
Аж ахуй нэгжид эзлэх хувь	Нийт ААН-д эзлэх хувь	-	5.17	2.50	3.00
Аж ахуй нэгжийн тоо	Зочид буудал, ресторан	-	1994	2186	2749
	Тур оператор	-	955	1155	1584
	Рашаан сувилал	-	126	148	156
	Нийт	-	3075	3489	4489
Жуулчдын тоо		434,083	426,623	407,800	356,365
Жуулчдын дундаж зардал (ам.доллар)		579.6	473.1	771.0	816.0

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

2006-2010 онуудад тулгар төр байгуулагдсаны 800 жилийн их ойн нөлөө, үргэлжлээд гадаадын хөрөнгө оруулалтын тэсрэлтийг даган жуулчдын орох урсгал нэмэгдсэнээр аялал жуулчлалын салбар 2006-2010 оны үед тогтвортой өсөж ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэх орлогыг олж байжээ. Харин 2011-2015 онуудад гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын нөлөө үргэлжилсээр байсан, 2011-2012 онд Европын өрийн хямрал хурцдаж, 2014 онд Орос Украин улсуудын хооронд газрын тосны маргаан үүдсэн, 2015 онд Хятадын хөрөнгийн зах зээлийн хямрал зэрэг шалтгаануудаас үүдэн гадаад жуулчдын Монгол Улсад ирэх урсгал багассан байна. Үүнийг дагаад эдгээр жилүүдэд дунджаар ДНБ-ий ердөө 1.7 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг олж байжээ. 2016-2020 онуудад аялал жуулчлалын салбар сэргэн дунджаар ДНБ-ий 3.3 хувьтай тэнцэх орлого олж байсан ч цар тахлын нөлөөгөөр огцом буурч ердөө 0.2 хувьтай тэнцэх болсон байна. Үүний нөлөөгөөр 2016-2020 онд ДНБ-ий 2.7 хувьтай тэнцэх орлогыг олох болжээ.


Дэлхий даяар хөл хорио тавьсан, дотооддоо цар тахлын нөлөөг хязгаарлах, тараахгүй үүднээс тавьсан хөл хорио зэргээс үүдэн аялал жуулчлалын салбар 2020, 2021 онуудад бараг л тэг зогсолт хийсэн бөгөөд ирэх жуулчдын тоо өмнөхөөс 10 дахин буурсан. Гэсэн хэдий ч 2022 оны дунд үеэс дэлхий даяар аялал жуулчлалын салбар сэргэж 2 жил хөл хорионд байснаас үүдэн хүмүүст аялах хүсэл ихээр төрөх болж аялал

⁵⁸ Аялал жуулчлалын салбар нь Дотоодын нийт бүтээгдэхүүний ангилалд багтдаггүй тул хүснэгт дэх тоог Монголбанкны төлбөрийн тэнцлийн статистикаас авсан.

жуулчлалын салбар дэлхий даяар огцом өсөж эхэлсэн. Үүнийг дагаад Монгол Улсын аялал жуулчлалын салбар ч тэлж, цар тахлын өмнөх түвшний тал хэмжээнд хүрч очсон. Харин 2023 онд визийг хөнгөвчлөн, зарим улсыг чөлөөлж, агаарын тээврийн либералчлалыг эхлүүлэн, эвент арга хэмжээний мэдээллийг нэгтгэн зарлаж, дэд бүтцийн стандартыг сайжруулан, жуулчдад НӨАТ-ыг буцаан олгох агуулга бүхий аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн баталснаар жил бүрийн жуулчдын орлого өмнөх жилийн түвшнийг давж цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 2024 онд 24.0 хувиар тэлсэн үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд 2021-2024 онд аялал жуулчлалын салбарын орлого ДНБ-ий 1.7 хувийг эзэлж байна. (График 22-23-т харуулав)

График 22. Жуулчдын тоо ба орлогын хэмжээ (хүн, сая ам.доллар)

График 23. Нэг жуулчны дундаж зардал, инфляцаар засварласан дүн (ам.доллар, 2006 оны ам.доллар)



Монгол Улсад 2006-2010 онуудад дунджаар 434 мянга, 2011-2015 онуудад 427 мянга, 2016-2020 онуудад 408 мянга (хэрэв 2020 оныг тооцохгүй бол 495 мянга), 2021-2024 онуудад 356 мянган (2021 оныг тооцохгүй бол 536 мянга) жуулчин иржээ. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт ирж буй жуулчдын тоо тогтмол хэмжээтэй бага хэмжээгээр өсөж байсан ч, 2018 оноос эхлэн эрчимтэй өсөх болж, нэн ялангуяа 2023-2024 онуудад бодлогын нөлөөгөөр ирэх жуулчдын тоо огцом нэмэгдэж жил бүр түүхэн дээд хэмжээнд хүрсээр байна. Ирж буй жуулчдын тоо нэмэгдэхийн хэлбэрээр салбарын аж ахуйн нэгжүүдийн тоо ч өссөөр байна. Өнгөрсөн 12 (2013-2025) жилийн хугацаанд тур операторуудын тоо 2 дахин, нийт аялал жуулчлалын салбарт харьяалагдаж болох аж ахуйн нэгжүүдийн тоо 1.6 дахин нэмэгдсэн байна.

Аялал жуулчлалын салбарыг дэмжих зорилгоор 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж, 2023 онд Welcome to Mongolia, 2024 онд Go Mongolia урианы дор сурталчлах болсон. Энэ хүрээнд 34 улсын иргэдэд 2025 он хүртэл визний хөнгөлөлт үзүүлж, нийт 61 улсын иргэд Монголд визгүй зорчих нөхцөл бүрдэх болсон. Мөн агаарын тээврийг либералчлах хүрээнд шаардлагатай гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулж, Монгол Улс дэлхийн 44 улсын 155 цэг рүү шууд нислэг үйлдэх боломжтой болов. Мөн аялал жуулчлалын тухай хуулийг цаг алдалгүй шинэчлэн баталснаар салбарын орлогын хэмжээ өмнөх жилийн түвшинг давж цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 2024 онд 24 хувиар тэлсэн үзүүлэлттэй байна.

Аялал жуулчлалын салбарт улсын хэмжээнд 793 жуулчны бааз, 571 зочид буудал, 486 дэн буудал, 661 гэр бааз, 72 рашаан сувилал, дотоод, гадаадын нийт 12 агаарын тээвэрлэгч, шууд бусаар 939 ресторан, зоогийн газар болон аялал

жуулчлалын салбарт хамаарах 2,583 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж, нийт 88,000 гаруй ажлын байрыг бий болгож байна.

Монгол Улсыг олон улсад таниулах, аялал жуулчлалын эерэг имижийг бэхжүүлэх зорилгоор "Монгол Улсыг олон улсад таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх нэгдсэн стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлж, 2024 онд олон улсын хэвлэл мэдээллээр дамжуулан сурталчилгаа зохион байгуулсан нь нийт 166.5 сая хүнд хүрсэн. Үүний үр дүнд Монголын талаарх ойлголт 73.0 хувь, сонирхох байдал 126.0 хувь, эерэг сэтгэгдэл 137.0 хувиар тус тус өссөн.⁵⁹

Хэдийгээр эдгээр ажлууд амжилттай хэрэгжсэнээр жуулчдын тоо цар тахлын өмнөх тренддээ хүрч, жил бүр өсөн нэмэгдсээр байгаа ч ирж буй жуулчдын хэмжээтэй харьцуулахад нэг жуулчны дундаж зардлын хэмжээ 2006 онтой харьцуулахад төдийлөн нэмэгдээгүй байна.

Манай улсад ирж буй нийт жуулчдын 60.0 хувь нь зөвхөн 6-9 саруудад ирдэг бөгөөд аялал жуулчлалын салбар улирлын хамаарал өндөртэй байна. Мөн Улаанбаатар хотоос гадна гадаад жуулчдад дэд бүтцийн хүртээмж сул, аялал жуулчлалын мэргэшсэн ажиллах хүч хомс бөгөөд хаягжилт мэдээлэл гадаад хэл дээр байхгүй зэрэг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой асуудлууд хэвээр байсаар байна.

Аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг бууруулж жуулчдын тоог нэмэгдүүлж хүлээн авах жуулчдын тоог 2030 онд 2.0 саяд хүргэхээр зорьж байна. Үүний тулд үйлчилгээний чанарыг сайжруулж аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, аялал жуулчлалын хөгжлийн индексийн эрэмбийг 20 байраар урагшлуулж 65-д хүргэнэ. Тогтвортой аялал жуулчлалын загварыг хэрэгжүүлэх замаар аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлж салбарын орлогыг 1.6 тэрбум ам.долларт хүргэнэ. Мөн олон улсын стандартад нийцүүлж Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Ингэснээр зэрэглэлтэй байршуулах үйлчилгээний байгууллага 35 болно.

Мөн зах зээл болон экспортын сувгийг өргөжүүлэх замаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг 4.0-д хүргэнэ. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд оюуны өмчийн баталгаажуулалт болон ур чадварыг сайжруулах замаар соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг нэмэгдүүлж үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд 2021 онд 5,565 байгааг 2030 онд 6,135-д хүргэж өсгөхөөр зорьж байна.

3.3.5. Санхүү

Санхүүгийн салбар нь эдийн засгийн өсөлт, тогтвортой байдал, эрсдэл удирдлага, хөрөнгө оруулалтын зуучлал, нийгмийн хөгжлийг дэмжих үүрэгтэй эдийн засгийн чухал салбар юм.

Манай улсын санхүүгийн зах зээл банкны салбар давамгайлсан бүтэцтэй, банкнуудын зах зээлд эзлэх хувь, гүйцэтгэх үүрэг оролцоо өндөр байсан нь банкнаас бусад санхүүгийн салбар хөгжихөд сөрөг нөлөөг үзүүлж ирсэн. Ялангуяа, эдийн засаг, санхүүгийн зах зээлд санхүүгийн зуучлалын үүргийг гүйцэтгэдэг хөрөнгийн зах зээл хөгжлийн түвшнээрээ бүс нутаг болон бусад Азийн орнуудтай харьцуулахад хангалтгүй үзүүлэлттэй байсан.

Банкнаас бусад санхүүгийн зах зээл 2024 онд нь санхүүгийн салбарын нийт хэмжээнд 22.9 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх 5 жилийн хугацаанд аажмаар өссөн үзүүлэлт юм. Сүүлийн жилүүдэд банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжлийн чиг хандлага тогтвортой өсөлттэй байгаа боловч нийт санхүүгийн зах зээлд

⁵⁹ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны нөхцөл байдлын дүн шинжилгээ

эзлэх хувь харьцангуй бага хэвээр байна. (Хүснэгт 45-д санхүүгийн салбарын эдийн засгийн үзүүлэлтийг харуулав.)

Хүснэгт 45. Санхүүгийн салбарын эдийн засгийн үзүүлэлт

Эдийн засгийн үзүүлэлт		2006-2010	2011-2015	2016-2020	2021-2024
ДНБ-д эзлэх хувь		3.1	3.8	4.1	5.0
Салбарын ДНБ	Нэрлэсэн ДНБ, их наяд төгрөг	0.19	0.72	1.31	3.03
	Дундаж өсөлт	6.3%	33.9%	9.6%	12.4%
Аж ахуй нэгжид эзлэх хувь	Нийт ААН-д эзлэх хувь	-	3.0	3.0	2.3
	Компани	-	83.6%	84.0%	87.8%
	Нөхөрлөл	-	5.4%	3.0%	1.6%
	Төрийн бус байгууллага	-	0.3%	0.1%	0.0%
	Төсвийн байгууллага	-	0.1%	0.2%	0.1%
	ТӨҮГ, ОНӨҮГ	-	0.0%	0.1%	0.2%
	Хоршоо	-	10.5%	12.7%	10.3%
	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	-	0.0%	0.0%	0.0%
	Бусад	-	0.1%	0.0%	0.0%
Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	ХО-ын дүн	57.3	265.2	515.7	500.5
	Нийт ХО-д эзлэх хувь	2.5	3.0	3.9	2.0
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг	Мөнгөн дүн	23	128	411	654
	Эзлэх хувь	1.0	1.4	2.6	2.5

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Санхүү, даатгалын салбар нь 2006-2010 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 3.1 хувийг бүрдүүлж байсан бол 2021-2024 онд 5.0 хувийг бүрдүүлж, ДНБ-д эзлэх хувь өссөн байна. Нийт аж ахуйн нэгжид эзлэх хувь 2021-2024 онд 2.3 хувь болж өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан байна. Санхүү, даатгалын салбарын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь 2021-2024 онд буурч 2.0 хувьд хүржээ. Зээлийн үлдэгдлийн нийт эзэлд эзлэх хувь 1.0 хувиас 2.5 хувь хүртэл өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын санхүүгийн систем нь банкны салбар давамгайлсан бүтэцтэй хэвээр байгаа ч банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаас, даатгалын салбаруудын оролцоо өсөж, системийн төрөлжилт нэмэгдэж байна. Цаашид шинэлэг инновац, технологи бүхий санхүүгийн бүтээгдэхүүний зохицуулалт, хяналтыг эрх зүйн орчны хувьд сайжруулж, хөрөнгийн зах зээлийг өргөжүүлэх, эрсдэлийн төвлөрлийг сааруулах, гадаадын банкиг нэвтрүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1990-2025 оны II улирал хүртэл 1.87 тэрбум ам.доллар буюу нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 3.8 хувийг эзэлж 3 дахь гол хөрөнгө оруулалт татдаг салбар болж байна. 2024 оны байдлаар тус салбарт 122.1 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирсэн нь өмнөх оноос 9.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үнэт цаасны салбар: Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2025 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсөж, 12.2 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 15.2 хувьтай тэнцэж байна. Хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн утга 2025 оны 2 дугаар улиралд 49,246 нэгжид хүрч, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар өссөн байна. ТОП-20 индексэд банк санхүүгийн салбар дийлэнх буюу 65.2 хувийг бүрдүүлж байна. Үүний дараа аж үйлдвэрийн салбар 18.3 хувийг, уул уурхайн салбар 14.6 хувийг тус тус бүрдүүллээ.

Даатгалын салбар: 2025 оны 2 дугаар улирлын байдлаар СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр нийт 354 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 1,093 даатгалын төлөөлөгч үйл

ажиллагаа эрхэлж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгө 703.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өссөн бол нөөц сангийн хэмжээ 337.5 тэрбум төгрөгт хүрлээ. Даатгалын нийт хураамж 295.6 тэрбум төгрөгт хүрч нэмэгдсэн бөгөөд үүний 82.0 хувийг ердийн даатгал, 17.0 хувийг давхар даатгал, 1.0 хувийг урт хугацааны даатгалын хураамж тус тус бүрдүүлж байна. Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 88.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар өсжээ. Нийт нөхөн төлбөрийн зардлын 86.3 тэрбум төгрөг буюу 97.9 хувийг ердийн даатгалын компани бүрдүүлэв. Давхар даатгалын нөхөн төлбөрийн дүн өмнөх оны мөн үеэс 52.2 хувиар өсөж 12.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын салбарын хувьд нийт хураамжийн 82 хувийг ердийн даатгал эзэлж, урт хугацааны болон давхар даатгалын хувь хэмжээ бага байна. Энэ нь даатгалын салбарын бүтэц нэг төрлийн, эрсдэлийн хамгаалалт хангалтгүй байгааг харуулж байна. Цаашид давхар даатгалын хамраг хүрээг өргөжүүлж, гадаадын эрсдэлийн сангуудтай холбох, урт хугацааны амьдралын болон хөрөнгө оруулалтын даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх шаардлагатай.

Банк бус санхүүгийн салбар: 2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт тусгай зөвшөөрөл бүхий 573 банк бус санхүүгийн байгууллага 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлжээ. Нийт ББСБ-уудын 89.0 хувь нь буюу 510 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс 308 ББСБ зөвхөн зээлээр дагнасан үйл ажиллагаа эрхэлж байна. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 178 ББСБ байна. Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), шинэ төрлийн болон уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлж буй 72 ББСБ байна. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-ын салбарын нийт хөрөнгө 8.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 93.6 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг авч үзвэл салбарын нийт актив 4.3 дахин, нийт зээлийн үлдэгдэл 5.1 дахин өсжээ. ББСБ-уудын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 45.4 хувиар өсөж, 6.7 их наяд төгрөгт хүрлээ.

Санхүүгийн системд арилжааны банкнуудын нөлөө өндөр хэвээр байна. Мөн Монгол Улсын санхүүгийн зуучлалын үйлчилгээг арилжааны банкнууд голлон гүйцэтгэж байгаа нь системийн эрсдэлийн төвлөрөл өндөр байгааг харуулж байна.

Хөрөнгийн зах зээл ДНБ-ий 15.2 хувь болж өмнөх онуудаас өссөн ч ойролцоо эдийн засагтай улс орнуудтай харьцуулахад бага түвшинд байна. Мөн ТОП-20 индексийн 65.0 хувийг зөвхөн банк санхүүгийн салбар бүрдүүлж байгаа нь бусад салбарын оролцоо сул, зах зээлийн төрөлжилт хангалттай биш байгааг илтгэж байна.

Даатгалын хувьд нийт хураамжийн 82.0 хувийг ердийн даатгал бүрдүүлж, урт хугацааны болон давхар даатгалын хувь хэмжээ бага байгаа нь энэ төрлийн даатгалын хөгжил сул байгааг харуулж байна. Даатгалын салбарын хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна.

Банк бус санхүүгийн салбарын хөрөнгө, зээлийн хэмжээ, технологид суурилсан үйлчилгээний тоо хурдацтай өсөж байгаа нь салбарын идэвхтэй хөгжлийг харуулж байна. Гэсэн хэдий ч санхүүгийн системд арилжааны банкны давамгайлал хэвээр байгаа нь эрсдэлийн төвлөрлийг нэмэгдүүлж, зах зээлийн төрөлжилт, өрсөлдөөнийг хязгаарлаж байна. Хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын оролцоо нэмэгдэж байгаа ч урт хугацааны болон давхар даатгалын хөгжил сул, бусад салбарын хөрөнгийн зах зээлд эзлэх хувь бага байгаа нь системийн тэнцвэртэй өсөлтөд саад болж байна.

Банкны салбар давамгайлсан бүтэцтэй хэвээр байгаа нь зах зээлийн өрсөлдөөн, хөрөнгө оруулалтын орчныг хязгаарлах эрсдэлтэй бөгөөд инновац, технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүний зохицуулалт, хяналтыг сайжруулах

шаардлагатай байна. Хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын үзүүлэлтүүд өсөлттэй байгаа ч гадаадын хөрөнгө оруулалт буурч, урт хугацааны даатгалын оролцоо сул байгаагаас салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд бодлогын дэмжлэг, эрх зүйн орчны шинэчлэл зайлшгүй шаардлагатайг илтгэж байна.

Санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь өсөж, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын оролцоо нэмэгдэж байгаа ч зах зээлийн төрөлжилт хангалтгүй, банкны салбар давамгайлсан бүтэцтэй хэвээр байна. Хөрөнгө оруулалт, урт хугацааны даатгал, давхар даатгалын хөгжил сул, гадаадын хөрөнгө оруулалт буурсан нь салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Мөн санхүүгийн зуучлалын үйлчилгээ арилжааны банкнуудад төвлөрсөн нь системийн эрсдэлийг нэмэгдүүлж, өрсөлдөөн, инновацын орчныг хязгаарлаж байна. Иймд санхүүгийн салбарын төрөлжилт, даатгалын хамрах хүрээ, хөрөнгийн зах зээлийн өргөжилт, технологид суурилсан шинэ бүтээгдэхүүний зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Цаашид санхүүгийн зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэхийн тулд олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын бодит өсөлтийг 9.1 хувьд хүргэхээр зорьж байна. Үүний тулд дижитал шийдлийг нэвтрүүлж санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж Санхүүгийн салбарын зах зээлийн үнэлгээ, нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувийг 27.4-д хүргэнэ. Ингэснээр бичил санхүүгийн салбарын оролцогчдын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж салбарын оролцогчдын найдвартай, тогтвортой байдал хангагдаж бичил санхүүгийн салбарын эрсдэл даах чадвар 30.0 хувьд хүрнэ. Мөн олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх замаар хөрөнгийн зах зээл дэх иргэд, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны арилжааны үнийн дүнг 20.0 их наяд төгрөгт хүргэнэ. Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж даатгалын гүнзгийрэлтийг 3.0 хувьд хүргэнэ.

Санхүүгийн зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэхийн тулд чанаргүй активын хэмжээг бууруулж банк, санхүүгийн салбарын чанаргүй зээлийг багасгахаар зорьж байна. Мөн түүнчлэн, санхүүгийн зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх чиглэлд чанаргүй активын хэмжээг бууруулж банк, санхүүгийн салбарын чанаргүй зээлийг бууруулахаар зорьж байна. Ингэснээр чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээг 4.3 хувьд хүргэнэ. Ингэснээр зах зээл дэх чанаргүй зээлийн эзлэх хэмжээг 4.3 хувьд хүргэнэ. Мөн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг системтэй бодлогын түвшинд тогтмол түгээж олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ. Олон нийтийн санхүүгийн боловсролын чадамжийн түвшнийг 10.7-д хүргэнэ.

3.3.6. Эрчим хүч

Аливаа улс орны хөгжил дэвшлийн хөдөлгөх хүч бол эрчим хүчний салбар байдаг. Эрчим хүчний салбар нь үндэсний аюулгүй, бие даасан байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий хөгжлийн тэргүүлэх салбарын нэг бөгөөд баруун, төв, өмнөд болон дорнод бүс, Алтай-Улиастайн гэсэн 5 эрчим хүчний системд нийт 330 гаруй сум, суурин газруудыг холбон төвлөрсөн эрчим хүчний системээс эрчим хүчний найдвартай, тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ⁶⁰ 2021-2024 оны дунджаар 0.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 62 хувиар, 2015 оны үнээр засварласан дүнгээр 0.7 их наяд төгрөгт хүрч, 31 хувиар тус тус өссөн байна. Эдийн засгийн эрчимжилттэй холбоотойгоор эрчим хүчний нийт хэрэглээ жилд дунджаар 6-10 хувиар тогтмол өсөж байгаа ч дэд бүтцийн хүрэлцээгүй байдал, шугам сүлжээ, тоноглолын өндөр насжилт (32-62 жил) зэргээс шалтгаалан нийлүүлэлтийн хэмжээ

⁶⁰ Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 2025 оны эхний хагас жилд 1.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 28 хувиар өссөн байна.


дутагдалтай байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 2021 106 дугаар “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” тогтоолоор эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх хүрээнд “Эрчим хүчний сэргэлт”-ийн зорилтыг дэвшүүлж, эрчим хүчний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2024 оны дунджаар 8.3 тэрбум кВт.ц болж, өмнөх таван жилийн дунджаас 1.3 дахин нэмэгдлээ. Мөн 2024 онд цахилгаан эрчим хүчний үнийг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийн өртөгт хүргэх эрчим хүчний салбарт либералчлалыг эхлүүлж, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн бие даасан байдлыг дэмжсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Тус салбар 2025 оны эхний хагас жилд 8.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 0.3 хувиар дэмжлээ. Үүнд шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөлөв. Тухайлбал, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 4.8 тэрбум кВт цагт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 9.5 сая.Гкалд хүрч, 7.7 хувиар нэмэгдэн эрчим хүчний салбар үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой хадгалагдлаа.

Цахилгааны эрчим хүч: Цахилгаан эрчим хүчний хэрэглээний 75.4 хувийг дотоодын эх үүсвэрээс 24.6 хувийг ОХУ, БНХАУ-аас тус тус ханган нийлүүлдэг. Бүтцийн хувьд 1.3 тэрбум кВт.ц буюу 46.1 хувийг ОХУ-аас худалдан авч өрх, аж ахуй нэгжийн хэрэглээнд ашиглаж байгаа бол 53.9 хувийг БНХАУ-аас худалдан авч уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байна. 2024 оны байдлаар 198 сая ам.долларыг эрчим хүчний импортод зарцуулсан байна. Дотоодын эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын 79.2 хувийг дулааны цахилгаан станц, 20.2 хувийг сэргээгдэх эрчим хүч эзэлдэг.

Улсын хэмжээнд 2024 онд 11.6 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулж, 10.6 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг түгээсэн байна. Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчний 75.4 хувь буюу 8.8 тэрбум кВт.ц-ийг дотоодын эх үүсвэрүүд, 24.6 хувь буюу 2.9 тэрбум кВт.ц-ийг импортын цахилгаан эрчим хүчээр тус тус хангажээ. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ 2020 оны мөн үеэс 2.7 тэрбум кВт.ц-аар буюу 31.3 хувиар нэмэгдсэн байна.

График 24. Эрчим хүчний үйлдвэрлэл



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ нь 2024 онд 8,754.7 сая кВт.ц байгаа нь 2020 онтой харьцуулан үзэхэд 22.5 хувь буюу 1,609 сая кВт.ц-аар нэмэгдсэн байна. (График 24-т харуулав)

Нийт импортолсон цахилгаан эрчим хүчний 1.3 тэрбум кВт.ц буюу 46.1 хувийг ОХУ-аас, 1.5 тэрбум кВт.ц буюу 53.9 хувийг БНХАУ-аас тус тус импортолсон.

Хүснэгт 46. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, /сая.кВт.ц/

Эх үүсвэр	2020	2021	2022	2023	2024
Дулааны цахилгаан станц	6,493.6	7,109.6	7,428.5	7,755.2	7,930.6
Дизель цахилгаан станц	2.7	1.1	1.2	0.5	0.1
Нарны эх үүсгүүр	108.9	156.9	178.7	193	232.3
Усан цахилгаан станц	83.3	83.1	61.7	48.1	74.1
Салхин цахилгаан станц	457.2	563.0	508.5	531.5	517.5
Нийт үйлдвэрлэл	7,145.7	7,913.6	8,178.6	8,528.3	8,754.7
Импорт	1,705.6	1,861.9	2,161.5	2,447.6	2,863.3
Хэрэглээ /боловсруулалт/	8,851.3	9,575.5	10,340.1	10,975.9	11,619.0

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг эх үүсвэрийн бүтцээр нь авч үзвэл 90.5 хувийг дулааны цахилгаан станц, 5.9 хувийг салхин цахилгаан станц, 2.7 хувийг нарны цахилгаан станц, 0.85 хувийг усан цахилгаан станц, 0.0016 хувийг дизель станцууд тус тус үйлдвэрлэсэн байна. (Хүснэгт 46-д харуулав)

Нийт үйлдвэрлэлийн 60.0 орчим хувийг дулааны 4-р цахилгаан станц дангаараа хангадаг ба 2024 оны байдлаар 4,985.9 сая кВт.ц эрчим хүчнийг хэрэглэгчдэд нийлүүлжээ. Дулааны 3-р цахилгаан станц 14.1 хувь, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүд 9.4 хувь, дулааны 2-р цахилгаан станц 2.2 хувийг тус тус үйлдвэрлэж хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангалаа. (Хүснэгт 47-д харуулав)

Хүснэгт 47. Эх үүсгүүрүүдийн суурилагдсан хүчин чадал, эзлэх хувь, ашиглалт, улсын хэмжээнд

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
ДЦС-ууд /МВт/	1,234.0	1,269.0	1,269.0	1,269.0	1,319.0
Эзлэх хувь	81.5	81.9	81.1	81.1	79.2
СЭХ эх үүсгүүрүүд /МВт/	271.2	271.2	286.8	286.8	336.8
Эзлэх хувь	17.9	17.6	18.3	18.3	20.2
Дизель үүсгүүр /МВт/	8.6	8.6	8.6	8.6	8.6
Эзлэх хувь	0.6	0.6	0.6	0.6	0.5
Суурилагдсан хүчин чадал /МВт/	1,513.8	1,543.8	1,564.4	1,564.4	1,664.0

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүчний үйлдвэрлэл нь хэрэглээний өсөлтөөс гүйцэхгүй байгаа нь эрчим хүчний хомсдолд хүргэж байна. Эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлттэй уялдан жил бүр 6-7 хувиар нэмэгдэж байгаа боловч шинэ эх үүсвэр нэмэгдэхгүй байгаатай холбогдуулан дотоодын ДЦС-уудын хүчин чадал дутагдаж, импортын эрчим хүчний хэмжээ 2020 онд 1,705.6 МВт хувь байсан бол 2024 онд 2,863.3 МВт буюу 1.7 дахин нэмэгдсэн байна. (График 25-д харуулав)

График 25. Импортоор авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, хувь



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Дулааны эрчим хүч: Дулааны эрчим хүчний нийт үйлдвэрлэл 2020 онд 14,121.5 мянган Гкал байсан бол 2024 онд 17,382.7 мянган Гкал буюу 23.1 хувиар нэмэгдсэн байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос олгодог тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд 2024 онд 12,577.5 мянган Гкал дулаан үйлдвэрлэснээс 792.2 мянган Гкал-ийг уураар, 11,293.4 мянган Гкал буюу 93.4 хувийг нь усаар үйлдвэрлэж хэрэглэгчдэд түгээсэн байна. Бүтцээр задалж үзвэл нийт үйлдвэрлэлийн 38.0 хувь буюу 4,733.8 мянган Гкал дулааныг ДЦС-4, 21.4 хувийг дулааны 3-р цахилгаан станц, 8.4 хувийг Амгалан дулааны станц, 5.6 хувийг Эрдэнэт дулааны станц, 2.2 хувийг ДЦС-2 тус тус үйлдвэрлэжээ. (Хүснэгт 48-д харуулав)

Хүснэгт 48. Дулааны тэнцэл, улсын дүнгээр, мян.Гкал

	2020	2021	2022	2023	2024
Үйлдвэрлэсэн	14,121.5	14,972.9	15,643	16,393.6	17,382.7
Дулааны цахилгаан станцын дотоод хэрэглээ	1,311.7	1,405.0	1,484.8	1,483.3	1,529.6
ААНБ болон өрхөд түгээсэн-Бүгд	12,190.5	13,011.5	13,478.6	14,445.2	15,314.0
Үйлдвэр, барилга	3,177.6	3,410.0	3,354.7	3,601.5	3,529.9
Тээвэр, холбоо	384.0	403.3	427.6	436.9	474.4
Хөдөө аж ахуй	57.3	58.1	70.5	65.0	85.7
Өрх, орон сууц, нийтийн аж ахуй	4,516.5	4,260.9	4,682.5	5,173.8	5,459.7
Бусад	4,055.2	4,879.2	4,943.4	5,077.3	5,764.2
Түгээлтийн алдагдал	619.3	556.4	562.6	555.9	539.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улаанбаатар хотын эрчим хүчний эх үүсвэрүүдийн дулаан үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал 2,418.0 Гкал/ц хүрч, дулаан хангамжийн системд холбогдсон хэрэглэгчдийн тооцоот ачаалал 3,558.1 Гкал/ц болж нэмэгдэж 47.2 хувиар хэтрээд байна. Мөн техникийн нөхцөлөө авсан 516.4 Гкал/ц-ийн хэрэглээ хүлээгдэж байна.

Улаанбаатар хотод агаарын температур -35° хэмээс доош хүйтэрсэн нөхцөлд дулаан хангамжийн систем чадлын дутагдалд орж алслагдсан цэгүүдэд хүндрэл үүсэх эрсдэлтэй нөхцөлд байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 190 гаруй Гкал/ц-ийн хэрэглээ бүхий 280 гаруй барилга байгууламж төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр холбогдож байна. Нийслэлийн дулааны хэрэглээ жилд 7-8 хувиар өсөн нэмэгдэж, энэ хэмжээгээр хэрэглээний өсөлт тогтвортой гарвал 2025 оны түвшинд холбогдсон хэрэглэгчдийн ачаалал 3,874.0 Гкал/ц болно.

Дулааны цахилгаан станцуудын тоноглолын насжилт 35-60 жил (Амгалан дулааны станцаас бусад), цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний насжилт 32-62 жил болж 40 орчим хувийнх нь ашиглалтын хугацаа дууссан байна. Насжилт өндөртэй шугам сүлжээг шинэчлэх хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тогтсон хугацаанд бүрэн шинэчилж чадахгүй өдийг хүрсэн бөгөөд үндсэн тоноглолуудын аваарын зогсолт хийх, цахилгаан дамжуулах, түгээх шугам сүлжээний их бага хэмжээний гэмтэл, тасралтын тоо жил бүр нэмэгдэж байна. 2025 оны 6 дугаар сард "ДЦС-3" ТӨҮГ томоохон гэмтэл гарсан ба 2025-2026 оны өвлийн ачааллыг хангахад эрсдэл үүсээд байна. Эрчим хүчнийг тасралтгүй найдвартай үйл ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой байна.

Мөн эрчим хүчний нийт үйлдвэрлэлд алдагдал өндөр буюу дулааны эрчим хүчний 18-19 хувийг, цахилгаан эрчим хүчний 13-15 хувийг түгээлт, дамжуулалт болон барилга байгууламжийн дулааны алдагдлаас шалтгаалан алдаж байна.

Эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлттэй уялдан жил бүр 7-8 хувиар нэмэгдэж байгаа ч шинэ эх үүсвэр хангалттай нэмэгдэхгүй байгаатай холбоотойгоор дотоодын ДЦС-уудын хүчин чадал дутагдаж, дотоодын хэрэгцээний өсөлтийг гүйцэхгүй байна. Эрчим хүчний нэмэгдэл эрэлтийг хангахын тулд эрчим хүчний импорт улам өсөж, валютын гарах урсгалыг нэмэгдүүлж байна. Мөн өвлийн их ачааллын үед суурилагдсан бүрэн хүчин чадлаараа, нөөц тоноглолгүй аваарын нөхцөл байдалд ажилласан хэвээр байгаа оргил ачааллын үед хэсэгчилсэн цахилгаан эрчим хүчний хязгаарлалт хийж байна. Энэ нь улмаар бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй байна.

Цаашид эрчим хүчний бие даасан тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болохын тулд ирэх 5 жил эрчим хүчний салбар томоохон станцын бүтээн байгуулалт болон шинэчлэлийг хийж эрчим хүчний хэрэглээгээ дотооддоо бүрэн хангахаар зорьж байна.

Олон төрөлт эх үүсвэрийг бий болгож цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 2024 онд 8,754.7 сая кВт.ц байгаа бол 2030 онд 1.6 дахин нэмэгдүүлж 14,078.0 сая кВт.ц

хүргэнэ. Засаглалын шинэчлэлийг эрчимжүүлэх замаар эрчим хүчний найдвартай, тогтвортой байдлыг хангаж цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амыг 100.0 хувьд хүргэж, эрчим хүчний хэрэглээгээ дотооддоо бүрэн хангана. Үүний тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар цахилгаан эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлж суурилагдсан хүчин чадлыг 3,074.6 МВт-аар өсгөж 4,888.6 МВт-д хүргэнэ. Олон талт санхүүгийн механизмыг бүрдүүлэх замаар эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг нэмэгдүүлж, оргил ачаалалд тохируулгын эх үүсвэрийн чадлыг 386.6 МВт, үйлдвэрлэлийг 1,399.8 МВт.ц болж нэмэгдэнэ. Мөн дэд бүтэц, техникийн шинэчлэл хийх замаар хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулж төвлөрсөн дулаан хангамжийн суурилагдсан чадлыг 4,013 МВт хүргэж 513 МВт-аар нэмэгдүүлнэ.

3.3.7. Зам, тээвэр

Эдийн засгийн нийлүүлэлтэд хүчтэй нөлөөлж, урт хугацааны өрсөлдөх чадвар, бүтээмжийг дэмждэг салбар бол зам тээвэр, логикийн салбар билээ.

Зам, тээврийн салбар нь бүх төрлийн тээврээр 2024 онд 131.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 2020 онтой харьцуулахад 70.8 сая тонн буюу хоёр дахин нэмэгдсэн байна. Нийт тээсэн ачааны 64.9 хувийг авто замаар, 35.0 хувийг төмөр замаар тээвэрлэсэн бөгөөд нийт ачааны 90.5 хувь буюу 118.6 сая тонн нь уул уурхайн салбар, 5.1 сая тонн буюу 3.9 хувь нь барилгын салбарын ачаа байна. (Хүснэгт 49-д харуулав)

Хүснэгт 49. Зам, тээврийн салбарын өсөлт

	2020	2021	2022	2023	2024
Дамжин өнгөрөх ачаа /мян.тн/	4,278.1	4,239.6	3,175.0	5,094.4	5,299.2
Ачаа гаргалт экспорт /мян.тн/	40,235.5	26,395.2	40,647.4	79,373.8	93,686.7
Ачаа оруулалт импорт /мян.тн/	4,539.7	4,368.5	4,976.6	6,639.5	6,883.1
Тээвэрлэсэн ачаа /мян.тн/	60,297.7	49,169.9	60,769.5	107,377.6	131,075.0
Төмөр зам /мян.тн/	29,840.1	31,193.2	27,680.9	36,114.1	45,899.1
Авто зам /мян.тн/	30,454.9	17,970.3	33,075.6	71,254.9	85,165.5
Агаарын зам /мян.тн/	2.7	6.4	12.9	8.57	10.4

Эх сурвалж: Зам, тээврийн яам

Зорчигч тээврийн хувьд 2024 онд 149.4 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өссөн байна. Үүнээс авто тээврийн нийслэлийн нийтийн тээвэр 142.8 сая зорчигч, улс, хот хооронд 2.3 сая зорчигч тээвэрлэсэн байна. Агаарын тээврээр 2.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 25.2 хувь, усан замаар 94.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 45.7 хувь, төмөр замаар 2.0 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 7.7 хувиар буурчээ.

Дэлхийн банкнаас гаргадаг улс орны логикийн системийн чанар, үр ашиг, өрсөлдөх чадварыг хэмждэг үзүүлэлт болох логикийн гүйцэтгэлийн индекс (Logistics Performance Index, LPI)-ээр 2023 оны байдлаар манай улс 139 орноос 2.5 оноотойгоор 109-д эрэмбэлэгдсэн байна.

Тус индекс нь:

- ✓ Улс орны логикийн гүйцэтгэл дэлхийд ямар түвшинд байгааг харьцуулах
- ✓ Худалдаа, тээвэр, дэд бүтэц, гаалийн процесс зэрэгт сайжруулах шаардлагатай хэсгийг илрүүлэх
- ✓ Бодлого боловсруулагч, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргах суурь мэдээлэл болох зорилготой.
- ✓ Үндсэн 6 гол шалгуур үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:
- ✓ Customs (Гааль, хил дээрх үйл ажиллагаа)
- ✓ Гаалийн шалгалт, хилийн нэвтрэлт хурдан, үр ашигтай юу гэдгийг хэмжинэ.
- ✓ Infrastructure (Дэд бүтэц)
- ✓ Зам, төмөр зам, боомт, агаарын тээвэр, мэдээллийн технологийн дэд бүтцийн чанарыг үнэлнэ.

- ✓ International Shipments (Олон улсын ачилт)
- ✓ Улс хоорондын бараа тээвэрлэлтийн үнэ, хурд, хүртээмжийн түвшин.
- ✓ Logistics Competence (Логистикийн үйлчилгээний чадвар)
- ✓ Тээвэр, экспедитор, агуулах зэрэг логистикийн үйлчилгээ үзүүлэгчдийн чанар, ур чадвар.
- ✓ Tracking and Tracing (Мөшгөх ба хянах чадвар)
- ✓ Илгээмж, ачилтыг онлайнаар дагах, ил тод байдлын түвшин.
- ✓ Timeliness (Хүргэлтийн хугацаа, цаг баримтлах чадвар)
- ✓ Ачаа, илгээмж төлөвлөсөн хугацаандаа очих магадлал

Хүснэгт 50. Логистикийн гүйцэтгэлийн индекс

Дд	Жил	Оноо	Эрэмбэ
1	2023	2.5	109
2	2018	2.37	130
3	2016	2.5	108
4	2014	2.4	135
5	2012	2.3	140

Эх сурвалж: Дэлхийн банк

Авто зам: Монгол Улс нийт 111,916.7 км авто замын сүлжээтэй. Үүнээс олон улс, улсын чанартай 14,960.1 км авто зам, орон нутгийн чанартай 95,990.6 км авто зам, тусгай зориулалтын 966.0 км авто зам тус тус байна.

Авто замын салбарт 2024 онд нийт 567.1 км хатуу хучилттай авто зам, 208.9 урт метр гүүр шинээр ашиглалтад орж 2020 онтой харьцуулахад 64.9 хувь буюу 223.1 километрээр нэмэгдлээ. Ингэснээр олон улс, улсын чанартай 7,887.8 км, орон нутгийн чанартай 1,976.7 км, тусгай зориулалтын 966.0 км, нийт 10,830.5 км хатуу хучилттай авто замтай болсон ба нийт авто замын сүлжээний 9.6 хувь, олон улс, улсын чанартай авто замын 52.7 хувь нь хатуу хучилттай авто зам болсон. (Хүснэгт 51-д харуулав)

Хүснэгт 51. Шинээр ашиглалтад орсон зам, гүүрний урт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Шинээр ашиглалтад орсон замын урт	км	344	90.7	142.5	318.9	567.1
Шинээр ашиглалтад орсон гүүрний урт	урт/м	648.9	1181.5	500.24	841.87	208.9

Эх сурвалж: Зам, тээврийн яам

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Азийн авто замын сүлжээний босоо тэнхлэгийн АН-3 чиглэлийн, АН-4 болон хэвтээ тэнхлэгийн АН-32 чиглэл дайран өнгөрдөг. Орос-Хятадыг хатуу хучилттай авто замаар холбосон Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн 1,002.9 км авто замын сүлжээний Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км авто замын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж, хөдөлгөөнийг бүрэн нээсэн.

Авто замын сүлжээг өргөжүүлснээр 2024 оны байдлаар 21 аймаг, 107 сум хатуу хучилттай авто замтай болжээ.

Авто тээвэр: Олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 16 улстай байгуулан олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж байна. Монгол Улсын хэмжээнд 2024 онд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл 1,338,956 байгаа өмнөх оноос 146,436 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн буюу 12.3 хувиар өссөн байна. Нийт тээврийн хэрэгслийн 66.9 хувь буюу 896,277 суудлын автомашин, 15.7 хувь буюу 210,780 ачааны автомашин, 1.8 хувь буюу 24,118 автобус, бусад тээврийн хэрэгсэл 15.6 хувийг тус тус эзэлж байна.

Улсын хэмжээний нийт тээврийн хэрэгслийн 59.5 хувь буюу 796,681 тээврийн хэрэгсэл Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Авто тээврээр 2024 онд 85.1 сая тонн ачаа тээвэрлэсэн ба өмнөх оны мөн үеэс тээвэрлэсэн ачаа 13.9 сая тонноор өссөн байна. Нийт тээвэрлэсэн ачааны 82.1 сая тонн экспортын ачаа бөгөөд өмнөх оноос

20.3 хувь, 3.1 сая тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.6 хувиар тус тус өссөн байна.

Экспортын тээвэрлэлтийг боомтуудаар авч үзвэл нийт 12 боомтоор 82.1 сая.тн ачаа тээвэрлэснээс Гашуунсухайт боомтоор 38.7 сая.тн, Шивээхүрэн боомтоор 24.6 сая.тн, Ханги боомтоор 8.7 сая.тн, Булган боомтоор 3.5 сая.тн бусад боомтоор 6.6 сая.тн ачаа тээвэрлэсэн байна. Тус салбар 2024 онд авто тээврээр 79.6 сая тонн нүүрс (+20.3), 982.5 мянган тонн зэсийн баяжмал (+56.5%), 456.8 мянган тонн газрын тос (-12.9%), 135.2 мянган тонн бусад ачаа (-81.1%) тээвэрлэсэн бөгөөд 753.6 төмрийн хүдэр тээвэрлэсэн нь 3.6 дахин, 131.9 мянган тонн жонш 16 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн 5.5 мянган цайр экспортолсон байна.

Төмөр замын тээвэр: Монгол Улс 3,368.8 км төмөр замын сүлжээтэй бөгөөд есөн аймгийн нутгаар дамжин өнгөрдөг. Сүлжээнд 11.8 мянган хагас вагон, 7.1 мянган тавцант вагон, 2.0 мянган зорчигчийн болон тусгай зориулалтын вагон, 321 зүтгүүр бүртгэлтэй байна.

Төмөр замын сүлжээг өргөтгөх ажлын хүрээнд 2024 онд Гашуунсухайт Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Шивээхүрэн-Сэхээ боомтын монголын нутаг дэвсгэр дэх 7.1 км төмөр замын бүтээн байгуулалтыг дуусгаж ашиглалтад хүлээн авч, Гашуунсухайт-Ганцмод төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангалаа. Мөн Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км (дэлгэмэл урт 286.9 км) төмөр замын барилгын ажлыг дуусгаж, 2023 оны эхнээс зүгшрүүлэх туршилтын тээвэрлэлтийг эхлүүлсэн бөгөөд 2024 онд байнгын ашиглалтад хүлээн авсан. Төмөр замаар 2024 онд 36.1 сая.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 9.8 сая.тн буюу 27.1 хувиар өссөн байна.

Нийт ачаа тээвэрлэлтэд экспортын ачаа 11.6 сая.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 4.3 хувиар, импортын ачаа 3.8 сая.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 4.5 хувиар, дотоодын ачаа 25.2 сая.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 54.9 хувиар, дамжин өнгөрөх ачаа 5.3 сая.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 4.0 хувиар тус тус өсжээ. Экспортын ачааны 98.3 хувь буюу 11.4 сая.тн ачааг БНХАУ руу тээвэрлэсэн бол, 1.7 хувь буюу 0.2 сая.тн ачааг ОХУ руу тээвэрлэжээ. Өмнөх онтой харьцуулбал БНХАУ руу тээвэрлэсэн экспортын тээврийн хэмжээ 4.5 хувиар өссөн бол ОХУ руу тээвэрлэсэн экспортын тээврийн хэмжээ 6.7 хувиар буурсан байна.

Төмөр замаар 2024 онд тээвэрлэсэн ачааг нэр төрлөөр нь авч үзэхэд уул уурхайн бүтээгдэхүүн 34.0 сая тонн буюу 92.5 хувь, барилгын материал 1.5 сая тонн буюу 4.1 хувь, хүнсний бүтээгдэхүүн 229.8 мянган тонн буюу 0.6 хувь, хар төмөр 201.4 мянган тонн буюу 0.55 хувь, ХАА-н бүтээгдэхүүн 170 мянган тонн буюу 0.46 хувь, мод модон материал 53.3 мянган тонн буюу 0.14 хувь, тоног төхөөрөмж 34.3 мянган тонн буюу 0.1 хувь, түргэн муудах бүтээгдэхүүн 0.8 мянган тонн буюу 0.01 хувь, бусад ачаа 0.6 сая тонн буюу 1.5 хувийг тус тус эзэлж байна.

Агаарын тээвэр: Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн орон бөгөөд 2024 оны байдлаар нийт 46 улсын Засгийн газартай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулсан бөгөөд 2024 онд Их Британи, Ирланд, Унгар, Латви Улстай агаарын харилцааны хэлэлцээрийг шинээр байгуулж 57 хотын чиглэлд дотоодын 5 агаарын тээвэрлэгчид давхардсан тоогоор нийт 132 томилгоо олгосон байна. Монгол Улс нийт 16 агаарын хаалгатай бөгөөд ОХУ-тай 10 агаарын хаалгаар, БНХАУ-тай 6 агаарын хаалгаар хиллэдэг.

Монгол Улсын агаарын зайг 6 секторт хуваан агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж байна. Монгол Улсад нийт 25 нисэх онгоцны буудал байгаагаас олон улсын 5, орон нутгийн 20 нисэх онгоцны буудал байна. Үүнээс 4Е ангилал 1, 4D ангилал 1, 4С ангилал 4, 3С ангилал 18, 2С ангиллын 1, 1А ангиллын 1, гэрчилгээгүй 3 нисэх онгоцны буудал байна.

Олон улсын чиглэлд 2024 онд дотоодын агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК-ууд 11 улсын 16 чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэж байна. Агаарын тээврээр зорчигчдын 80.6 хувийг олон улсын зорчигчид эзэлж байгаа бол 19.4 хувийг орон нутгийн зорчигчид эзэлж байна.

Агаарын тээврээр 2024 онд нийт 2.2 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнө оноос 25.2 хувиар өссөн байна. Олон улсад зорчигчдын тоо 2024 онд 1.7 сая болж өмнөх оноос 33.1 хувиар өссөн бөгөөд нийт бүх төрлийн тээврээр олон улсад зорчигчдын 68.3 хувийг эзэлж байна. Мөн орон нутагт зорчигчдын тоо 2024 онд 420.4 мянга болж өмнөх оноос 0.3 хувиар өсжээ.

Агаарын тээврээр 2024 онд нийт 10.4 мянган тонн ачаа, шууданг агаарын тээврээр тээвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 21.2 хувиар өссөн байна. Үүнээс олон улсад 10,365.7 тонн ачаа тээвэрлэсэн нь нийт тээвэрлэсэн ачаа, шуудангийн 99.7 хувийг эзэлж байгаа бол орон нутагт 28.3 тонн ачаа, шуудан тус тус тээвэрлэсэн байна.

Авто тээвэр, төмөр зам, агаарын тээврийн тээвэрлэлтийн хэмжээ, чиглэл, дэд бүтэц өргөжин хөгжиж, олон улсын хамтын ажиллагаа нэмэгдсэн нь салбарын идэвхтэй өсөлтийг харуулж байна. Гэсэн хэдий ч авто тээврийн хэрэгслийн хэт төвлөрөл, боомтын нэвтрэх чадварын хязгаарлалт, төмөр замын дотоод холболтын сул байдал, агаарын тээврийн өрсөлдөөнгүй орчин зэрэг асуудлууд салбарын үр ашиг, тэнцвэртэй хөгжлийг хязгаарлаж байна. Тээвэр, логикийн салбарын дэд бүтэц, уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ операторуудыг дэмжих бодлого шаардлагатай байна.

Зам тээврийн салбар нь хөрөнгө оруулалтын хязгаарлалт, улирлын нөлөө, техник хяналтын сул байдал, боомт, зам, тээврийн уялдаа холбоо муу, агаарын болон төмөр замын өрсөлдөөн, холболт хязгаарлагдмал зэрэг олон талт тулгамдсан асуудлаас шалтгаалан тэгш бус, үр ашиг багатай хөгжиж, эдийн засгийн интеграци, бүс нутгийн тэнцвэрт хөгжилд саад учруулж байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд тээвэр зохион байгуулалтыг сайжруулах замаар тээвэр, логикийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд тээвэр зохион байгуулалтыг Хөрөнгө оруулалтын нөөц хязгаарлагдмал, төвлөрсөн байдлаар хуваарилдаг.

Тээвэр зохион байгуулалтыг сайжруулах замаар тээвэр, логикийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр зорьж байна.

Тээвэр, логикийн хүртээмжийг нэмэгдүүлснээр логикийн гүйцэтгэлийн индекс 2023 онд 2.5 оноо байгаа бол 2030 онд 2.56-д хүрч, логикийн дэд бүтцийн тоо 11 болж өснө.

Тээвэр логикийн дэд бүтцийг өргөтгөх, сайжруулах замаар Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ. Ингэснээр авто тээврээр тээсэн ачааг 11.8 сая тонноор нэмэгдүүлж 2030 онд 97.0 сая тоннд хүргэж, авто тээврээр зорчсон зорчигчийн тоо 150.0 саяд хүрч, төмөр замаар тээсэн ачаа 65.0 сая тонн, төмөр замаар зорчсон зорчигч 2.0 саяд хүрнэ. Мөн агаарын тээврээр тээсэн ачаа 0.024 сая тонн, агаарын тээврээр зорчсон зорчигч 3.0 саяд хүрч нэмэгдэнэ. Үүний тулд санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх замаар олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлж хатуу хучилттай авто замын эзлэх хувийг 65.0-д, олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын норм, стандартад нийцүүлж, хатуу хучилттай авто замын сүлжээнд 4-өөс доош тэгш байдлын үзүүлэлттэй авто замын эзлэх хэмжээг 80.0 хувьд хүргэнэ. Төмөр замын дэд бүтцийг өргөтгөх, сүлжээний бэлэн байдлыг хангах замаар төмөр замын уртыг 3,503.6 км-д хүргэж нэмэгдүүлнэ. Мөн агаарын тээврийн, Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах, хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж олон улс, орон нутгийн нисэх буудлыг

өргөтгөн шинэчилж, нислэгийн чиглэл, тоо, давтамжийг нэмэгдүүлж олон улс, орон нутгийн нислэгийг 69,000-д, улс хооронд зорчих зорчигчийг 2.2 сая хүргэнэ.

Дэвшилтэт технологи болон дижитал шийдлийг нэвтрүүлснээр ачаа, зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний үр дүнд стратегийн ач холбогдол бүхий боомтуудын хоногийн нэвтрэлтийн хэмжээ 2024 онд 783 байсан бол 1,130 болж өснө. Хил, гаалийн хяналтын процесс оновчтой болж, зорчигчийн гарц 24 (гарах-24, орох-24), ачааны гарц гарах-34, орох-34 болж нэмэгдэнэ. Мөн олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлснээр идэвхтэй ажиллагаатай боомтын тоо 28-д хүрч, нэвтрэлтийн үр ашиг сайжирна.

3.3.8. Мэдээлэл, харилцаа холбоо

Мэдээлэл, харилцаа холбооны салбар нь дижитал эдийн засгийг хөгжүүлж, бизнесийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг үр ашигтай болгож, нийгмийн харилцааг сайжруулах замаар эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээг хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт нэвтрүүлэхэд чиглэсэн томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэн 52,480 км урт шилэн кабелийн сүлжээг байгуулж, бүх аймаг, сумын төв, томоохон суурин газруудад хөдөлгөөнт холбооны 3G, 4G/LTE сүлжээг нэвтрүүллээ. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 4 сая 909 мянгад хүрч, үүнээс 4G/LTE сүлжээний хэрэглэгчдийн тоо 3 сая 664 мянга байна. Монгол Улсын хэмжээнд 1,639 баг байгаагаас 1,506 багийн иргэд үүрэн холбооны сүлжээнд холбогдоод байна. Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг (5G) нэвтрүүлэхэд баримтлах чиглэлийг 2020 онд баталж, 2021-2022 онд 5G технологийг нэвтрүүлэх техникийн туршилтыг амжилттай зохион байгуулав.

Дэлхийн харилцаа холбооны холбоо (ITU)-оос боловсруулсан, улс орнуудын мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн түвшнийг үнэлдэг олон улсын үзүүлэлт буюу мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн индекс (ICT Development Index, IDI) нь манай улсын хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд тогтвортой өсөлттэй байна. (График 26-д харуулав.) Тус индекс нь дараах 3 үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд:

- ✓ Технологийн дэд бүтэц (Infrastructure): Интернэт хурдац, 4G/5G сүлжээний хамрах хүрээ, өргөн зурвасын нэвтрэлт гэх мэт.
- ✓ Хэрэглээний түвшин (Usage): Интернэт хэрэглээ, гар утасны хэрэглээ, цахим үйлчилгээний хүртээмж.
- ✓ Мэдлэг, ур чадвар (Skills): Цахим боловсрол, мэдээллийн технологийн ур чадвар, дижитал боловсролын түвшин.

График 26. Мэдээлэл, харилцаа холбооны индекс /оноо/



Эх сурвалж: Мэдээллийн технологийн үндэсний парк

Мэдээлэл, харилцаа холбооны индекс 2024 онд 87 оноо авсан ба энэ нь 2020 онтой харьцуулахад 9.4 хувь буюу 7.5 оноогоор ахисан байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1,448 багийн 178,000 өрх буюу нийт өрхийн 94.5 хувьд үүрэн холбооны үйлчилгээ


хүргэж, цахим хэрэглээг бий болгов. Харин алслагдсан бүс нутгийн 191 багт оршин суугаа 10,412 өрхийн 42,000 иргэн үүрэн холбооны сүлжээнд холбогдож, мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг авч чадахгүй байна.

Түүнчлэн бүх аймаг, сум, томоохон суурин газарт тавигдсан харилцаа холбооны дэд бүтцийн хүчин чадал нь өсөн нэмэгдэж байгаа мэдээллийн технологийн үйлчилгээнд хангалтгүй буюу интернэтийн багтаамж бага, хурд удаан байгаагаас шалтгаалж төрийн болон хувийн хэвшлийн байгууллага цахим үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үүсэж байгаа тул шилэн кабелийг өргөтгөх, шилэн кабель тавих боломжгүй газруудад хиймэл дагуулын болон бусад технологи ашиглан харилцаа холбооны дэд бүтцийг байгуулах шаардлагатай байна.

Шуудан: Монгол Улсын 21 аймаг, 330 сумын төв шуудангийн үйлчилгээний сүлжээнд холбогдож, нийт өрхийн 88.0 хувь нь шуудангийн хүргэлт, илгээмжийн үйлчилгээг авах боломжтой болов. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн агентлаг Дэлхийн шуудангийн холбоо (Universal Postal Union)-ноос 192 улсын шуудангийн үйлчилгээний бодлого, стандарт, дижитал хөгжил, хүртээмжийн үзүүлэлтийг үнэлж шуудангийн хөгжлийн индекс (Postal Development Index)-ийг жил бүр гаргадаг бөгөөд манай улс сүүлийн 5 жилийн хугацаанд тогтвортой өсөлттэй байна. (График 27-д харуулав.) Тус индекс нь дараах 4 үндсэн хэсгээс бүрддэг:

- ✓ Хүргэлтийн найдвартай байдал, хугацаа, гомдлын түвшин (Reliability);
- ✓ Дотоод болон олон улсын хамрах хүрээ (Reach);
- ✓ Шуудангийн үйлчилгээний иргэдийн хэрэгцээнд нийцэх байдал, шинэ үйлчилгээний төрөл (Relevance);
- ✓ Салбарын тогтвортой байдал, дижитал болон эдийн засгийн уян хатан байдал (Resilience).

График 27. Шуудан үйлчилгээний индекс /оноо/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд цахим хаягийн систем нэвтрүүлэх, хөдөө орон нутгийн айл өрхөд илгээмж хүргэх үйлчилгээг сайжруулах чиглэлд ажиллаж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбар нь дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжиж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж байгаа ч дэд бүтцийн хүчин чадал, интернэтийн хурд, багтаамж хөдөө орон нутагт хангалтгүй хэвээр байна. Үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй алслагдсан багууд, цахим үйлчилгээ авч чадахгүй өрхүүдийн тоо өндөр байгаа нь мэдээллийн тэгш бус хүртээмжийг илтгэж байна. Мөн шуудангийн үйлчилгээ өргөжиж байгаа ч зарим бүс нутагт хүртээмж, чанар, дижитал шийдлийн нэвтрэлт хангалтгүй байна. Иймд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг тэлэх, технологийн шинэчлэл, хиймэл дагуулын шийдлийг ашиглан алслагдсан бүс нутгийг хамруулах шаардлагатай байна.

Цаашид хүн амын тоо болон аялал жуулчлалын тэргүүлэх бүс нутаг зэргийг харгалзан үзэж 151 багт харилцаа холбооны дэд бүтэц байгуулан үүрэн холбооны

үйлчилгээ хүргэж, иргэдэд гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний зарлан мэдээллээс хоцрох, төрийн цахим үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авахгүй байх зэрэг эрсдэлийг бууруулахаар ажиллаж байна. Үүний тулд мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийг эрчимжүүлж, мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн индексийг 5 оноогоор ахиулж 92 болгоно. Интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх буюу интернэт ашигладаг хувь хүмүүсийн эзлэх хувь 15, түүнээс дээш насны хүмүүс 2024 онд 77.7 хувь байгааг 85.0 хувьд хүргэнэ. Мөн үүрэн холбооны дэд бүтэц байгуулсан багийн тоог 95.7 болгоно.

Алслагдсан сум, баг, суурин газрын 40 гаруй мянган өрх шуудангийн тогтмол үйлчилгээ авах боломжгүй, хүргэлтийн зардал өндөр, авто болон дэд бүтцийн хүртээмж муу байгаагаас шуудангийн хүртээмж, чанар, хугацааны ялгаа үүссээр байна. Мөн орон нутаг болон хилийн боомтод шуудангийн ялган боловсруулах төв, логистикийн байгууламж байхгүйгээс Шуудангийн хөгжлийн индексийн гол үзүүлэлт болох хүргэлтийн хугацаа, найдвартай байдал хангалтгүй хэвээр байна.

Мөн харилцаа холбооны дэд бүтэц тавигдсан газруудын харилцаа холбооны дэд бүтцийг өргөтгөн шинэчилж, мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн индексийг 2024 онд 0.94 түвшинд байсныг 2030 онд 1-р түвшинд хүргэнэ.

Замын Үүд боомтод шуудан, логистикийн төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан, хөдөө орон нутагт бүсчилсэн байдлаар логистикийн төв байгуулан орон нутгийн хэрэглэгчдийн шуудан, цахим худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хөдөө орон нутгийн иргэдэд хямд бүтээгдэхүүнийг хурдан шуурхай, найдвартай хүлээн авах боломжийг бүрдүүлэхээр зорьж байгаа ба дэлхийн шуудан холбооноос жил бүр шинэчлэн гаргадаг Шуудангийн хөгжлийн индекс (шуудан холбооны гишүүн орнуудыг 10 түвшинд эрэмбэлдэг)-ээр Монгол Улс 2024 онд 46.4 буюу 5 дугаар түвшинд байсныг 2030 онд 8 дугаар түвшинд хүргэнэ.

3.4. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ

Байгаль орчны гүйцэтгэлийн индекс (EPI)⁶¹-ээр 180 гаруй улс орны уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчин, экосистемийн төлөв байдлыг 58 гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр 2 жил тутамд эрэмбэлэн гаргадаг байна. Монгол Улсын тухайд уг индексээр 2020 онд 32.2 оноо авч 147 дугаар байрт, 2022 онд 29.6 оноогоор 155 дугаар байрт, 2024 онд 37.2 оноогоор 143 дугаар байрт жагсжээ. Энэ нь Монгол Улсын байгаль орчны гүйцэтгэл тогтворгүй, жил бүр харилцан адилгүй үнэлэгдэж байгааг харуулж байна. (хүснэгт 52-т харуулав).

Хүснэгт 52. Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	2020 он			2022 он			2024 он
	Эрэмбэ	Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн оноо	Эрэмбэ	Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн оноо	Эрэмбэ	Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн оноо	Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн оноо
Байгаль орчны гүйцэтгэлийн индекс EPI	147	32.2	155	29.6	143	37.2	37.2
Экосистемийн төлөв байдал	128	27.6	83	45.9	68	55.2	55.2
Орчны эрүүл мэнд	147	35.3	141	23.8	140	28.5	28.5
Уур амьсгалын өөрчлөлт	173	17.4	178	14.6	177	17.6	17.6

Эх сурвалж: Йелийн их сургууль

Тиймээс дээрх нөхцөл байдлыг сайжруулахын тулд экосистемийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, байгалийн нөөцийн хамгаалал,

⁶¹ Ейлийн Их сургуулиас хийсэн үнэлгээ, 2024

нөхөн сэргээлт, зохистой ашиглалт зэргийг онцлон анхаарч шийдвэрлэх, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

Цаашид байгаль орчны тогтвортой байдлыг хадгалахын тулд анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар байгаль орчны гүйцэтгэлийн индексийг 2024 онд 37.2 онооноос 2030 онд 59 оноо хүртэл нэмэгдүүлэхийг зорьж байна.

3.4.1. Анхдагч экосистемийн тэнцвэрт байдал

Уур амьсгалын өөрчлөлт болон хүн ам, эдийн засгийн хурдацтай өсөлт, хотжилт, үйлдвэржилт зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөгөөр сүүлийн 25 жилд дэлхийн экосистемийн үйлчилгээ⁶² 60.0 хувиар буурсан байна. Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн нэг бүлэг болох экосистемийн төлөв байдлыг нийт 6 дэд үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд тэдгээрийн нэг дэд үзүүлэлт нь “Биологийн олон янз байдал ба амьдрах орчны үзүүлэлт” юм. Уг үзүүлэлтийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн төлөөллийн индекс (PARI) нь 2024 онд хамгийн бага буюу 26.5 оноогоор үнэлэгдсэн байна. Тусгай хамгаалалттай газар нутаг нь дэлхийд ховордсон, эмзэг зүйлсийн амьдрах орчныг хадгалах үндсэн хэрэгсэл юм⁶³.

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор болон ховордсон ургамал, амьтан, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх, мөн газар нутгийн унаган төрхийг хамгаалах зорилгоор тодорхой нутаг дэвсгэрийг улсаас тусгай хамгаалалтад авдаг. Монгол Улс 2024 оны байдлаар улсын тусгай хамгаалалтад 32.8 сая.га газрыг авсан ба энэ нь нийт нутаг дэвсгэрийн 20.8 хувийг эзэлж байна. Харин Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбай 49.9 хувийг эзэлж байна. (Хүснэгт 53-т харуулав)

Хүснэгт 53. Ногоон хөгжил зорилгын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт

дд	Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	21.0	21.0	21.0	21.0	20.8
2	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	49.9	49.9	49.9	49.9	49.9

Эх сурвалж: Алсын хараа 2050-ын 2020-2024 оны хэрэгжилтийн тайлан

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн болон гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувьд 2020-2024 онд бодит ахиц гараагүй байна. Энэ нь “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан, 2030 он гэхэд нийт газар нутгийн 30 хувийг улсын тусгай хамгаалалтад хамруулах зорилтыг биелүүлэхийн тулд ирэх таван жилд 14.0 сая.га газрыг шинээр хамгаалалтад авах шаардлагатай.

Улсын хэмжээнд дархан цаазат газар 23 буюу 13.8 сая.га талбай, байгалийн цогцолборт газар 37 буюу 13.5 сая.га, байгалийн нөөцийн газар 47 буюу 5.3 сая.га, дурсгалт газар 13 буюу 0.1 сая.га талбайг хамрах нийт 120 тусгай хамгаалалттай газар байна. (Хүснэгт 54-т харуулав)

⁶² Экосистемийн үйлчилгээ нь хүн төрөлхтний байгаль, экосистемээсээ үнэ төлбөргүйгээр хүртэж буй үр ашиг юм (Монгол Улсын Шинжлэх ухааны академийн нийтлэл, 2022.02.28)

⁶³ Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн биологийн олон янз байдлын суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа хийх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний тайлан, 2016.

Хүснэгт 54. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, 2024 он

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллаар	Тоо	Талбайн хэмжээ, сая.га
Дархан цаазат газар	23	13.8
Байгалийн цогцолборт газар	37	13.5
Байгалийн нөөц газар	47	5.3
Дурсгалт газар	13	0.1
Нийт дүн	120	32.8

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Монгол Улсаас дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд 7 газар бүртгэгдсэн байна. Үүнээс гадна орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын менежментийг нийт 42 хамгаалалтын захиргаа хариуцан ажиллаж байна. Үүнд: улсын төсвөөс санхүүждэг 35, төрийн бус байгууллагын 7 хамгаалалтын захиргаа байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх арга замын нэг нь менежментэд ашиглаж буй арга аргачлалыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх явдал юм. Иймээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас үр дүнд суурилсан, дасан зохицох менежментийн зарчимд нийцсэн, талуудын оролцоонд тулгуурласан менежментийн төлөвлөлтийн арга зүйг шинэчлэн гаргасан. Тус арга зүйг ашиглан тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийн үр ашигт байдлыг сайжруулах шаардлагатай тулгараад байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувьд тодорхой ахиц гараагүй байгаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцад хүндрэл үүсгэж байна. Энэ нь олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан биологийн олон янз байдал, мөн зөвхөн Монгол Улсад бүртгэгдсэн ховор зүйлийн тоо толгой цөөрч, устах аюулд өртөхөд нөлөөлж байна. Монгол орны ургамлын төрөл зүйлүүдийг 2022-2023 онд Улаан дансны шалгуураар үнэлж, нийт 1436 зүйл ургамал дараах нөлөөгөөр ховордож байгааг тогтоожээ (Хүснэгт 55-д нөлөөллөөр задлан харуулав).

Хүснэгт 55. “Улаан данс”-ны 4-р цувралын үнэлгээ

ДД	Ховордож байгаа шалтгаан	Эзлэх хувь
1	Амьдрах орчны алдагдал ба доройтол	39.3
2	Байгалийн гамшиг (ган гачиг, салхи шуурга гэх мэт)	26.9
3	Орчны бохирдол	18.6
4	Дотоод хүчин зүйлс (тархалт хязгаарлагдмал, нягтшил бага, эзэмшил нутаг хумигдах)	9.1
5	Хүний шууд нөлөө	3.5
6	Нөөц ашиглалт	1.3
7	Зүйлийн динамик өөрчлөлт	0.7
8	Харь зүйлийн нөлөө	0.6

Эх сурвалж: “Улаан данс”-ны 4-р цуврал

Иймд ус, ой, биологийн олон янз байдлын чухал бүс нутгийг үр дүнтэй хамгаалж, менежментийг сайжруулах шаардлага тулгараад байна.

Цаашид тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр өгөөжийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Ингэснээр байгаль орчны тогтвортой байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой юм.

Дээрх үр дүнг бий болгохын тулд тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийн үр ашигт байдлыг сайжруулах хэрэгцээтэй бөгөөд оролцогч талуудын хамтын ажиллагаа зөвшилцлийг бэхжүүлэх замаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 2024 онд 20.8 хувь байгааг 2030 онд 30.0 хувьд хүргэнэ. Мөн онцлог экосистемийн төлөөлөл бүхий газар нутгийн судалгааг өргөжүүлэх замаар тусгай хамгаалалтад авсан усны урсац бүрдэх эхийн эзлэх хувийг 2024 онд 49.9 хувь байгааг

2030 онд 60.0 хувьд, тусгай хамгаалалтад авсан ойн сан бүхий газрын эзлэх хувийг 2024 онд 42.3 байсныг 50.0 хувьд тус тус хүргэхээр төлөвлөсөн.

3.4.2. Хүлэмжийн хий

Монгол улс газар зүйн байрлалын хувьд, далайн түвшнээс дээш өргөгдөж, өндөр уулс нуруудаар хүрээлэгдсэн, Евро-Азийн төвд орших далайд гарцгүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд ихээр өртөж байгаа орнуудын нэгд зүй ёсоор ордог⁶⁴.

Уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан болж байгаа хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг 2 жил тутамд тооцдог бөгөөд нь 2018 онд нийт 42,544.2 мян.тн CO₂-экв, 2022 оны урьдчилсан үзүүлэлтээр 48,509.1 мян.тн CO₂-экв хэмжээнд хүрч 5,964.9 мян.тн CO₂-экв хэмжээгээр нэмэгдсэн байна (Хүснэгт 56-д харуулав).

Хүснэгт 56. Хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ, мян.тн CO₂-экв

Он	Эрчим хүч	Эрчим хүчний бус	Хөдөө аж ахуй	Хог хаягдал	Нийт
2018	19,813.9	841.8	21,669.7	218.7	42,544.2
2020	19,292.5	1,147.7	22,390.6	250.8	43,081.6
2022*	20,394.8	709.9	26,762.2	642.1	48,509.1

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Харин хүлэмжийн хийн ялгарлын бууралт 2020 оны байдлаар 1,006.6 мян.тн CO₂-экв хэмжээтэй байсан бол 2024 онд 2,982.9 мян.тн CO₂-экв хэмжээнд хүрч бууралтын хэмжээ 2.9 дахин нэмэгдсэн байна. (График 28-д харуулав.)

График 28. Хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт, 2024 он



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмэр: Монгол Улс 1992 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцод, 2016 онд Парисын хэлэлцээрт нэгдэн орж, дэлхийн улс орнуудын адилаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо 5 жил тутамд шинэчлэн баталж байна. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтоо 2015 онд 14 хувь, 2019 онд 22.7 хувиар бууруулахаар тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хамгийн сүүлд 2025 онд шинэчлэн баталсан 2035 он хүртэл хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН3.0)-ийн зорилтод хүлэмжийн хийн нийт ялгарлыг суурь түвшинтэй харьцуулахад 2025 онд 4.9 хувь, 2030 онд 23 хувь, 2035 онд 30 хувиар тус тус бууруулахаар 2019 оны зорилтоо 7.6 хувиар ахиулж шинэчлэн тодорхойлсон (Хүснэгт 57-д харуулав).

Хүснэгт 57. Хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт (дэд салбараар), мян.тн CO₂-экв.

ҮТХН 3.0	2025	2030	2035
Эрчим хүчний үйлдвэрлэл	959.5	5,556.3	8,264.9
Хөдөө аж ахуй	1,009.5	5,277.7	9,781.2
Аж үйлдвэр	682.2	1,163.6	1,313
Зам тээвэр	70.6	2,762.2	3,465.9
Барилга	80.2	633.5	1,066.1

⁶⁴ Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх монголчуудын мэдлэг, хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа, 2023

Хог хаягдал	3.9	641.5	844.4
Хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт	2,806.1	16,034.9	24,735.4
Хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт, хувь	4.9	23.0	30.3


Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Монгол Улсын хэмжээнд 2035 он хүртэл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтыг салбаруудаар авч үзвэл эрчим хүч 8,264.9 мян.тн CO₂-экв, барилга 1,066.1 мян.тн CO₂-экв, аж үйлдвэр 1,313.0 мян.тн CO₂-экв, тээвэр 3,465.9 мян.тн CO₂-экв, хөдөө аж ахуй 9,781.2 мян.тн CO₂-экв, хог хаягдал 844.3 мян.тн CO₂-экв нийт 24.7 сая.тн нүүрстөрөгчийн давхар ислийн эквивалент (CO₂-экв)-тай тэнцэх хэмжээгээр бууруулахаар зорьжээ.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг 2020-2024 оны байдлаар үнэлэхэд 2024 онд суурь сценаритай харьцуулахад 7,519.7 мян.тн CO₂-экв хэмжээгээр бууруулах зорилтод хүрээгүй, 39.7 хувь буюу 2,982.9 мян.тн CO₂-экв хэмжээгээр бууруулсан байна. Үүнээс харахад эрчим хүчний болон эрчим хүчний бус салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хүлэмжийн хийн ялгарал тогтвортой буурч байна.

Харин 2022 онд малын тоо толгой өссөний улмаас хүлэмжийн хийн ялгарал 5,352.5 мян.тн CO₂-экв хэмжээгээр бууруулах зорилтод хүрээгүй эсрэгээрээ суурь сценариас 657.0 мян.тн CO₂-экв хэмжээгээр илүү ялгаруулж 12.3 хувиар давсан байна. (зураг 2-т харуулав).

Зураг 2. Хүлэмжийн хийн ялгарлын бууруулах зорилт, GgCO₂e



Эх сурвалж: УТХН-ийн зорилтын хэрэгжилтийн тайлан, НҮБХХ, 2025

Цаашид ногоон эдийн засгийг дэмжих замаар орчны чанарыг стандарт түвшинд хүргэх, хот суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийн сайжруулах, байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэж нийт үндэсний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

Ингэхдээ 2024 онд 2,982.90 мян.тн CO₂-экв байсан хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг 2030 он гэхэд 16,034.9 мян.тн CO₂-экв хэмжээнд хүргэнэ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох дотоодын материал зарцуулалтыг 2030 он гэхэд 6.0 кг/мян.төгрөг болгож 2022 онтой харьцуулахад 2.3 кг/мян.төгрөгөөр бууруулахаар зорьж байна.

Хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэхэд нөлөөлж байгаа агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын менежментийг сайжруулах нь орчны чанарыг стандарт түвшинд хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.


Агаарын бохирдол: Монгол улсын хэмжээнд агаарын чанарын хяналт шинжилгээг 1976 оноос эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Улаанбаатар хотын агаарын чанарыг 19 цэгт хүхэрлэг хий, азотын давхар исэл, PM 2.5 тоосонцор, PM тоосонцор, озон, нүүрстөрөгчийн дутуу исэл гэсэн 6 үзүүлэлтийг автоматаар тасралтгүй, харин 21 аймгийн төв болон томоохон хот суурины 27 цэгт хүхэрлэг хий, азотын давхар исэл гэсэн үзүүлэлтийг 20 минутаар, өдөрт 3 удаагийн хэмжилтээр, PM 2.5 тоосонцрын

агууламжийг 2022-2023 онуудад бага оврын сенсор ашиглан 24 цагаар хэмжилт хийн тодорхойлж байна. Агаарын чанарын хяналт шинжилгээний дүн мэдээг Агаарын чанар. Техникийн шаардлага MM84585:2016 стандарт дахь хүлцэх агууламжтай харьцуулан үнэлдэг.

Улсын хэмжээнд ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай 352,892 зуух, 15-100 кВт хүртэл хүчин чадалтай усан халаалтын 4,521 зуух, 100- 4200 кВт хүртэл хүчин чадалтай 1,173 зуух, 4200кВт-аас дээш хүчин чадалтай 43 байгууламжийн 126 зуух тус тус бүртгэгдсэн байна.

Агаарын чанарын индексийн жилийн үнэлгээгээр 2024 онд индексийн нийт үзүүлэлт 2020 онтой харьцуулахад цэвэр түвшин 7.8 хувиар нэмэгдэж, хэвийн түвшин 4 хувиар, бага бохирдолтой түвшин 6.4 хувиар тус тус буурсан байна. Харин их бохирдолтой түвшин 0.8 хувиар, аюултай түвшин 0.2 хувиар тус тус нэмэгдсэн байна (График 29-д харуулав).


График 29. Агаарын чанарын индексийн түвшин, хувиар



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Улаанбаатар хотын 2024 оны агаар дахь бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2020 оны сарын дундаж агууламжтай харьцуулахад PM2.5, PM10 тоосонцор, хүхэрлэг хийн агууламж багасаж, азотын давхар исэл 1 мкг/м³-аар нэмэгдсэн байна. (График 30-д харуулав)


График 30. Агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж, мкг/м³



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Орон нутагт 2024 оны байдлаар хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 3-28 мкг/м³-ийн хооронд хэлбэлзэж, үүнээс Алтай, Баянхонгорт агаарын чанарын стандартаас 2-6 мкг/м³-ээр их байна. Бусад аймгийн хувьд чанарын стандарт (MNS4585:2016) дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Харин азотын давхар ислийн агууламжаар Эрдэнэт, Мөрөн, Арвайхээр хотууд бохирдолтой байна. Аймгийн төвүүдэд 2025-2026 онд PM10, PM2.5 тоосонцрын хэмжилтийн багаж суурилуулах ажил хийгдэж байна. (График 31-д харуулав.)

График 31. Аймгийн төвүүдийн хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж, мкг/м³



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Иймд эдгээр дүн мэдээ, тайлан, зураглалыг үндэслэн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөх, бохирдол багатай цэвэр технологи нэвтрүүлэх замаар Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг бууруулах шаардлага тулгарч байна.

Үүний тулд Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын дундаж агууламж 2024 онд 53 мкг/м³ байсныг 2030 он гэхэд 38 мкг/м³, PM10 тоосонцрын дундаж агууламж 100 мкг/м³ байсныг 2030 он гэхэд 84 мкг/м³, азотын давхар исэл (NO2)-ийн дундаж агууламж 54 мкг/м³ байсныг 2030 он гэхэд 50 мкг/м³, хүхэрлэг хий (SO2)-н дундаж агууламж 80 мкг/м³ байсныг 2030 он гэхэд 74 мкг/м³ болгож бууруулах зорилтыг тавьж, орчны чанарыг стандарт түвшинд хүргэнэ.

Ингэснээр агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой хот суурин газрын тоог 2024 онд 21 байсныг 2030 он гэхэд 12 болгож бууруулах юм.

Ус, хөрсний бохирдол: Ус, хөрсний бохирдол нь боловсруулах үйлдвэр бохирдол ихтэй усаа гадагшлуулснаас үүдэн цэвэрлэх байгууламжуудын ачаалал нэмэгддэг.

Улсын хэмжээнд хөрсний чанарын хяналт шинжилгээг 396 цэгт, Улаанбаатар хотод жил бүр 102 цэгт, аймгийн төвүүдэд хоёр жил тутам 294 цэгт хяналт шинжилгээ хийж байна. Монгол орны гадаргын усны чанарын хяналт-шинжилгээний улсын сүлжээнд 94 гол мөрөн, 19 нуурын 193 цэгээс жилд 4-12 удаагийн сорьц авч, хяналт шинжилгээг хийн гадаргын усны чанарыг тодорхойлж байна.

Гадаргын усны чанарыг усны бохирдлын индексээр тодорхойлдог бөгөөд 2021-2023 оны үнэлгээгээр “Бохир”, “Маш бохир”, ангилалд Туул голын Сонгино доод, Хадан хясаа, Алтанбулаг, Хиагт (Сэлэнгэ), Уртбулаг (Орхон) гол, “Бохирдолтой” ангилалд Туул голын Шувуун фабрик, “Бага бохирдолтой” ангилалд Сэлбэ, Дундгол, Хангал, Чингэл (Эрдэнэт), Туул голын Лүн орчимд ажиглагдаж байна.

Монгол орны гадаргын усны объектуудаас маш их бохирдолтой байгаа нь Туул голын Сонгины гүүр орчмоос Алтанбулаг хүртэлх хэсэг, Сэлэнгэ аймгийн Хиагт гол, Орхон аймгийн Хангал гол байна. Туул голыг бохирдуулж буй гол эх үүсвэр нь Толгойт дахь Төв цэвэрлэх байгууламж, Хиагт голыг бохирдуулж буй эх үүсвэр хилийн

чанадаас, Хангал голын эх үүсвэр цэвэрлэх байгууламж юм. 2021-2023 онд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар жилд дунджаар 59.1%-тай байна.

Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн ам 2021 онд 83.0 хувь байгааг 2024 онд 83.6 хувь, харин ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн ам 2021 онд 69.2 хувиас 2024 онд 69.4 хувь хүрч нэмэгдсэн байна (Хүснэгт 58-д харуулав).

Хүснэгт 58. Ногоон хөгжил зорилгын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

дд	Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
1	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	-	83.0	83.5	83.5	83.6
2	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	-	69.2	69.3	69.4	69.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цаашид алтны үндсэн ордын ашиглалт нэмэгдэхийн хэрээр циант, хүхрийн хүчил болон бусад уул уурхайн технологийн хэрэгцээний хорт бодисоор гол мөрний сав газар бохирдож, бохирдлын байнгын эх үүсвэрүүд буй болох магадлал их байгаа тул усны тоо хэмжээнээс гадна чанарын байнгын хяналт шинжилгээ, судалгааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Үүний тулд бохирдуулагч эх үүсвэрийг орлуулах бүтээгдэхүүнийг дэмжих замаар орчны чанарыг стандарт түвшинд хүргэхээр зорьж байна.

Дээрх үр дүнд хүрэхдээ усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэгийн тоог бууруулж, чанарын үнэлгээг 2024 онд 89.6 хувь байсныг 2030 онд 95.0 хувьд хүргэж ахиулна.

Хог хаягдал: Улс орны хог хаягдлын бүтэц өөрчлөгдөн, хэмжээ нэмэгдэж байгаа нь хүлэмжийн хийн ялгарал, агаар орчны бохирдлын гол эх үүсвэр болж байна.

Улсын хэмжээнд цуглуулж, тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээ 2021 онд 2402.5 мянган тонн байсан бол 2022 онд 2496.5 мянган тонн болж, 3.9 хувиар нэмэгдсэн, 2023 онд 2082.4 мянган тонн болж өмнөх оноос 16.6 хувиар буурсан байна. 2023 онд энгийн хатуу хог хаягдлын 63.7 хувийг өрхийн хог хаягдал, 36.3 хувийг ААНБ, зам талбай, бусад газраас цуглуулсан хог хаягдал эзэлж байна

Цуглуулсан хог хаягдлын тодорхой хэсэг нь дахин ашиглагдаж, дахин боловсруулагддаг. (Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын 2021-2023 оны мэдээг хүснэгт 59-д харуулав).

Хүснэгт 59. Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдал, мян.тн

дд	2021			2022			2023		
	Нийт	ААНБ	Өрх	Нийт	ААНБ	Өрх	Нийт	ААНБ	Өрх
1	2402.5	881.7	1520.8	2496.5	916.2	1580.3	2082.4	755.6	1326.8


Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

2023 оны байдлаар дахин ашиглах, боловсруулахаар цуглуулсан хог хаягдлын бүтцийг хог хаягдлын төрлөөр авч үзвэл хаягдал төмөр 10.9%, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 12.9%, хүнсний бүтээгдэхүүний хаягдал 5.8%, цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 15.3%, барилгын хог хаягдал 9.9%, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 27.7%, автомашины эд ангийн хог хаягдал 5.8%, бусад хог хаягдал 10.9%-ийг тус тус эзэлж байна.

Байгаль, цаг уурын аюулт үзэгдэл: Монгол орны жилийн дундаж агаарын температур сүүлийн 85 жилд цельсийн 2.5 хэмээр дулаарсан бөгөөд 1988 оноос хойш

дулаарал эрс нэмэгдэж, хур тунадасны горим өөрчлөгдөж байна. Уур амьсгалын эрчимтэй өөрчлөлтийн улмаас ган, зуд болон хүчтэй салхи, шуурга, ширүүн аадар, уруйн үер зэрэг ус, цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж сүүлийн 20 гаруй жилд 2 дахин ихсэж, тэдгээрээс үүдсэн нийгэм, эдийн засгийн учрах хохирол нэмэгдсэн. (График 32-т харуулав.)

График 32. Аюулт, гамшигт үзэгдлийн давтамж



Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар

Улсын хэмжээнд 2001-2024 онд цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн улмаас 599 хүн амь эрсдэж, 29,780.0 мянган толгой мал хорогдож, 844.1 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан байна.


Улсын хэмжээнд 2024 онд 15 төрлийн, нийт 104 удаагийн цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл болсноос аюултай үзэгдэл 91 удаа, гамшигт үзэгдэл 13 удаа болж үүний улмаас 3 хүн амь насаа алдаж, 3.0 сая толгой мал хорогдож, улсын чанартай авто зам, гүүр 13, 4 эрчим хүчний шон, нурсан гэр 108, барилгын дээвэр хуурч унасан тохиолдол 10, 374 хашаа эвдэрч, шороон шуурганд өртсөн авто машины шил 5 байсан ба 3.0 га тариалангийн талбай өртсөн бөгөөд 3.3 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан байна.

Манай улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 63 удаа тохиолддог байна. Харин сүүлийн 10 жилд дунджаар 99 удаа болж нэмэгдсэн байна.

Иймд байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх ажлыг сайжруулах шаардлага тулгарч байна. Үүний тулд дэвшилтэт технологи нэвтрүүлэх нь маш чухал бөгөөд ингэснээрээ цаг агаарын урьдчилсан мэдээ болон орчны чанарын талаарх мэдээллийг хариуцан гаргадаг мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.

Хүлэмжийн хийн ялгарал, салбар: Монгол Улс 2018 оны байдлаар 42,544.2 мян.тн CO₂-экв дүйцэхүйц хүлэмжийн хий ялгаруулж байгаагаас 46.5 хувь нь эрчим хүч, 50.9 хувь нь хөдөө аж ахуй, 1.9 хувь нь эрчим хүчний бус, үлдсэн 0.5 хувь нь хог хаягдлын салбараас ялгарч байна. Харин 2024 оны байдлаар 48,509.1 мян.тн CO₂-экв дүйцэхүйц хүлэмжийн хий ялгаруулж байгаагаас 42.0 хувь нь эрчим хүч, 55.1 хувь нь хөдөө аж ахуй, 1.4 хувь нь эрчим хүчний бус, үлдсэн 1.3 хувь нь хог хаягдлын салбараас ялгарч байна. (График 33-т харуулав.)

График 33. Хүлэмжийн хийн ялгарал /хувиар/




Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Дээрх графикаас харахад 2022 онд эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарал 2018 онтой харьцуулахад 4,5 хувиар, эрчим хүчний бус салбарын хувьд 0.5 хувиар тус тус буурсан байна. Харин хөдөө аж ахуйн салбарын хүлэмжийн хийн ялгарал 4,2 хувиар, хог хаягдлын салбарын хувьд 0.8 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь эдгээр хоёр салбарт хүлэмжийн хийн ялгарал бууруулах бодлого, технологийн шинэчлэл зайлшгүй шаардлагатайг илтгэж байна.

Эрчим хүчний салбар: Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарал 2018 онд нийт 19,813.9 мян.тн CO₂-экв, 2022 оны урьдчилсан үзүүлэлтээр 20,394.8 мян.тн CO₂-экв хэмжээнд хүрч 580.9 мян.тн CO₂-экв-ээр нэмэгдсэн байна. (График 34-т харуулав.)

График 34. Хүлэмжийн хийн ялгарал, мян.тн CO₂-экв



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хүрээнд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлэх замаар эрчим хүчний үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээг нэмэгдүүлж байна.

Зураг 3. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадал, МВт



Эх сурвалж: Эрчим хүчний яам, НҮБХХ

Дээрх график-д үзүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээ 2020 онд 719.6 мян.тн CO₂-экв байсан бол 2024 онд 1,042.4 мян.тн CO₂-экв болж өссөн нь

сэргээгдэх эрчим хүчний нийлбэр чадал 2016 онд 76.0 МВт байсан бол 2024 онд 324.0 МВт болж 4.2 дахин өссөн үзүүлэлттэй уялдан тус салбарт ахиц гарч байгааг харуулж байна (Зураг 3-т харуулав).

Улсын хэмжээнд хувийн хэвшлийн 155 МВт-ын салхин цахилгаан станц, 155 МВт-ын нарны эрчим хүчний эх үүсвэрүүд ажиллаж байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал системийн нийт суурилагдсан хүчин чадлын 20.2 хувь байгаа ба нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 9.5 хувийг үйлдвэрлэж байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр 2024 оны байдлаар эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадалд 336.3 МВт буюу 18.6 хувь, эрчим хүчний үйлдвэрлэлд 823.9 сая кВт.ц буюу 7.0 хувийг эзэлж байна.

Монгол Улсын хэмжээнд 8,299.0 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 105 ком дэд станц, 51,927 км цахилгаан түгээх шугам, 12,294 дэд станц байгаагаас Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Баян-Өлгий аймгийн төв, Ховд аймгийн Манхан суманд байрлах дэд станцууд болон Улаанбаатар хотын 110 кВ-ын 12 дэд станц 75.0-95.0 хувь, Булган А, Б, Мөрөн, Бор-Өндрийн 110 кВ хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам 90.0-96.0 хувь хүртэл ачаалагдаж байна. Үүнээс шалтгаалан хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх боломжгүй, оргил ачааллын үед хязгаарлах горимд хүргэж байна. Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний насжилт 21.7-32.9 жил байгаа ба 40.0 орчим хувийнх нь ашиглалтын хугацаа дууссан, нийт 6.0-35.0 кВ-ийн Цахилгаан дамжуулах агаарын шугамын 28.5 хувийг модон тулгуур эзэлж байна.

“Монцемент билдинг материалс” ХХК-ийн цементийн үйлдвэрт суурилуулсан хаягдал дулаан ашиглах систем нь 2020 оноос хойш жилд 10.0 сая кВт.ц эрчим хүч үйлдвэрлэж, 12.0-15.0 мян.тн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж байна. Мөн тус үйлдвэр болон “Мөнхийн баян гал” ХХК-ийн цементийн үйлдвэрүүд жилд тус бүр 10.0 мян.тн орчим нунтаг үнсийг ДЦС 4, Амгалан дулааны станцаас авч ашиглаж байна. Эдгээр нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахын зэрэгцээ эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хаягдлыг дахин ашиглах тойрог эдийн засгийг хөгжүүлэх бодитой жишээ болж байна.


Сүүлийн 5 жилд эрчим хүчний үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй харагдаж байгаа ч нийт улсын хэмжээнд ялгарсан хийн 42.0 хувийг эзэлж байна.

Иймд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар эрчим хүчний үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгарлын бууралт 2024 онд 1,042.4 мян.тн CO₂-экв хэмжээтэй байгааг 2030 он гэхэд 5,399.3 мян.тн CO₂-экв хүргэж нэмэгдүүлэх зорилт тавьсан.

Үүний тулд сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд эзлэх хувийг нэмэгдүүлж, цахилгаан эрчим хүчний дамжуулалтын алдагдал, цахилгаан түгээлтийн алдагдлыг тус тус бууруулахаар төлөвлөсөн. Мөн үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүчний нийт хэрэглээнд хэмнэлтийг нэмэгдүүлснээр анхдагч эрчим хүчээр хэмжсэн үр ашиг өснө.

Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарал: Барилгын салбарын хувьд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээ 2020 онд 275.4 мян.тн CO₂-экв байсан бол 2024 онд 353.9 мян.тн CO₂-экв хүрч 22.1 хувиар нэмэгдсэн байна (График 35-д харуулав.).

График 35. Хүлэмжийн хийн ялгарлын бууралт, барилгын салбараар



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2024 онд улсын болон нийслэлийн төсвийн санхүүжилтээр угсармал орон сууцны 302 блокийг дулаалж, 24.6 мян.тн хүлэмжийн хий ялгарахаас сэргийлсэн байна.

Эрчим хүчний хэмнэлттэй, орлогод нийцсэн ногоон орон сууц барих төслүүдийг 2022 оноос БНСУ-ын хөнгөлөлттэй зээл болон Уур амьсгалын ногоон сан, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж энэ хүрээнд 15,000 айлын орон сууц баригдаж байна.


Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 2016-2022 онд 2.4м^2 -с 5.1м^2 хүрсэн байна. ДЭМБ-аас нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг дунджаар 9м^2 гэж заасан байдаг. 2030 он хүртэлх хугацаанд 120.0 сая мод тарьж ургуулсны дараа нийслэлийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 15м^2 хүрнэ гэж тооцоолжээ.

Барилгын материалын үйлдвэрлэл нь барилга угсралтын хурд, хэрэгцээ шаардлагаас хоцорч байгаагаас нийт хэрэгцээнийхээ дийлэнх хувийг импортоор авч, импортын материал, тоног төхөөрөмжид олон сая доллар зарцуулж байгаа тул бүтээн байгуулалтын үндэс суурийг бэхжүүлж, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг зөв зохистой дэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Цаашид барилгын чанар, дулаан хамгааллыг сайжруулах хүрээнд барилга, байгууламжийн дулаан хамгаалал, чанар аюулгүй байдалд анхаарч ажиллах хэрэгцээтэй бөгөөд ногоон технологи нэвтрүүлэлтийг дэмжих замаар барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг 2024 оны 353.9 мян.тн CO_2 -экв хэмжээтэй байсныг 2030 он гэхэд 633.5 мян.тн CO_2 -экв хүргэхэд зорино.

Тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарал: Тээврийн салбараас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээ 2020 онд 199.6 мян.тн CO_2 -экв байсан бол 2024 онд 227.7 мян.тн CO_2 -экв хүрч 28.1 хувиар нэмэгдсэн байна (График 36-д харуулав).

График 36. Хүлэмжийн хийн ялгарлын бууралт, барилгын салбараар



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Тээврийн салбар, түүний тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй агаар, орчны бохирдолд автомашин, түүний хөдөлгүүрээс ялгарах бохидуулах бодис голлох нөлөө үзүүлж байна. Учир нь агаарын тээвэр болон төмөр замын тээврийн хэрэгсэл нийт паркийн бүтцэд бага хувийг эзлэх бөгөөд автомашин дийлэнх хувийг эзэлж байна. Мөн 2025 он гэхэд Евро-5 стандартын шатахууны импортыг 70.0 хувьд хүргэх зорилт тавьсан боловч 2024 онд 13.0 хувьтай байна. Нүүрсний экспортын тээвэрлэлтийг төмөр замын тээвэрт шилжүүлэх, зорчигчийн галт тэргийг цахилгаан халаалтад шилжүүлэх зорилтын хэрэгжилт хангалтгүй байгаа тул тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгаралт дорвитой буураагүй байна.

Иймд хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулахын тулд бензин болон дизель хөдөлгүүр бүхий автомашины хэрэглээг багасгаж цахилгаан болон хосолмол хөдөлгүүр бүхий автомашины хэрэглээг дэмжих шаардлагатай бөгөөд ингэснээр агаар орчны бохирдлыг бодитойгоор бууруулах боломж бүрдэх юм.

Манай улсын автопаркийн бүтцийн хувьд насжилт өндөртэй автомашинууд нийт паркийн 70-аас дээш хувийг эзэлж байгаа бөгөөд жилээс жилд насжилт болон техникийн байдлын хувьд шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийг ашиглалтаас хасах, уг тээврийн хэрэгслийг хүн ам, байгаль орчин, эдийн засагт ээлтэйгээр устгалд оруулах асуудал тулгарч байна.

Цаашид ашиглалтаас хасагдаж байгаа автомашин, тээврийн хэрэгслийг задалж, дахин ашиглах, зай хураагуур, ашигласан тосыг байгаль орчинд ээлтэйгээр дахин боловсруулах, төмрийн хаягдалд өгөх эд ангиудыг ялгах зэрэг ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг байгаль орчин, эдийн засагт ээлтэйгээр устгалд оруулах, энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулах дахин боловсруулах үйлдвэрийг байгуулах шаардлагатай байна.

Иймд тээврийн салбараас үүдэлтэй агаарын бохирдол, хог хаягдлыг ногоон технологи нэвтрүүлэлтийг дэмжих замаар 2024 онд 227.70 мян.тн CO₂-экв байсан хүлэмжийн хийн бууралтыг 2030 онд 2,762.0 мян.тн CO₂-экв хүргэхээр зорьж байна. Үүний тулд цахилгаан болон хосолмол хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгслийн эзлэх хувь, автомашинаас үүссэн аюултай хог хаягдлыг (шингэн болон хатуу) дахин боловсруулж, шинээр байгуулах үйлдвэрийг тоог нэмэгдүүлнэ.

3.4.3. Байгалийн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалт

Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх нэг хэлбэр нь доройтсон ойг нөхөн сэргээж, ой хамгааллын ажлыг эрчимжүүлэх нь чухал юм.

Ойжуулалт: Улсын хэмжээнд 2024 онд 41 сум дундын ойн анги, 5 сумын ойн анги, аймгуудын Байгаль орчны газрын дэргэд 7 ойн алба тус тус ажиллаж, орон нутагт ойн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байна. Монгол орны ойн санд 2024 оны байдлаар 700 нөхөрлөл 1.9 сая.га талбай, ойн мэргэжлийн 200 аж ахуй нэгж 631.3 мян.га талбайг урт хугацаагаар гэрээлэн эзэмшиж хамгаалж байна.

Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, ой хамгааллын арга хэмжээ болон цаг агаарын таатай нөхцөлд байгалийн аясаар ойн сэргэн ургалт эрчимжсэнээр 2019 оноос хойш ойгоор бүрхэгдсэн талбай 760.0 мян.га-аар нэмэгдэж, 2024 онд нийт газар нутгийн 8.4 хувьд хүрсэн байна. Ойжуулалт 2024 онд 4,299.0 га, байгалийн сэргэн ургалтыг дэмжсэн талбай 460.0 га бүртгэгдсэн бол мод бэлтгэсэн талбай 33.4 мян.га байсан нь нөхөн сэргээлтийн хэмжээ ашиглалтынхаа ойролцоогоор 14.0 хувийг бүрдүүлж байна. (Хүснэгт 60-д харуулав).

Хүснэгт 60. Монгол Улсын ойн сан

Он	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Ойн сангийн талбай, сая.га	18.4	18.4	18.6	18.6	18.6	18.6	18.7	19.1	19.1	19.1*
Ойгоор бүрхэгдсэн талбай, сая.га	12.3	12.3	12.4	12.4	12.4	12.6	12.8	12.9	13.2	13.2*
Ойгоор бүрхэгдсэн талбай, хувь	7.85	7.86	7.94	7.94	7.96	8.07	8.18	8.28	8.45	8.45
Ойжуулалт хийсэн талбай, га	524	3163	2382	3222	2392	3089	2967	1859	1393	4299
Байгалийн сэргэн ургалтыг дэмжсэн, га	85	100	1067	2460	4684	582	1647	354	1250	460
Мод бэлтгэсэн, мян.га	32.5	29.7	34.6	33.7	37.9	34.9	33.3	34.0	33.8	33.4

Эх сурвалж: Ойн газар, *2023 оны тоон үзүүлэлт

Ойжуулалт хийсэн талбай Байгалийн сэргэн ургалтыг дэмжсэн талбайн хэмжээ нэмэгдэж байгаа нь ойн хомсдол, доройтол буурахаас гадна 2024 онд 24.6 сая.тн CO₂-экв. хүлэмжийн хийг шингээсэн байна⁶⁵.

Жил бүр ойгоос дунджаар 30.0-35.0 мян.га талбайд мод бэлтгэл хийгддэг ч ойжуулалт болон байгалийн сэргэн ургалтыг дэмжсэн талбай дунджаар 3.0-4.0 мян.га байна. Энэ нь ой ашиглалтын хэмжээнээс нөхөн сэргээлтийн хэмжээ 8 дахин бага байгаа нь ой доройтох гол хүчин зүйлсийн нэг болж байна.

Ойн доройтолд мөн ой хээрийн түймэр, ойн хөнөөлт шавж зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хуурайшилт, салхи шуурганы давтамж нэмэгдэх, мөн хүний буруутай үйлдэл (ил задгай гал түлэх, хаясан тамхи, хяналтгүй нүүдэл, хөдөө аж ахуйн ажил) ихэссэн нь ойн түймэр гарах нөхцөлийг нэмэгдүүлж байна.

Улсын хэмжээнд 2020 онд нийт 140 удаагийн ой, хээрийн түймэр гарч, 10.0 мян.га ой, 235.0 мян.га хээр шатсан бол 2024 онд түймэрт өртсөн ой 0.1 мян.га талбайгаар буурч, түймэрт өртсөн хээр 798.8 мян.га талбайгаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. (Хүснэгт 61-д харуулав.)

Хүснэгт 61. Ой хээрийн түймрийн статистик үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Түймэрт өртсөн ой	мян.га	10	2	16	1.3	0.9
Түймэрт өртсөн хээр	мян.га	235	202	117	1,028.1	1,033.8
Ой хээрийн түймэр гаралт	тоо	140	65	179	101	137
Хохирлын хэмжээ	тэр.төг	1	3	13	3,082	-

Эх сурвалж: Ойн газар, Үндэсний статистикийн хороо

Эдгээр тоон мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд ой түймрийн гаралт буурч байгаа хэдий ч хээрийн түймрийн тархалт эрс нэмэгдэж, байгалийн экосистем, хөрсний бүрхэвч, бэлчээрийн чанарт сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Ой хээрийн түймэр нь ой модны бие махбодод шууд гэмтэл учруулдаг. Үүнд модны хальс түлэгдэх, мөчир, ишний бүтэц эвдрэх, хөрс доройтох зэрэг сөрөг үр

⁶⁵ НҮБ-Хөгжлийн хөтөлбөр, 2025 он.

дагавар орно. Галын дараах нөхцөлд модны эсэргүүцэл буурч, ой хөнөөлт шавж амьдрах, үржин олшрох таатай орчин бий болдог. Эдгээр шавж модны навч, иш, үндэс болон үрийг идэж, модны өсөлтөд саад болж, хатаж үхэх нөхцөл байдал үүсгэдэг байна. Монгол оронд 8 баг, 62 овог, 316 төрөлд хамаарах 737 зүйлийн шавж мод, бут, сөөгийн навч шилмүүс, иш холтос, модлог, үр жимс, үндсээр хооллон ойд их, бага ямар нэг хэмжээгээр хөнөөл учруулдаг.

Ойн хөнөөлт шавжийн голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг 2024 онд авиа микробиологи, үүргийн шүршигч багаж, өндөг хусаж цуглуулах механик арга, гэрлэн урхи тавих аргуудаар ойн сангийн 341.0 мян.га талбайг хамруулан гүйцэтгэсэн. (Хүснэгт 62 -т харуулав)

Хүснэгт 62. Ойн хөнөөлт шавж

Арга хэмжээ	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Хөнөөлт шавжид нэрвэгдсэн, мянган га	477	591	503	322	170	202	298	737	730	490
Хөнөөлт шавжтай тэмцсэн, мянган га	148	65.3	171	231	67.1	65.8	33.9	31.0	185	341

Эх сурвалж: Ойн газар

Энэ нь тэмцэл хийх шаардлагатай талбайн 79.0 хувийг хамарсан байна. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулснаар 0.8 тэрбум модыг доройтолд өртөн, хатаж хуурайших эрсдэлээс сэргийлээд байна. Хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбайн хэмжээ тодорхой хэмжээнд буурахгүй байна.

Иймд ойн түймэр, хөнөөлт шавжид өртөхөөс сэргийлэх, гэрэлтүүлэх, тохируулах хэлбэрийн арчилгааны огтлолт хийх, өсөлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж ойгоор бүрхэгдсэн талбайг сэргээх, мөн сэргэн ургалт хангалтгүй байгаа талбайд тарьц, суулгацаар зориудаар ойжуулах шаардлагатай байна.

Байгалийн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулахын тулд мэдлэг, дадал, судалгаанд суурилсан олон талт оролцоог дэмжих замаар ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 2024 онд 8.45 хувь байгааг 2030 онд 9.0 хувь болгож 0.55 хувиар нэмэгдүүлнэ.

Үүний тулд байгалийн нөөцийн хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг дэмжих замаар ойжуулалт хийсэн талбайн хэмжээг 2024 онд 10 мян.га байсныг 2030 он гэхэд 93 мян.га хүргэж байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулна.


Усны нөөц: Ус нь хүн амын амьдрал, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, эрчим хүч болон экосистемийн тэнцвэрт байдлыг хангах стратегийн чухал баялаг юм. Монгол Улсын усны нийт нөөцийн 88.5 хувь нь нуурт, 6.1 хувь нь гол, мөрөнд, 3.4 хувь нь мөстөл, мөсөн голд, харин 2.0 хувь нь газрын дор агуулагддаг. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулааралт нэмэгдэж, ууршилт эрчимжихийн зэрэгцээ цэвдэг, мөстлийн хайлалт идэвхэжсэн нь усны нөөцийн хэмжээнд сөргөөр нөлөөлж байна.

Улсын хэмжээнд хүн амын 83.6 хувь баталгаат ундны усаар хангагдаж байгаа⁶⁶ бөгөөд эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд газрын доорх ус нь тогтвортой, хамгаалагдсан гол эх үүсвэр болж байна.

Улсын хэмжээнд жил бүр дунджаар 677.0 сая шоо метр ус ашиглаж байгаа бөгөөд үүний 50 орчим хувийг газрын доорх усаар хангаж байна. Усны ашиглалтыг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар хамгийн их хэрэглээтэй байгаа бөгөөд ашиглалтын хэмжээ 2020 оныг 2024 онтой харьцуулахад буурсан, бусад салбар өссөн дүнтэй байна. (График 37-д харуулав)

⁶⁶ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, 2025 он.


График 37. Ус ашиглалт, сая.м³



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Монгол Улсын нийт ус ашиглалтын хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байсан бөгөөд 2020 онд 591 сая.м³ байснаас 2024 онд 677 сая.м³ болж 14.6 хувиар өсжээ. (График 38-д харуулав)

График 38. Ус ашиглалт



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Дэлхий даяар “байгальд суурилсан шийдэл” буюу байгалийн өөрийнх нь үйлчилгээг ашиглахыг чухалчилж байгаа бөгөөд тухайлбал, голын татмын нуга, хүлэрт намаг бүхий газар нь их хэмжээний үерийн усыг тогтоон барих байгалийн нөөцлүүрийн үүргийг гүйцэтгэхээс гадна цэвдгийг хамгаалах, олон зүйл ургамал, амьтан, бичил биетний амьдрах орчныг бүрдүүлэх, ихээхэн хэмжээний нүүрстөрөгчийг агуулж, хүлэмжийн хийг шингээх өндөр чадвартай байдаг.

Усны нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах иргэдийн амь нас, эд хөрөнгийг үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор гол мөрөн, нуур зэрэг усны сан бүхий газарт хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоодог. Гэтэл голын татамд буюу үерийн аюултай бүсэд зөвшөөрөлгүй суурьшлын бүс бий болж хууль тогтоомж огт хэрэгжихгүй байгаагаас үер, усны гамшгийн эрсдэлийг ихэсгэхийн зэрэгцээ усны нөөцийг ихээхэн бохирдуулж, хомсдуулж байна. Хурх, Хүйтэн голын хөндийн нуурууд, ус намгархаг газрын хэмжээнд усны эх үүсвэрийг дагасан малын хэт бөөгнөрлөөс үүдэлтэй бэлчээрийн талхагдал, амьдрах орчны доройтол, газар тариалангаас үүдэлтэй ус, намгархаг газрын талбайн хэмжээ буурах үйл явц алдагдаж байна. Голын хөндий, татмын нугыг шинээр хагалж тариалангийн талбай болгон ашиглаж байгаа ба талбайг их хэмжээгээр уриншуулж, өнжөөж байгаа нь намгийг хатааж, хөрсний үржил шимийг алдагдуулж байна⁶⁷.

Улсын хэмжээнд усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд 33,706 нэгж талбар бүхий газар олголт хийгдсэн байна. Нийслэл, аймгийн төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм зөрчигдөж, эрүүл

⁶⁷ Хэнтий аймгийн (БОАЖГ, 2021)

ахуйн бүс болон тэжээгдлийн мужид газар олголт хийгдэж суурьшлын бүс бий болсноор газрын доорх ус бохирдох нөхцөл үүсэж, хүн амын ундны усны аюулгүй байдал алдагдахад хүргэж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд 4,051, хязгаарлалтын бүсэд 6,564 нэгж талбар бүхий газарт ашиглалт явагдаж байна⁶⁸.

Монгол орны хур тунадасны улирлын шилжилт болж зуны хур бороо татрахын хамт эрчим нь ихсэх, өвлийн цасны хэмжээ нэмэгдэх хандлагатай байгааг харгалзан хаврын шар усны үер, зуны аадар борооны үерээс сэргийлэхийн зэрэгцээ үерийн усыг тогтоон хуримтлуулж гачиг үед хэрэглэх, үүнийг далан хаалт барьж их хэмжээний хөрөнгө зарахгүйгээр “Байгальд суурилсан шийдэл” буюу газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан татмын нуур, цувраа хөв цөөрөм байгуулахыг үр дүнд суурилсан төлөвлөлтөөр санхүүжилтийг баталгаажуулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Газрын тогтцыг ашиглан хөв цөөрөм байгуулах ажлын хүрээнд Завхан, Ховд зэрэг аймгийн нутаг дэвсгэрт 256.0 мян.шоо метр ус агуулах багтаамжтай 50 хөв цөөрөм байгуулсан байна⁶⁹.

Хүн амыг баталгаат ундны усаар хангахын тулд усны нөөцийн эрэл хайгуул хийж, нөөц тогтоон, ус хангамжийн эх үүсвэрийг байгуулах шаардлагатай байдаг. Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2024 онуудад Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Булган аймгийн есөн сум суурины хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгаа хийж, нийт 236 л/с усны нөөцийг тогтоосон нь тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, баталгаатай ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болж байна.

Усны бодлогыг оновчтой тодорхойлох үндэс нь региональ судалгаа хийж газрын доорх усны нөөц баялгийг зөв тогтоох явдал юм. Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг 2022-2024 онд Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн нутагт хийж, нийт газар нутгийн 17.8 хувийг зураглалд хамруулж усны нөөцийн тойм мэдээлэлтэй болсон байна⁷⁰.

Хүн амын өсөлт, хотжилт, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжлийн хурдац, төлөвлөлтийг харгалзан гол ус хэрэглэгчдийн хэтийн төлөвийг тоймлон тооцож үзэхэд 2030 онд ус хэрэглээ 3-4 дахин нэмэгдэхээр төлөвтэй байна. Усны ойрын болон хэтийн хэрэглээг хангахад усны нөөцийн жигд бус тархалт, уур амьсгалын өөрчлөлт хүндрэл учруулахаар байна.

Цаашид байгалийн нөөцийн хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг дэмжих замаар дахин ашигласан усны хэмжээг нэмэгдүүлнэ. Үүний тулд үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгцээтэй бөгөөд 2024 онд 17 хувь байсныг 2030 онд 30 хувьд хүргэх зорилт тавьж байна.

Биологийн олон янз, нэн ховор амьтан, ургамал, генетик нөөц: Биологийн олон янз байдал нь ургамал, амьтан болон бичил биетнээс бүрддэг бөгөөд экосистемийн тэнцвэрийг хадгалах, экосистемийн үйлчилгээг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулах, гамшгийн эрсдэлийг багасгах зэрэг байгаль орчны тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл юм.

Улсын хэмжээнд нэн ховор, ховор амьтдыг хамгаалах чиглэлд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөөцийн хамгаалал, олон улсын конвенцыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, үүний хүрээнд зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн зам, холбоос нутгийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, амьтныг сэргээн болон сэлгэн нутагшуулахад анхааран ажиллаж байна.

⁶⁸ Усны газар, 2025

⁶⁹ Усны газар, 2024

⁷⁰ Усны газар, 2025

Монгол орны ургамлын аймаг, түүний олон янз байдалд 5 бүлэгт хамаарах 18 хүрээний 50 ангийн 179 багийн 497 овогт багтах 1,723 төрлийн 7,620 зүйл гуурсгүй болон гуурст ургамал бүртгэгдээд байна. Үүнд 88 овгийн 237 төрлийн 631 зүйл дээд мөөг, 162 овгийн 415 төрлийн 2289 зүйл замаг, 62 овгийн 208 төрлийн 1,079 зүйл хаг, 74 овгийн 210 төрлийн 580 зүйл хөвд, 111 овгийн 653 төрлийн 3,041 зүйл гуурст ургамал багтана. (Хүснэгт 63-т харуулав)

Хүснэгт 63. Монгол орны ургамлын аймгийн бүтэц, бүрэлдэхүүн, 2023 он

дд	Бүлгийн нэрс	Хүрээ	Анги	Баг	Овог	Төрөл	Зүйл, дэд зүйл	Эзлэх хувь
1	Мөөг дээд	2	7	31	88	237	631	8.27
2	Замаг	9	23	67	162	415	2289	30.02
3	Хаг	1	6	22	62	208	1079	14.16
4	Хөвд	1	2	2	74	210	580	7.61
5	Гуурст ургамал	5	12	39	111	653	3041	39.94
Нийт		18	50	179	497	1723	7620	100

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2021-2023

Хангайн уулын ойт хээрийн тойргийн ургамал, ургамалжлын судалгааг 2021 онд хийж, эмийн, хүнсний, ашиглалтад өртөж байгаа 3 зүйлийн мод, 19 зүйлийн сөөг, 156 зүйлийн заримдаг сөөгөнцөр болон өвслөг, нийт 178 зүйл ургамлыг судалгаанд хамруулсан. Эдгээр ургамлын 10,685 тархцын цэгийг тэмдэглэн 161 зүйл ургамлын биологийн нөөц, 133 зүйл ургамлын ашиглалтын болон нэг жилд бэлтгэх нөөцийг хуурай болон нойтон жингээр тооцон тархац, нөөцийн зураглалыг гаргасан.

Байгальд ашиглалтын нөөцгүй болж байгаа зарим зүйл ургамлыг тарималжуулан генетик нөөцийг нэмэгдүүлэх нь чухал бөгөөд 2023 оны байдлаар 16 аж ахуйн нэгж, байгууллага, 3 иргэн 10 гаруй төрлийн байгалийн ургамлыг тарималжуулж байна.

Монгол оронд өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 141 зүйл хөхтөн амьтан, 519 зүйл шувуу, 23 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 79 зүйл загас, 1 мянга гаруй зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдээд (Хүснэгт 64-т харуулав).

Хүснэгт 64. Монгол орны амьтны аймгийн төлөв байдал

дд	Амьтны аймаг	1998 он				Тоо 2020 он				2022 он			
		ширхэг	Овог	Төрөл	Зүйл	ширхэг	Овог	Төрөл	Зүйл	ширхэг	Овог	Төрөл	Зүйл
1	Шавьж	-	2	100	13,000	-	2	100	13,000	-	-	100	13,000
2	Загас	-	11	36	75	-	11	36	74	8	15	47	79
3	Хоёр нутагтан	2	4	-	6	2	4	-	6	2	4	5	6
4	Мөлхөгчид	2	7	15	22	2	6	15	22	1	7	15	23
5	Шувуу	17	56	193	434	23	68	235	519	23	69	235	519
6	Хөхтөн	8	22	73	197	8	22	73	141	8	24	79	141

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2021-2023

2022-2023 онд хийсэн зарим зүйл нэн ховор, ховор амьтдын тоо толгой, тархац нөөцийн судалгааны дүнг 2020 онтой харьцуулахад зүйлийн тоо өссөн байгаа нь судалгааны ажил эрчимжиж шинээр олон зүйлийг тэмдэглэсэн болон олон талт хамгааллын арга хэмжээний үр дүн юм (Хүснэгт 65-д харуулав).

Хүснэгт 65. Зарим зүйл амьтдын судалгааны дүн

Он	Халиун буга	Аргаль хонь	Янгир ямаа	Монгол бөхөн	Хулан адуу	Мазаалай баавгай	Цоохор ирвэс
2020	10,000	13,000	11,000	4000	64,000	34	900
2023	55,215	19,691	31,178	20,540	87,000	50	1,000
2024	-	-	-	23,000	-	-	-

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Судалгаанд хамрагдсан амьтдын тоо толгой өсөх хандлагатай байгаа ч уур амьсгалын өөрчлөлт, ган зудын давтамж нэмэгдэх, малын тоо толгойн хэт өсөлт, шугаман дэд бүтэц болох авто болон төмөр замын хөгжлөөс шалтгаалан зэрлэг амьтны тархац нутаг тасархайтах эрсдэл үүсэж байна.

Цаашид байгалийн ургамлын ашиглалт, хамгаалалт, зохистой нөхөн сэргээлт, нэн ховор, ховор амьтны нөөцийн хамгаалалт, ашиглалт, өсгөн үржүүлэлт, сэргээн нутагшуулалтад онцгой анхааран ажиллах шаардлагатай байна.

Хөрс: Хөрс нь амьд биетийн амьдрах орчин, хүнсний гол эх үүсвэр төдийгүй экосистемийн үнэт бүрэлдэхүүн хэсэг юм. Хүн төрөлхтөн хүнс тэжээлийнхээ 95.0 хувийг хөрснөөс авдаг ба хөрс нь агаар мандлаас гурав, ойгоос хоёр дахин их хэмжээний нүүрстөрөгчийг өөртөө шингээж хадгалдаг. Харин хөрс доройтсон нөхцөлд энэ нүүрстөрөгч агаарт ялгарч, хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг байна.

Хөрс нь шавхагдах нөөц бөгөөд зохисгүй ашиглалтаас үүдэн үржил шимээ алдаж, нөхөн сэргэх чадвар нь буурснаар хүнсний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны чанарт аюул учруулж байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тооцоогоор 1 см шимт хөрс бий болоход 1,000 жил шаардагддаг гэсэн судалгаа гаргажээ. Цөлжилтийн төлөв байдлын үнэлгээг 5 жилд тутамд хийдэг бөгөөд 1992 онд хийсэн судалгаагаар нийт нутаг дэвсгэрийн 41.3 хувь нь цөлжилтөд илэрч байсан бол цөлжилтөд нэрвэгдсэн газар нутгийн хэмжээ жил бүр нэмэгдэж, 2020 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая.га талбай бүхий газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Үүний 23.3 хувь буюу 30 орчим сая.га талбай цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд орж байгаа бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд доройтлын тархалт буураагүй хэвээр байна. (Хүснэгт 66-д харуулав).

Хүснэгт 66. Цөлжилтийн үйл явцын хандлага, (хувиар)

Цөлжилтийн үнэлгээ хийсэн он	Сул илэрсэн нутаг	Дунд зэрэг илэрсэн нутаг	Хүчтэй илэрсэн нутаг	Нэн хүчтэй илэрсэн нутаг	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
2006	23.0	26.0	18.0	5.0	72.0
2010	35.3	25.9	6.7	9.9	77.8
2015	24.1	29.8	16.8	6.1	76.8
2020	31.5	22.1	18.6	4.7	76.9

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилгоор Монгол орны экосистемийн харилцан адилгүй газар нутгуудыг төлөөлүүлэн 3 газарт суурин судалгааны станц байгуулан туршилт судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Улсын хэмжээнд зохион байгуулсан эвдэрсэн газрын тооллогын дүнгээр нийт 34.1 мянган га талбай эвдрэлд өртсөн дүн гарсан. Үүнээс ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд эвдрэлд орсон 26.3 мянган га, зам барилга байгууламжийн ажлын улмаас эвдрэлд өртсөн 2 мянга гаруй га, бичил уурхай, хууль бус ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас 3 мянга гаруйг, бичил уурхайн үйл ажиллагааны улмаас 2 мянга гаруй талбай эвдэрсэн байна. Сүүлийн таван жилийн

хугацаанд нийт 12,117 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг амжилттай хийсэн байна (График 39-д харуулав).

График 39. Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, га талбайгаар



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Байгалийн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулахын тулд доройтсон ойг нөхөн сэргээж, ойжуулалт, ой хамгааллын ажлын үр дүнг сайжруулах, усны нөөц болон биологийн олон янз байдал, нэн ховор, ховор амьтан ургамлыг хамгаалж, нөхөн сэргээж, цөлжилт нэмэгдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулах шаардлагатай.

Нэн хүчтэй болон хүчтэй доройтсон газар нутгийн эзлэх хувь 2024 оны байдлаар 23.3 хувь байгаа бол 2030 он гэхэд тус үзүүлэлтийг 22.0 хувь болгож бууруулна. Тус зорилтыг хэрэгжүүлэхдээ хөрсийг хамгаалж, уул уурхайн нөхөн сэргээлтийг хийх замаар хамгаалах арга хэмжээ авсан газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Газрын доройтлоос сэргийлэх бас нэг арга зам нь бэлчээрийн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлж, ачааллыг нь багасгах явдал юм.

Бэлчээрийн ачаалал: Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хоногийн дундаж агаарын температурын хэмжээ буюу дулааны нөөц нэмэгдэх, хуурайшилт эрчимжиж гангийн давтамж нэмэгдэх, хөрсний гадарга орчмын органик нүүрстөрөгчийн агууламж буурах, малын тоо эрчимтэй нэмэгдэн бэлчээрийн даац хэтэрч ургамлын зүйлийн бүрэлдэхүүн нь өөрчлөгдөн ургамлын нөмрөг доройтсон зэрэг нь цөлжилт нэмэгдэх нөхцөлийг бий болгож байна.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар бэлчээрийн мониторингийн үр дүнгээр хонин толгойд шилжүүлснээр 82.0 сая мал өвөлжиж, хаваржих боломжтой байсан бол жилийн эцсийн малын тоо 117.0 сая хонин толгой байсан нь боломжит даацаасаа 35.0 сая хонин толгойгоор хэтэрсэн байна.

Бэлчээрийн газрын төлөв байдлын өөрчлөлтийн мониторингийн 2017 оны үр дүнг 2023 он хүртэлх үр дүнтэй харьцуулахад бэлчээрийн төлөв байдлын доройтлын хэмжээ нэмэгдсэн байна. Нийт бэлчээрийн газрын доройтол байгалийн унаган төрхөө алдаагүй 12.0 хувиас 11.0 хувь болж, маш хүчтэй доройтсон 8 хувиас 6.6 хувь болж буурсан бол бага зэрэг доройтсон 45 хувиас 45.7 хувь болж, дунд зэрэг доройтсон 18.0 хувиас 19.6 хувь болж өссөн, хүчтэй доройтсон өөрчлөгдөөгүй үзүүлэлттэй байна.

Малын тэжээлээр дагнасан нийт 50 аж ахуйн нэгж, хоршоо ажиллаж байгаа ба үүнээс 37 нь одоогоор үйл ажиллагаа явуулж, 13 нь зогссон байна. Тэжээлийн үйлдвэрүүдийн суурилагдсан нийлбэр хүчин чадал жилд 176.1 мян.тн тэжээл үйлдвэрлэх боломжтой бөгөөд одоогоор ашиглаж буй хүчин чадал нь жилд 55,762.5 тн буюу нийт хүчин чадлын 31.6 хувьтай тэнцэж байна.

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн ачаалал нэмэгдэж, даацыг хэтрүүлэн ашигласнаас үүдэн бэлчээрийн ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн багасаж, хөрсний үржил шим доройтож байна. Үүний нөлөөгөөр малын тэжээлийн хүртээмж, чанар буурч, малын эрүүл мэнд, ашиг шимд сөргөөр нөлөөлж байна.

Цаашид бэлчээрийн даацыг зохистой түвшинд хадгалахын зэрэгцээ малын тэжээл бэлтгэл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх шаардлагатай байна.

Үүний тулд малыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар бэлчээрийн ачааллыг багасгаж 100 га талбайд ногдох 2024 онд 101.0 байсныг 2030 он гэхэд 95.0 болгож бууруулахыг зорьж байна.

3.5. ЗАСАГЛАЛ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Эдийн засгийн хөгжлийг нийгмийн хөгжилд үр дүнтэй хүргэх арга зам нь засаглалын бодлого буюу зөв засаглал юм.⁷¹ Монгол Улсын хувьд засаглалын тогтвортой, үр дүнтэй байдал алдагдаж, хариуцлага, хяналт бүх түвшинд суларч, шударга ёсны болон хууль дээдлэх зарчим, төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж чанар алдагдан, төрийн захиргаа, үйлчилгээнд хүнд суртал, шат дамжлага нэмэгдэж, мэргэшсэн бус тогтолцоо⁷², харилцаа, хандлага газар авч засаглалын үйл явцад аж ахуйн нэгж, иргэдийн итгэх итгэл сул байна. Өнгөрсөн хугацаанд тэр дундаа 2008 оноос хойш 8 удаа Засгийн газар байгуулагдаж, Засгийн газрын дундаж насжилт 2.2 жил болж, засаглалын тогтвортой байдал алдагдаж, Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл ойр ойрхон өөрчлөгдөж, хоорондын уялдаа холбоогүй, бодит байдалд нийцээгүй, төрийн залгамж чанаргүй, улсын болон орон нутгийн төсөвтэй уялдаагүй бодлогын баримт бичиг хэт олширсон.⁷³ Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны судалгаанд сууриллаагүй, хэрэгжих боломж багатай, уялдаа холбоогүй 567 бодлогын баримт бичгийг баталсан байсан нь⁷⁴ Монгол Улсын хөгжлийн бодлогыг тогтворгүй, нийтээрээ хөгжлийн талаарх нэгдсэн ойлголтгүй болгож, баялгийн тэгш бус хуваарилалт нэмэгдэж, иргэдийн төрдөө итгэх итгэлийг сулруулсан зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэж байгаа талаар үндэсний сайн дурын илтгэл (2023)-д дурдсан байна.

Дэлхийн банкны 1996 оноос хойш тооцож байгаа улс орнуудын төрийн засаглалын чанар, үр ашиг, оновчтой байдлыг үнэлэх зорилгоор тооцдог дэлхий нийтийн засаглалын үзүүлэлтээр Монгол Улс 2024 оны байдлаар 114 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.⁷⁵ Үүнд тухайн улс орны хууль дээдлэх ёс, засгийн газрын үр ашиг, зохицуулалтын чанар, авлигын хяналт, иргэдийн дуу хоолой ба оролцоо, улс төрийн тогтвортой байдлын үзүүлэлтийг голчлон авч үздэг байна. Тус үзүүлэлтийг хүснэгт 67-д харуулав.

Хүснэгт 67. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт

	2020		2021		2022		2023		2024	
	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
Хууль дээдлэх ёс	45.2	116	44.3	118	44.8	117	45.8	116	43.9	120
Засгийн газрын үр ашиг	41.4	127	37.1	133	33.3	141	34.9	139	34.0	141
Иргэдийн дуу хоолой ба оролцоо	57.5	89	58.5	87	57.5	89	56.0	92	56.4	98
Зохицуулалтын чанар	53.8	98	48.1	110	43.8	119	42.5	123	45.8	116
Авлигын хяналт	37.1	133	34.3	139	33.3	141	32.5	143	35.4	138
Улс төрийн тогтвортой байдал	67.9	69	71.2	62	68.4	68	62.7	79	67.3	71

Эх сурвалж: Дэлхийн банкны засаглалын индекс

⁷¹ Алсын хараа 2050 4-р бүлгээс ишлэв

⁷² Алсын хараа 2050 4-р бүлгээс ишлэв

⁷³ Алсын хараа 2050 4-р бүлгээс ишлэв

⁷⁴ Макро эдийн засгийн танилцуулга

⁷⁵ Макро эдийн засгийн танилцуулга

Дээрх хүснэгтээс харвал Хууль дээдлэх ёсны үзүүлэлтийн үнэлгээ 2020 оны түвшнээс буурч 4 байраар ухарсан байна. Үүнд хууль, эрх зүйн тогтолцоо сул, шүүхийн үйл ажиллагааны чанар олон улстай харьцуулахад доогуур байгаа нь нөлөөлжээ.⁷⁶ Мөн Засгийн газрын үр ашгийн үзүүлэлтээр 7.4 оноогоор буурч 14 байраар ухарсан байна. Үүнд бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлсөн гэж дүгнэжээ. Түүнчлэн Иргэдийн дуу хоолой ба оролцоо буюу иргэдийн төрд итгэх итгэлийг илэрхийлдэг үзүүлэлт 2020 оноос 1.4 оноогоор буурч 9 байраар ухарсан үзүүлэлттэй байна. Харин төрийн үйл ажиллагааг цахимжуулах цогц арга хэмжээний үр дүнд төрийн байгууллагын үр ашиг, ил тод байдал нэмэгдсэнээр, зохицуулалтын чанарын үзүүлэлтийн эрэмбэ өмнөх оноос 7 байраар, авлигын хяналтын үзүүлэлтийн эрэмбэ өмнөх оноос 5 байраар ахиж, улс төрийн тогтвортой байдал сайжирснаар уг үзүүлэлтийн үнэлгээ өмнөх оноос 0.06 оноогоор өсөж, 8 байр ахисан боловч 2020 оны түвшинд хүрээгүй хэвээр байна.

Цаашид эдгээр үзүүлэлтийг сайжруулан Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж үзүүлэлтийн эрэмбийг ахиулж 2030 он гэхэд тус үзүүлэлтээр 90 дүгээр байранд эрэмбэлэгдэхээр зорьж байна. Уг зорилгыг хангахын тулд дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулан дараагийн таван жил дараах үндсэн зорилтуудад чиглэх болно.

3.5.1. Авлига

Авлига нь Монгол Улсын Үндсэн хуулиар хүн бүрд олгогдсон тэгш боломжийг хязгаарлаж, шударга ёсны тогтолцоо алдагдаж, хууль дээдэх ёсыг үнэгүйдүүлж, бүх түвшинд авлига газар авч, эдийн засаг, нийгэм, байгаль орчны ноцтой сөрөг үр дагаварт хүргэж байна⁷⁷. Авлига, албан тушаалын гэмт хэргүүд буурахгүй байгаагаас төрийн институцийн нэр хүнд унаж, хууль бүх хүнд ижил үйлчилдэггүй гэсэн ойлголтыг нийгэмд төрүүлж, төрдөө итгэх иргэдийн итгэл буурч, төрийн шийдвэрүүд нийгмийн бус, хувийн ашиг сонирхолд нийцэх болж, бодлого тогтворгүй, үр ашиггүй болох, нийгмийн болон эдийн засгийн амьдралд оролцох иргэдийн идэвх, оролцоо сулрах эрсдэлийг дагуулж байна. Нөгөө талаас төрийн худалдан авах ажиллагаа, тендерүүд шударга бус явагдаж төсвийн алдагдал, үр ашиггүй зарцуулалт үүсэх, гадаад, дотоод хөрөнгө оруулалт буурах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг хязгаарлах сөрөг үр дагавартай.

Монгол Улсын хувьд 2024 онд Дэлхийн банкны засаглалын үнэлгээгээр авлигын индекс 33-т байгаа буюу 180 орноос 114 дүгээр байранд жагсжээ⁷⁸. Манай улс авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц болон бусад олон улсын байгууллагуудын шаардлагын дагуу хэрэгцээтэй бүхий л хууль тогтоомжийг баталсан боловч хэрэгжилт, ил тод байдал, мэдээллийг олон нийтэд хүргэх тал дээр доголдолтой, мэдээллийг нуун дарагдуулсан эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийг алдагдуулсан зэрэгт тооцох хариуцлага хангалтгүй байна.⁷⁹ Авлигыг бууруулах хүрээнд 2002, 2016, болон 2023 онуудад нийт 3 удаа “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна.

Авлигатай тэмцэх хоёр дахь стратеги хэрэгжсэний дараа хэрэгжүүлэхээр тусгасан нийт арга хэмжээний 75.0 хувийг амжилттай хэрэгжүүлсэн хэмээн хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэгдсэн⁸⁰ боловч Трансперенси интернэшнл байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индексээр Монгол Улсын үзүүлэлт огтхон ч сайжраагүй төдийгүй уг стратегийг хэрэгжүүлэх хугацаанд Монгол Улсын авлигын төсөөллийн индекс 6 оноогоор буурч (2015 онд 39 оноотой байсан бол 2023, 2024 онд 100 оноо авахаас ердөө 33 оноо авсан) байна.⁸¹ Иймд авлига, ашиг сонирхлоос сэргийлэх үндэсний

⁷⁶ Макро эдийн засгийн танилцуулга 2024 он

⁷⁷ Алсын хараа 2050

⁷⁸ Транспэрэнси Интернэшнл Монгол, Авлигын индекс

⁷⁹ Транспэрэнси Интернэшнл Монгол, Иргэний нийгмийн байгууллагын зэрэгцээ (сүүдэр) тайлан


⁸⁰ Улсын Их Хурлын тойм мэдээ

⁸¹ Транспэрэнси Интернэшнл Монгол

тогтолцоо бүрдүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, нийгмийн бүхий л хүрээнд авлигыг тэвчих хандлага тогтооход чиглэх нь зүйтэй байна.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2024 онд “Бодлогын шийдэл” ТББ-ын гүйцэтгэсэн шударга байдлын үнэлгээгээр манай улсын төрийн байгууллагын дундаж оноо 72.6 гарч өмнөх оноос 4.0 оноогоор буурсан байна. Уг судалгаанд төрийн 16 яам, 34 агентлаг, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийт 81 байгууллага хамрагдсан. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар 2023 онтой харьцуулахад төрийн байгууллагын авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автах, бусдад хууль бусаар давуу байдал олгох, бусдаас нэмэлт төлбөр, бэлэг хандив, санхүүгийн тусламж авах, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй байх үйлдлийг хийх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох зэрэг тохиолдлууд нэмэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлсөн гэж үзсэн байна.⁸² Шударга байдлын үнэлгээний сүүлийн таван жилийн өөрчлөлтийг доорх графикаар харуулав.(График 40-д харуулав.)

График 40. Шударга байдлын үнэлгээ түүний өөрчлөлт



Эх сурвалж: Шударга байдлын үнэлгээ судалгааны тайлан

Манай улсын хувьд авлигын эсрэг бүхий л хууль дүрмийг батлуулсан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй, мэдээллийг олон нийтэд хүргэх, ил тод байдал дутмаг, олон нийтийн оролцоо муу байгаагаас сүүлийн таван жил авлигын индекс өссөн үзүүлэлттэй байна. Цаашид авлигыг бууруулахын тулд ил тод байдал, авлигын эсрэг үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх замаар иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах, төрийн байгууллагуудын шударга байдлыг дээшлүүлж, авлигыг тэвчих соёл, хандлагыг нэмэгдүүлж 2024 онд 114-т байгаа авлигын индексийг 24 байраар ахиулж 2030 он гэхэд 90 дүгээр байранд хүргэх боломжтой байна.

3.5.2. Хууль, шүүхийн байгууллагын засаглал

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг 2021 онд батлан, хэрэгжүүлж байна.⁸³

⁸² Авлигатай тэмцэх газар, Шударга байдлын үнэлгээ, 2024 судалгааны тайлан

⁸³ Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль

Тухайн улсын хүний эрх, эрх чөлөөний байдал, хууль дээдлэх ёс ямар түвшинд хүрснийг гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль, хяналтын байгууллагууд хэрхэн харьцаж байгаа, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг хэрхэн хүндэтгэн хамгаалж байгаагаар илэрхийлдэг. 2024 оны байдлаар шүүхийн алдаатай шийдвэрийг залруулах тухай 306 санал гарсан нь өмнөх оноос 130 буюу 73.8 хувиар өссөн байна. Шүүхийн алдаатай шийдвэр нь хүн иргэдийн эрх, эрх чөлөөнд нөлөөлөөд зогсохгүй, нийгэмд шударга ёс, хууль дээдлэх зарчимд итгэх итгэлийг сулруулж, шүүхийн байгууллагын нэр хүнд, төрийн хууль ёсны үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэлийг бууруулахад нөлөөлж байна.

Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тулгуур нь ёс зүйтэй, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх асуудал бөгөөд шүүхийн эрх мэдлийн байгууллага нь бие даасан, хараат бус, ил тод, мэргэшсэн байх явдал нь шударга хуулийн засаглалыг тогтоох болон шүүхийн байгууллагад олон нийтийн итгэх итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой. Монгол Улсын шүүхийн индексийг 2021 оны 51.94 хувьтай харьцуулахад 2024 онд 53.22 хувь болж өссөн бөгөөд өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь “шүүгчийн ёс зүй, хариуцлага”-ын шалгуур үзүүлэлтийн оноо 45.17 хувиас 58.13 хувь болж, 12.9 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн шүүх болон прокурорын байгууллагын нээлттэй ил тод байдал нь иргэдийн итгэл, үнэмшлийг нэмэгдүүлэх чухал нөлөө үзүүлдэг ба шүүхийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, прокурорт итгэх олон нийтийн итгэлийн индекс 2023 онд хийсэн судалгаагаар 4.6 оноогоор үнэлэгдэж байсан бол 2024 онд 5.1 оноогоор үнэлэгдэж, олон нийтээс өгсөн үнэлгээ өссөн эерэг үр дүн гарсан байна.

Прокурорын байгууллага, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын хоорондын харилцан хамаарал нь прокурорын байгууллагын бие даасан байдлыг хангахад чухал үүрэгтэй. Монгол Улсын хувьд 1992 оны үндсэн хуулиар прокурорын байгууллагын үндсэн зарчим, үүрэг, зохион байгуулалт, прокурорын эрх хэмжээ зэргийг хуульчилсан байна.⁸⁴ Дэлхийн улс орнуудад прокурорын байгууллага нь ихэвчлэн шүүх засаглалаас хамаарсан, гүйцэтгэх засаглалаас хамаарсан, хосолсон, бие даасан салбар гэх байдлаар зохион байгуулагдсан байна. Прокурорын байгууллага нь аль ч эрх мэдлээс хамаарсан эсэхээс үл шалтгаалан хараат бус байх мөн чанар, хүрээг хуулиар тогтоож өгөх, мөн прокурор, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой хуулийг тус тусад нь батлан хэрэгжилтийг хангаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “...шударга шүүхээр шүүлгэх...”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах” гэж заасан байна.

Шударга шүүхээр шүүлгэх эрхийн агуулга нь аливаа хүн эрүүгийн хэрэгт татагдсан үеэс эхлэн ял шийтгэл эдэлж дуусах хүртэлх үе шатыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт юм.⁸⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст 2024 оны байдлаар нийт 7,226 хоригдол хорих ял эдэлсэн нь өмнөх оноос 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн хорихоос өөр ялаар шийтгүүлсэн буюу нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрх хязгаарласан ял, эрх хасах ялыг биелүүлээгүй биелүүлэхээс зайлсхийсэн торгох ял шийтгүүлсэн 107, нийтэд тустай ажил хийлгэх ялтай 246, зорчих эрх хязгаарлах ялтай 247 ялтны ялыг хорих ялаар солиулсан бол торгох ялаар шийтгүүлсэн 10,418 хүн, хуулийн этгээдийн 23.8 тэрбум төгрөгийн торгох ялын биелэлтэд хяналт тавьж ажиллахад 8,051 хүн, хуулийн этгээдийн 13.0 тэрбум төгрөгийн торгох ялыг биелүүлсэн байна.

⁸⁴ Монгол Улсын Үндсэн хууль

⁸⁵ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл

Тухайн улсын хүний эрх, эрх чөлөөний байдал, хууль дээдлэх ёс ямар түвшинд хүрснийг гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүнтэй мөрдөн шалгах, шүүх эрх мэдлийн байгууллагууд хэрхэн харьцаж байгаа, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг хэрхэн хүндэтгэн хамгаалж байгаагаар тодорхойлогддог.⁸⁶ Хүний эрхийн Үндэсний Комисст 2024 онд ирсэн гомдол мэдээллийн 52.9 хувь нь шударгаар шүүлгэх эрх зөрчигдсөн талаарх мэдээлэл эзэлж байх ба агуулгаар нь авч үзвэл, хууль зүйн туслалцаа авах, эрүү шүүлтээс ангид байх, хууль бусаар цагдан хоригдсон, шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон зэрэг гомдол дийлэнх хувийг эзэлж байна.

Түүнчлэн гэмт хэргийг илрүүлэх, нотлох, хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гэрч, хохирогч нь гол үүрэг гүйцэтгэдэг тул тэдний аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр тэдэнд нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний улмаас гэрч, хохирогч мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх зэрэг үйлдлүүд гардаг талаар судлаачид тэмдэглэжээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль 2013 онд баталснаас хойш 2016 онд тус хуулийн дагуу 42 хүнийг хамгаалалтад авч байсан бол 2024 онд хамгаалалтад хамрагдсан хүний тоо 116 болж нэмэгдэн, 2016-2024 оны хугацаанд нийт 1,134 иргэн хамгаалалтад хамрагдсан байна. Цаашид гэрч, хохирогчийг хамгаалах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог системээр нь эргэн харж, олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр хөгжүүлэх шаардлагатай байна.

Эдгээр нөхцөл байдал нь иргэдийн эрх, эрх чөлөөнд нөлөөлөөд зогсохгүй, нийгэмд шударга ёс, хууль дээдлэх зарчим, шүүхийн байгууллагын нэр хүнд, төрийн үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэлийг бууруулахад нөлөөлж байна.⁸⁷

Манай улсын хувьд иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг, хууль зүйн туслалцаа, үйлчилгээний хүртээмж сул, гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, хууль, хяналтын байгууллагын ил тод, нээлттэй байдал, хариуцлагын тогтолцоо хангалтгүй, төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй дутагдалтай, мэргэшсэн хүний нөөцийн хомсдол зэргээс шалтгаалан хууль, шүүхийн байгууллагын засаглал, хараат бус, бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байгааг өөрчилж хуулийн засаглалын индексийг 2024 онд 120 дугаарт эрэмбэлэгдэж байгааг 2030 онд 100-д хүргэхээр зорьж байна.

3.5.3. Төрийн бүтээмж

Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн оновчтой бөгөөд тогтвортой байдал, бодлого-төсөв, бодлого-гүйцэтгэл уялдсан байх юм. Өнгөрсөн хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл байнга өөрчлөгдөж, уялдаа холбоо сул, бодит нөхцөл байдалд нийцээгүй, төрийн залгамж чанар алдагдсан, улсын болон орон нутгийн төсөвтэй уялдаагүй нийт 567 бодлогын баримт бичиг батлагдсан байсан. Харин 2020 онд шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар бодлого, төлөвлөлтийн эрх зүйн орчныг сайжруулж, хоорондоо уялдаагүй хэт олон бодлогын баримт бичгийг хүчингүй болгож дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн судалгаа шинжилгээнд тулгуурлан, зорилго зорилт нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь зорилгодоо нийцсэн, төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байхаар урт, дунд,

⁸⁷ Алсын хараа 2050

богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинээр боловсруулан, батлуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна.

Хүн ам, эдийн засгийн өсөлт, төрөлжилт, төсвийн тэлэлт, төрийн байгууллагын бүтцийн нэгж, орон тоо өссөөр байгаа нь төсөвт ачаалал өгч, урсгал зардлыг нэмэгдүүлж, бүтээмжийг бууруулах гол хүчин зүйл болж байна. Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг "Government Effectiveness Index" буюу Засгийн газрын үр нөлөөний үзүүлэлтээр Монгол Улсын Засгийн газрын үр дүнтэй байдал өсөөгүй үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл бүтэц, орон тооны өсөлт нь үр дүнтэй байдалтай урвуу хамааралтай байна.

Урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-ын Засаглалын талаар баримтлах бодлогын 5.2-т "Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна" гэж заасан байна. Цаашид төрийн үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримталж, албан тушаалын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, орон тоо, бүтцийг оновчтой тогтоох болон төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх зэргээр бүтэц, орон тоог оновчлох нь зохимжтой байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж 2019 оноос хэрэгжиж эхэлснээс хойш "сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "сургалтын хөтөлбөр" болон "хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч төрийн захиргааны байгууллагууд сургалт, хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахдаа хуульд заасан агуулгыг ёс төдий байдлаар тусгаж, энэхүү баримт бичгийг тунхгийн шинж чанартай гэж ойлгоход хүргэж байна. Мөн энэхүү баримт бичгийг дунджаар 2-4 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байхаар дунд хугацааны баримт бичиг байдлаар гаргадаг ч энэ нь ажилтнуудад хүртээмжтэй, ойлгомжтой, үр дүнтэй арга хэлбэрээр хүрдэггүй байна.⁸⁸

Судалгаагаар "Сургалт, хөгжлийн хэрэгцээг тодорхойлсон байдал" хэсэгт яамдын дундаж оноо 1.9 буюу 4 үндсэн хэсгээс хамгийн өндөр оноотой, "Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт"-ын хэсэгт дундаж оноо нь хамгийн бага буюу 1.3 оноотой шалгуур хангасан. Энэ үнэлгээ нь яамдын сургалтын хөтөлбөр гэсэн баримт бичгийн агуулга нь хангалтгүй байгааг илтгэхийн зэрэгцээ хөтөлбөрт хэрэгжүүлэх үйл явцыг тодорхой тусгадаггүйг харуулж байна.

Төрийн алба тогтворгүйгээс сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр хэрэгжихэд хүндрэл учирч байна. Төрийн албанд хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалж "Яаманд тодорхой чиглэлээр бэлтгэгдсэн, сургасан хүнээ улс төрийн шалтгаанаар явуулчихдаг", туршлагагүй, бэлтгэгдээгүй албан тушаалтан, албан хаагч ирснээр хүний нөөцийн чанар сулрах, хүний нөөцийн сургалт, хөгжлийн ажил тасрах, хөтөлбөрийн залгамж байдал алдагддаг байна.⁸⁹

Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг шударга, бодитой үнэлэх тогтолцоо бүрдээгүй, цалин хөлс бага, ачаалал их байдагтай холбоотойгоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан олгодог мөнгөн урамшууллыг нийтлэг байдлаар олгох хандлага их байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дунджаар 77.0 хувьтай байхад албан хаагчдын 98.7 хувь нь "маш сайн", "хангалттай" гэсэн үнэлгээтэй байна.⁹⁰

Үнэлгээ бодит бус байгаа учир шалтгааныг нарийвчлан тогтоож, бодит байдалд нийцүүлсэн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг бий болгох шаардлагатай байна. Субъектив бус байдлаар технологи ашиглан гүйцэтгэлийг үнэлж болох тухай

⁸⁸ "ЗГХЭГ"-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ.

⁸⁹ "ЗГХЭГ"-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ.

⁹⁰ "ЗГХЭГ"-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ.

зохицуулалтыг оруулах, гүйцэтгэлийн удирдлагыг үр дүнд суурилсан байдлаар төлөвлөх, олон нийтийн хяналтыг сайжруулж, ил тод нээлттэй болгох эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөр, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ батлагдаж ёс зүй хариуцлагын тогтолцоо бүрдсэнтэй холбоотойгоор иргэд, олон нийтийн зүгээс төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сайжирч, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөө дээшилнэ гэсэн хүлээлт бий болж нийгэмд шинэ хэлбэрийн ёс зүй нэвтэрч байна.

Түүнчлэн, төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааг зохицуулж буй хүчин төгөлдөр 20 гаруй хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, салбарын онцлогийг харгалзан тогтоосон 28 байгууллагын ёс зүйн 30 дүрэм, журам мөрдөгдөж байна.

Төрийн албан хаагчид ёс зүйтэй байх нь нийгмийн итгэл, засаглалын үр дүнтэй шууд холбоотой төдийгүй төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдлыг баталгаажуулахад чухал ач холбогдолтой юм. Иргэдийн амьдралд нөлөөлөх төрийн шийдвэр, бодлого, үйл ажиллагааны хувьд ёс зүйн стандартыг сахих нь иргэдийн итгэлийг даасан засаглалыг бий болгоход чухал түлхэц болдог гэж үздэг.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихдээ хэрэгжүүлсэн өмч хувьчлалын бодлогын дагуу төрийн өмчид үлдээсэн үйлдвэр, аж ахуйн газрууд нь эдүгээ цагийн шаардлагад нийцсэн төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компани болон өөрчлөгдөн ажиллаж байна.⁹¹ Төрийн өмчит компаниудын улсын төсөвт оруулах хувь нэмэр их боловч зардлын хяналт сул, төсөвт хэт үрэлгэн хандах, бараа материалыг хэт өндөр үнээр худалдан авах, тендергүй худалдан авалт хийх, мэдээллийг нийтэд ил тод болгох тал дээр хойрго ханддаг сул тал дэлхий даяар нийтлэг байдаг. Мөн төрийн өмчит компанид Засгийн газар болон яам, удирдах байгууллагаас улс төрийн шууд болон шууд бус нөлөө, дарамт их байдгаас ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах явдал түгээмэл байна. Мөн төрийн өмчит компаниудын худалдан авалт ил тод биш байх нь оновчгүй шийдвэр гаргах, их хэмжээний алдагдал хүлээх, албан тушаалтнууд авлигад өртөх үндсэн шалтгаан болж байна.

Монгол Улсад газар эзэмших, өмчлөх, захиран зарцуулах, ашиглахтай холбоотой бүхий л асуудал нь “Газрын тухай хууль”, “Газрын өмчлөлийн тухай хууль” болон холбогдох хууль, дүрэм, журмаар зохицуулагддаг байна. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 2003 онд батлагдаж хэрэгжиж эхэлснээс хойш 2024 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 701,705 иргэнд 72,735.24 га газрыг өмчлүүлсэн байна. Үүнээс нийт 700,441 иргэнд 72,631.9 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй, нийт 1,264 иргэнд 103.34 га газрыг аж ахуйн зориулалтаар үнээр нь тус тус өмчлүүлж, улсын хэмжээнд нийт иргэдийн 20 хувь нь газраа өмчилж авсан байна. Мөн улсын хэмжээнд 2020-2024 оны хооронд нийт шүүхээр шийдвэрлэгдэж буй маргааны 22.8 хувийг газрын маргаан эзэлж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн дунджаар шүүхээр шийдвэрлэгдсэн газрын маргаан 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Манай улсын бүхий л салбарт, тэр дундаа тээвэр, логистик, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний үйл ажиллагаанд тулгарч буй гол хүндрэл нь хаягжилтын асуудал юм. Улсын хэмжээнд хаяг олгох үйл эрхэлдэг байгууллагууд нь задгай болон түр хаяг олгох, давхардаж хаяг олгох, хаягийн иж бүрдэл дутуу, хаяг олгох шат дамжлага олон, хаягийн мэдээлэл нь нэгдсэн стандартгүй нь улмаас мэдээллийг ашиглахад хүндрэлтэй, төрийн байгууллага хоорондын газар, үл хөдлөх хөрөнгийн

⁹¹ Төрийн өмчит аж ахуйн нэгжийн эдийн засагт гүйцэтгэх үүргийн шинжилгээ - судалгаа

хаягийн мэдээлэл зөрүүтэй бүртгэлтэй байна. Улсын хэмжээн 206 сум, нийслэлийн хэмжээнд 1 дүүрэг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системээс хаяг олгодог байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих зорилтын хүрээнд цахим болон операторын горимоор төрийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн портал систем хэрэглээнд нэвтрүүлсэн. 2025 оны эхний 9 сарын байдлаар 87 байгууллагын 1,268 төрлийн үйлчилгээг E-Mongolia платформд холбож, насанд хүрсэн хүн амын 89 хувийг хамарч нийт 85 сая үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахимаар хүргэж, 1.7 их наяд төгрөгийг хэмнэсэн нь цахим шилжилтийн бодит үр дүнг харуулж байна.⁹² Төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн байгууллагуудаас үзүүлэх үйлчилгээ хүнд сурталгүй, цаг хугацаа, орон зай хэмнэсэн, хүний хүчин зүйлээс шалтгаалах хүндрэл, чирэгдэлгүй болж төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа өргөжих, төрийн албаны шинэтгэлийн үйл явцыг хурдасгах, иргэдийн итгэлийг хүлээсэн, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, шуудан, шатахуун, бичиг хэргийн зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

Цаашид цахимаар түрүүнд зарчмыг баримтлан төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэн төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг, орон тоог оновчтой тогтоон чадахуйн зарчимд суурилсан оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий цомхон, чадварлаг төрийн албыг бэхжүүлэх, хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг сайжруулах, ур чадварт суурилсан томилгоог төлөвшүүлэх замаар төрийн албанд чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэн төрийн бүтээмж 2024 онд 141-д эрэмбэлэгдэж байгааг 108-д хүргэхийг зорилоо.

3.5.4. Төлөөллийн байгууллага

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар төрийн байгууламж, засаглалын хэлбэр, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын тогтолцоо, төрийн удирдлагын зарчмуудыг улс төрийн олон ургалч үзэл, ардчилсан дэглэмийн үнэт зүйл, шалгуурт нийцүүлэн шинээр тодорхойлсон.⁹³ Монгол Улсын Үндсэн хуульд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоонд шилжиж, анхны 126 гишүүнтэй Улсын Их Хурал байгуулагдаж, ард иргэдийн сонгуулиар өгсөн саналыг орхигдуулахгүй байх зарчмыг үндэслэн анхны гурван намын хамтарсан Засгийн газрыг байгуулсан.

Парламент бол ард иргэд өөрсдийгөө төлөөлөн эрх ашгаа даатгаж сонгосон итгэмжит төлөөлөгчдийн байгууллага бөгөөд бүх нийтийн хяналтад байдаг төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага юм. Ард түмний төлөөллийн байгууллага болохын хувьд Улсын Их Хурлын бодлого тодорхойлох, хууль батлах чадавх сайн байх учиртай. Гэтэл УИХ-ын гишүүдийн нэр хүнд, УИХ-д чиглэсэн иргэдийн итгэл суларч байна. Дэлхийн банкны засаглалын судалгааны иргэдийн дуу хоолой ба хариуцлага гэсэн үнэлгээгээр Монгол Улсын индекс 56.4 байгаа буюу 98-д эрэмбэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, бодлого тодорхойлох үйл явц дахь иргэдийн оролцоо дунд хэсэгт эрэмбэлэгдэж байна. УИХ-ын гишүүд улс орны хөгжил, бодлогын асуудалд анхаарал хандуулах гэхээсээ илүүтэй сонгогдсон тойрогтоо хамааралтай байдлаар бодлого, шийдвэрт хандах нь давамгайлах болсон. Үүний үр дүнд үндэсний хэмжээний бодлого тодорхойлох, томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд ашиглагдах захиргааны болон санхүүгийн нөөц үр дүнгүй, үр ашиггүй зарцуулагдах

⁹² E-Mongolia платформ.

⁹³ Алсын хараа 5-р бүлгээс ишлэв.

нөхцөл байдал үүсэж байна. Улс төрчид маргаашийн сонгуулийг бодох, сонгогдсон тойргийнхоо явцуу эрх ашгийг үндэсний хэмжээний томоохон бодлого, хөтөлбөрөөс илүүд үзэх улс төрийн соёл хэвшил болоод байна. Иймд төлөөллийн байгууллагын асуудал оновчтой шийдвэрлэх чадавхыг сайжруулж, нотолгоо ба үр дүнд суурилсан шийдвэр гаргалтыг хэвшүүлэх шаардлагатай байна.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар төлөөллийн байгууллагын хууль тогтоох, хяналт тавих чадавхыг сайжруулж хууль, УИХ-аас баталсан бусад шийдвэрийн биелэлт 2024 онд 30.0 хувь байгааг 2030 онд 70.0 хувьд хүргэнэ. Үүний тулд олон ургалч үзлийг дээдэлж, парламентын ардчилсан зарчмыг бэхжүүлэн шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн санаа бодлыг тусгасан үр дүнтэй гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь 2024 онд 30.0 байгааг 2030 онд 70.0 хувьд хүргэнэ.

3.5.5. Үндсэн хуулийн хяналт

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага мөн” гэж Үндсэн хуулийн цэцийн чиг үүрэг болоод бүрэн эрхийг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлаас 1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 1997 онд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус баталсан бөгөөд Үндсэн хуулийн цэц эдгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангах бөгөөд Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих чиг үүргээ Үндсэн хуулийн тухай маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргааныг шийдвэрлэж гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргаж байна.

Үндсэн хуулийн цэц нийт 231 дүгнэлт гаргаснаас Үндсэн хууль зөрчсөн дүгнэлт 135 (58.4%), үндсэн хууль зөрчөөгүй дүгнэлт 96 (41.6%) гарсан бөгөөд Улсын Их Хурал 56 (41.5%) дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, 79 (58.5%) дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй байна. (Хүснэгт 68-д харуулав.)

Хүснэгт 68. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр

Он	Дүгнэлт	Үүнээс:		Улсын Их Хурал	
		Үндсэн хууль зөрчсөн	Үндсэн хууль зөрчөөгүй	Хүлээн зөвшөөрсөн	Хүлээн зөвшөөрөөгүй
2020	12	5	7	2	3
2021	7	6	1	4	2
2022	2	-	2	-	-
2023	5	5	-	2	3
2024	4	4	-	3	1
1992-2024	231	135	96	56	79

Эх сурвалж: Үндсэн хуулийн цэц

Сүүлийн таван жилийн тархалтын хурдыг үзэхэд жилд дунджаар 6 дүгнэлт гаргаж байгаагаас Үндсэн хууль зөрчсөн дүгнэлт 4, зөрчөөгүй дүгнэлт 2 гарч байгаа бол УИХ-аас 2.2 дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, 1.8 дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 онд байгуулагдсанаас хойш 4,200 өргөдөл, мэдээлэл, хүсэлт авч хянаснаас 90.0 хувь нь Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй, бусад байгууллагын эрх хэмжээний асуудал, 10.0 хувь нь маргаан үүсгэж хянан шийдвэрлэсэн байна. Хүний эрхийн асуудлаар хандсан байдлыг үзэхэд 46.0 хувь нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан, 54.0 хувь нь бусад асуудлаар ханджээ.

Цэцийн хүлээн авсан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн 64.5 хувь нь Монгол Улсын хуультай, 10.8 хувь нь Үндсэн хуулийн Жаран зургаадугаар дугаар зүйлд зааснаас бусад харьяаллын бус, 7.0 хувь нь Ерөнхий сайд, 5.6 хувь нь Монгол Улсын Их Хурлын тогтоол, 5.2 хувь нь Монгол Улсын Их Хурлын гишүүн, 1.7 хувь нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолтой холбоотой, 5.2 хувь нь бусад асуудалд хамаарч байгаа бол 92.0 хувийг шийдвэрлэж, 8.0 хувь хяналтын шатанд ажиллаж байна.⁹⁴

Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах, Үндсэн хуулийг иргэдэд сурталчлан таниулж цэцэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгааны чанарыг сайжруулж, ил тод байдлыг хангах, шийдвэрийн үндэслэлийг чанаржуулах, цэцийн шийдвэрийн хэрэгжилт, үр дүн, нөлөөллийг дээшлүүлэх, Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус, эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангах замаар Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулахаар зорьж байна. Үүний тулд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрлэлтийн түвшнийг 2024 онд 77.9 байгааг 2030 онд 82.0 хувь болгож нэмэгдүүлнэ.

Маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай харьцуулсан болон бусад судалгааны чанарыг сайжруулж, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангаж, шийдвэрийн үндэслэлийг чанаржуулан Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах аргачлалын хэрэгжилтийг хангана.

3.5.6. Улс төрийн тогтвортой байдал

Монгол Улсын ардчиллын түүх эерэг өнгө төрхтэй ч улс төр, сонгуулийн хувьд нэлээд сорилттой тулгарч иржээ. Идэвхтэй эхэлсэн ардчилсан хөдөлгөөний эхэн үед буюу 1992 оны Монгол Улсын анхны ардчилсан сонгууль, 1993 оны Ерөнхийлөгчийн анхны сонгуулийн үеэр сонгуулийн ирц 90 гаруй хувь, орон нутгийн сонгуулийн ирц 70 гаруй хувьтай байсан байна. Үүнээс хойш бүх төрлийн сонгуулийн хувьд сонгогчдын ирц тогтмол буурсаар байна. 2000-2024 оны сонгуулийн ирцийг доорх хүснэгтээр (Хүснэгт 69) харуулбал:

Хүснэгт 69. Улсын Их Хурал, Орон нутгийн сонгуулийн ирц

Хүснэгтийн нэр	2000	2004	2008	2012	2016	2020	2024
Ерөнхийлөгч	83	75	74	67	68	59	-
Улсын Их Хурал	82	81	76	67	74	73	69
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	65	67	65	52	60	56	50

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Бүх төрлийн сонгуулийн ирц буурахад нийт ард иргэдийн сонгуулийн талаарх ойлголт дутмаг, сонгуулийн тогтолцоо, хууль дүрмийн байнгын өөрчлөлт, үүнтэй

⁹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны тойм 2024

холбоотой ойлгомжгүй байдал, бухимдал, улс төрийн томоохон намуудын талаарх нийгмийн сөрөг ойлголт, Монголын сонгуулийн тогтолцоо байнга өөрчлөгддөг, Монгол Улсын сонгуульд зарим судалгаа, дүн шинжилгээг хийхэд хүндрэлтэй зэрэг нийтлэг хүчин зүйлс нөлөөлж болно.

Монгол Улс 1992 оноос хойш буюу сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд УИХ-ын сонгуулийн тухай хуулиа зургаан удаа шинэчилж, нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

- ✓ 1992 он - Ардчилсан Үндсэн хууль батлагдсаны дараа анхны УИХ-ын сонгуулийн хууль гарсан;
- ✓ 2000 он - Сонгуулийн тойргийн зохион байгуулалт, санал тоолох журамд өөрчлөлт орсон;
- ✓ 2005 он - Сонгуулийн тогтолцоонд зарим өөрчлөлт орсон;
- ✓ 2011 он - Холимог тогтолцоо (мажоритар + пропорциональ) анх нэвтэрсэн;
- ✓ 2016 он - Дахин мажоритар тогтолцоонд шилжсэн (76 мандат бүгд нэг мандаттай тойргоор).
- ✓ 2023 он - Хамгийн сүүлд нэмэлт, өөрчлөлт орсон. Үүнд гадаад дахь иргэдийн санал өгөх эрх, сонгуулийн бэлтгэл, санал хураалтын зохицуулалт, жендэрийн тэнцвэрийн талаар шинэ заалтууд орсон байна.

Энэ мэтээр байнга өөрчлөх нь сонгогчдын боловсрол, улс төрийн намын институтчилал, стратегид сөргөөр нөлөөлж, тогтолцоонд урьдчилан таамаглах боломжгүй, тодорхойгүй байдлыг бий болгож болзошгүй юм. Түүнчлэн улс төрийн намуудын эрх ашгаа тэргүүнд тавьдаг хандлага, улс төрийн байр сууриа бэхжүүлэх сонирхлын үүднээс сонгуулийн тогтолцоог сонгодог, улмаар бага саналын зөрүүтэй ч төрийн эрхийг үргэлжлүүлэн барих улс төрийн зорилготой байдаг зэрэг нь сонгогдсон албан тушаалтнуудад итгэх иргэдийн итгэлийг бууруулдаг байна.⁹⁵

Сүүлийн жилүүдэд улс төрийн талцал, хуваагдал эрчимтэй өрнөж байгаа нь Засгийн газар тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэхгүй байна.⁹⁶ Тухайлбал 2008-2025 онд 8 удаа Засгийн газар байгуулагдаж, Засгийн газар дунджаар 26.4 сар буюу 2.2 жилийн настай байна. Энэ хугацаанд 8 ерөнхий сайд томилогдсон бөгөөд 7 нь бүрэн эрхийнхээ хугацаагаа дуусгалгүй огцорсон байна. Дэлхийн банкны засаглалын үнэлгээгээр 1996 оноос хойших хугацаанд Монгол Улс дахь улс төрийн тогтвортой байдлын индексийн дундаж 2023 оны байдлаар 0.59 оноотой байна.⁹⁷

Улс төрийн тогтворгүй байдал нь бодлогын тогтворгүй байдал үүсэхэд ихээхэн нөлөөлж байгаа бөгөөд аливаа шийдвэр нь цогц суурь судалгаанд суурилаагүй, улс төрийн шийдэл давамгайлсан, зохих бэлтгэлийг бүрэн хангаагүй богино хугацаанд хэрэгжүүлэхийг зорьсон шинэчлэлийн бодлого, стратеги, тэдгээрийн хэрэгжилтийн менежментийн зарим алдаа, дутагдлаас шалтгаалж хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Цаашид Улс төрийн тогтвортой байдлыг нэмэгдүүлж, шударга ардчилсан сонгуулийн соёлыг төлөвшүүлэх үүднээс иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, сонгуульд оролцож буй иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь чухал шаардлагатай байна.

3.5.7. Гадаад таатай орчин

Олон улсын харилцаанд үүссэн ээдрээтэй байдал, зэвсэгт мөргөлдөөн, томоохон улс гүрнүүд хоорондын талцах явдал гүнзгийрч буй нөхцөлд манай улс “энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт” суурь зарчмыг тууштай

⁹⁵ Монгол Улсын сонгууль эмхэтгэл

⁹⁶ Алсын хараа - 2050 5 бүлгээс ишлэв

⁹⁷ Economies around the world | TheGlobalEconomy.com

баримтлах, хоёр хөрш болон гуравдагч хөрш орнуудад ойлгуулах, тэнцвэртэй харилцах, байр сууриа хадгалах, гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, дээд, өндөр түвшний айлчлалуудыг хэрэгжүүлэхэд анхаарсан байна. Монгол улсын хувьд гадаад харилцааны салбар нь 2024 онд өндөр, дээд түвшний айлчлалын тоо түүхэн дээд түвшинд хүрсэн байна. (Хүснэгт 70-д гадаад харилцааны тоон мэдээлэл харуулав.)

Хүснэгт 70. Гадаад харилцааны тоон мэдээлэл

дд	Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
1	Дээд, өндөр түвшний хэрэгжүүлсэн харилцан айлчлал	-	17	18	46	34
2	Засгийн газар хоорондын комиссын хуралдаан	3	7	8	11	6
3	ДЭМБ -д хоорондын зөвлөлдөх уулзалт	11	9	16	21	19
4	НҮБ-д Монгол Улсын санаачлан батлуулсан тогтоол	2	2	2	2	2
5	Тухайн жилд нэгдсэн орсон олон талт олон улсын гэрээ	5	6	6	6	6
6	Тухайн жилд байгуулсан Засгийн газар хоорондын гэрээ	17	10	24	15	16
7	Тухайн жилд байгуулсан байгууллага хоорондын гэрээ	24	20	61	41	108
8	Гадаад бодлого, бүс нутаг, олон улсын харилцааны асуудлаар төрийн албан хаагчдыг мэдээллээр хангах зорилгоор боловсруулж, хүргүүлсэн гадаад хэвлэлийн тойм	-	245	274	244	250
9	Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулан зохион байгуулсан сургалт	-	2	2	2	3
10	Тухайн жилд шинээр нээсэн эсвэл бүтэц орон тоог өөрчилсөн Дипломат төлөөлөгчийн газар	-	2	3	-	2
11	Визгүй зорчих улсын тоо	22	23	25	26	29
12	Визийн нөхцөл хөнгөвчилсөн улсын тоо	68	69	70	72	74
13	Гадаадад амьдарч буй монгол иргэдийн тоо	122,300	-	167,000	211,600	271,446
14	Иргэдэд үзүүлсэн консулын үйлчилгээ	-	60,000	76,141	152,059	151,265

Эх сурвалж: TheGlobalEconomy

Гадаад харилцааны салбарт 2024 онд Ерөнхийлөгчийн түвшинд 15, УИХ-ын даргын түвшинд 3, Ерөнхий сайдын түвшинд 8, Гадаад харилцааны сайдын түвшинд 8 айлчлал хэрэгжүүлсэн байна. Засгийн газар хоорондын комиссын 6 хуралдаан, Гадаад харилцааны яам хоорондын 19 зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Мөн энэ онд нийт 6 олон талт гэрээнд гэрээнд нэгдэн орох дотоодын процедураа хангасан бол Засгийн газар хоорондын 16 гэрээ байгуулсан.

Дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээг эдийн засгийн агуулгаар улам баяжуулах, хөгжлийн стратегитай уялдуулах, худалдааны бүтцийг төрөлжүүлэх, хилийн боомтуудыг харилцан холбох, аялал жуулчлал, үйлдвэрлэл, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд нягт хамтран ажиллах, хамтын ажиллагааны шинэлэг хэлбэрүүдийг идэвхтэй эрэлхийлж ажиллаж байна. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах тэргүүн зорилт хэвээр байна.

Монгол Улсын иргэдийн гадаад улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх “Хүчирхэг Монгол паспорт” ажлын хүрээнд Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулж, “Global Passport Power Bank Ranking”-ын эрэмбийг нэмэгдүүлж ажиллахаар төлөвлөсөн байна. Монгол Улсын иргэд 2024 оны байдлаар гадаадын 29 улсад визгүй зорчих боломжтой байгаа бөгөөд 31 улсын визийг цахимаар авч байна. Цаашид 2026-2030 онд визгүй зорчих

боломжтой улсын тоог 35 хүргэхийг зорьж, зорчих нөхцөлийг улам хялбаршуулахыг эрэлхийлж ажиллана.

Одоогийн байдлаар Монгол Улс 15 улс буюу ОХУ, БНХАУ-тай "Иж бүрэн стратегийн түншлэл", АНУ-тай Стратегийн гуравдагч хөршийн түншлэл", Япон Улстай "Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэл", БНСУ, БНЭУ, ХБНГУ, БНКаЗУ, БНТУ-тай "Стратегийн түншлэл", Канад, Вьетнам, Чех, Польш, Узбекистантай "Иж бүрэн түншлэл", Австрали Улстай "Өргөн хүрээний түншлэл" тогтоогоод байна. (Хүснэгт 71-д харуулав).

Хүснэгт 71. Түншлэлийн харилцаатай улс орнууд

дд	Улс	Түншлэлийн харилцаа
1	ОХУ	Иж бүрэн стратегийн түншлэл
2	БНХАУ	
3	АНУ	
4	Япон	Стратегийн гуравдагч хөршийн түншлэл
5	БНСУ	Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэл
6	БНЭУ	
7	ХБНГУ	
8	БНКаЗУ	
9	БНТУ	
10	Канад	
11	Вьетнам	Стратегийн түншлэл
12	Чех	
13	Польш	
14	Узбекистан	
15	Австрали	
		Иж бүрэн түншлэл
		Өргөн хүрээний түншлэл

Эх сурвалж: Гадаад харилцааны яам

Консулын харилцаа, хилийн чанад дахь Монгол иргэддээ зориулж 2026-2030 онд монгол хэл, соёл, өв уламжлал, үндэсний үнэт зүйлсийг хадгалан тээх, эх оронтойгоо холбоотой байх сэтгэлгээ, оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад Монгол Улсын эерэг байдлыг олон улсад таниулах, нэр хүндийг нь өсгөх замаар улс орны язгуур эрх ашиг, үндэсний ашиг сонирхлыг хамгаалах зорилготой "Дэлхийн Монголчууд III" цогц хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр байна.

Мөн хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцаж, гуравдагч хөршийн бодлогод ахиц гаргаж гуравдагч орнуудын төрийн тэргүүн нарыг хүлээн авсан. Тухайлбал ХБНГУ, Швейцар, Словени улсын төрийн тэргүүн нар, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Гадаад харилцааны сайд нар Монгол Улсад айлчилсан. Мөн АНУ-тай хийсэн эрчим хүчний яриа хэлэлцээ, УИХ-ын даргын Япон Улсад хийсэн айлчлал гэх зэргээр гуравдагч хөршийн бодлогод ахиц дэвшил гарсан.

Дэлхий дахины геополитикийн тодорхойгүй нөхцөл байдал, их гүрнүүдийн өрсөлдөөн, талцал гүнзгийрч, олон улсын харилцааны цаашдын хандлага, төлөв таамаглахад төвөгтэй болж байна. Олон улсын түвшинд тогтсон дэг журам өөрчлөгдөх үйл явц ажиглагдаж буй энэ цаг үед Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар бататган хамгаалах, олон улсын түвшинд байр сууриа бэхжүүлэх үүднээс хамтын ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, улс орнуудтай тогтоосон харилцааны түвшнийг ахиулах, нягт хамтрах шаардлага тулгарч байна. Иймд манай улс дэлхийн нөлөө бүхий болон бусад улстай түншлэлийн харилцааны түвшнийг ахиулах, хоёр талт болон олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, нэгдэн орох замаар Монгол Улсын нэр хүндийг өргөх, тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бататган бэхжүүлэх арга зам эрэлхийлж байна.

Монгол Улс холбогдох улс орнуудтай одоо байгаа харилцааны түвшнийг улам ахиулах болон шинээр түншлэлийн харилцаа тогтоосноор олон улсын тавцанд манай улсын байр суурь улам бэхжиж, улс орны нэр хүнд, аюулгүй байдал баталгаажих юм.

Цаашид манай улс хоёр хөрш болон гуравдагч хөрш орнуудтай дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалан хэрэгжүүлж, бүс нутаг, олон талт хамтын ажиллагааны цар хүрээг улам нэмэгдүүлж, худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн бэхжүүлэх шаардлагатай байна.

Үүнд хүрэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлж Монгол Улсын соёлын нөлөөг өргөжүүлэх, хилийн чанад дахь монгол угсаатны хамтын ажиллагааг бэхжүүлэх, гадаад улсын виз авах нөхцөлийг хөнгөвчилж Монгол иргэдийн гадаад улс руу визгүй зорчих улсын тоог нэмэгдүүлэх замаар гадаад таатай орчныг бэхжүүлэн Дэлхийн энх тайвны үзүүлэлтийн индекс 2024 онд 1.85 байгааг 2030 онд 1.49-д хүргэхийг зорьж байна.

3.5.8. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх

“Алсын хараа-2050”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах, стратегийн баримт бичгийг боловсруулах, түүнд дэмжлэг үзүүлэх үндэсний тогтолцоог бий болгох зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээнд Батлан хамгаалахын сайдын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/77 дугаар тушаалаар “Ажлын дэд бүлэг”-ийг төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулж “Үндэсний сөрөн тэсвэрлэх цогц стратеги”-ийн баримт бичгийн төслийг боловсруулсан

Стратегийн үндсэн чиглэлийг *нэгдүгээрт*, Улс төр, нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавх, *хоёрдугаарт*, эдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадавх, *гуравдугаарт*, батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавх, *дөрөвдүгээрт*, гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавх, *тавдугаарт*, хүрээлэн буй орчны өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох чадавх, *зургаадугаарт*, мэдээлэл, кибер аюулгүй байдлын сөрөн тэсвэрлэх чадавх гэж тодорхойлон үндсэн чиглэл бүрд тайван цагт, хямралын үед, хямралын дараах үед хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Энэхүү стратегийг хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд тулгарч болзошгүй аюул, эрсдэл, сорилт, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, сөрөн тэсвэрлэх бэлтгэлийг хангах, хохирол багатайгаар даван туулах, сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх цогц чадавх бүрдэнэ.

Өнөө үед дэлхий даяар улс орнуудын аюулгүй байдалд учирч буй эрсдэлүүд улам бүр нэмэгдэж байна. Байгалийн гамшиг, олон улсын терроризм, эдийн засгийн хямрал, нийгмийн эмх замбараагүй байдал зэрэг асуудлууд нь улс орнуудын аюулгүй байдалд шууд нөлөөлж байгаа нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд өндөр ач холбогдол өгөх шаардлагатайг харуулж байна.

Улс орнууд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хөгжүүлэх нь улс үндэстний үүрэг, хариуцлага гэдгийг хүлээн зөвшөөрч, зорилго, тэргүүлэх чиглэлээ өөрсдийн нөхцөл байдалд тулгуурлан тодорхойлж, өөрийн туршлага, сургамж, нөхцөл байдал, хөгжлийн онцлогтой уялдуулан боловсруулдаг бөгөөд хүндрэлтэй нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлдэг төдийгүй урьдчилан сэргийлэх, эрсдэлүүдийг удирдах боломжтой болгодог онцлогтой.

Манай улс өмнө нь Үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг боловсруулж, хэрэгжүүлж байгаагүй бөгөөд цаашид уг стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч, эрсдэлийн удирдлагыг бүх шатанд нэвтрүүлэх, нөөцийн бэлэн байдлыг хангах, технологийн дэвшлийг ашиглах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын асуудал нь салбар дундын шинжтэй тул

дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх замаар 2024 онд 2.11 байгаа үзүүлэлтийг 2030 онд 2.09-д хүргэх зорилт тавьж байна.

3.5.9. Батлан хамгаалах чадавх

Батлан хамгаалах салбар нь “Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны төлөв, өөрчлөлтийн хандлагад нийцсэн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, улс орны хөгжлийн зорилго, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэн, улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг найдвартай хангах” эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийг батлуулсан нь Үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын өөрийгөө хамгаалах чадавхыг бэхжүүлэх, иргэн-цэргийн харилцааг төлөвшүүлэх, батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны цогц байдлыг хангах боломжийг бүрдүүлж, улс оронд дайны байдал зарлах, дайны байдалд шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Дээрх чиглэлийн хүрээнд батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, батлан хамгаалах салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, шинэ төрлийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг жигдрүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагаа идэвхжүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах, зарим төрлийн техник, хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтад оролцох, алба хаагчдынхаа ажиллах, амьдрах орчин нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулах, салбарын төсөв, санхүүгийн чадавхыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна.

Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д “Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Батлан хамгаалахын сэргэлт” бодлогыг эрчимжүүлж, салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт ихээхэн өөрчлөлтийг бий болгож буй “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж-дрон”, “Хиймэл оюун ухаан”-д суурилсан зэвсэг, техник, хэрэгслээр хангах, зохион бүтээх, бие бүрэлдэхүүнийг чадваржуулах, тэдний ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, бүтээн байгуулалт болон энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог 3 дахин өсгөх, цэргийн алба хаах насны иргэдийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх, сонирхлыг бий болгох, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, материал техникийн хангалт, үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдсэн 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний Туршилт, судалгааны төвүүдийг түшиглэн, тэдгээрийг чадавхжуулж, батлан хамгаалахын аж үйлдвэрийн суурийг амжилттай тавьснаар батлан хамгаалах эрх ашигт нийцсэн цэргийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх суурийг тавьж, тусгай зориулалтын хөнгөн хуягласан жижиг бүлгийн байлдааны, тагнуул-дайралтын, хөнгөн хуягласан байлдааны зэрэг 25 нэгж цэргийн техник, орон зайн тандалт, агаарын тагнуулын зориулалт бүхий загварын нисгэгчгүй нисэх төхөөрөмж 3 нэгж, богино долгионы дунд чадлын радиостанцын анхны загварыг шинээр амжилттай бүтээсэн. Эдгээр судалгаа-туршилтын арга хэмжээг хэрэгжүүлснээр батлан хамгаалах аж үйлдвэрийн суурь тавигдах, цэргийн шинжлэх

ухааны судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, Зэвсэгт хүчний тусгай хүчний анги, салбаруудын гал, маневрын боломж нэмэгдэх, гаднын худалдан авалтыг багасгаж, эх орондоо нэмүү өртөг шингээсэн техник, технологийг хөгжүүлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой болсон.

Монгол Улсын аюулгүй байдлыг цэрэг-улс төр, дипломатын аргаар хангах бодлогын хүрээнд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, өнөөдрийн байдлаар 39 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Батлан хамгаалах яам гадаад хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Турк Улсын "МКЕ" корпорацтай байгуулсан гэрээний дагуу сум үйлдвэрлэх үйлдвэрийн тоног, төхөөрөмжийн угсралт, тохируулгын ажлыг бүрэн хийгдэж, бие даан үйлдвэрлэлээ явуулж эхэлсэн. Үйлдвэр ашиглалтад орсноор Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлд шаардагдах сумыг дотооддоо ханган, төрийн цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хэрэгцээнд нийлүүлж, импортын хамаарлыг бууруулах нөхцөл бүрдсэн байна.

Цаашид Зэвсэгт хүчнийг зэвсэглэл, цэргийн техникээр хангах зорилтыг хэрэгжүүлэхдээ гадаад орны цэргийн техникийг худалдан авах, буцалтгүй тусламжид тулгуурлахаас гадна нөөц бололцоо, хөгжингүй орнуудаас суралцаж, орчин үеийн цэргийн техник, технологийн суурь мэдлэгийг эзэмшсэн алба хаагчдаа түшиглэн орчин үеийн технологийн ололт, шийдлийг тодорхой хэмжээнд нутагшуулан нэвтрүүлэх, дотооддоо цэргийн техник үйлдвэрлэх, удаан хугацааны хадгалалтад байгаа зэвсэглэл, цэргийн техникийг сэргээн сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь 23 жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах болон эвслийн цэргийн ажиллагаанд давхардсан тоогоор нийт 23,000 гаруй цэргийн алба хаагч оролцож, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн энх тайван, бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулж байна.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа штабын ажилтан, цэргийн мэргэжилтнээр үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдын 13.0 хувь, цэргийн багийн бие бүрэлдэхүүний 12.0 хувийг эмэгтэй цэргийн алба хаагчид эзэлж байгаа ба цаашид НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн "Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал" тогтоолын дагуу НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын тоог үе шаттай нэмэгдүүлж 15.0 хувьд хүргэх чиглэлийг баримтлан ажиллаж байна. Энхийг дэмжих ажиллагааны туршлага, ололт амжилтыг бататгасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэнтэй болсныг илтгэх "Сургалтын хөдөлгөөнт бүлэг"-ийг гадаад улсад үүрэг гүйцэтгүүлэхээр анх удаа илгээсэн байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Түргэн байрлах хүчний рот", "Инженерийн рот", "Цэргийн хээрийн II шатны эмнэлэг"-ийн үндсэн болон өөрийгөө хангах техник, тоног төхөөрөмж, бэлэн байдал, сургалтын түвшнийг НҮБ-ын "Үнэлгээ зөвлөмжийн үзлэг"-т шалгуулж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чадавхын бэлэн байдлын системийн II түвшинд гаргасан.

Дэлхийн геополитикийн нөхцөл байдал урьдчилан таамаглахын аргагүй эгзэгтэй болохын зэрэгцээ их гүрнүүдийн үл ойлголцол гүнзгийрч, ардчилал, хүний эрх, олон улсын хамтын нийгэмлэгийн тогтсон дэг журмаас илүүтэй өөрийн улсын ашиг сонирхлыг хүчээр тулгах тааламжгүй хандлага нэмэгдэн, бүс нутагт өрнөж буй зэвсэгт тэмцэл, мөргөлдөөн улам эрчимжиж, түүнд дэвшилтэд техник, технологийг өргөн хэрэглэж байна.

Цаашид манай улс батлан хамгаалах тогтолцооны чадавхыг тасралтгүй бэхжүүлж, 2024 онд 2.11 байгаа батлан хамгаалах чадавхын индексийг 2030 он гэхэд 2.09 түвшинд хүргэхийг зорьж байна. Үүний хүрээнд батлан хамгаалах салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, аж үйлдвэрлэлийг дотооддоо хөгжүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг дээшлүүлэх, төрлийн цэргийн бүтэц, тоог оновчтой нэмэгдүүлэх, мөн орон нутгийн хамгаалалт болон улсын дайчилгааны чадавхыг бэхжүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

3.6. БҮСИЙН ХӨГЖИЛ

Өргөн уудам газар нутагтай, цөөн хүн амтай, дэд бүтцийн хөгжил сул, хөрөнгө оруулалтын хэмжээ хязгаарлагдмал байдал нь нэг талаас хамгийн оновчтой байршилд хөрөнгө оруулалт хийж төвлөрлийг үүсгэх, нөгөө талаас газар нутгаа бүрэн эзэмшиж тархан амьдрах гэсэн сорилтыг бий болгож байна. Хүн амын өсөлт нь эдийн засгийн хэт төвлөрлөөс гадна хүний хөгжлийн ялгаатай байдал, дэд бүтцийн хоцрогдол, нийгмийн суурь үйлчилгээний хомсдолоос хамаарч байна. Түүнчлэн боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээ бүсүүдэд сул байгаа нь хүний хөгжлийн ялгаатай байдлыг өдөөж байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөний зохист байдал, бүс нутгийн нийгэм эдийн засгийн төрөлжсөн хөгжлийг орхигдуулж ирсний улмаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувьд хүн амын 49.6 хувь суурьшиж, Их, дээд сургуулийн 96.0 хувь, иргэдийн хадгаламжийн 82.0 хувь, автомашины 68.0 хувь, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 75.0 хувь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 70.6 хувийг үйлдвэрлэж байгаа нь бүс, орон нутгийн хөгжлийн зөрүү өндөр⁹⁸ байгааг харуулж байна. (Хүснэгт 72-д харуулав).

Хүснэгт 72. Улаанбаатар болон орон нутгийн хөгжлийн ялгаатай байдал /2023 он/

	Хүн ам	Хүн амын өсөлт	Ядуурал	Өрхийн орлого	Хуримтлал	ХХИ /оноо/	Худалдаа үйлчилгээ	Их, дээд сургууль
Нийслэл	49.6%	2.6%	21.6%	2.6 сая.төг	77.0%	0.83	84.0%	96.0%
Орон нутаг	50.4%	1.5%	30.0%	1.9 сая.төг	23.0%	0.76	16.0%	4.0%

Эх сурвалж: Бүсчилсэн хөгжил сэтгүүл

Дэлхийн улс орнууд бүсчилсэн хөгжлийн загварыг чухалчлах болсон бөгөөд газар нутаг, хүн амын байршил, баялгийн нөөцдөө үндэслэн бүсчилсэн байдлаар хөгжих нь хамгийн зөв бодлого гэж үзэх болсон. Монгол Улс 2001 онд “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, 2003 онд Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийг баталсан ч өнгөрсөн хугацаанд дорвитой өөрчлөлт гараагүй байгаа нь доорх эдийн засгийн хөгжил, амьжиргааны бодит үзүүлэлт харуулж байна. (Хүснэгт 73-т харуулав)

Хүснэгт 73. Эдийн засгийн хөгжил, амьжиргааны бодит үзүүлэлт

Аймаг	Хүн ам, 2024	Төсвийн гүйцэтгэл /2024 он/		Дотоодын нийт бүтээгдэхүүн				
		Орлого (тэр.төг)	Зарлага (тэр.төг)	ДНБ (тэр.төг)	1 хүнд ногдох ДНБ (мян.төг)	ХАА (%)	Үйлдвэрлэл (%)	Үйлчилгээ (%)
Архангай	91,559	80.9	73.2	754.6	8.1	48.8	13.3	37.9
Баянхонгор	88,029	100.6	92.0	757.6	8.6	43.8	10.4	45.8
Өвөрхангай	114,351	95.0	86.4	1,119.4	9.7	50.5	12.7	36.8
Хангайн бүс дүн	422,845	276.5	251.6	2,631.6	8.9	48.1	12.2	39.7
Баян-Өлгий	118,275	71.2	70.8	815.1	7.4	42.0	10.8	47.2
Говь-Алтай	56,523	79.2	76.2	562.7	9.9	46.8	11.8	41.5
Завхан	70,719	85.5	84.9	607.0	8.5	38.2	9.7	52.0

⁹⁸ “Бүсчилсэн хөгжил” сэтгүүл, 2024 он

Увс	84,911	81.1	74.5	684.4	8.0	39.5	10.1	50.4
Ховд	92,417	110.1	110.6	1,239.8	13.6	30.8	38.0	31.2
Баруун бүс дүн	308,658	427.1	416.9	3,908.9	9.4	38.1	19.3	42.6
Булган	60,332	91.7	86.4	601.4	10.0	52.1	13.1	34.8
Орхон	111,890	116.9	95.6	3,581.6	33.7	1.4	83.7	14.9
Хөвсгөл	136,436	311.4	316.7	1,110.1	8.0	44.7	15.3	40.0
Хойд бүс дүн	308,141	1,057.3	1,026.3	5,283.1	17.4	16.2	61.4	22.4
Дархан-Уул	110,544	99.0	81.5	1,128.9	10.8	7.7	39.4	52.9
Сэлэнгэ	106,042	119.4	109.7	1,550.5	14.7	29.6	41.8	28.5
Төв	91,555	140.8	125.4	1,145.2	12.5	51.6	19.2	29.2
Төвийн бүс дүн	308,141	359.1	316.7	3,824.5	12.6	29.7	34.3	35.9
Дорнод	84,604	97.3	92.0	1,009.0	11.9	37.2	28.5	34.3
Сүхбаатар	65,791	77.5	72.4	390.6	5.9	-0.7	47.2	53.5
Хэнтий	79,180	107.2	93.9	566.9	7.2	32.7	14.6	52.7
Зүүн бүс дүн	213,526	282.0	258.3	1,966.5	8.5	28.4	28.2	43.4
Говьсүмбэр	18,159	31.7	28.7	173.0	9.4	7.9	20.9	71.2
Дорноговь	72,097	158.5	153.4	751.7	10.4	5.6	17.2	77.2
Дундговь	45,900	95.3	63.5	471.7	10.2	48.3	12.0	39.7
Өмнөговь	77,370	1,879.3	1,904.4	4,664.9	59.2	3.4	67.5	29.2
Говийн бүс дүн	213,526	2,164.8	2,150.0	6,061.3	28.2	7.3	55.6	37.1
Орон нутаг	1,776,684	4,029.6	3,892.2	23,676.1	13.4	31.5	25.6	42.9
Улаанбаатар	1,768,151	3,103.6	3,361.9	56,987.0	34.0	0.2	40.3	59.5
Улсын дүн	3,544,835	7,133.3	7,254.1	80,663.0	23.6	30.1	26.3	43.7

Эх сурвалж: Бүсчилсэн хөгжлийн хүрээлэн

Улсын Их Хурлаас 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн 7 бүсчлэлийн тогтолцоонд хуваасан (Хүснэгт 74-т харуулав). Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар 7 бүсийг 21 орон нутгийн төв (Багануур, Багахангай, Налайх 3 дүүрэг, 21 аймгийн төв, 66 сумын төв, 1 тосгон) байхаар тогтож, эдгээрт таталцах сумдыг тогтоож өгсөн. Ингэснээр хөрөнгө оруулалтыг дэмжих, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжсэнээр хүн амын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хүснэгт 74. Бүсчлэлийн тогтолцоо

Бүс	Нутаг дэвсгэр	Эзлэх хувь	Хүн ам, 2024	Эзлэх хувь	Сум, дүүрэг	Эзлэх хувь	Орон нутгийн хөгжлийн төв
Хангайн	234,186.9	15.0	296,983	8.6	58	17.1	14
Баруун	415,253.8	26.5	415,576	12.1	91	26.8	28
Хойд	150,250.8	9.6	303,534	8.8	41	12.1	11
Төв	118,470.0	7.6	302,355	8.8	48	14.2	10
Зүүн	286,209.7	18.3	230,012	6.7	45	13.3	13
Говийн	355,085.0	22.7	215,266	6.3	47	13.9	12
Улаанбаатар	4,704.4	0.3	1,677,872	48.8	9		3

Эх сурвалж: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

Шинэчлэн баталсан 2024 оны “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-аар бүс тус бүрийн онцлог, давуу талд тулгуурлан хөгжүүлэх зорилго тавьсан. Үүнд:

1. Хангайн бүсийг дэлхий дахинд Монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгуурлан “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд хот байгуулалтын дэд бүс”
2. Баруун бүсийг Төв Азийн орнууд болон ОХУ, БНХАУ-ын зах зээлтэй холбогдож, Дэлхийн өв Увс нуурын ай сав, Монгол Алтайн нуруу – Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өв, эрчим хүчний нөөцөд түшиглэн “Эрчим хүчний төрөлжсөн бүс бөгөөд байгалийн аялал жуулчлалын дэд бүс”
3. Хойд бүсийг ОХУ болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх,

соёлын өвд тулгуурлан “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс”

4. Төвийн бүсийг ОУ-ын эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логикийн нэгдсэн сүлжээнд холбогдон хөдөө аж ахуй болон байгалийн нөөцөд тулгуурлан “Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс”
5. Зүүн бүсийг Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэн “Түүхийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс”
6. Говийн бүсийг БНХАУ болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн “Аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс”
7. Улаанбаатарын бүсийг Төв болон Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчны зохистой бүтэцтэй, 20 минутын үйлчилгээний хүртээмжтэй төвүүд бүхий хот болж “Олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв” болгоно тодорхойлсон.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зарчимд тулгуурлан бүс орон нутгийн хөгжлийн ялгаатай байдлыг бууруулах нь нэн чухал юм. Үүний тулд бүс, орон нутгийн хүний хөгжлийн ялгаатай байдлыг бууруулах, орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн индекс нь аймаг, сумын хөгжлийн түвшин, ялгаатай байдлыг тоон болон чанарын үзүүлэлтээр илэрхийлж, нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох, хөгжлийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэдэг. Энэхүү индекс нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, байгаль орчин болон засаглалын үзүүлэлтийг харьцуулан үнэлж, хөгжлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлох суурь үзүүлэлт болдог.

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 20 дугаар тогтоолоор “Орон нутгийн индекс тооцох аргачлал”-ыг баталсан. Энэ хүрээнд “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ нь 2016 оноос орон нутгийн хөгжлийн индексийг тооцон гаргаж байна. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах хүрээнд орон нутгийн хөгжлийн индексийг 2020-2024 оноор үзүүлэв. (Хүснэгт 75-д харуулав).

Хүснэгт 75. Орон нутгийн хөгжлийн индекс /оноогоор/

дд	Аймаг	2020	2021	2022	2023	2024
Хангайн бүс						
1	Архангай	0.530	0.513	0.509	0.442	0.457
2	Баянхонгор	0.496	0.462	0.513	0.474	0.494
3	Өвөрхангай	0.479	0.496	0.461	0.509	0.534
Баруун бүс						
4	Баян-Өлгий	0.487	0.459	0.473	0.545	0.560
5	Говь-Алтай	0.488	0.455	0.451	0.462	0.497
6	Завхан	0.472	0.450	0.433	0.503	0.523
7	Увс	0.505	0.477	0.486	0.500	0.521
8	Ховд	0.452	0.440	0.471	0.479	0.498
Хойд бүс						
9	Булган	0.517	0.506	0.480	0.510	0.533
10	Орхон	0.539	0.521	0.604	0.532	0.595
11	Хөвсгөл	0.456	0.424	0.529	0.455	0.481
Төвийн бүс						
12	Дархан-Уул	0.575	0.537	0.478	0.479	0.473
13	Сэлэнгэ	0.518	0.411	0.479	0.479	0.499
14	Төв	0.493	0.460	0.451	0.489	0.506
Зүүн бүс						
15	Дорнод	0.451	0.421	0.476	0.509	0.525
16	Сүхбаатар	0.526	0.472	0.465	0.495	0.511

17	Хэнтий	0.462	0.479	0.499	0.455	0.465
Говийн бүс						
18	Говьсүмбэр	0.488	0.530	0.515	0.444	0.456
19	Дорноговь	0.519	0.492	0.497	0.504	0.505
20	Дундговь	0.486	0.442	0.476	0.426	0.439
21	Өмнөговь	0.660	0.639	0.469	0.536	0.562

Эх сурвалж: Бүсчилсэн хөгжлийн хүрээлэн

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд орон нутгийн индекс 0.45 - 0.55 нэгжээр хэлбэлзэж байгаа нь орон нутгийн хүний хөгжлийн түвшин дунд шатанд байгааг харуулж байна. Ковид - 19 цар тахлын улмаас 2021 онд ихэнх аймгууд буурсан үзүүлэлттэй байгаа нь эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөөтэй холбон тайлбарлаж болно. Харин сүүлийн 2 жилийн хугацаанд аажмаар өсөлттэй буюу эерэг өөрчлөлт ажиглагдаж байна. Өмнөговь, Орхон, Баян-Өлгий аймгууд өсөлттэй байгаа бол Дундговь, Говьсүмбэр, Архангай аймгууд доогуур үзүүлэлттэй байна.

Орон нутгийн хөгжлийн индексийг 2020-2024 оноор авч үзвэл Монгол Улсын аймгуудын хоорондын хөгжлийн тэгш бус байдал хэвээр байгаа боловч 2023-2024 онд сэргэлтийн шинжтэй өсөлт ажиглагдаж, орон нутгийн эдийн засгийн идэвхжил сэргэж байна. Хөгжлийн ялгаа өндөр байгаа нь аймгуудын дэд бүтэц, ажлын байр, хөрөнгө оруулалтын чиглэлд анхаарах шаардлагатай байна. Харин өндөр үзүүлэлттэй аймгуудын жишээг бусад бүс нутагт туршлага болгон түгээн, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсад ган, зуд тохиолдсон жилүүдэд хүн амын шилжилт хөдөлгөөн эрчимждэг бөгөөд үүнийг дагаж нийслэл Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо тасралтгүй нэмэгдэх хандлагатай байдаг. Үндэсний Статистикийн хорооны тайлангаас харвал 2000 оноос хойш Улаанбаатар хотод 665 мянган хүн орон нутгаас шилжиж ирсэн. Жилд дунджаар 27.7 мянган хүн шилжиж ирдэг бол 2020 оноос хойш огцом нэмэгдэж жилд ирэх хүний тоо 40.0 мянгад хүрээд байна. 2024 оны байдлаар нийт хүн амын 51.2 хувь буюу 1,763,726 хүн нийслэл Улаанбаатар хотод, үлдсэн 48.8 хувь нь орон нутагт суурьшиж байна. (Хүснэгт 76-д харуулав)

Хүснэгт 76. Хот, хөдөөгийн хүн амын эзлэх хувь

Хүн ам	2020	2021	2022	2023	2024
Орон нутаг	53.9	53.5	52.6	51.7	51.2
Улаанбаатар	46.1	46.5	47.4	48.3	48.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Орон нутгийн түвшинд хөдөөгийн 309 (аймгийн төвийн 21 сумыг хасаад) суманд Засаг даргын тамгын газар, сургууль, эмнэлэг гэсэн төрийн байгууллагад ажилладаг иргэдээс өөр тогтмол орлоготой иргэн бага байдаг. Тийм ч учраас хөдөөгийн суманд төв, суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн байсаар байна. Учир нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх зах зээлийн багтаамж багатай байдаг. Хөдөөгийн сумын хүн амын тоон өөрчлөлтийг 2020-2024 оны байдлаар хүснэгт 77-д харуулав.

Хүснэгт 77. Хүн амын тоон ангилал (хөдөөгийн 309 сумаар)

Тоон ангилал	2020	2021	2022	2023	2024
10,001-ээс дээш	3	4	5	5	5
5,001-1,0000 хүн	42	43	42	38	37
3,001-5,000 хүн	102	101	99	97	99
1,501-3,000 хүн	148	148	147	151	146
1,500 хүртэл хүн	14	13	16	18	22

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөөгийн сумдын хүн амын байршлыг харвал 2024 оны байдлаар 54.4 хувь буюу 168 сумын хүн ам 3,000-аас цөөн хүн амтай байна. Эдгээр 168 сумаас 22 сум нь 1,500 хүрэхгүй хүн амтай байна. Хөдөөгийн суманд 1,500 хүрэхгүй хүнтэй сумын тоо

сүүлийн жилүүдэд өсөх хандлага ажиглагдаж байна. Завхан аймгийн 6 (Асгат, Завханмандал, Цагаанчулуут, Ургамал, Цагаанхайрхан, Цэцэн-Уул), Дундговь аймгийн 5 (Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Говь-Угтаал, Дэлгэрцогт), Дорноговь аймгийн 3 (Сайхандулаан, Улаанбадрах, Алтанширээ), Өмнөговь аймгийн 3 (Ноён, Хүрмэн, Мандал-Овоо), Төв аймгийн 2 (Архуст, Баянхангай), Увс (Давст), Дорнод (Гурванзагал), Говьсүмбэр (Баянтал) аймгуудын тус бүр 1 сумын хүн ам 1,500-аас цөөн байна. Харин хүн амын тоо нь 10,001-ээс дээш хүнтэй Сэлэнгэ аймгийн Мандал (Зүүнхараа), Дорноговь аймгийн Замын-Үүд, Өвөрхангай аймгийн Хархорин, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ховд аймгийн Булган сумд байна.

Шинэ Сэргэлтийн бодлогын хүрээнд аймгуудыг хүн амаа нэмэгдүүлэх чиглэл авсан. Тухайлбал, Орхон, Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул, Дорнод аймгууд, Багануур, Багахангай, Налайх дүүргүүд хүн амаа 20 хувиар нэмэгдүүлэх, бусад аймгууд 10 хувиар нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд орон нутгийн хүн амын эзлэх хувь буурах хандлагатай байгаа ба ирэх 2030 онд 52.5 хувьд хүргэх зорилт тавьж байна.

3.6.1. Орон нутгийн засаглал

Орон нутгийн засаглал гэдэг нь тухайн нутаг дэвсгэрийн түвшинд төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, нутгийн хөгжлийг төлөвлөж, зохион байгуулах зорилгоор ажилладаг орон нутгийн засаг захиргаа, иргэдийн төлөөллийн байгууллагуудын үйл ажиллагааны цогц систем⁹⁹ юм. Энэ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын уялдаа холбоонд тулгуурладаг бөгөөд тухайн орон нутгийн онцлог, нөөц бололцоонд нийцүүлэн бодлого, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх чадамжийг илэрхийлнэ.

Орон нутгийн засаглалыг бэхжүүлэхийн тулд эрх мэдэл, үүрэг хариуцлагын тэнцвэрийг хангаж, төвлөрлийг сааруулах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал юм. Үүнд орон нутгийн байгууллагын санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн татварын орлого, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өргөжүүлэх, иргэдийн оролцоо, хяналтын тогтолцоог сайжруулах, шийдвэр гаргах үйл явцад ил тод, нээлттэй байдлыг хангах шаардлагатай. Мөн нутгийн удирдлагын хүний нөөцийг чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албаны мэргэшил, ёс зүйг бэхжүүлэх нь засаглалын чанарт шууд нөлөөлдөг.

Түүнчлэн орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг үндэсний хөгжлийн зорилттой уялдуулах, төр-хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх замаар мэдээллийн нээлттэй, ил тод байдал, шийдвэр гаргалтын хурд, үр ашигт байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Орон нутгийн засаглалыг бэхжүүлснээр тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжил хангагдаж, төрийн үйлчилгээ дэх сэтгэл ханамж, итгэлцэл дээшлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журмыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан байдаг. Тус үнэлгээний журмаар аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:


- ✓ Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ;
- ✓ Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ;
- ✓ Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ;

⁹⁹ Н.Бурмаа. (2021). "Орон нутгийн хөгжил, засаглал, төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх", 205-р тал

- ✓ Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээг 2023 оноос хийж эхэлсэн бөгөөд 2024 оны байдлаар дундаж үнэлгээ 74.45 байна. Аймгуудаас Орхон, Төв, Хэнтий, Хөвсгөл, Булган аймаг улсын дунджаас өндөр байгаа бол 16 аймаг, нийслэл Улаанбаатар хот улсын дунджаас доогуур үнэлэгдсэн. Ялангуяа Дорнод, Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд аймгийн хамгийн бага үнэлгээг авчээ.

График 41. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дүн



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын судалгаа, 2024 он

Орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дундаж үнэлгээ 74.45 байгаа нь орон нутгийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх чиглэлд анхаарах хэрэгтэйг харуулж байна. Аймгуудын дийлэнх нь улсын дунджаас доогуур түвшинд байгаа нь орон нутгийн засаглалд нийтлэг тулгамдаж буй асуудал гэдгийг илтгэж байна.

Орон нутгийн засаглалыг бэхжүүлэхгүй байх нь бүс, орон нутгийн хүний хөгжлийн зөрүүтэй байдлыг улам гүнзгийрүүлэх хандлагатай байна. Өнгөрсөн 2020-2024 оны таван жилийн хугацаанд орон нутгийн хүний хөгжлийн индексийн зөрүү тогтвортой хадгалагдаж, орон нутгийн хөгжлийн тэгш бус байдал буурахгүй, тогтмол зөрүүтэй байна. Улаанбаатарын бүс тогтмол өндөр буюу 0.820-0.80-ийн хооронд хэлбэлзэж, улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй явж иржээ. Эсрэгээрээ Хангайн бүс хамгийн бага буюу 0.67-0.69-ийн хооронд тогтвортой байснаар 2024 онд Улаанбаатарын бүс болон Хангайн бүсийн хооронд 0.11 нэгжийн зөрүү үүссэн нь бүс хоорондын хөгжлийн ялгааг тод харуулж байна.

Баруун болон Зүүн бүсийн хувьд өсөлт удаан, 0.68-0.71-ийн хооронд бага зэрэг нэмэгдсэн боловч нийт улсын дундажтай харьцуулахад хоцрогдсон хэвээр байна. Энэ нь эдийн засгийн идэвх сул, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байгаатай шууд холбоотой юм. Харин Говийн болон Төвийн бүсийн үзүүлэлт харьцангуй тогтвортой өсөлттэй буюу 0.73-0.74 хүртэл өссөн нь уул уурхайн салбар, тээвэр логистикийн хөгжилтэй холбоотой зэрэг өөрчлөлт байна.

Хойд бүсийн үзүүлэлт 0.70-0.73 болж тогтвортой өссөн боловч өсөлтийн хурд харьцангуй бага байгаа нь орон нутгийн нөөц, дэд бүтэц, ажил эрхлэлтийн нөхцөл сул байгааг илтгэж байна. Нийт дүнгээр нь авч үзвэл 2020-2024 онд хүний хөгжлийн индексийн тархалтын хурд бага, бүс хоорондын зөрүү өөрчлөлт багатай бөгөөд эдийн засгийн идэвхтэй бүсүүдийн давамгайл байдал хэвээр хадгалагдсан байна. (Хүснэгт 78-д харуулав.)

Хүснэгт 78. Хүний хөгжлийн зөрүүтэй байдал /бүсээр/

Бүс	2020	2021	2022	2023	2024
Улаанбаатар	0.82	0.82	0.82	0.80	0.80
Говийн	0.71	0.71	0.72	0.75	0.75
Хойд	0.70	0.71	0.71	0.73	0.73

Төвийн	0.70	0.71	0.70	0.72	0.73
Баруун	0.68	0.68	0.68	0.70	0.71
Зүүн	0.69	0.70	0.70	0.71	0.70
Хангайн	0.67	0.66	0.67	0.69	0.69
Зөрүү	0.15	0.16	0.15	0.11	0.11

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Орон нутгийн засаглал сул байгаа нь бүс нутгийн хөгжлийн ялгааг багасгах бодит боломжийг үгүй хийж байна. Ирэх 2026-2030 онд Улаанбаатарын бүсийн давамгайлал үргэлжилж, бусад бүсийн хүний хөгжлийн түвшний өсөлт удаашрах эрсдэлтэй байгааг дээрх хүний хөгжлийн индексийн зөрүүтэй байдлын тархалтаас тодорхой харагдаж байна.

Өрсөлдөх чадвар, тэгш боломж: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс аймгуудын өрсөлдөх чадварын тайланг 2012 оноос жил бүр гаргаж байна. Ингэхдээ эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн дөрвөн бүлгийн хүрээнд нийт 181 шалгуур үзүүлэлтээр үнэлж тооцож¹⁰⁰ байна. Аймгуудын 2023 оны өрсөлдөх чадварын онооны дундаж 66.6 болж өмнөх оноос 1.6 оноогоор өссөн байна. Орхон, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь, Говьсүмбэр зэрэг аж үйлдвэр, уул уурхай, тээвэр логистикийн чиглэлээр идэвхтэй аймгууд өндөр оноотой бол Говь-Алтай, Завхан, Дундговь, Булган, Архангай аймгууд хамгийн муу үзүүлэлттэй байгаа нь хөгжлийн бодлого, орон нутгийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх стратегийн үр нөлөө сул байгааг илтгэж байна. (Хүснэгт 79-д харуулав)

Хүснэгт 79. Аймгуудын өрсөлдөх чадварын индекс. 2023 он

Аймаг	Ерөнхий үнэлгээ	Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн үр ашиг	Дэд бүтэц
Орхон	100.00	95.04	100.00	99.25	100.00
Дорноговь	97.96	100.00	99.24	89.20	98.14
Дархан-Уул	95.12	92.23	93.68	100.00	89.01
Өмнөговь	81.88	99.68	75.74	75.59	71.01
Говьсүмбэр	81.73	52.66	93.90	80.42	97.26
Дорнод	79.36	86.81	98.60	75.22	57.33
Сэлэнгэ	78.62	74.97	80.44	99.10	56.57
Хэнтий	78.24	65.14	94.22	78.70	74.01
Өвөрхангай	77.25	61.32	74.49	85.23	82.65
Увс	66.67	55.50	64.55	95.69	47.22
Сүхбаатар	64.10	63.78	80.83	57.62	54.54
Төв	63.78	81.45	76.62	67.97	29.53
Баян-Өлгий	63.50	36.01	63.97	76.79	73.17
Ховд	62.15	48.87	50.55	75.12	67.66
Хөвсгөл	57.33	35.51	36.45	85.60	63.49
Баянхонгор	55.52	39.20	77.37	66.34	41.16
Архангай	48.89	64.17	56.45	45.55	29.06
Булган	40.08	50.17	54.42	21.65	35.24
Говь-Алтай	36.72	41.84	56.07	23.43	28.06
Завхан	35.69	33.67	31.00	45.61	29.58
Дундговь	34.93	33.92	31.73	34.06	37.25

Эх сурвалж: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан, 2023

Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээг бүсээр авч үзвэл Хангайн бүсээс Архангай, Баруун бүсээс Говь-Алтай, Завхан аймгууд, Хойд бүсээс Булган, Говийн бүсээс Дундговь аймаг хамгийн доогуур үнэлгээтэй байна. Ерөнхий үнэлгээг гаргаж буй үндсэн 4 бүлгээр авч үзвэл эдийн засгийн тамир тэнхээгээр Говийн бүсийн Дорноговь, Өмнөговь, Хойд бүсийн Орхон, Төвийн бүсийн Дархан-Уул, Зүүн бүсийн Дорнод аймгууд тэргүүлж байгаа бол Баруун бүсийн Баян-Өлгий, Завхан, Хангайн бүсийн Баянхонгор, Хойд бүсийн Хөвсгөл, Говийн бүсийн Дундговь аймгууд хамгийн

¹⁰⁰ Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв. 2023 он. 21-р тал

доогуур үнэлгээтэй байна. Засаглалын үр ашгаар Говийн бүсийн Дорноговь, Говьсүмбэр, Зүүн бүсийн Дорнод, Хэнтий, Хойд бүсийн Орхон аймгууд дээгүүр, Баруун бүсийн Ховд, Завхан, Хойд бүсийн Хөвсгөл, Булган, Говийн бүсийн Дундговь аймгууд хамгийн доогуур байна. Бизнесийн үр ашгийн хувьд Хойд бүсийн Орхон, Төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Говийн бүсийн Дорноговь, Баруун бүсийн Увс аймгууд тэргүүлж, Баруун бүсийн Завхан, Говь-Алтай, Говийн бүсийн Дундговь, Хойд бүсийн Булган, Хангайн бүсийн Архангай аймгууд хамгийн муу байна. Дэд бүтцээр Говийн бүсийн Дорноговь, Говьсүмбэр, Хойд бүсийн Орхон, Төвийн бүсийн Дархан-Уул, Хангайн бүсийн Өвөрхангай аймгууд хамгийн өндөр үнэлгээтэй бол Баруун бүсийн Завхан, Говь-Алтай, Төвийн бүсийн Төв, Хангайн бүсийн Архангай, Хойд бүсийн Булган аймгууд хамгийн муу байна.

Аймгуудын өрсөлдөх чадвар хол зөрүүтэй байгаа нь эдийн засгийн төвлөрөл, дэд бүтцийн хүртээмж, бизнесийн орчны ялгаатай байдал болон төрийн үйлчилгээний үр ашиг зэрэгт тэнцвэргүй байдал гүнзгийрэх хандлагатай байна. Тухайлбал, өндөр үнэлгээтэй аймгууд нь хөрөнгө оруулалт татах чадвартай, үйлдвэрлэлийн тогтвортой бүтэцтэй байгаа бол үнэлгээ доогуур байгаа аймгууд ажил эрхлэлт, өрхийн орлого, дэд бүтцийн хүртээмжгүй байдал, хүний нөөцийн чадавх сул байгаа зэрэг нь өрсөлдөх чадварыг хязгаарлаж байна.

Иймд аймгуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд орон нутгийн засаглалыг сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хэлбэрээр дэмжих, бизнесийн орчныг сайжруулах чиглэлд бодлогын уялдаа холбоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хэрэв эдгээр асуудлыг шийдвэрлэхгүй бол ирэх жилүүдэд аймгуудын өрсөлдөх чадварын зөрүү гүнзгийрч, бүс нутгийн хөгжлийн тэгш бус байдал улам нэмэгдэх эрсдэлтэй байна.

Бүс, орон нутгийн төрийн үйлчилгээний ялгаатай байдал: Ардчилсан засаглал судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж байгаа бөгөөд Үндэсний статистикийн хорооноос “Ардчилсан засаглал судалгаа”¹⁰¹-ны 2021-2024 оны үр дүнгийн тайлан гарсан. Уг судалгааг Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 13 дугаар тогтоолд Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан мэдээллийн санг улсын хэмжээнд бий болгохыг Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл болон Хүний эрхийн үндэсний комисст үүрэг болгосон байдаг.

Мянганы хөгжлийн зорилтын 9 дүгээр зорилгын 3 шалгуур үзүүлэлт нь олон нийтийн үнэлгээний үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлтүүдийг олон улсын туршлага, санаачилгыг харгалзан Үндэсний статистикийн хорооноос тогтмол зохион байгуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” /ӨНЭЗС/-ны хавсралт судалгаагаар цуглуулахаар Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 7 дугаар сарын А/228 тоот тушаалын зургаадугаар хавсралтаар батлуулж мэдээлэл цуглуулалтад ашиглаж байна.

Тус судалгааны зорилго нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүд, Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн “Чанартай боловсролыг дэмжих” 4 дүгээр зорилго, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” 5 дугаар зорилго, “Энх тайван, шударга ёсыг цогцлоох” 16 дугаар зорилго, “Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх” 17 дугаар зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх зарим шалгуур үзүүлэлтүүдийг улс, бүс нутгийн түвшинд тодорхойлоход чиглэгдэж байна.

Судалгааны тайлангийн 2.2-т Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээг 2021-2024 оноор гаргасан байна. Төрийн

¹⁰¹ УСХ. “Ардчилсан засаглал судалгаа”. 2025 он

захиргааны дээд байгууллагууд, түүний дотор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн өгсөн хариулт нь төр, засагтаа хэр зэрэг итгэл хүлээлгэж буйг илэрхийлэх үзүүлэлт юм. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтийн хүрээнд хийгдсэн судалгаанд үндэслэн аймаг, нийслэлийн ИТХ болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл хангалуун байдлын үнэлгээг хүснэгт 80-д харуулав.

Хүснэгт 80. Иргэдийн сэтгэл хангалуун байдлын судалгаа

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Төрийн албаар үйлчлүүлсэн иргэдээс сүүлийн үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа иргэдийн эзлэх хувь /нийслэл, аймгийн ИТХ/	18.1	20.6	15.8	8.9	12.5
Төрийн албаар үйлчлүүлсэн иргэдээс сүүлийн үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа иргэдийн эзлэх хувь /нийслэл, аймгийн ЗДТГ/	25.2	24.7	21.7	13.9	19.2

Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн зорилгын судалгаа

Судалгаанаас үзвэл иргэдийн сэтгэл хангалуун байдлын үнэлгээний хувь буурч байгаа нь орон нутагт төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, хариуцлагын түвшин дутагдалтай байгааг харуулж байна. Орон нутагт төрийн байгууллагуудын иргэн төвтэй үйл ажиллагаа сул, үйлчилгээний ил тод байдал, шуурхай хариу арга хэмжээ авах чадвар хангалтгүй байгааг илтгэж байна. Аймаг, нийслэлийн ИТХ-д иргэдийн оролцоо, санал бодлыг шийдвэр гаргалтад тусгах байдал хангалтгүй, олон нийттэй харилцах сувгийн хүртээмж бага байгаа нь сэтгэл ханамжийн түвшин буурахад нөлөөлнө. Мөн аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн ч үйлчилгээний чанар, хүнд суртал, мэдээллийн хүртээмжийн асуудал байгаа нь иргэдийн итгэлийг сулруулах хүчин зүйл болно.

Орон нутагт төрийн үйлчилгээнээс гадна нийгмийн дэд бүтцийн хүртээмж, чанарын асуудал иргэдийн сэтгэл ханамжгүй байдалд шууд нөлөөлж байна. Тухайлбал, сумын иргэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авах боломж бага байдгаас хот, суурин газар руу явж төрөлжсөн мэргэжлийн эмнэлгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээ авдаг. Орон нутгийн түвшинд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Ховд аймгуудад байгаа бол бусад 16 аймгийн төвд аймгийн нэгдсэн эмнэлэг үйлчилгээ үзүүлж байна. Хөдөөгийн 309 сумын түвшинд 2024 оны байдлаар 321 эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байна. (Хүснэгт 81-д харуулав.)

Хүснэгт 81. Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд

Аймаг	БОЭТ	АНЭ	ХНЭ	Сумын ЭМТ	Тосгоны ЭМТ	Нийт
Архангай		1		18		19
Баян-Өлгий		1		12	1	14
Баянхонгор		1		19	1	21
Булган		1		15	1	17
Говь-Алтай		1		17	2	20
Говьсүмбэр		1		2		3
Дархан-Уул		1		3		4
Дорноговь		1	1	12	1	15
Дорнод	1			13		14
Дундговь		1		14		15
Завхан		1	1	22		24
Орхон	1			1		2
Өвөрхангай	1		1	17		19
Өмнөговь	1			14		15
Сүхбаатар		1		12		13
Сэлэнгэ		1	1	15	6	23
Төв		1		26		27
Увс		1		18		19
Ховд	1		1	15		17
Хөвсгөл		1		22	1	24
Хэнтий		1	1	16	5	23

Нийт	5	16	6	303	18	348
------	---	----	---	-----	----	-----

Эх сурвалж: ЭМСайдын 2019 оны А/540 тушаал

Хөдөөгийн сумдаас Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Мандал, Завхан аймгийн Тосонцэнгэл, Өвөрхангай аймгийн Хархорин, Ховд аймгийн Булган, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумдад хөдөөгийн нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бол Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Цагааннуур тосгон, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Шаргалжуут тосгон, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон, Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгон, Дэлгэр сумын Гуулин тосгон, Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тосгон, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон, Хэрх тосгон, Ерөө сумын Бугант тосгон, Шаамар сумын Дулаанхаан тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгон, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян /Хурх/ тосгон, Батноров сумын Бэрх тосгон, Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан тосгон, Хэрлэн /Өндөрхаан/ сумын Өлзийт тосгон, Тахилгат тосгонуудад эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хувьд хөдөөгийн 309 сумын түвшинд хамран сургалтын хувь болон сурагчийн тоо бага байна. Ялангуяа хөдөөгийн сумдаас 38 сумын сургуулийн хамран сургалт 50.0 хувиас бага, сургуулийн сурагчийн тоо 360-аас бага 125 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Хөдөөгийн суманд сургуулийн чанар, боловсон хүчний тогтвортой байдал тулгамдаж буй асуудал болоод байна. Эдгээр 125 сумын сургуулиас Завхан аймгийн Алдархаан, Яруу, Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд 100 хүрэхгүй суралцагч байна. Мөн хөдөөгийн алслагдсан багийн төвд 63 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа ч сурагчийн тоо нь 10 хүрэхгүй, бүлэг дүүргэлт хангалтгүй байна.

Мөн хөдөө, орон нутагт гамшиг, ослын үед ажиллагаа явуулах гал унтраах, аврах ангийн хүрэлцээ хангалтгүй байна. Аймгийн төвийн бус хөдөөгийн 309 сумаас 25 суманд гал унтраах, аврах анги, 11 суманд эрэн хайх бүлэг үйл ажиллагаа явуулж байна. Хөдөөгийн 309 сумын түвшинд 11.7 хувьд нь гамшиг, ослын үед үйлчилгээ үзүүлэх байгууллага ажиллаж байна.

Энэ бүгдээс үзвэл хөдөө орон нутагт нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх болон иргэдийн гамшиг ослын үед тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын чанар, хүртээмж хангалтгүй байна. Мөн сумын түвшинд боловсон хүчний тогтвортой байдал хангалтгүй байгаа нь орон нутгийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйл болно.

Иймд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нэмэгдүүлэхийн тулд иргэн төвтэй үйлчилгээний стандарт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, мөн тогтвор суурьшилтай ажиллах чиглэлд бодлогын түвшний цогц арга хэмжээ авах шаардлагатай байна.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бүс, орон нутгийн хүний хөгжлийн зөрүүтэй байдлыг бууруулах чиглэлд нутгийн удирдлагын өөрийн санаачилгыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвар, тэгш боломжийг нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний ялгаатай байдлыг бууруулах хүрээнд нутгийн захиргааны байгууллагын өөрийн санаачлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бүсийн түвшинд хүний хөгжлийн зөрүүтэй байдал 2024 оны байдлаар 0.110 байгааг 0.071 болгон бууруулахаар зорьсон. Энэ хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг 2023 онд 66.6 оноотой байсныг 69.3-д хүргэх, иргэдийн нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авсан сэтгэл ханамжийн түвшинд аймаг, нийслэлийн ИТХ-д 2024 онд 12.5 хувь байсныг 50.0-д хүргэх, аймгийн, нийслэлийн ЗДТГ-д өгөх үнэлгээг 2024 онд 19.2 хувь байсныг 50.0-д хүргэж нэмэгдүүлэх зорилтыг тавиад байна.

Дээрх бодлогын үр дүнд бүс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн иргэдэд чиглэсэн хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлт тэлж, орон нутгийн засаг захиргаа, иргэдийн хамтын ажиллагаа сайжрах замаар хүн амын нийгмийн идэвх, амьдралын чанар өсөх, бүс, орон нутгийн өрсөлдөх чадвар нэмэгдэх боломж бүрдэнэ. Мөн хүний хөгжлийн индексийн зөрүүтэй байдал багассанаар бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдал сайжирч, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хүртээмж бүс нутгийн хэмжээнд хүрэлцээтэй болж, иргэдийн амьдралын чанар болон нийгмийн дэмжлэгийн тогтолцоо нэмэгдэнэ.

Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдал: Монгол Улсын 21 аймгаас Өмнөговь, Орхон, Дорноговь, Дархан-Уул, Дорнод аймгууд сүүлийн 5 жил тогтмол улсын төсөвт орлого төвлөрүүлж байгаа бол 2022 оноос Сэлэнгэ аймаг нэмэгдсэнээр 6 аймаг болоод байна. (Хүснэгт 82-т харуулав.) Бусад аймгууд нь улсын төсвөөс татаас авч байна. Цаашид аймаг бүр орлогоо бие даан бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг үе шаттай дэмжих шаардлагатай байна.

Хүснэгт 82. Улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгууд /сая төгрөг/

дд	Аймаг	2020	2021	2022	2023	2024
1	Өмнөговь	51,434.7	78,349.7	264,709.6	456,418.8	1,419,975.6
2	Орхон	29,220.1	24,601.6	91,010.6	164,107.3	137,661.3
3	Дорноговь	1,079.0	2,211.7	4,617.3	16,015.4	11,773.8
4	Дархан-Уул	199.7	1,232.6	5,798.6	3,050.8	2,619.1
5	Сэлэнгэ	1,824.1	1,646.5	1,777.6	892.6	1,355.1

Эх сурвалж: Төсвийн тухай 2020-2024 оны хууль

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөлт уул уурхайн салбарт шинэ зохицуулалт авчирсан. Тус хуулийг дагаж Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын 40.0 хувийг аймаг, нийслэлд үлдээхээр болсон⁸. Мөн Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн эх үүсвэр, зарцуулалтын хуваарилалтад өөрчлөлт орсон. Сангийн эх үүсвэрийг тэгшитгэн хуваарилдаг байсныг өөрчилж уул уурхайн орлогоос илүү ихийг сумд, орон нутгийн иргэд хүртэх болж байна. Энэ нь төсвийг төвлөрсөн биш тараан байршуулж, орон нутагт илүү эрх мэдлийг олгож байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, төсвийг захиран зарцуулах эрх нь орон нутагт шилжиж байгаа хэрэг юм. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдээ дэмжих, хөрөнгө оруулалт татах, хамтран ажиллах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар ажиллах боломж нээлттэй болж байна. (Хүснэгт 83-т харуулав.)

Хүснэгт 83. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж

Бүс	2020	2021	2022	2023	2024
Хангайн	3,041	2,895	3,139	3,359	4,007
Баруун	6,231	6,042	6,311	6,841	8,431
Хойд	4,287	4,263	4,715	5,174	5,638
Төвийн	4,869	4,695	5,007	5,409	5,982
Зүүн	2,874	2,951	3,283	3,523	4,045
Говийн	3,436	3,630	4,136	4,623	5,121

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгжүүд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд татвар төлөгчөөр тухайн орон нутагт бүртгэх зарчмыг баримтлан холбогдох журмыг шинэчлэн боловсруулж, өөрчлөлт оруулсан. Энэ хүрээнд аймаг, нийслэлийн захиргааны байгууллагуудаас олгож буй бүх төрлийн тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нэгдсэн байдлаар нэгтгэн авч, татвар төлөгчийн бүртгэлийг холбогдох орон нутагт шилжүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг тухайн орон нутгийн үндсэн татвар төлөгчөөр бүртгэх шаардлагыг аймгийн татварын алба тавьж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Харин уул уурхайн

салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд лицензийн байршлаар татварын орлогын 40 хувийг хуваарилан тооцох зохицуулалт хийгдсэн.

Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.1 дэх заалтад “аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол оршдог аймаг, хот, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь тухайн орон нутагт бүртгэлтэй, орон нутгийн татварын албатай харьцдаг, нийгмийн даатгалын төлөлтөөр баталгаажсан ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийн тухайн нутаг дэвсгэр дээрх үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох татварыг 500 км-ээс хол аймагт 50 хувиар, 1,000 км-ээс хол аймагт 90 хувиар хөнгөлнө” гэж заасан байдаг. Ийнхүү хууль эрх зүйн орчин бүрдсэнээр татвар төлөгч аж ахуйн нэгжүүд татварын дэмжлэгт хамрагдах бүрэн боломжтой болсон.

Үүнтэй уялдан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн төсвийн орлогыг өөрсдөө бүрдүүлэх боломж нэмэгдэж, төсвийн бүтцэд орон нутгийн оролцоо нэмэгдэж, аймгуудын санхүүгийн бие даасан байдлыг хангах чиглэлд тодорхой ахиц гарч байна. 2020-2024 оны хооронд Өмнөговь, Орхон, Дорноговь, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ аймгууд тогтмол улсын төсөвт орлого төвлөрүүлж, эдгээр аймаг орон нутгийн эдийн засгийн өсөлт, уул уурхайн ашиглалт, аж үйлдвэрийн бүтээмжийн үр дүнд төсвийн орлогын гол эх үүсвэр болж байна. 2025 оны төсвийн тухай хуулиар Төв, Булган, Дундговь аймгууд нэмэгдсэнээр улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн тоо ес болон өргөжив. Энэ нь орон нутгийн эдийн засгийн чадавх, татварын орлогын бүтэц аажмаар тэлж, төвлөрсөн төсвийн хамаарал буурах хандлагатай болсныг илтгэж байна.

Гэсэн хэдий ч улсын төсвөөс татаас авдаг бусад аймгуудын тоо өндөр хэвээр байгаа нь эдийн засгийн төвлөрсөн бүтэц бүрэн өөрчлөгдөөгүйг харуулж байна. Хэрэв улсын төсвөөс татаас авдаг аймгийн тоо буурахгүй, орлогоо бие даан бүрдүүлэх чадавх суларсан хэвээр байвал цаашид төвлөрлийг сааруулах бодлого үр дүнгүй болох, бүс нутгийн хөгжлийн ялгаа нэмэгдэх, аймаг хоорондын эдийн засгийн зөрүү гүнзгийрэх эрсдэлтэй байна. Иймд аймаг бүрийн орлого бүрдүүлэх чадварыг сайжруулах, орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, үйлдвэрлэл, бизнесийн орчныг өргөжүүлэх бодлогыг шат дараатай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д бүс тус бүрээр зорилгыг тодорхойлсон. Ингэхдээ тухайн бүсийн нийгэм-эдийн засаг, газар зүйн нөхцөл байдал, давуу талд нь тулгуурласан байна. Энэ нь улсын төсвөөс татаас авдаг аймгийн тоог цаашид бууруулж, орон нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг сэргээх нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь төвлөрлийг сааруулахад чухал ач холбогдолтой юм.

Хангайн бүсийн мал аж ахуйн гаралтай брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл: Хангайн бүсийн эдийн засгийн төрөлжилтийг харвал ДНБ-д эзлэх мал аж ахуйн салбарын эзлэх хувь 46.3 хувьтай байгаа нь бүсийн эдийн засгийн бүтэц МАА-гаас хэт хамааралтай байгааг харуулж байна. Энэ нь үйлдвэрлэлийн төрөлжилт хангалтгүй, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл сул, зах зээлийн өрсөлдөх чадвар хязгаарлагдмал байгаагийн илрэл юм.

Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг анхан шатны боловсруулалтгүйгээр түүхий эд хэлбэрээр борлуулах хандлага давамгайлж байна. Үүнээс үүдэн орон нутгийн эдийн засагт орлого бага төвлөрч, тогтвортой ажлын байр нэмэгдэхгүй байна. Мөн дотоодын болон гадаадын зах зээлд брэнд бүтээгдэхүүн экспортлох суурь дэд бүтэц, боловсруулах үйлдвэр, хангамжийн сүлжээний хөгжил сул байгаа нь эдийн засгийн үр өгөөжийг хязгаарлаж байна. Мал аж ахуйн салбарын бүтээмж, бүтээгдэхүүний чанарын хяналт, гарал үүслийн баталгаажуулалт, стандартын тогтолцоо бүрэн

хөгжөөгүй байгаа нь брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлд саад болж байна. Түүхий эдийн улирлын шинж чанар, байгаль цаг уурын эрсдэл, малчдын санхүүгийн чадавх сул байгаа нь тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ бүрдүүлэхэд хүндрэл үүсгэж байна. (Хүснэгт 84-т харуулав)

Хүснэгт 84. Хангайн бүсийн МАА-н үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь, 2024 он

Бүс	2020	2021	2022	2023	2024
Архангай	56.50	61.85	63.52	54.81	46.51
Баянхонгор	52.27	36.45	48.12	51.58	43.40
Өвөрхангай	45.56	41.36	45.35	48.51	48.11
Хангайн бүс	51.37	49.31	53.14	51.50	46.31

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цаашид Хангайн бүсийн аймгуудад мал аж ахуйн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл хөгжүүлэх, брэндийн бодлогыг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг олон улсын стандартын түвшинд баталгаажуулах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ чиглэлд төр-хувийн хэвшлийн түншлэл, инновац, технологийн шинэчлэлд суурилсан үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлж чадвал Хангайн бүсийн эдийн засгийн бие даасан байдал эрчимтэй нэмэгдэх боломжтой юм.

Баруун бүсийн эрчим хүчний найдвартай хангамж: Баруун бүс нутаг нь эрчим хүчний үйлдвэрлэл дотооддоо хангалтгүй, эрчим хүчний аюулгүй байдал сул байна. Тухайлбал, 2024 оны байдлаар нийт эрчим хүчний хэрэглээ 79.1 хувийг ОХУ болон БНХАУ-аас импортоор хангаж, үлдсэн хувийг нь Дөргөний УЦС, Ховд нар НЦС-уудаас хангаж байна.

Энэ байдал нь орон нутгийн аж үйлдвэр, дэд бүтэц, иргэдийн орон сууц, үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагаанд эрсдэл учруулж, эдийн засгийн бие даасан байдлыг хязгаарлаж байна. Түүнчлэн эрчим хүчний хязгаарлагдмал үйлдвэрлэл, импортоос хэт хамааралтай, дотоодын үйлдвэрлэлд нэмэлт зардал үүсгэх, бизнесийн орчныг сааруулах гол хүчин зүйл болж байна. Бүс нутгийн эрчим хүчний үйлдвэрлэлийн дэд бүтэц хуучирсан, сэргээгдэх эрчим хүчний нөөц ашиглалт дутмаг, санхүүжилт, хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байгаа нь дотоод үйлдвэрлэл, технологийн шинэчлэлийг сааруулж байна. Мөн орон нутгийн эрчим хүчний тогтвортой байдлыг хангах урт хугацааны стратеги хангалтгүй, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах арга хэмжээ сул байгаа нь эрчим хүчний найдвартай хангамжид хүндрэл учруулж байна. (Хүснэгт 85-д харуулав)

Хүснэгт 85. Эрчим хүчний хэрэглээ, мянган кВт.цаг

Бүс	2020	2021	2022	2023	2024
Говь-Алтай, дизель	157.46	100.00	76.27	139.41	10.32
Улиастай, дизель	48.50	-	-	9.30	3.56
Алтай сум.ГА, дизель	25.15	39.34	12.97	2.20	7.08
Дөргөн, УЦС	7,504.96	4,379.20	3,548.16	2,436.49	3,227.21
Тайшир, УЦС	1,501.62	3,784.00	3,758.28	2,318.70	2,321.22
Алтай сум.ГА, НЦС	40.55	39.34	34.97	110.58	66.33
Борх /Алдархаан/, НЦС	-	-	-	334.80	414.20

Эх сурвалж: Эрчим хүчний яамны тайлан

Иймд Баруун бүсийн аймгуудын эрчим хүчний найдвартай хангамжийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, бүс нутгийн эрчим хүчний тогтвортой байдлын менежментийг бэхжүүлэх шаардлагатай байна. Хэрэв энэ чиглэлд дорвитой арга хэмжээ авахгүй бол эрчим хүчний импортын хамаарал өндөр хэвээр, бүс нутгийн эдийн засгийн бие даасан байдал удаан хугацаанд хангагдахгүй, орон нутгийн хөгжлийн тэгш бус байдал улам гүнзгийрэх эрсдэлтэй байна.

Хойд бүсийн аж үйлдвэрлэл: Хойд бүсийн аж үйлдвэрийн салбарын борлуулалтын хэмжээ 2024 онд 4,136.9 тэрбум төгрөгт хүрсэн. Гэвч бүсийн хэмжээнд нийт аж үйлдвэрийн салбарын борлуулалтын 98.0-аас дээш хувийг Орхон аймаг дангаараа бүрдүүлж байгаа нь бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжлийн тэгш бус байдлыг илэрхийлж байна.

Булган, Хөвсгөл аймгуудын хувьд аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй бага, дэд бүтцийн хүртээмж, үйлдвэрлэлийн хүчин чадал, хөрөнгө оруулалтын боломж хязгаарлагдмал байгаагаас эдийн засгийн өсөлт, ажлын байрны бүтээмж, орлогын төвлөрөл Орхон аймагтай харьцуулахад сул байна. Энэ нь бүс нутгийн эдийн засгийн тэнцвэргүй байдлыг нэмэгдүүлж, бусад салбарын хөгжилд шууд нөлөөлөх эрсдэлтэй юм. Мөн үйлдвэрлэлийн төрөлжилт хангалтгүй, дотоодын болон экспортын зах зээлд бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сул байгаагаас орон нутгийн аж үйлдвэрийн салбарын өсөлт тогтвортой бус байна. Үүнээс гадна, хөрөнгө оруулалтын дэмжлэг, технологийн шинэчлэл, үйлдвэрлэлийн менежментийн чадавх хязгаарлагдмал байгаа нь орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна. (Хүснэгт 86-д харуулав)

Хүснэгт 86. Аж үйлдвэрийн борлуулалт, тэрбум төгрөг

Бүс	2020	Хувь	2021	Хувь	2022	Хувь	2023	Хувь	2024	Хувь
Булган	8.9	0.4	11.5	0.3	10.9	0.3	16.1	0.4	15.2	0.4
Орхон	2,403.	98.4	3,803.2	98.8	4,077.6	98.8	4,402.2	98.4	4,074.2	98.5
Хөвсгөл	29.3	1.2	35.0	0.9	38.6	0.9	56.9	1.3	47.6	1.2
Хойд бүс	2,441.5	100.0	3,849.8	100.0	4,127.1	100.0	4,475.2	100.0	4,136.9	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Иймд Хойд бүсийн аймгуудын аж үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих, Булган, Хөвсгөл аймгуудын дэд бүтцийг сайжруулах, технологи, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Энэ арга хэмжээний үр дүнд бүс нутгийн аж үйлдвэрлэлийн тэнцвэртэй өсөлт хангагдаж, эдийн засгийн бие даасан байдал сайжирч, орон нутгийн хөгжлийн ялгаа буурах боломжтой болно.

Төвийн бүсийн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл: Төвийн бүсийн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 2024 оны байдлаар 1,159.23 тэрбум төгрөгт хүрсэн боловч үйлдвэрлэлийн бүтээмж, бүтээгдэхүүний төрөлжилт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хувь харьцангуй бага байгаа нь бүс нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хязгаарлаж байна.

Гол тулгамдсан асуудал нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг анхан шатны боловсруулалтгүйгээр борлуулах, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн суурь дэд бүтэц хангалтгүй, хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлийн боломж хязгаарлагдмал байгаагаас орон нутгийн эдийн засгийн үр өгөөж сул байна. Мөн зах зээлийн өрсөлдөх чадвар, экспортын боломж хязгаарлагдмал, бүтээгдэхүүний чанар, стандартын баталгаажуулалт бүрэн хөгжөөгүй байгаа нь үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хязгаарлаж байна.

Үүнээс гадна ХАА-н салбарын хөрөнгийн хүртээмж, санхүүжилт, агуулах, тээвэр, боловсруулалтын дэд бүтцийн дутагдал нь бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой хангахад хүндрэл учруулж, ажлын байр, орлогын төвлөрлийг хязгаарлаж байна. Иймд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудын ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн шинэчлэл, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг үе шаттай хийх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Энэ арга хэмжээний үр дүнд Төвийн бүсийн эдийн засгийн бие даасан байдал сайжирч, орон нутгийн хөгжлийн ялгаа буурах боломж бүрдэнэ.

Зүүн бүсийн хил дамнасан аялал жуулчлал: Бүсийн эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлагатай. 2024 оны байдлаар Зүүн бүсэд ирсэн дотоод болон гадаадын жуулчдын тоо 173.8 мянга байгаа нь аялал жуулчлалын салбарын боломж харьцангуй бага байгааг илтгэж байна. (Хүснэгт 87-д харуулав)

Хүснэгт 87. Жуулчдын тоо

Бүс	2019		2022		2023		2024	
	Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод
Дорнод	7,729	16,000	1,539	21,311	8,014	13,186	14,120	27,365
Сүхбаатар	964	23,150	237	35,549	1,810	35,687	1,185	36,345
Хэнтий	6,105	60,000	1,500	70,000	3,500	90,000	4,395	90,427
Нийт	14,798	99,150	3,276	126,860	13,324	138,873	19,700	154,137

Эх сурвалж: Аймгуудын АЖ-ын мэргэжилтнүүдийн 2025 оны 5 сарын тайлан
Тайлбар: 2020-2021 оны цар тахлын үеийн жуулчны тоо багассан тул хассан

Бүс нутгийн дэд бүтцийн хүртээмж сул, зам тээвэр, орон нутгийн тээврийн үйлчилгээ, зочид буудал, аялал жуулчлалын үйлчилгээний чанар стандартын шаардлага хангахгүй байгаагаас орон нутгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийг хязгаарлаж байна. Мөн олон улсын зах зээлд танигдсан брэнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, маркетингийн стратеги, мэдээллийн хүртээмж дутмаг, орон нутгийн аялал жуулчлалын менежментийн чадавх хязгаарлагдмал байгаа нь жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх боломжийг бууруулж байна.

Түүнчлэн хил дамнасан аялал жуулчлалын хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд орон нутгийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо хязгаарлагдмал, хамтын ажиллагааны механизмууд бүрэн төлөвшөөгүй байгаа нь зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар тогтвортой өсөхөд саад болж байна. Иймд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, брэнд бүтээгдэхүүн, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх, орон нутгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна. Энэ арга хэмжээний үр дүнд Зүүн бүсийн эдийн засгийн бие даасан байдал сайжирч, аялал жуулчлалын салбарын орлого, ажлын байр нэмэгдэж, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдал хангагдах боломжтой болно.

Говийн бүсийн ногоон эрчим хүчний үйлдвэрлэл: Говийн бүс нутагт өсөн нэмэгдэж буй уул уурхай дагасан аж үйлдвэрийн хэрэглээг хангах эрчим хүчний найдвартай эх үүсвэр чухал байна. Нийт суурилагдсан хүчин чадал 190 МВт байгаа ба 2024 оны байдлаар нийт үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний 21.8 хувийг ДЦС-аас, үлдсэн 78.2 хувийг сэргээгдэх эрчим хүч эзэлж байна. Байгалийн нөхцөл буюу нарны тусгал, салхины нөөц Говийн бүс нутаг дахь сэргээгдэх эрчим хүчний нөөц боломж өндөр байгааг харуулж байгаа ч өсөн нэмэгдэж буй хэрэглээ, хөгжлийн эрэлтээс харахад хангалттай түвшинд хүрч чадахгүй, төвийн эрчим хүчний систем болон импортын хараат байдал үргэлжилж байна.

Засгийн газраас Тавантолгойн 450 МВт-н хүчин чадалтай ДЦС барих, 10 аймгийн төвд дулааны станц барих ажлын хүрээнд Говийн бүсийн Говьсүмбэр, Дундговь аймгуудад дулааны станц барих ажлууд байна. Харин байгалийн давуу талыг ашиглан байгальд ээлтэй ногоон эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнийг шийдвэрлэх хүрээнд байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах механизм бүрэн төлөвшөөгүй нь эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд удаашрах шалтгаан болно. Иймд Говийн бүсийн аймгуудад ногоон эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь бүс нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, орон нутгийн хөгжлийн тэгш бус байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой болно.

Улаанбаатарын бүсийн алслагдсан дүүргүүдийн бизнес эрхлэлт: Нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ 2024 оны байдлаар 1,343 байгаа нь төвийн бусад дүүрэгтэй харьцуулахад маш бага үзүүлэлт юм. (Хүснэгт 88-д харуулав)

Хүснэгт 88. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж

Дүүрэг	2020	2021	2022	2023	2024
Багануур	374	382	456	489	510
Багахангай	80	75	89	96	97
Налайх	565	572	633	704	736

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Алслагдсан дүүргүүдэд бизнесийн төрөлжилт хангалтгүй, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбар тогтвортой хөгжөөгүй байгаатай холбоотой юм. Дүүргүүдийн дэд бүтэц, зам тээвэр, логистикийн хүртээмж сул, хөрөнгө оруулалтын боломж хязгаарлагдмал, бизнесийн үйл ажиллагааг дэмжих санхүүгийн үйлчилгээний хүртээмж бага байгаа явдал юм. Мөн зах зээлийн өрсөлдөх чадвар сул, инновац, технологийн шинэчлэл, мэргэжлийн хүний нөөцийн хүртээмж хангалтгүй байгаа нь аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагаанд саад болж байна.

Түүнчлэн орон нутгийн зохицуулалт, зөвшөөрөл авах үйл явц төвөгтэй, татвар, хяналтын механизмууд тодорхой бус байгаагаас бизнес эрхлэгчдийн итгэл буурч, шинэ аж ахуйн нэгж, байгууллага байгуулах эрмэлзэл хязгаарлагдмал байна. Иймд алслагдсан дүүргүүдэд бизнесийн орчныг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнес эрхлэгчдэд зориулсан зөвлөх үйлчилгээ, сургалт, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд энэ арга хэмжээний үр дүнд орон нутгийн эдийн засгийн төрөлжилт нэмэгдэж, эдийн засгийн бие даасан байдал сайжрах боломжтой болно.

Шинэ хоршоо, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл: Монгол Улсад Сум хөгжүүлэх санг Хоршоог хөгжүүлэх сан болгон өөрчилж, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 2,724 иргэн, компани, хоршооны төсөлд 54.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 3,995 ажлын байр шинээр бий болгож, 4,242 ажлын байрыг хадгалсан нь хоршоодын салбарын хөгжлийг дэмжих чухал алхам болсон. Үүнээс 167 хоршоонд 5.5 тэрбум төгрөгийг олгосон нь мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг дэмжих, орон нутгийн эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй хөрөнгө оруулалт байв.

Гэвч хоршоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд нэг хоршооны гишүүнд ногдох борлуулалтын орлого тооцогдоогүй нь эдийн засгийн үр ашиг, гишүүдийн орлогыг үнэн зөвөөр тооцох, төлөвлөх үйл явцад саад учруулж байгаа тулгамдсан асуудал болж байна. Энэ байдал нь хоршооны гишүүдийн санхүүгийн чадавх, бизнесийн шийдвэр гаргах чадвар, хөрөнгө оруулалтын сонирхолд шууд нөлөөлж, хоршоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл бий болгох боломжийг хязгаарлаж байна. Иймд цаашид нэг гишүүнд ногдох борлуулалтын орлогыг үнэн зөв тооцох, гишүүдийн санхүүгийн мэдээллийг системчилж бүртгэх, хоршоодын бүтцийг сайжруулах, санхүү, хөрөнгө оруулалтын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, малчдад учирсан эрсдэлийг хоршооны бүтцэд тулгуурлан бууруулах, хоршооны хууль, эрх зүйн орчныг сайжруулах, санхүү, хөрөнгө оруулалтын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тулгамдсаар байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хүрээнд орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд зөвхөн төсвийн орлого, аж үйлдвэрийн бүтээмжээр бус тухайн бүсийн бизнесийн орчин, дотоод нөөцийн үр ашигтай байдал зэргээр


тодорхойлно. Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх хүрээнд бүс тус бүрийн онцлог, давуу талыг онцолсон. Улсын төсвөөс татаас авдаггүй аймаг 2024 онд 6 байгаа бол 2030 он гэхэд 11 болох зорилттой холбогдуулан хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд орон нутгийн санхүүгийн бие даасан байдал мэдэгдэхүйц сайжирч, аймгууд өөрсдийн орлогыг тогтвортой бүрдүүлэх чадавх нэмэгдэж, улсын төсвийн төвлөрсөн хамаарал буурч байна. Энэ хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтыг үе шаттай дэмжиж, уул уурхайн болон бусад үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн орлогоос аймаг, сумд илүү хүртэх зохицуулалтыг боловсруулснаар аймгууд татварын дэмжлэгт хамрагдах боломжтой болж, орон нутгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийн түвшин дээшилж, бизнесийн орчин тогтвортой болно.

Мөн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн бүс тус бүрийн нийгэм, эдийн засгийн давуу талыг ашигласан хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжсэнээр аймаг хоорондын хөгжлийн ялгаа багасаж, орон нутгийн эдийн засгийн тэнцвэрт өсөлт бий болж, төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийг жигд дэмжих нөхцөл бүрдэнэ. Үүний үр дүнд иргэдийн амьжиргаа, нийгмийн дэмжлэгийн хүртээмж нэмэгдэж, орон нутгийн удирдлагын чадавх бэхжихийн зэрэгцээ улс орны төсвийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой болно.

3.7. ҮНДЭСНИЙ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн (International Institute for Management Development)-ээс өрсөлдөх чадварыг “Улс орон ард түмнийхээ аж амьдралыг илүү чинээлэг болгохын тулд өөрийн нөөц бололцоо болон чадавхыг хэрхэн удирдаж байгааг өрсөлдөх чадвар харуулна” гэж тодорхойлон¹⁰² “Дэлхийн өрсөлдөх чадварын индекс”-ийг 1989 оноос жил бүр тооцож “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д тусгадаг. Монгол Улсын хувьд 2015 оноос өрсөлдөх чадварын индексэд хамрагдаж эхэлсэн бөгөөд 2024 оны байдлаар дэлхийн 67 орноос 61 дүгээр байрт эрэмбэлэгдэж байна. Өрсөлдөх чадварын үзүүлэлтийн эрэмбийг харвал Монгол Улс сүүлийн 10 жилийн хугацаанд 55-аас 61 дүгээр байр луу ухарчээ. (График 42-т харуулав.)

График 42. Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт, эрэмбэ




Эх сурвалж: Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн

Тус индексийг тооцохдоо Эдийн засгийн гүйцэтгэл, Засгийн газрын үр ашигтай байдал, Бизнесийн үр ашигтай байдал, Дэд бүтэц гэсэн 4 хэсэг, 20 бүлгийн 256 үзүүлэлтээр хэмждэг. (График 43-т харуулав.)

¹⁰² Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн, (IMD)

График 43. Өрсөлдөх чадварын үзүүлэлт, байр, 2024 он



Эх сурвалж: Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн

Манай орны хувьд доогуур үнэлэгдэхэд нь бизнесийн үр ашигтай байдал, дэд бүтэц гэсэн 2 хэсэгт хангалтгүй үнэлгээ авсантай холбоотой байна. Иймд, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд эдийн засаг, инфляц, засгийн газрын өр, гадаад худалдааг голчлон тодорхойлоо.

3.7.1. Эдийн засгийн эрх чөлөө

Өв уламжлалын сангаас "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийг хууль дээдлэх ёс, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлт ашиглан тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 60.6 оноотойгоор 76 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна. (Хүснэгт 89-д харуулав)

Хүснэгт 89. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Хууль дээдлэх ёс	Өмчийн эрх	48.8	муу	92/176
	Шүүхийн үр ашиг	34.8	бага	71/176
	Төрийн зарчимт байдал	55.0	муу	117/176
Засгийн газрын хэмжээ	Татварын дарамт	84.0	бүрэн	59/176
	Засгийн газрын зарлага	62.0	дунд	113/176
	Төсвийн сахилга бат	64.3	дунд	83/176
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.0	дунд	79/176
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	67.5	дунд	24/176
	Мөнгөний эрх чөлөө	67.9	дунд	117/176
Зах зээлийн нээлттэй байдал	Худалдааны эрх чөлөө	74.4	сайн	72/176
	Хөрөнгө оруулагчдад эзлтэй байдал	50.0	бага	119/176
	Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50.0	бага	96/176

Эх сурвалж: Дэлхийн өв уламжлалын сан

Дээрх индексийн дэд хүчин зүйлсийг шалгуур үзүүлэлт болгон үнэлэхдээ дараах агуулгын хүрээнд хянадаг байна. Үүнд:

- ✓ Өмчийн эрх – Өмчлөх эрх, ашиглах эрх хуулийн хүрээнд хэрхэн хангагдаж байгааг хэмждэг.

- ✓ Шүүхийн үр ашиг – Шүүх засаглал Засгийн газар, улс төрийн намаас хараат бус байж, аливаа гэмт хэрэг зөрчилд иргэдэд эрх тэгш үйлчилдэг эсэхийг хэмждэг.
- ✓ Төрийн ёс зүй – Төрийн болон шийдвэр гаргах түвшний байгууллагад авлига байгаа эсэхийг хэмждэг.
- ✓ Татварын дарамт- Хувь хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд татвар хэр их дарамт учруулж байгааг харуулна.
- ✓ Засгийн газрын зарлага – Засгийн газрын зардлын төсөвт учруулж буй дарамтыг хэмждэг.
- ✓ Төсвийн сахилга бат – Төсвийн алдагдлын тэлэлт, өрийн дарамтыг хэмждэг.
- ✓ Бизнесийн эрх чөлөө – Дэд бүтэц, хууль эрх зүйн зохицуулалтын орчин бизнесийн үр ашигт үзүүлэх нөлөөг харуулдаг.
- ✓ Хөдөлмөр эрхлэх эрх чөлөөт байдал – Хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил, ажлын байр бий болгоход хэр сайн дэмжлэг үзүүлж, ажилчдын эрх, бизнесийн уян хатан байдлыг тэнцвэржүүлж байгааг хэмждэг.
- ✓ Мөнгөний бодлогын чөлөөт байдал – Мөнгөний бодлогын үр дүнтэй байдал болон дотоодын инфляцын байдлыг дүгнэн үнэлдэг.
- ✓ Чөлөөт худалдаа - Экспорт, импортод нөлөөлж буй тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг харуулна.
- ✓ Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал – Хөрөнгө оруулалтын эрсдэл, хөрөнгө оруулалтын урсгалд хэр их хязгаарлалт байгааг харуулна.
- ✓ Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал - Банкны үйл ажиллагааны үр ашгийг харуулна.

Шалгуур үзүүлэлтүүдийн онооны ангиллаар өмчийн эрх 92/176 муу, төрийн зарчимт байдал 117/176 муу, бизнесийн эрх чөлөө 79/176 дунд, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал 119/176 бага гэж үнэлэгдсэн байна. Эндээс харахад хувь хүмүүсийн өмч эзэмших эрх чөлөөг хангах, төрийн албаны авлига авах эрсдэлийг бууруулах, бизнесийн үр ашигтай үйл ажиллагааны хязгаарлалтыг бууруулах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Манай улсын хувьд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 2018 онд 28.7 хувь, 2019 онд 28.8 хувь байсан бол 2023 онд 33.1 хувь, 2024 онд 36.8 хувь болж нэмэгдсэн.

Засгийн газрын зүгээс цаашид уг харьцааг үе шаттай бууруулахаар төлөвлөж байгаа ба ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг үүсгэж, хувийн хэвшлийн бизнесийг тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.

Монгол Улсын өрсөлдөх чадварыг зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, инфляцыг зорилтот интервалд тогтворжуулах, засгийн газрын өрийг бууруулах, гадаад худалдааны хэмжээг нэмэгдүүлэх замаар нэмэгдүүлж олон улсын өрсөлдөх чадварын индексийг 11 эрэмбээр ахиулж 50-д хүргэхээр зорьж байна.


Үүний тулд өмчлөх эрхийг баталгаажуулах замаар эдийн засгийн эрх чөлөөг сайжруулж, 2024 онд 76-т байгаа эдийн засгийн эрх чөлөөний индексийг 16 байр ахиулж 2030 он гэхэд 60-д хүргэхээр зорьж байна. Эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах хүрээнд төрийн оролцоо, гааль, татвар, бизнесийн орчин, ХАА, стандарт зэрэг асуудлуудыг сайжруулах шаардлагатай байна.

Зах зээл дэх төрийн оролцоо: Монгол Улсад хувиараа бизнес эрхлэгчид, бичил, жижиг, дунд үйлдвэрүүд нь эдийн засгийн хөгжлийн суурь болж орон нутгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэвч бизнесийн орчинд татварын дарамт, төрийн хүнд суртал, дэд бүтцийн асуудал,

хөрөнгө оруулалтын орчны саад бэрхшээл зэрэг олон асуудал тулгарч байгаа нь бизнесийн идэвхийг бууруулж, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлсөөр байна.

Иймд бизнесийн орчныг бодитоор сайжруулж, зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд зах зээл дэх төрийн оролцоог бууруулах шаардлагатай байна. Зах зээл дэх төрийн оролцоог илэрхийлдэг ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хэмжээ 2024 онд 72.5 хувь болж 2020 онтой харьцуулахад 4.6 нэгж хувиар буурсан байна. (График 44-т харуулав.)

График 44. ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүнд суртлын индекс 2024 оны дундаж үнэлгээгээр 2.85 гарсан¹⁰³ нь 2021 оны үр дүнгээс 0.13 нэгж сайжирсан боловч 2018 оны 2.90 үнэлгээнээс 0.05 нэгж буурсан байна. (Хүснэгт 90-д харуулав)

Хүснэгт 90. Хүнд суртлын индекс

Үзүүлэлт	2018	2021	2024
Хүнд суртлын индекс	2.90	2.72	2.85

Эх сурвалж: Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим

Хүнд суртлын индексийг тооцохдоо дараах 2 дэд индексийн дунджаар тооцдог бөгөөд индекс тус бүрээр үр дүнг авч үзлээ.

Хүнд суртлын ерөнхий индекс нь судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн үнэлгээний үр дүнд үндэслэн тооцдог бөгөөд төрийн байгууллагуудын ил тод байдал, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага, төрийн бодлого, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргалтад бизнес эрхлэгчид оролцох боломжийн үнэлгээнд үндэслэдэг. Хүнд суртлын ерөнхий индекс 2024 онд 2.60 үнэлэгдсэн нь 2021 оны судалгаанаас 0.18 нэгжээр, 2018 оноос 0.09 нэгжээр тус тус сайжирсан байна. (Хүснэгт 91-д харуулав.)

Хүснэгт 91. Хүнд суртлын ерөнхий индекс

Үзүүлэлт	2018	2021	2024
Төрийн бодлого, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргах процесст бизнес эрхлэгчид оролцох боломж	2.48	2.45	2.43
Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага	2.75	2.58	3.19
Төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал	2.39	2.35	2.43
Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо	2.40	2.28	2.40
Төрийн байгууллагуудын ил тод байдал	2.51	2.45	2.55
Дундаж	2.51	2.42	2.60

Эх сурвалж: Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим

Төрийн үйлчилгээний хүнд суртлын индекс нь төрийн байгууллагууд үйлчилгээ үзүүлэх явцдаа хэр зэрэг хүнд суртал гаргаж байгааг болон энэ нь бизнесийн үйл

¹⁰³ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Бизнес эрхлэхэд тулгарч буй төрийн үйлчилгээний хүндрэл, бэрхшээл, өртгийг тодруулах судалгаа

ажиллагаанд яаж нөлөөлж байгааг үнэлдэг бөгөөд зардал, төрийн албан хаагч, хугацаа, баримт бичиг, мэдээлэлд үндэслэдэг. (Хүснэгт 92-т харуулав.)

Хүснэгт 92. Төрийн үйлчилгээний хүнд суртлын индекс

Үзүүлэлт	2024	2021	2018
Зардал	3.16	3.27	3.31
Төрийн албан хаагч	3.10	2.91	3.46
Хугацаа	2.86	2.69	3.06
Баримт бичиг	3.08	2.97	3.31
Мэдээлэл	3.17	3.23	3.39
Дундаж үнэлгээ	3.07	3.01	3.31

Эх сурвалж: Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим

Төрийн үйлчилгээний хүнд суртлын индекс 2024 оны 3.10 үнэлгээтэй гарсан. Нарийвчлан авч үзвэл, баримт бичиг, хугацаа, төрийн албан хаагч гэсэн гурван үзүүлэлт нь өмнөх судалгаанаас сайжирсан боловч 2018 оны түвшинд хүрээгүй байна. Харин мэдээлэл болон албан зардал гэсэн хоёр үзүүлэлт 2018 оноос хойш тогтмол буурч байгаа нь анхаарал татахуйц асуудал юм. Мөн мэдээллийн үнэлгээ 3.17, албан зардлын үнэлгээ 3.16 оноотой байгаа нь төрийн үйлчилгээний хүнд суртлын индексийн үнэлгээнээс өндөр байна. Өөрөөр хэлбэл, сайжруулах шаардлагатай байсан гурван үзүүлэлтүүдийн хувьд ахиц дэвшил гарсан байна.

Төрийн хууль, дүрэм, журмын зохицуулалтуудын нарийн төвөгтэй байдал, алдагдсан цаг хугацаа, албан бус зардлууд нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл үүсгэж байна.

Өрсөлдөөнийг хязгаарлагч хүчин зүйлүүдийг бууруулах замаар зах зээл дэх төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2024 онд 72.5 хувь байгааг 2030 онд 84.0 хувьд хүргэнэ. Үүний тулд өмчлөх эрхийг баталгаажуулах замаар эдийн засгийн эрх чөлөөг сайжруулж, эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс 2024 онд 76-д байгааг 2030 онд 60-д хүргэн 16 байраар ахиулна. Төрөөс үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах замаар бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүнд суртлыг бууруулж, хүнд суртлын индекс 2024 онд 2.85 байгааг 2030 онд 3.8-д хүргэнэ.


Гааль: Гаалийн байгууллагаас 2024 онд импортын 197,640 барааг гаалийн хяналтад авч, улсын хилээр 2,516,315 тээврийн хэрэгсэл, 420,871 чингэлэг, 10,062 агаарын хөлгөөр тээвэрлэгдсэн 103.3 сая тонн бараанд 1.2 сая орчим гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийж улсын төсөвт 6.7 их наяд төгрөгийн гаалийн болон бусад татварыг төвлөрүүлсэн. Тухайлбал, 2024 онд Монгол Улс 83.3 сая тонн нүүрс экспортолсон нь өнгөрсөн оноос 19.7 хувиар буюу 13.7 сая тонноор нэмэгдсэн байна.¹⁰⁴

Гаалийн шинэчлэлийн хүрээнд Засгийн газрын 2019 оны Гаалийн талаар авах зарим арга хэмжээний тухай 47 дугаар тогтоолыг үндэслэн хилийн хяналтын болон гүний гаалийн байгууллагуудыг орчин үеийн рентген болон хяналтын тоног төхөөрөмжөөр хангах, салбар лабораторийг байгуулах, ГЕГ-ын дэргэдэх Шуурхай хяналтын төв байгуулах, хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн бүртгэлийг цахимжуулах, хилийн боомтуудад олон улсын жишигт нийцсэн цахим гарцын системийг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулсан. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хилийн боомтуудын цогцолборын барилга, зам талбай, гэрэлтүүлэг, шилэн кабель тавих, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар зарим хилийн боомтын шалган нэвтрүүлэх цогцолборын барилга, байгууламж, өргөтгөл, шинэчлэлийн ажлыг тус тус хэрэгжүүлсэн.

¹⁰⁴ Гаалийн ерөнхий газрын 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Улсын төсвийн гаалийн орлогын төлөвлөгөөний төлөвлөлт 2020 онд 3.02 их наяд төгрөг байсан бол 2024 онд 2.2 дахин өсөж 6.79 их наяд төгрөгт хүрсэн байна. (График 45-д харуулав)

График 45. Улсын төсвийн гаалийн орлого, их наяд төгрөг



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гаалийн байгууллагын хяналтын хүрээнд гадаад худалдааны эргэлт 2020 онд 12.9 тэрбум ам.доллар байсан бол 2024 онд 27.3 тэрбум ам.доллар буюу 2.1 дахин өссөн үзүүлэлттэй байна. (График 46-д харуулав)

График 46. Гадаад худалдааны эргэлт, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Улсын хилээр нэвтрүүлж буй бараанд хийх гаалийн хяналт шалгалтаас харахад нийт барааны 42.0-53.0 хувьд биет болон бичиг баримтын шалгалт (улаан төлөв) хийж байсан бол 2024 оноос эхлэн 37.0 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Гаалийн хяналт шалгалтад цахим бүрдүүлэлт, теле хяналтын нэгдсэн систем, тээврийн цахим хяналтыг бүрэн нэвтрүүлсэн.

Дэлхийн гаалийн байгууллагын дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх аюулгүй байдлын багц стандарт, ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг үндэслэж Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/288 дугаар тушаалаар “Гаалийн итгэмжлэл олгох журам”-ыг анх баталж байсан бол ГЕГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/118 дугаар тушаалаар “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. Гаалийн итгэмжлэлийг 2024 оны байдлаар 4 аж ахуйн нэгжид олгоод байна.¹⁰⁵ (Хүснэгт 93-т харуулав)

¹⁰⁵ Гаалийн ерөнхий газрын 2024 оны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Хүснэгт 93. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж

дд	Нэр	Гаалийн итгэмжлэл	
		Олгосон огноо	Төрөл
1	Эрдэнэт үйлдвэр ТӨХК	2023	Экспорт
2	АПУ ХК	2024	Экспорт, Импорт
3	Ханбогд кашемир ХХК	2024	Экспорт, Импорт
4	Говь ХК	2024	Экспорт, Импорт

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж болсноор дараах хөнгөлөлтүүдийг авна. Үүнд:

- ✓ Гаалийн бүрдүүлэлтийн дараалал харгалзахгүй хийх;
- ✓ Барааг эзэмшигчийн байр, агуулах, талбайд түр хадгалах;
- ✓ Нийт гаалийн бүрдүүлэлтийн 90 хүртэлх хувийг бараанд хийх шалгалтаас чөлөөлөх;
- ✓ Нэг сарын хугацаанд нэг гаалийн байгууллагын хяналтад орсон, нэг илгээгчээс хэд хэдэн ачилтаар нийлүүлэгдэх нэг төрлийн бараанд багцалж гаалийн нэг мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлтийг дор дурдсанаас бусад тохиолдолд хийх боломжийг олгох; (гэрээний нэгж үнэ өөрчлөгдсөн; гаалийн болон бусад татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон)
- ✓ Гаалийн хууль тогтоомжийн болон гаалийн үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, гомдлыг нэн даруй шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх үүрэг бүхий гаалийн улсын байцаагчийг гаалийн удирдах төв байгууллагаас тусгайлан томилох;
- ✓ Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн талаар олон нийтэд сурталчлах;
- ✓ Гаалийн бүрдүүлэлтийг барааны байршлаас үл хамааран аль ч гаалийн байгууллагад хийх;
- ✓ Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан бусад улс оронд хөнгөлөлт эдлэх.

Цаашид итгэмжлэлийн төрлийг нэмэгдүүлэх хууль тогтоомжийг шинэчлэх, бусад улс орны Гаалийн байгууллагатай Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулж, хэрэгжилтийг хангах шаардлагатай байна. Иймээс аж ахуйн нэгжүүдийн чадавхыг сайжруулах замаар гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг нэмэгдүүлж итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тоо 2024 онд 4 байгааг 2030 онд 25-д хүргэнэ. Үүний тулд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулж бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувь 2024 онд 63.2 байгааг 2030 онд 69.0 болгоно.

Татварын орчин: Монгол Улсын татварын нийт орлого 2024 онд 27.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 5.9 их наяд төгрөгөөр буюу 27.6 хувиар өссөн байна. Энэ орлогын 32.7 хувийг орлогын албан татвар, 21.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 17.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар 4.0 хувийг онцгой албан татварын орлого, 22.9 хувийг бусад төрлийн татвар, төлбөр, хураамжийн орлого, гадаадын үйл ажиллагаа тус тус бүрдүүлж байна. Орлогын албан татварын 71.6 хувийг ААНОАТ эзэлж байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд цахим төлбөрийн баримтын системийг нэвтрүүлснээр нийт хэрэглэгчийн тоо 2.3 саяд хүрч, сард дунджаар хэвлэгдэж байгаа баримтын үнийн дүн 6.2 их наяд төгрөгт хүрч, 37.3 сая баримт хэвлэсэн үзүүлэлттэй байна. Мөн цахим төлбөрийн баримтын системийг ашиглан хөрөнгийн татварын нэхэмжлэхээ төлөх боломж бүрдсэн.

Цаашид татварын эрсдэлийг цахим систем үнэлж, эрсдэлтэй татвар төлөгчдөд эрсдэлийг анхааруулдаг, сануулдаг, урьдчилан сэргийлдэг, мэдээлэлд суурилсан

шийдвэр гаргадаг тогтолцоонд шилжинэ. Ингэснээр татварын албаны хяналт шалгалтын тоог бууруулахаас гадна татвар төлөгчдөд учирдаг хүндрэл, зөрчлийн тоог бууруулах эерэг үр нөлөөтэй юм.

Олон улсын чиг хандлагаас харахад сүүлийн жилүүдэд татварын албаны хяналтын механизмыг хялбаршуулах, татвар төлөгчдөд зөвлөн туслах үйлчилгээг сайжруулах чиглэлээр томоохон шинэчлэлүүд хийгдэж байна. Тухайлбал, Шинэ Зеланд, Австрали, Канад, Финланд зэрэг улс орнууд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх механизмыг нэвтрүүлж байна. Эдгээр улсуудад татвар төлөгчийг зөрчил гаргасны дараа шийтгэл хүлээлгэх бус, зөрчил гарахаас нь өмнө урьдчилан мэдээлж, тайлан гаргах, татвар төлөх үйл явцыг хялбар, ойлгомжтой болгох бодлого баримталдаг.

Монгол Улс мөн энэ чиг хандлагыг баримталж, цахим системийн хөгжлийг ашиглан зөвлөн туслах үйлчилгээ, автомат хяналтын тогтолцоог нэвтрүүлж, татварын орчныг хялбаршуулж, сайжруулах замаар татварын ачааллыг бууруулахыг зорьж байна.

Олон улсын валютын сангаас 2022 онд хийсэн “Монгол Улс: Татварын албаны үйл ажиллагааг үнэлэх хэрэгслийн тайлан”-д дурдсанаар Монгол Улсын татварын албаны үйл ажиллагааг нийт 32 үзүүлэлтээр үнэлэхэд үйл ажиллагааны эрсдэл, татварын тайлангийн хамрагдалт, татварын үнэн зөв тайлагнал, татварыг хугацаанд нь төлж буй байдал зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд хангалтгүй үнэлгээ авсан байна.

Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох зорилгоор 2022 онд жижиг, бичил сегментийн аж ахуйн нэгж болон иргэдээс нийт 78 үзүүлэлтээр судалгаа авсан. Судалгаагаар татвар төлөгчдийн 18.0 хувь нь сургалт, зөвлөгөө, заавар, зөвлөмж өгдөггүй гэж, 25.0 хувь нь татвар төлөх хугацаа уян хатан биш гэж дүгнэсэн. Мөн татвар төлөгчид санал хүсэлтэд хариу өгөх үзүүлэлтэд бага оноо өгч, мэдээлэл өгөх, зөвлөх үйлчилгээг сайжруулах, мэдээллийг энгийн ойлгомжтой болгох, татварын албаны харилцах үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Төр, татвар төлөгчийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар татварын ачааллыг бууруулж Татвар төлөгчдийн дундаж бодит татварын хувийг 2030 онд одоо байгаагаас 5.0 хувиар бууруулна. Үүний тулд татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулж Татвар төлөгчийн үнэлгээг 2030 онд одоо байгаагаас 11.0 хувиар нэмэгдүүлнэ.

Бизнесийн орчин: Үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид 2024 оны байдлаар 108,378 болж өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар, үйл ажиллагаа эрхлээгүй бизнес эрхлэгчдийн тоо 2024 онд 49,406 болж өмнөх онтой харьцуулахад 63.5 хувиар, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон аж ахуй нэгж 2.3 дахин өссөн байна. Харин үйл ажиллагаа нь түр зогссон бизнес эрхлэгчдийн тоо 2024 оны байдлаар 89,326 болж 7.8 хувиар буурчээ. (Хүснэгт 94-т харуулав)

Хүснэгт 94. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуй нэгж, байгууллагын тоо, жил, хариуцлагын хэлбэр, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар

Статистик үзүүлэлт	Бизнесийн төрөл	2023	2024
Үйл ажиллагаа явуулж байгаа	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	-	-
	Компани	84,660	87,626
	Хоршоо	1,570	3,869
	Нөхөрлөл	1,558	1,600
	ТӨҮГ, ОНӨҮГ	464	475
	Төсвийн байгууллага	4,900	4,997
	Төрийн бус байгууллага	7,739	9,116
	Бусад	691	695

	Нийт	101,582	108,378
Үйл ажиллагаа эрхлээгүй	Компани	23,358	36,715
	Хоршоо	321	5,346
	Нөхөрлөл	536	646
	ТӨҮГ, ОНӨҮГ	3	6
	Төсвийн байгууллага	-	-
	Төрийн бус байгууллага	5,792	6,432
	Бусад	212	261
	Нийт	30,222	49,406
Үйл ажиллагаагаа түр зогсоосон	Компани	72,624	67,937
	Хоршоо	2,730.00	2,368
	Нөхөрлөл	3,103	2,877
	ТӨҮГ, ОНӨҮГ	64	64
	Төсвийн байгууллага	2	2
	Төрийн бус байгууллага	17,479	15,258
	Бусад	904	822
	Нийт	96,906	89,328
Үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон	Компани	2,103	4,008
	Хоршоо	142	362
	Нөхөрлөл	88	214
	ТӨҮГ, ОНӨҮГ	7	6
	Төсвийн байгууллага	2	3
	Төрийн бус байгууллага	267	1,412
	Бусад	35	63
	Нийт	2,644	6,068

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Бизнес эрхлэгчид компани байгуулан нэр авахад 10 хоногийн хугацаанд 7 шат дамжлагын дагуу бичиг баримт бүрдүүлдэг бол нэр авсны дараа бизнесийн орчны үнэлгээ хийлгэх, эрчим хүчинд холдогдох гэх мэтэд хамгийн багадаа 140-150 өдрийг зарцуулдаг байна.

Баримт бичгийн бүрдүүлэлт их, олон шат дамжлагатай, хугацаа их шаарддаг зэрэг нь шинээр бизнес эрхлэх гэж буй иргэд, ялангуяа залуу гарааны бизнес эрхлэгчид, эмэгтэйчүүд, хөдөө орон нутгийн иргэдийн хувьд бизнес эрхлэх урам зоригийг мохоох, бизнесийн хамтрагчид, хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулах, санхүүгийн хувьд дарамт болох зэрэг нөлөөтэй байдаг ба үүний үр дүнд албан бус, бүртгэлгүй эдийн засаг руу шилжих эрсдэлийг бий болгож байна.

Тухайлбал, барилгын зөвшөөрөл авах нөхцөлийн үзүүлэлтээр 190 орноос 29 дүгээр байр, эрчим хүчний холболтын үзүүлэлтээр 152 дугаар байр, өмч бүртгүүлэх нөхцөлийн үзүүлэлтээр 50 дугаар байранд тус тус эрэмбэлэгдсэн.

Бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа эхлүүлэн тасралтгүй, хэвийн явуулахад тулгарч буй бэрхшээлүүдээс хамгийн өндөр хувийг бэлэн мөнгө, эргэлтийн хөрөнгийн хомсдол, бизнес эрхлэх тодорхойгүй нөхцөл байдал, тээвэр логистиктой холбогдох удаашрал, тасалдал зэрэг эзэлж байна.

Аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах замаар бизнесийн орчныг сайжруулж, бизнесийн орчны ерөнхий үнэлгээ 2023 онд 2.71 байгааг 2029 онд 3.11-д хүргэнэ. Үүний тулд зүй ёсны монопол болон давамгайл байдлтай аж ахуй эрхлэгчийг тогтоон, хяналт тавьж эдгээр аж ахуйн эрхлэгчдэд хүргүүлсэн зөвлөмж, шаардлагын хэрэгжилт 2024 онд 40.0 хувь байгааг 2030 онд 65.0

хувьд хүргэнэ. Мөн мэдээлэл, ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлж хэрэглэгчийн итгэлийн индекс 2024 онд 104.7 байгааг 2030 онд 114-т хүргэнэ.

Худалдан авах ажиллагаа: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020-2024 онуудын хооронд зарласан тендер шалгаруулалтын төсөвт өртгийн хэмжээ 5.7 их наяд төгрөгөөс 26.0 их наяд төгрөг болж 4.5 дахин нэмэгдсэн байна. (График 47-д харуулав.)

График 47. Тендер шалгаруулалтын төсөв (их наяд төгрөг)



Эх сурвалж: ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайлан

Зохион байгуулсан тендер шалгаруулалтын төсөвт өртөг 2024 онд 26.0 их наяд төгрөг болж 2023 оноос 14.1 их наяд төгрөг буюу 18.5 хувиар нэмэгдсэн нь Нийслэлээс зарласан “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро” барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот), “Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол”, “Эрдэнэс таван толгой” ХК-аас зарласан “Цанхын зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт”, “Таван толгой” ХК-аас зарласан “Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/” зэрэг төсөл, арга хэмжээний төсөвт өртөгтэй холбоотой байна. Дээрх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 11.1 их наяд төгрөг буюу 2024 онд зохион байгуулсан нийт тендер шалгаруулалтын төсөвт өртгийн 42.0 хувийг эзэлж байна.

Нөгөөтээгүүр, 2024 оны нийт зарласан тендер шалгаруулалт 2023 оноос 4,071 буюу 29.8 хувиар нэмэгдсэн байна. Дээрх үзүүлэлтээс харахад зохион байгуулж байгаа тендер шалгаруулалт нь төсөвт өртгийн өсөлттэй шууд хамааралгүй байна. Харин цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагчийн тоо нэмэгдсэн, бага төсөвт өртөг бүхий олон тендер шалгаруулалт зарласантай холбоотой байна.

Нэг тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 15,777 буюу 89.1 хувийг эзэлж байна. Энэ нь нийт тендер шалгаруулалтад нэг тэрбумаас доош төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт давамгайлж буйг харуулж байна. Харин нэг тэрбумаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 1,941 буюу 10.1 хувийг эзэлж байна. Гэсэн хэдий ч эдгээр төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 23.4 их наяд төгрөг буюу зарлагдсан тендер шалгаруулалтын нийт төсөв өртгийн 90.0 хувийг эзэлж байна. (Хүснэгт 95-д тендер шалгаруулалтын төсөвт өртгийг харуулав.)

Хүснэгт 95. Тендер шалгаруулалтын төсөвт өртөг (1 тэрбум хүртэлх ба түүнээс дээш)

Ангилал	Тоо		Тендер шалгаруулалтын төсөвт өртөг	
	Нийт тендер шалгаруулалтын тоо	Эзлэх хувь	Төсөвт өртөг (Их наяд төгрөг)	Эзлэх хувь
Нэг тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй	15,777	89.1	2.6	10.0
Нэг тэрбумаас дээш төсөвт өртөгтэй	1,941	10.9	23.4	90.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайлан

Худалдан авах ажиллагаанд дахь хүний оролцоог бууруулах замаар тендер шалгаруулалт амжилтгүй болсон хувийг 2024 онд 53.0 байгааг 2030 онд 10.0 хувьд хүргэхээр зорьж байна. Үүний тулд ил тод байдлыг нэмэгдүүлж тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдолд үндэслэлтэй гомдлын эзлэх хэмжээг 2024 онд 80.6 хувь байгааг 2030 онд 40.0 хувьд хүргэнэ.

Стандарт: Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа нь 1921 оноос хойш улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилго, зорилт, удирдлагын арга хэлбэртэй нягт уялдаа холбоотой төдийгүй тодорхой үе шатуудыг дамжин хөгжиж иржээ. Монгол Улсын үндэсний стандартчилал нь хөгжлийнхөө үе шат болгонд тодорхой зорилтыг шийдвэрлэж, улс орны худалдаа, эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Хэмжилзүй нь худалдаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, холбоо, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах салбарын хэмжээнд хурдацтайгаар үүсэн хөгжиж, аливаа үзэгдэл, үйл ажиллагаа, түүний үр дүнгийн тоо болон чанарын үзүүлэлтийг үнэлж дүгнэхэд чухал хэрэглүүр болж байна. Улсын стандартчиллын бодлогыг 1976-1988 онд хэрэгжүүлж, хөгжүүлэх үе шатанд, ялангуяа 1980-аад он хүртэл эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнийг стандартчиллын норматив-техникийн баримт бичгээр бүрэн хангах зорилттой ажилласны үр дүнд 1988 онд нийт бүтээгдэхүүний 98.0 хувийг стандартчилсан байна.

Зах зээлд шилжиж буй 1990-ээд оноос бүтээгдэхүүний нэр төрөл, гарал үүсэл эрс олширч, бүтээгдэхүүний чанар, хэрэглээний аюулгүй байдлыг хангах явдал нэн тулгамдсан зорилт болсон. Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар нь стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын чиглэлээр орон нутгийн 21 салбар, хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Салбарын тулгамдсан асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлж, дараах үйл ажиллагааны чиглэлээр сайжруулах хэрэгцээ шаардлага байна. Үүнд:

- ✓ Салбарын хэмжээний санхүү, эдийн засгийн боломж болон материаллаг бааз хязгаарлагдмал;
- ✓ Төсвийн хөрөнгө бага байдлаас болж хүний нөөцийг чадавхжуулах асуудал орхигдсон;
- ✓ Салбарын мэдээллийн нэгдсэн цахим системийг үе шаттай нэвтрүүлэхэд төсөв санхүүжилт хангалтгүй;
- ✓ Санхүүжилт байхгүйн улмаас хэмжил зүйн лаборатори шинээр байгуулагдаагүй бөгөөд сорилт шинжилгээний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийгдээгүй;
- ✓ Олон улсын түвшинд хүрсэн стандартын тоо хэмжээ хангалтгүй бөгөөд стандартын шинжлэх ухаан, техникийн түвшнийг нэмэгдүүлэх шаардлагатай;
- ✓ Лабораториудын хүчин чадал хангалтгүй бөгөөд сорилтын дүнг үндэслэж тохирлын үнэлгээ хийх боломж хязгаарлагдмал;
- ✓ Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн олон улсын төсөл, хөтөлбөр хангалтгүй;

- ✓ Стандартчиллын бүрэн цахимжуулалт болон хэмжил зүйн үйлчилгээний цахимжуулалтын ажил хангалтгүй;
- ✓ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн үйл ажиллагааны чиглэлд хүний нөөцийн хомсдолтой, мэргэшсэн боловсон хүчин дутмаг бөгөөд тогтвортой ажиллах байдал алдагдсан.

Лаборатори, туршилтын чадавхыг өргөжүүлэх замаар бүтээгдэхүүн, үйлчилгээнд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлж заавал баталгаажуулалтад хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хувийг 2024 онд 53.4 байгааг 2030 онд 78.0 болгож нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний тулд хэрэглэгчийн оролцоог хангаж олон улс, бүс нутгийн стандартад нийцүүлэн баталсан үндэсний стандартын эзлэх хувь 2024 онд 44.7 байгааг 2030 онд 50.0 хувьд хүргэнэ. Мөн дэвшилтэт технологи нэвтрүүлж нормчилсон хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт 2024 онд 67.0 хувь байгааг 95.0 хувьд хүргэнэ. Шинэ төрлийн хэмжилтийн хэрэгсэл, стандарт хэмжүүр нэвтрүүлж олон улсын жишигт хүрсэн хэмжлийн нэр төрлийг 5-аар нэмэгдүүлж 2030 онд 16-д хүргэнэ.

3.7.2 Инфляц


Инфляц 2024 онд дунджаар 6.8 хувь, оны эцэст 9 хувь байна. Инфляц оны эхний хагаст буурах хандлагатай, төв банкны зорилтот интервалд байсан бол 2024 оны гуравдугаар дугаар улирлаас эхлэн эрчимжсэн байна.

Эдийн засгийн идэвхжилээс үүдэлтэйгээр эрэлтийн гаралтай инфляц өсөхийн зэрэгцээ импортын бараа болон үйлчилгээний үнийн өсөлт 2024 оны сүүлд эрчимжсэн байна. Тухайлбал, импортын барааны инфляц 2024 оны 12 дугаар сард 5.7 хувь гарч, нийт инфляцын 29.1 хувийг бүрдүүллээ. Импортын барааны инфляцын 92 гаруй хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна.

Дотоодын бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өсөж, нийт инфляцын 70.9 хувийг бүрдүүлсэн байна. Дотоодын инфляцад хүнс болон үйлчилгээний үнийн өсөлт голчлон нөлөөлж байна. Тухайлбал, 2024 оны 12 дугаар сард үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өсөж, инфляцад 3.4 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Үйлчилгээний үнийн өсөлт эрчимжихэд цахилгааны төлбөр, нийтийн хоолны үйлчилгээний үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

Хүнсний барааны инфляц 2024 оны эцсийн байдлаар 8.9 хувьд хүрч, нийт инфляцын 2.5 нэгж хувийг эзэлж байна. Үүнд мах, махан бүтээгдэхүүний үнэ 17.1 хувиар, талх, нарийн боовны үнэ 9.4 хувиар өссөн нь голлох нөлөөтэй байв. Харин хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 2024 оны 12 дугаар сард 8.7 хувьд хүрсэн байна. Хүнсний бус инфляц оны эцэст эрчимжихэд орон сууцны бодит түрээсийн үнэ 40.9 хувиар, цахилгааны төлбөр 77.9 хувиар болон суудлын автомашины үнэ 6.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. (График 48-д харуулав.)

График 48. Инфляцын бүрэлдэхүүн (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тодорхой бус байдал, эдийн засгийн эрсдэлийг харгалзан үзэж мөнгөний бодлогыг хэрэгжүүлж ажиллаж байна. Инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрт үндэслэн мөнгөний бодлогын шийдвэр гаргахаас гадна макро эдийн засагт учирч болзошгүй хүндрэл, шокуудыг шийдвэр гаргалтдаа харгалзан үзнэ.

Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, аянуудыг эцсийн үр дүнд чиглүүлж инфляцын түвшнийг 2024 онд 9.0 хувь байгааг 2023 онд 5.0 хувь болгож зорилтот интервалд тогтворжуулахаар зорьж байна. Үүний тулд оновчтой мөнгөний бодлого хэрэгжүүлж эрэлтийн гаралтай инфляц 2024 онд 8.2 хувь байгааг 2030 онд 5.0 хувьд хязгаарлана. Худалдааны сүлжээ, тээвэр логикийг сайжруулж нийлүүлэлтийн шалтгаантай инфляц 2024 онд 8.6 хувь байгааг 2030 онд 5.0 хувьд хязгаарлана. Мөн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж хүнсний барааны үнийн өсөлт 2024 онд 8.9 хувь байгааг 2030 онд 6.0 хувьд хязгаарлана. Боомт, тээвэр, логикийн өртгийг бууруулж импортын барааны үнийн өсөлтийг 2030 онд 4.0 хувьд хязгаарлана.

3.7.3 Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөг, ДНБ-д харьцуулсан харьцаа 41.8 хувьтай тэнцэж байна.

Засгийн газрын нийт өрийн 90.6 хувийг гадаад өр бүрдүүлж байна. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2024 оны эцсийн байдлаар 30.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 22.9 тэрбум төгрөг буюу 0.1 хувиар буурсан байна. Нийт гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2025 онд 391.8 сая ам.доллар, 2026 онд 978 сая ам.доллар, 2027 онд 918.5 сая ам.доллар, 2028 онд хамгийн өндөр буюу 1,078.5 сая ам.долларын өрийн төлбөр хүлээгдэж байгаа бол 2029 оноос ачаалал буурч, гадаад өрийн эргэн төлөлт 760.4 сая ам.доллар болж буурахаар байна. Засгийн газрын гадаад өрийн дарамт 2021 оноос тогтвортой буурч ирсэн боловч 2026 оноос өсөх төлөвтэй байгаа тул цаашид валютын нөөцөө нэмэгдүүлэх, ханшийн хэлбэлзлээс үүдэлтэй эрсдэлийг бууруулах, гадаад зээлийг эдийн засгийн үр өгөөжтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэх нь чухал байна.

Засгийн газар 2017 оны аравдугаар сараас хойш дотоод зах зээлд нээлттэй хэлбэрээр дотоод үнэт цаас арилжаалаагүй тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 48.5 дахин буурч 2024 оны гуравдугаар улиралд 96.8 тэрбум төгрөгт хүрээд байв. Засгийн газрын зүгээс 2024 оны 11 дүгээр сард 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын санд 300 тэрбум төгрөгийн

үнэт цаас арилжаалснаар 2024 оны эцэст Засгийн газрын дотоод өрийн үлдэгдэл 400.5 тэрбум төгрөгт хүрээд байна.

Цаашид Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт болон үндсэн тэнцлийн алдагдал голлох үүрэг гүйцэтгэхээр байна. Иймд цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үр ашиггүй төсвийн зардлыг танаж төсвийн нийт зардлын ДНБ-д эзлэх хувь 2024 онд 37.9 байгааг 2030 онд 26.0 болгож бууруулна. Мөн төрийн албанд чиг үүргийн шинжилгээ хийж төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг 2024 онд 27.5 байгааг 2030 онд 22.0 хувьд хүргэнэ.

3.7.4 Гадаад худалдаа

Монгол Улс 2024 онд нийт 164 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 27.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 12.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт 2024 онд 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 3.9 хувиар өслөө. Өсөлтөд зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн, алтны дэлхийн зах зээл дэх үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөллөө.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 5.6 хувиар өссөн байна. Хилийн голлох боомтуудын тээвэр зохион байгуулалт сайжирч, ажиллах цагийн хуваарь уртассанаар нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрч, өмнөх оноос 20 хувиар нэмэгдлээ. Оюу толгойн далд уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмалын экспорт 2024 онд 1,695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11 хувиар, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 7,511 мянган тоннд хүрч, өмнөх оноос 31 хувиар тус тус өслөө.

Харин уул уурхайн бус экспорт 1.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 13.9 хувиар буурлаа. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 493 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 33.6 хувиар буурсан байна. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлж, 2024 оны эцсийн байдлаар малын махны экспорт 14 хувиар, ноолуурын

Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, дотоод идэвхжил өндөр байснаар бараа, бүтээгдэхүүний импорт 2024 онд 11.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллараар буюу 26 хувиар өслөө. Худалдааны гол түнш орнуудад үнийн өсөлт саарсан нь импортын барааны үнийн өсөлт бага түвшинд хадгалагдахад нөлөөлөв.

Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт өсөлтийн 11.6 нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик, тоног төхөөрөмж, барилгын материал, 10.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 3.3 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна. (График 48-д харуулав)

График 49. Монгол Улсын гадаад худалдааны үндсэн үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад худалдааг хөнгөвчлөх:

Манай хөрш хоёр улс нь гадаад худалдааны нийт бараа эргэлтэд өндөр жин эзэлдэг бөгөөд 2024 онд БНХАУ-тай 19.1 тэрбум ам.доллар, ОХУ-тай 2.9 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. БНХАУ болон ОХУ-тай 2024 онд хийсэн худалдаа манай улсын нийт бараа эргэлтийн 80.4 хувийг эзэлж байна. (Хүснэгт 96-д харуулав)

Хүснэгт 96. Гадаад худалдаа гол түнш улс орнууд, 2024 он

Улс	Нийт эргэлт	Экспорт	Импорт	Тэнцэл
сая ам.доллар				
Нийт	27,398.0	15,783.4	11,614.7	4,168.7
БНХАУ	19,093.2	14,420.7	4,672.5	9,748.2
ОХУ	2,925.5	100.7	2,824.8	-2,724.1
Япон	1,187.6	12.6	1,175.0	-1,162.5
Швейцар	777.7	745	32.7	712.3
АНУ	701.6	166.4	535.2	-368.8
БНСУ	534.9	52.6	482.3	-429.8
ХБНГУ	262.3	7.2	255.1	-247.9
Бусад	1,915.4	278.3	1,637.1	-1,358.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 онд БНХАУ-тай 9.7 тэрбум ам.доллар, Швейцар Улстай 712.3 сая ам.долларын ашигтай худалдаа хийсэн бол ОХУ-тай 2.7 тэрбум ам.доллар, Япон Улстай 1.2 тэрбум ам.доллар, бусад улстай 2.4 тэрбум ам.долларын алдагдалтай худалдааг хийж нийт тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.

Сүүлийн жилүүдэд гадаад худалдааны баланс эерэг гарсаар байгаа ч экспортын барааны 90.0 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүн болох чулуун нүүрс, зэсийн баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайрын хүдэр болон боловсруулаагүй нефть бүтээгдэхүүн эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүн давамгайлж, боловсруулах үйлдвэрлэл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспорт харьцангуй бага, гадаад зах зээлийн хэрэгцээ, стандарт, хэрэглэгчийн зан төлөвийн талаарх мэдээлэл экспортлогчдод хангалтгүй, Монголын бүтээгдэхүүнүүд олон улсын зах зээлд танигдсан байдал бага, брэндийн өрсөлдөх чадвар сул байна. (Хүснэгт 97-д харуулав)

Хүснэгт 97. Монгол Улсын хил дамнасан худалдаанд зарцуулах хугацаа, зардал, 2020 он

Үзүүлэлт		Монгол 143/190	
		Үнэлгээ	Оноо
Экспорт	Хилийн зохицуулалтын шаардлага биелүүлэх хугацаа	134 цаг	16.4
	Хилийн зохицуулалтын шаардлага биелүүлэх зардал	225 ам.доллар	78.8
	Баримт бичгийн шаардлага хангах хугацаа	168 цаг	1.2

	Баримт бичгийн шаардлага хангах зардал	64 ам.доллар	84.0
Импорт	Хилийн зохицуулалтын шаардлага биелүүлэх хугацаа	48 цаг	83.2
	Хилийн зохицуулалтын шаардлага биелүүлэх зардал	210 ам.доллар	82.5
	Баримт бичгийн шаардлага хангах хугацаа	115 цаг	52.4
	Баримт бичгийн шаардлага хангах зардал	83 ам.доллар	88.2

Эх сурвалж: Дэлхийн банк, *doing business*

Гадаад худалдаанд экспортын бичиг баримт бүрдүүлэхэд 168 цаг, 64.0 ам.доллар, хилийн зохицуулалтад 134 цаг, 225.0 ам.доллар зарцуулж Монгол Улс 190 орноос 143-д жагсаж байна. Гадаад худалдаанд импортын бичиг баримт бүрдүүлэхэд 115 цаг, 83 ам.доллар, хилийн зохицуулалтад 48 цаг, 210 ам.доллар зарцуулж байна.

Гаалийн болон хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа удаан, тээвэр логистикийн зардал өндөр, төрийн гадаад худалдааны үйлчилгээний нэгдсэн системгүй явж ирлээ. Экспортын барааны нэр төрлийг төрөлжүүлэхийн тулд гадаад худалдааны экспортын үйл ажиллагаанд учирч буй саад тотгорыг бууруулах, төрийн үйлчилгээг нэгдсэн нэг мэдээллийн системээр үзүүлж, үндэсний үйлдвэрлэгчдийн барааг гадаад зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Хилээр нэвтрэх дундаж хугацаа 2020 оноос хойш сайжирсан боловч худалдаа эрхлэгчдэд зориулсан төрийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем нэвтрээгүй. "Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр"-ийн 10 дугаар зүйлд Монгол Улс нь худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд төрийн үйлчилгээг "нэг цонхны систем"-ээр үзүүлэх талаар Дэлхийн худалдааны байгууллагын өмнө үүрэг хүлээсэн. Үүрэг амлалтыг 2025 онд хэрэгжүүлж дууссан байх шаардлагатай. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 сарын 21-ний өдрийн 41 дүгээр захирамжаар "Экспортыг нэмэгдүүлж, худалдааг дэмжих" ажлын хэсэг, Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих ажлын дэд хэсгүүд байгуулагдаж экспортын зөвшөөрлийн системийн шинэчлэл, хялбаршуулах, хөрөнгө оруулах, бизнес эрхлэх орчныг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Худалдааны тариф, тарифын бус саад тотгорыг бууруулах замаар гадаад худалдааг хөнгөвчилж гадаад худалдааны хөнгөвчилсөн байдлын үзүүлэлтийг 2023 онд 50.5 байгааг 2029 онд 73.0 болгож нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний тулд экспортын барааны гаалийн бүрдүүлэлттэй холбоотой үйл ажиллагааг цахимжуулаж экспортын бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа 2024 онд 302 цаг байгааг 2030 онд 22 цагт хүргэнэ. Мөн чөлөөт худалдаа хэлэлцээрийн тоог 2024 онд 2 байгааг 5-д хүргэнэ.

Гадаадын хөрөнгө оруулалт: Монгол Улсад 1990 оноос 2025 оны I улирал хүртэл нийт 49.0 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал бүртгэгдсэн бөгөөд үүнээс 43.4 хувийг Нидерланд, 13.1 хувийг БНХАУ, 8.3 хувийг Сингапур Улс тус тус бүрдүүлсэн бол үйл ажиллагааны салбарын ангиллаар уул уурхай, олборлолтын салбар 74.0 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 9.9 хувийг тус тус бүрдүүлсэн байна.¹⁰⁶

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 52.0 хувь буюу 17,254.0 сая ам.доллар нь гадаадын хөрөнгө оруулалттай компанийн толгой компаниас авсан зээлээс, 48.0 хувь буюу 16,228.0 сая ам.доллар нь хувь нийлүүлэгчийн дүрмийн сангийн хөрөнгө оруулалтаас бүрдсэн бөгөөд улсаар нь ангилбал Нидерланд 42.0 хувь (14,227 сая ам.доллар), БНХАУ 16.0 хувь (5,443 сая ам.доллар), Сингапур 9.0 хувь (2,956 сая ам.доллар), Их Британи 7.0 хувь (2,351 сая ам.доллар), Хонг-Конг 4.0 хувь (1,441 сая ам.доллар) тус тус эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 2025 оны I улирлын байдлаар 665.0 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 240.0 сая ам.доллар байснаар цэвэр дүнгээр 425.0 сая

¹⁰⁶ Хөрөнгө оруулалт худалдааны газрын нөхцөл байдлын дүн шинжилгээ

ам.долларын орох урсгал бүртгэгдэж, энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 34.0 хувь буюу 342.0 сая ам.доллараар буурсан байна. Цэвэр урсгалын хувьд Нидерландын хөрөнгө оруулалт 100.0 сая ам.доллараар өсөж 291.0 сая ам.долларт, Хонг-Конгийн хөрөнгө оруулалт 25.0 сая ам.доллараар өсөж 31.0 сая ам.долларт хүрсэн, Их Британийн хөрөнгө оруулалт 228.0 сая ам.доллараар буурч 30.0 сая ам.доллар, Люксембургийн хөрөнгө оруулалт 7.0 сая ам.доллараар буурч 5.0 сая ам.долларын түвшинд байна.¹⁰⁷ (Хүснэгт 98-д харуулав.)

Хүснэгт 98. Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, хөрөнгө оруулагч улс, сая ам.доллар

Улс	2022	2023	2024	2025-I	1990-2025-I	1990-2025-I (%)
Нийт	3,417.8	3,533.3	4,180.2	665.5	48,953.9	100.0
Канад	111.0	54.2	18.5	1.2	1,059.0	2.2
АНУ	91.9	97.1	157.3	23.0	2,023.4	4.1
БНХАУ	193.7	180.0	235.9	59.1	6,396.9	13.1
Сингапур	215.9	500.2	894.4	58.0	4,041.0	8.3
Япон	75.8	108.1	153.3	38.4	1,720.5	3.5
Швейцарь	0.1	1.8	4.9	0.1	189.2	0.4
Их Британи	171.6	871.3	940.5	37.8	2,777.9	5.7
Герман	2.6	39.7	17.3	8.0	342.0	0.7
Итали	0.8	0.3	2.0	0.3	80.7	0.2
Люксембург	85.2	67.1	54.6	7.0	3,207.8	6.6
Франц	9.0	10.1	11.6	4.0	250.6	0.5
ОХУ	10.9	27.0	38.3	7.0	362.0	0.7
Шинэ Зеланд	0.0	0.0	0.1	0.0	33.2	0.1
БНСУ	12.8	57.2	30.5	2.9	694.6	1.4
Австрали	24.0	22.7	17.9	0.9	1,022.2	2.1
Нидерланд	2,263.5	1,353.0	1,449.0	357.3	21,250.5	43.4
Моноко	0.0	0.0	0.0	0.0	6.3	0.0
Катар	0.0	0.3	0.2	0.0	16.0	0.0
Турк	0.9	0.8	0.9	0.3	26.5	0.1
Белги	38.7	49.7	46.1	2.1	354.7	0.7
Филиппин	0.1	0.2	0.4	0.0	14.3	0.0
Чех	5.1	3.7	1.1	0.1	25.6	0.1
Камбож	0.4	2.6	1.8	0.1	5.6	0.0
Малайз	1.0	2.2	0.8	0.2	59.3	0.1
Ирланд	0.0	0.1	0.2	0.3	8.0	0.0
Киргиз	0.0	0.3	0.0	0.1	1.0	0.0
Армен	0.0	0.0	0.0	0.0	1.2	0.0
Узбекистан	0.0	0.0	0.0	0.0	1.9	0.0

¹⁰⁷ Хөрөнгө оруулалт худалдааны газрын нөхцөл байдлын дүн шинжилгээ

Финлянд	0.0	0.1	0.1	0.0	1.3	0.0
Украин	0.0	0.0	0.0	0.0	7.8	0.0
Бусад	102.7	83.6	102.9	57.5	45,980.9	6.1

Эх сурвалж: Хөрөнгө оруулалт худалдааны газар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал, уул уурхайн салбар 495.0 сая ам.доллар, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 61.0 сая ам.доллар, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар 45.0 сая ам.доллар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 26.0 сая ам.доллар, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 4.0 сая ам.доллар, бусад салбарууд нийт 33.0 сая ам.долларын орох урсгалтай байна.¹⁰⁸ (Хүснэгт 99-д харуулав)

Хүснэгт 99. Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, сая ам.доллар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2022	2023	2024	2025-I	1990-2025-I	1990-2025-I (хувиар)
Нийт	3,417.8	3,533.3	4,180.2	665.5	48,953.9	100.0
Барилга	63.6	19.2	15.2	2.3	998.0	2.0
Боловсрол	0.2	0.8	0.3	0.4	11.5	0.0
Боловсруулах үйлдвэрлэл	8.2	4.1	20.5	2.8	542.7	1.1
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	149.4	246.6	204.6	61.3	4,835.3	9.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.0	2.4	0.9	0.0	469.8	1.0
Мэдээлэл, холбоо	15.6	28.3	36.9	8.2	282.1	0.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	32.6	217.4	235.8	45.3	816.3	1.7
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2.1	1.2	6.1	1.9	30.4	0.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	116.1	133.5	122.3	26.4	1,852.3	3.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	19.9	40.2	34.8	4.2	307.4	0.6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	157.4	50.6	23.8	10.7	596.8	1.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.0	0.1	2.2	0.0	9.9	0.0
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.0	0.0	0.0	0.0	11.2	0.0
Уул уурхай, олборлолт	2,819.0	2,759.4	3,382.0	494.9	36,229.7	74.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	13.5	2.9	6.4	1.2	1,305.9	2.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	17.4	5.0	3.2	0.3	307.3	0.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.1	1.3	1.0	0.1	129.3	0.3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	0.5	18.9	61.5	5.6	92.6	0.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0.0	0.7	1.8	0.0	42.0	0.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.2	0.0	21.0	0.0	81.4	0.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.0	0.8	0.0	0.0	2.2	0.0

¹⁰⁸ Хөрөнгө оруулалт худалдааны газрын нөхцөл байдлын дүн шинжилгээ

Олон улсын хөрөнгө оруулагчид болон холбогдох талуудтай ногоон эрчим хүчийг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд сэргээгдэх эрчим хүчний арвин баялаг нөөцийг ашиглан экспортын төслүүдийг хэрэгжүүлэх, олон улс, бүс нутаг, хөрш орны түвшинд харилцан ашигтай хамтран ажиллах боломжийг тодорхойлох, тухайлбал сэргээгдэх эрчим хүчээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг БНХАУ-д экспортлох чиглэлийг хамтарч судлах ажлыг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн цэвэр эрчим хүч үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч компани болох Саудын Арабын Хаант Улсад төвтэй “Аква пауэр” компанитай хамтран ажиллах боломжийг бүрдүүлж, хамтын ажиллагааны хүрээнд сэргээгдэх эрчим хүчний экспортын төслүүдийг хэрэгжүүлэх тал дээр нэгдсэн ойлголтод хүрч холбогдох ажлыг эхлүүлсэн.¹⁰⁹

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын харилцааг анх 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулж байсныг 2013 оноос Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулах болсон. Хөрөнгө оруулалтын тухай хууль хэрэгжсэн өнөөдрийг хүртэлх 11 жилийн хугацаанд Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 15 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсны дийлэнх нь бусад хуулийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт орсон ба энэ нь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах асуудалд чиглээгүй нь хууль, эрх зүйн орчны зохицуулалтыг сайжруулах шаардлагыг үүсгэж байна. Хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлүүлэх тогтолцоо нь шуурхай, оновчтой биш байгаа нь хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол, итгэл үнэмшлийг бууруулж байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2024 онд 4 тэрбум төгрөг байгааг 2030 онд 6.6 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлэхээр зорьж байна. Үүний тулд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэсэн байдал 2024 онд 25 хувь байгааг 2030 онд 100 хувьд хүргэнэ.

Чөлөөт бүс: Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” үзэл баримтлалыг 1995 оны 87 дугаар тогтоолоор баталснаар чөлөөт бүс байгуулах үндэс суурийг тодорхойлсон. Улмаар 2002 онд “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хууль, 2003 онд “Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хууль, “Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хуулийг тус тус баталсан.

Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах зорилгоор 2003 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр нийт 359.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсүүд байнгын үйл ажиллагаа явуулж байгаа ч өнгөрсөн хугацаанд хийгдсэн газар олголт нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримтлаагүй, мөн шугам сүлжээний ачааллыг тооцоолоогүй баригдсан барилга байгууламжууд нь дэд бүтэц, шугам сүлжээний хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

Чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлсэн улс орнууд нь далайн боомт болон бусад улстай хил залгаа эдийн засгийн ач холбогдолтой байршилд чөлөөт бүсээ байгуулан тухайн улсын бусад нутаг дэвсгэрийн үл хэрэглэгдэх бизнес орчин, нөхцөл, хөнгөлөлт, чөлөөлөлт урамшуулал бүхий төрийн бодлогоор дэмжин гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, ажлын байрыг

¹⁰⁹ Шадар сайдын Ажлын алба (Гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа эрхэлсэн) нөхцөл байдлын дүн шинжилгээ

нэмэгдүүлэх зэргээр эдийн засгийн олон талын үр ашгийг бий болгодог. Дэлхий нийт харилцан уялдаатай болохын хэрээр дэлхийн худалдаа, эдийн засгийн өсөлт, хөгжилд чухал ач холбогдолтой болж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд худалдааны саад тотгорыг багасгаж, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн ач тусыг хүлээн зөвшөөрч, чөлөөт бүс байгуулах хандлага эрчимжиж байна.

Технологийн дэвшил, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, бизнесийн орчин өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор дэлхийн худалдааны үйл явцад томоохон өөрчлөлт гарч чөлөөт бүсүүд нь үйлдвэрлэл, агуулах, түгээлтийн иж бүрэн төв болж олон улсын худалдааг хөнгөвчлөх татвар, гаалийн зохицуулалт бүхий таатай орчныг бүрдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Улсын Их Хурлын “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” 2022 оны 10 дугаар тогтоолоор “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг түшиглэн “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийг байгуулж, 2024 оны 6 сард “Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “Эдийн засгийн чөлөөт бүс” байгуулахаар заасан. Улмаар Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ Зуунмод хот (Хүннү хот)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, Улаанбаатарын бүсийн хөгжлийг шинэ шатанд гаргахуйц олон улсын нисэх буудлын ашиглалтыг сайжруулах, Хүннү хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор экспортын баримжаатай, өндөр технологийн үйлдвэрлэл бүхий Хөшигийн Хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэхээр тодорхойлсон. Цаашид чөлөөт бүсүүдийн хөгжлийн стратеги, бизнес загварыг тодорхойлох, орчин үеийн дэвшилтэт технологи, олон улсын бизнесийн орчин нөхцөлийг бүрдүүлэх нийлүүлэлтийн сүлжээний менежментийг нэвтрүүлэх шаардлагатай.

Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалыг 1995 онд баталснаас хойш Засгийн газраас чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх зорилтын хүрээнд холбогдох бодлогын арга хэмжээ авч ирсэн боловч өнөөг хүртэл чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажил удаашралтай, үйл ажиллагаа жигдрээгүй байна. Энэ нь улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан бодлогын залгамж алдагдаж хөгжлийн боломжийг хязгаарласантай холбоотой. Олон улсын туршлагаас авч үзвэл улс орнууд чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаанд аль болох төрийн оролцоог багасгаж, үр ашигтай байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилтийг хангахдаа чөлөөт бүсийн үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, чөлөөт бүсүүдийн төлөвлөлт бүтээн байгуулалтын ажилд хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлийг хангуулах, чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд туссан зарим төсөл арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Чөлөөт бүсүүдэд нэвтрэх барааг хэрхэн тээвэрлэж, түргэн шуурхай ачих, буулгах, хадгалах, тээвэр-логистик, төлбөр тооцоог гүйцэтгэх мөнгөн тэмдэгт, банк санхүүгийн байгууллагыг хэрхэн байгуулах асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байна. Мөн Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатны дагуу шаардлагатай хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах замаар чөлөөт бүсүүдийн худалдааны эргэлтийг нэмэгдүүлж чөлөөт бүс дэх бараа эргэлтийн хэмжээг 2024 онд 165.8 тэрбум төгрөг байгааг 2030 онд 320 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлэхээр зорьж

байна. Үүний тулд чөлөөт бүс дэх аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж чөлөөт бүсэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоог 2024 онд 50 байгааг 2030 онд 250 хүргэнэ.

3.8 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ХИЙМЭЛ ОЮУН

Өнөө үед дэлхийн ихэнх улс орон шинжлэх ухаан, технологи, инновацад суурилсан эдийн засгийг хөгжлийн гол тулгуур гэж үзэж онцгойлон анхаарч байна.

Нийгэм, эдийн засгийн хөгжил маш хурдацтай урагшилж байгаа өнөө үед мэдлэгийг шуурхай ашиглах дадал, чадвар болон өндөр мэргэшил нь баялгийг бий болгох, тухайн хувь хүн болон байгууллагын нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох хамгийн гол нөөц, хүчин зүйл болж байгаа ч манай улсын шинжлэх ухаан, технологийн салбарын дэлхийн болон бүс нутгийн инновацын үйл явц, үндэсний эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр хангалтгүй хэвээр байна.

Монгол Улсын экспортод гаргаж буй бүтээгдэхүүний технологийн агууламжийн түвшнийг авч үзвэл түүхий эдийн нөөцийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник технологийн түвшин хангалтгүй, эдийн засгийн чадавх сул байгаагаас технологийн агууламжгүй бүтээгдэхүүн, нам технологийн бүтээгдэхүүн экспортын бүтээгдэхүүний дийлэнх хувийг эзэлж байна. (Хүснэгт 100-д харуулав)


Хүснэгт 100. Экспортын бүтэц (технологийн агууламжийн хувиар)

Үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023	2024
Технологийн багтаамжгүй болон нам технологит бүтээгдэхүүн	87.0	86.5	84.1	87.2	87.2
Дундаж нам технологит бүтээгдэхүүн	0.9	0.88	0.88	0.88	0.88
Дундаж өндөр технологит бүтээгдэхүүн	0.8	0.8	0.8	0.8	0.8
Өндөр технологит бүтээгдэхүүн	0.02	0.02	0.04	0.03	0.03
Нийт экспорт	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл

Манай улсын ДНБ-д дунд болон өндөр технологийн үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь 6.6 хувь байгаа нь дэлхийн дунджаас ойролцоогоор 7 дахин бага байна. (График 49-д ДНБ-д хэмжээг харуулав.)

График 50. ДНБ-д дунд болон өндөр технологийн үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэ нь ажиллах хүч, зах зээл хязгаарлагдмал орны хувьд эдийн засгийн өсөлтийг хангах, хүн амын амьдралын түвшин, чанарыг сайжруулахдаа шинжлэх ухаан, технологи, инновацыг түлхүү хөгжүүлж, түүний ололтод тулгуурлан олон улсын зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, экспортын чиг баримжаа бүхий, мэдлэг шингэсэн, шинжлэх ухааны багтаамж ихтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж эдийн засгийн бүтцээ түүхий эдээс хамаарал багатай, өндөр технологи, мэдлэг шингэсэн салбар руу шилжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Шинжлэх ухаан, технологийн удирдлага, тогтолцоо: Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Улсын Их Хурал, Засгийн газар, Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хороо, Шинжлэх

ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны академи, яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл, аймаг, нийслэлийн шинжлэх ухаан, технологи, инновацын дэд зөвлөл, эрдэм шинжилгээний байгууллагын өөрийн удирдлагын байгууллагаас бүрдэж байна.

Зураг 4. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо



Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Патентын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам, Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам, Эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журам зэрэг 20 орчим хууль тогтоомж, дүрэм, журам үйлчилж байна.

Шинжлэх ухааны байгууллага, хүний нөөц: Шинжлэх ухааны салбарт нийт 66 эрдэм шинжилгээний байгууллага байгаагаас 17 нь яам, агентлагийн харьяанд, 16 нь Шинжлэх ухааны академийн харьяанд, 30 нь эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага болон тэдгээрийн харьяа хүрээлэнгүүд, 3 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хэлбэрээр шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагаа эрхэлж байна.

Эдгээр байгууллагад нийт 7004 ажилтан ажиллаж байгаагаас 4569 нь үндсэн ажилтан (бүтэн цагаар ажилласан), үүний 1754 нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Нийт судлаачдын дотор 3053 (55.4%) нь эрдмийн зэрэг цолтой буюу академич 64, шинжлэх ухааны доктор 108, боловсролын доктор 1840, профессор 372, дэд профессор 669 байна. (Хүснэгт 101-д салбарын хүний нөөцийг харуулав)

Хүснэгт 101. Шинжлэх ухаан, технологийн хүний нөөц


дд	Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
1	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагын тоо	68	71	63	63	66
2	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагын тоо	35	35	35	35	36
2	Нийт ажиллагчид /эрдэм шинжилгээний байгууллага их, дээд сургууль/	6926	7,072	6,880	6,965	7,004

3	Нийт судлаачид /эрдэм шинжилгээний байгууллага их, дээд сургууль/	5033	5,085	5,224	5,266	5,501
4	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй ажилтан	2263	1,970	1,815	1,736	2,402
5	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан	1635	1,349	1,488	1,243	1,754

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл

Монгол Улс 1 сая хүнд ногдох эрдэм шинжилгээний ажилтны тоогоор Азийн дунджаас 3 дахин, цөөн хүн амтай Финлянд улсаас 14 дахин доогуур үзүүлэлттэй байгаа нь шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөц хангалтгүй байгааг харуулж байна.

График 51. Нэг сая хүн амд ногдох эрдэм шинжилгээний ажилтны тоо /2024 оны байдлаар/



Эх сурвалж: 2024 оны статистик мэдээ. UNESCO

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор эрдэм шинжилгээний ажилтны цалингийн доод хэмжээг 1,100,000.0 төгрөг байхаар тогтоосон нь улсын дунджаас 1.75 дахин доогуур байгаа нь судлаачдын нийгмийн баталгаа бүрэн хангагдаагүйг нотолж байна.

Эрдэм шинжилгээний ажилтны цалин хөлс инфляцын түвшинтэй уялдахгүй, нийгмийн баталгаа хангалтгүй байгаагаас салбарын мэргэшсэн хүний нөөц, ялангуяа залуу судлаачид өндөр цалинтай өөр ажилд шилжих, гадаадад гарч ажиллах үзэгдэл сүүлийн жилүүдэд эрчимжиж, энэ нь судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмж, салбарын нийт бүтээмжид сөрөг нөлөө үзүүлж боловсон хүчний дутагдалд орох эрсдэлийг бий болгоод байна.

Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, хөрөнгө оруулалт: Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт 2025 онд 105.33 тэрбум төгрөг батлагдсанаас 67.3 хувь буюу 70.9 тэрбум төгрөг нь урсгал зардал, 5.0 хувь буюу 5.3 тэрбум төгрөгийг эрдэм шинжилгээний ажлын зардалд зарцуулж байгаа нь ДНБ-ий 0.11 хувийг эзэлж байна. (Хүснэгт 102-т харуулав)

Хүснэгт 102. Шинжлэх ухааны салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт /2025 оны үзүүлэлт батлагдсан дүнгээр/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025*
Шинжлэх ухааны салбарын нийт зардал, тэрбум төгрөг	47.23	65.22	71.02	103.78	98.97	105.33
Урсгал зардал, тэрбум төгрөг	39.42	35.85	42.48	65.72	57.94	70.89
ЭША-ын зардал, тэрбум төгрөг	3.06	5.72	11.77	10.7	13.53	5.29
Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	5.0	24.0	19.08	27.60	27.5	29.15
ДНБ-д эзлэх хувь	0.13	0.15	0.13	0.14	0.12	0.11

Эх сурвалж: 2020-2024 он Боловсролын яам, 2025 он Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дүн мэдээнээс

Сүүлийн арваад жилд эрдэм шинжилгээний ажлын зардал тогтмол 12.0 тэрбум орчим төгрөг буюу огт нэмэгдээгүй байгаа ба энэ нь 1 судалгаанд дунджаар 14.8-19 сая төгрөгийг зарцуулдаг гэсэн тооцоо гарч байна. Энэхүү байдал нь судалгааны

чанар, хүртээмж хангалтгүй байх үндсэн шалтгаан болж байна. (График 51-д салбарын санхүүжилтийг харуулав)

График 52. Шинжлэх ухааны салбарын санхүүжилт /тэрбум төгрөг/, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: 2020-2024 он Боловсролын яам, 2025 он Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дүн мэдээнээс

Сүүлийн 30 гаруй жил шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт туйлын хангалтгүй, 2024 оны байдлаар шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь дэлхийн дунджаас 15-20 дахин бага үзүүлэлттэй байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарт сүүлийн 5 жилд хийсэн хамгийн томоохон хөрөнгө оруулалт бол “Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор”-ын бүтээн байгуулалтын ажил бөгөөд тус цогцолбор нь нийт 4.8 га, 74300 кв.м ашиглалтын талбайтай олон улсын стандартад нийцсэн лаборатори, оффис, музей, спорт заал бүхий шинжлэх ухаан, инновац, технологи, танин мэдэхүйн цогцолбор, 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах судалгааны орчин үеийн жишиг байгууламж юм. Цогцолборын барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлж, тухайн онд 3.0 тэрбум төгрөг, 2021 онд 22.1 тэрбум төгрөг, 2022 онд 20.0 тэрбум, 2023 онд 24.5 тэрбум, 2024 онд 23.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэснээр, лабораторийн 3 байгууламж нь 2025 оны эхний хагас жилд бүрэн ашиглалтад орсон ба оффисын 2 барилгын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна.

Зураг 5. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор



Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг 2020 оноос барьж эхэлсэнтэй холбоотойгоор салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ жилд 5-24 тэрбум төгрөг болж нэмэгдсэн боловч судалгааны ажилд амин чухал шаардлагатай лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл сүүлийн 30 жилд бараг хийгдээгүй. Иймд хүрээлэнгүүдийн багаж тоног төхөөрөмжийн 80 гаруй хувь нь 1990 оноос өмнө ашиглаж байсан багаж, тоног төхөөрөмж байгаа учраас ашиглан хийсэн судалгааны үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүл хүлээн зөвшөөрөхгүй нөхцөл байдал үүсээд байна.


2022 онд хийсэн лабораторийн тооллого судалгаанаас үзэхэд 311 лаборатори байгаагийн 24 нь магадлан итгэмжлэгдсэн лаборатори байна. Лабораторийн 65 хувь нь (тухайлбал, МУИС лазерын лаборатори, ШУТИС-ийн биотехнологийн лаборатори, хүнсний лаборатори зэрэг) сул ашиглалттай байгаа нь лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг ажиллуулах нарийн мэргэжлийн хүний нөөц дутагдалтай холбоотой байна.

Судалгаа хөгжүүлэлтийн үр дүн: Өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд нийт 4244 төсөлд 178.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосны үр дүнд нийт 51572 үр дүнг гаргасан байна. Тухайлбал, шинэ бүтээлийн патент 352, ашигтай загвар 304, бүтээгдэхүүний загвар 700, шинэ технологи 768, үйлдвэрлэлд нэвтэрсэн үр ашиг 723, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах ТЭЗҮ 148, зохиогчийн эрх 166-г тус тус оюуны өмчөөр баталгаажуулсан байна.

Монгол эрдэмтдийн бүтээл дэлхийн түвшинд үнэлэгдэж, гадаадад хэвлүүлсэн бүтээлийн тоо 10 дахин өсөж, жилийн дундаж өсөлт нь 9.0 хувьтай байгаагийн дээр жилд эшлэгдэж буй эшлэлийн тоо нэмэгдсээр байна. Тухайлбал, Монгол Улсаас Скопус (Scopus)-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж буй бүтээлийн тоо 2024 оны 12 сарын байдлаар 10,565-д хүрч, үүнээс 10,000 хүртэлх бүтээл нийт 181,519 удаа эшлэгджээ (h-index=148). Энэ үзүүлэлтээрээ Монгол Улс Азид 21 дүгээр байранд орж байна. Dimensions мэдээллийн сан дахь эшлэлийн тоо 182,630, АНУ-ын Clarivate Analytics компанийн “Web of Science” группийн мэдээллийн санд манай улсаас бүртгэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо 2024 оны 12 дугаар сарын байдлаар 9,083 болсон байна.

Манай эрдэмтэн судлаачид 2024 онд дотоодод 3,573 бүтээл, гадаадад 1,048 бүтээлийг хэвлүүлснээс импакт фактор өндөртэй эрдэм шинжилгээний сэтгүүлд 449 өгүүлэл хэвлүүлж шинээр 77 патент, 49 шинэ технологи, 53 биет бүтээгдэхүүн, 271 зохиогчийн эрхийг баталгаажуулжээ.(График 52-т хэвлүүлсэн бүтээлийн тоог харуулав.)

График 53. Монгол судлаачдын хэвлүүлсэн бүтээлийн тоо



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам, 2024

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг Дэлхийн мэдлэгийн индекс (Global Knowledge Index, UNDP) үзүүлэлтээр Монгол Улс 2020 онд 45.2 оноогоор 138 орноос 70 байранд байсан бол 2024 онд 47.2 оноогоор 141 орноос 65 дугаар байранд оржээ. Дэлхийн дундаж 47.8 байна.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас гаргадаг Дэлхийн инновацын индексээр Монгол Улс 2020 онд 131 орноос 58 дугаар байр, 2023 онд 68 дугаар байранд орж 10 байраар ухарсан байна.

Дэлхийн мэдлэгийн индекс, Инновацын индекс болон шинжлэх ухаан, технологи, инновацын бусад үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн дундаж орчимд байгаа нь манай улсад шинжлэх ухаан, технологи, инновацын бааз суурь бүрэлдэн бий болж, цаашид санхүүгийн болон бусад дэмжлэг, нөхцөлийг бүрдүүлж чадваас инновацыг эрчимжүүлэх боломж байгааг илтгэж байна.

Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа: Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд гадаад хамтын ажиллагаа, хамтарсан төсөл, хөтөлбөрийн үүрэг маш чухал байдаг бөгөөд энэ нь мэдлэг, технологи дамжих гол арга замын нэг юм. Хамтарсан төслийн хүрээнд Монголын судлаачид олон улсын судалгаанд оролцох, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд судалгааны үр дүнгээр өгүүлэл хэвлүүлэхээс гадна судалгааны олон улсын шинэ мэдлэг, технологи, арга зүйд суралцах, харилцан туршлага солилцох, мэдлэг хуваалцах боломж бүрддэгээрээ ач холбогдолтой юм.

Шинжлэх ухаан, технологийн салбарт Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс зэрэг орнуудтай Засгийн газар, төрийн байгууллага хоорондын санамж бичгийн хүрээнд хамтарсан судалгааны төслүүдийг сүүлийн 5 жил тогтвортой хэрэгжүүлж байна.

Эдгээр хамтарсан төслийг байгаль, нийгэм, хүмүүнлэг, анагаах, инженер технологи, хөдөө аж ахуй гэсэн шинжлэх ухааны 6 салбар чиглэлээр хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол Улсын талаас 1 судалгаанд дунджаар 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож байна. (Хүснэгт 103-т харуулав)

Хүснэгт 103. Хамтарсан төслийн мэдээлэл

Он	ОХУ	БНХАУ	ВЬЕТНАМ	БЕЛАРУСЬ	ЯПОН	БНСУ	Бүгд
2001-2019	308	38	-	26	-	8	380
2020	22	6	1	3	2	-	34
2021	0	0	-	4	-	-	4
2022	0	12	-	7	-	-	19
2023	10	10	-	7	-	-	27
2024	12	12	-	6	-	-	30
2025	0	0	0	0	1	-	1
Нийт	352	78	1	53	3	8	495

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам, 2024

Мөн 2024 оны байдлаар Шинжлэх ухааны академи, харьяа эрдэм шинжилгээний 11 хүрээлэн судалгааны үндсэн чиглэлийн хүрээнд Ази-Номхон Далайн Уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны сүлжээ байгууллага (APN), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), ЮНЕСКО-Дэлхийн хөгжиж буй орнуудын эмэгтэй эрдэмтдийн байгууллага (UNESCO-OWSD), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн (НҮББОХ) Тусгай хөтөлбөрийн сан, Австрийн Шинжлэх ухаан, боловсрол, судалгааны яамны Боловсрол, олон улсын харилцааны агентлаг (OeAD), Олон улсын атомын энергийн агентлаг, ХБНГУ-ын Макс Планкийн Гео-антропологийн хүрээлэн, БНСУ-ын Одон орон, сансар судлалын хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн хүрээлэн (KIST) зэрэг олон улсын байгууллагын 44 судалгааны төсөлд шууд оролцож байна.

Нийгэм, эдийн засгийн хөгжил маш хурдацтай урагшилж байгаа өнөө үед мэдлэгийг шуурхай ашиглах дадал, чадвар болон өндөр мэргэшил нь баялгийг бий

болгох, тухайн хувь хүн болон байгууллагын нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох хамгийн гол нөөц, хүчин зүйл болж байгаа хэдий ч манай улсын шинжлэх ухаан, технологийн салбарын дэлхийн болон бүс нутгийн инновацын үйл явц, үндэсний эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр хангалтгүй хэвээр байна.

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд импортын эзлэх хувь дунд, бага орлоготой бусад орныхоос өндөр байгаа нь шинээр бий болгож байгаа нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн харьцангуй бага, үндэсний эдийн засаг гаднын технологиос бүрэн хамааралтай байгааг харуулж байна.

Нийгэм, эдийн засгийн салбаруудын хөгжлийн баримт бичгүүдэд шинжлэх ухаан, технологийн хүчин зүйлийг дутуу тусгасан, "боловсрол-шинжлэх ухаан-үйлдвэрлэл"-ийн хамтын ажиллагааг дэмжсэн эдийн засгийн хөшүүрэг хангалтгүй байна.

Авьяастныг багаас нь нээн хөгжүүлэх, гадаад улсад ажиллаж амьдарч байгаа оюутан, эрдэмтэн судлаач нараа эгүүлэн татах, ашиглах, ахисан түвшний сургалт, хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай.

Бүтэн цагаар ажилладаг эрдэм шинжилгээний ажилтны тоог Ази тивийн дундаж түвшинд ойртуулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээс бус төсвийн бус бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломжийг нээх шаардлагатай байна. Үүний тулд хувийн хэвшлийн шинжлэх ухаан, технологи, инновацад зарцуулах зардал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн дэмжлэгийн хөшүүрэг (гааль, татвар, санхүүгийн арга хэрэгсэл зэрэг)-ийг бүрдүүлэх хэрэгтэй.

Төрийн өмчийн лабораторийн эрхзүйн орчныг боловсронгуй болгож нээлттэй, дундын ашиглалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, лабораторийн ашиглалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх нь чухал гэж үзэж байна.

Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх эрхзүйн орчин харьцангуй сайн бүрдсэн ч шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд төрийн оролцоо хэт давамгайлсан, хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа салбар бүрд жигд бус байна.

Иймд бүх салбарт шинжлэх ухааны оролцоог жигд хангах, тогтолцооны хувьд төрийн бүх шатанд хувийн хэвшлийн түншлэл, төр-хувийн хэвшлийн харилцан уялдааг бэхжүүлэх шаардлагатай байна.

Судалгаа хөгжүүлэлтийн санхүүжилт бага, хүний нөөцийн хүрэлцээ, цалин хөлс, нийгмийн баталгаа хангалтгүй зэрэг хүчин зүйлсээс хамаарч бүх салбарт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээ, үр дүн хязгаарлагдмал, шинжлэх ухааны үр өгөөж, үр нөлөө улс орны хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой байж чадахгүйд хүргэж байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зөвхөн их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хариуцуулж тэдгээрийг улсын төсвөөс санхүүжүүлэх нь үр ашиг багатай болохыг харуулж байна. Иймд томоохон компани, ААН-үүдийн инновацын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлын хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбогдсон хөрөнгө оруулалтыг урамшуулах, эдийн засгийн хөшүүргийг оновчтой ашиглах шаардлагатай байна.

Гадаадтай хамтарсан төсөл хөтөлбөрийг шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, шинэ мэдлэг, технологи нэвтрэх арга зам, төсвийн бус санхүүжилтийн чухал эх үүсвэр хэмээн үзэж бүх талаар дэмжих, нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь салбаруудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шинжлэх ухаан, инновацын оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан-аж үйлдвэр, үйлчилгээний салбарын үр ашигтай хамтын ажиллагааг бий болгох замаар Шинжлэх ухаан, технологи, инновацыг улс орны нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн үндсэн хүчин зүйлийн нэг болгон хөгжүүлэх явдал гэж дүгнэж байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлж ашиглах үйл явцыг эрчимжүүлж дэлхийн инновацын индексийг 28 байраар урагшлуулж 50-р байрт орох ба үүний тулд технологи дамжуулалт, патент оюуны өмчийн ашиглалт, үнэлэмжийг нэмэгдүүлнэ. Мөн шинжлэх ухаан, технологи инновацын салбарт ажиллаж буй судлаачдын бүтээлийн чанарыг сайжруулж ОУ-ын хянан магадлал бүхий мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог 2030 онд 42.6 хувиар өсгөж 1405-д хүргэнэ.

3.8.1. Дижитал эдийн засаг

Цахим засаглал: Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Үндэсний дата төвийн сервер, тоног төхөөрөмжийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн өргөтгөн сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтарсан “mcloud.gov.mn” үүлэн дэд бүтцийг нэвтрүүлсэн. Мөн үндсэн болон дэмжих системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д төрийн 178, хувийн хэвшлийн 481 байгууллага холбогдож, 4.6 тэрбум мэдээллийг амжилттай солилцсон.

Түүнчлэн хамгийн их цаг зарцуулдаг, хүнд сурталтай хэмээн олон жил иргэд шүүмжилж ирсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-г 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж, 2020 онд төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээ, 2021 онд 59 байгууллагын 606 үйлчилгээ, 2022 онд 69 байгууллагын 897 үйлчилгээ, 2023 онд 86 байгууллагын 1,033 үйлчилгээг, 2024 онд 86 байгууллагын 1,250 үйлчилгээг, 2025 онд 87 байгууллагын 1,263 үйлчилгээг уг системд бүртгэлтэй 2.0 сая хэрэглэгчид 85.0 сая удаа дамжуулж, 2020 оноос хойших хугацаанд нийт 1.7 тэрбум төгрөгийн шууд бус хэмнэлт (цаас, цаг хугацаа, унааны зардал)-ийг бий болгосон бөгөөд дараах 6 сувгаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байна (Хүснэгт 104-т харуулав):

- ✓ e-Mongolia (иргэн), e-business.mn (хуулийн этгээд),
- ✓ lavlagaa.e-mongolia.mn (үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд),
- ✓ operator.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ),
- ✓ kiosk.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ),
- ✓ мобайл аппликейшн.

Хүснэгт 104. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр гарсан хэмнэлт /сая төгрөг/

Зардал хэмнэлт	2020	2021	2022	2023	2024	2025	Нийт
Иргэн төрийн үйлчилгээ авахдаа үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу очих, буцах үйл ажиллагаа /унаа/-ны зардал	272.3	7,658.1	18,203.	21,883.4	31,910.8	26,457.8	106,385.3
Иргэн төрийн үйлчилгээ авахдаа зарцуулж байгаа хугацаанаас үүдэлтэй зардал	4,541.5	114,470.8	280,110.6	327,518.4	477,594.4	395,918.4	1,600,155.0
Бичиг цаасны зардал	24.9	591.4	1,287.9	1,548.3	2,257.8	1,872.0	7,582.2
Нийт	4,838.7	122,720.3	299,602.0	350,950.1	511,763.0	424,248.1	1,714,121.7

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

Мөн хөдөө орон нутаг, алслагдсан сум, суурин газар болон хилийн чанадад байгаа ард иргэд, байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2023 онд байгуулж, түүний салбар, харьяа төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэгийг нийслэлд 145, орон нутагт 332, хилийн чанад дахь 31 улсын 47 байршилд, хилийн 1 боомтод тус тус нээж, 43 байгууллагын 471 үйлчилгээг нийт нийт 524 цэгээр дамжуулан 1,2 сая гаруй хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хоёр жил тутам шинэчлэн гаргадаг “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ээр Монгол Улс 2020 онд 193 орноос 92 дугаарт, 2022 онд 74 дүгээрт, 2024 онд 27 байр урагшилж, 46 дугаар байрт орсон ба дараах 3 үзүүлэлтээр гаргадаг. (Хүснэгт 105-д харуулав)

- ✓ Цахим үйлчилгээний индекс (Online Service Index & e-participaion);
- ✓ Харилцаа холбооны дэд бүтцийн индекс(Telecommunication Infrastructure Index);
- ✓ Хүний нөөцийн чадавхын индекс (Human Capital Index).
- ✓

Хүснэгт 105. Цахим засаглалын хөгжлийн индекс

Цахим засаглалын хөгжлийн индекс					
Огноо	2016	2018	2020	2022	2024
Эрэмбэ (Rank)	84	92	92	74	46
Цахим оролцооны индекс					
Огноо	2016	2018	2020	2022	2024
Эрэмбэ (Rank)	39	65	87	57	37
Цахим үйлчилгээний индекс					
Огноо	2016	2018	2020	2022	2024
Үнэлгээ (Value)	0.51449	0.59720	0.52940	0.62630	0.82219
Харилцаа холбооны дэд бүтцийн индекс					
Огноо	2016	2018	2020	2022	2024
Үнэлгээ (Value)	0.28411	0.36020	0.61.350	0.69730	0.93741
Хүний нөөцийн чадавхын индекс					
Огноо	2016	2018	2020	2022	2024
Үнэлгээ (Value)	0.75968	0.78990	0.80630	0.83910	0.77748

Эх сурвалж: <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia>

Төрийн байгууллагын мэдээллийн системүүдийн ялгаатай байдлаас шалтгаалж, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцоо хангалтгүй буюу бусад төрийн байгууллагаас гарах боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаарддаг хэвээр байна. Мөн нэг төрлийн үйлчилгээг нийслэл, орон нутагт ялгаатай байдлаар, олон шат дамжлагатайгаар (үйлчилгээ авах бүрдүүлбэр өөр, өөр) үзүүлж байгаагаас гадна аливаа үйлчилгээг уламжлалт аргаар буюу олон дамжлагатайгаар цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн системийн давхардал үүсгэн, төсөв, нөөцийн үр ашиггүй зарцуулалтыг бий болгосоор байна. Түүнчлэн төрийн байгууллагын үйлчилгээнд “Digital First” буюу аливаа үйлчилгээг цахим хэлбэрээр эхэлж үзүүлэх зарчим бодитоор хэрэгжихгүй байгаа нь цахим шилжилтийн бодлого хэрэгжилтэд хүндрэл учруулж байгаагаас гадна төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, мэдээллийн системийн уялдаа хангалтгүй, дотоод үйл ажиллагаа цахимжихгүй байгаа нь Digital First зарчмыг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байх тул Digital First зарчмыг бодитоор хэрэгжүүлэх тогтолцоо, хяналт-шинжилгээ, дотоод процессын шинэчлэл хийх шаардлагатай байна.

Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдал: Оксфорд Инсайтс байгууллага нь “Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индекс” нь Засгийн газар, Технологийн салбар, Өгөгдөл ба дэд бүтэц гэсэн 3 үндсэн тулгуурын 40 шалгуур үзүүлэлтийг жил бүр судалж, үнэлдэг бөгөөд уг индекс нь улс орны амжилт, дэвшлийг онцолж, дутагдлыг илрүүлж, хиймэл оюуныг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэхийг эрмэлзэж буй

бодлого боловсруулагчдад бодитой дүгнэлтийг өгдөг. Монгол Улсын хувьд дээр дурдсан тулгуур үзүүлэлт бүрийн оноог 2024 оны байдлаар задалбал:

1. Засаглалын үзүүлэлт – 49.2 оноо
2. Технологийн салбарын үзүүлэлт – 26.78 оноо
3. Өгөгдөл ба дэд бүтцийн үзүүлэлт – 63.36 оноо

Сүүлийн 4 жилийн хувьд Монгол Улс 5 байраар урагшилсан хэдий ч хиймэл оюуны хөгжүүлэлт удаашралтай байна. Тухайлбал, энэ чиглэлийг хөгжүүлэх нэгдсэн төлөвлөлт, бодлогын баримт бичигтэй эсэх үзүүлэлтээр 0 оноо авсан нь манай улсын хувьд хөгжлийн бодлого баримт бичигт их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийг анхаарч, цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Монгол Улс 2024 онд “Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индекс”-ээр өмнөх оноос 11 байр урагшилж, 188 орноос 98 дугаарт эрэмбэлэгджээ. (Хүснэгт 106-д харуулав.)

Хүснэгт 106. Монгол Улсын Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индексийн эрэмбэ

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Эзэлсэн байр / оноо	93 / 37.8	103 / 37.2	102 / 37.21	109 / 38.99	98 / 42.36
Үүнээс: Засаглал	-	33.45	35.21	35.83	36.94
Технологийн салбар	-	27.24	26.68	27.71	26.78
Өгөгдөл ба дэд бүтэц	-	50.9	49.76	53.43	63.36
Нийт үнэлэгдсэн орны тоо	172	160	181	193	188

Эх сурвалж: Оксфорд Инсайтс

Монгол Улсын хувьд судалгаанд хамрагдсан 188 улсын дундажтай харьцуулахад өгөгдөл болон дэд бүтэц, цахим ур чадвар зэргээр дэлхийн дундажтай адил байгаа ч Засгийн газар, хиймэл оюунд бэлэн технологийн дэд бүтэц (жишээ нь: өндөр хүчин чадалтай тооцоолох дэд бүтэц), хиймэл оюуны ур чадвартай хүний нөөцийн хувьд хангалтгүй байна.

Улс орнуудын төр засаг хиймэл оюуны технологийг ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн, хариуцлагатай, үр дүнтэй ашиглахад хэр бэлтгэгдсэн эсэхийг тодорхойлох зорилгоор НҮБХХ-ийн Цахим хөгжлийн бодлогоос боловсруулсан “Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ”-ний аргачлалыг ашиглан Монгол Улсын хиймэл оюуны өнөөгийн бэлэн байдлыг ерөнхий түвшнийг хиймэл оюуныг хэрэглэгч төр (3.2 оноо), хиймэл оюуныг идэвхжүүлэгч төр (3.4 оноо), хиймэл оюуны ёс зүй (2.4 оноо) гэсэн үндсэн гурван тулгуур чиглэлийг хамруулан үнэлсэн бөгөөд уг аргачлалаар “3 оноо” буюу “Тогтолцоо бүрэлдэх шат”-д байрлаж байна.

Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдал: Улс орнуудын төр засаг хиймэл оюуны технологийг ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн, хариуцлагатай, үр дүнтэй ашиглахад хэр бэлтгэгдсэн эсэхийг тодорхойлох зорилгоор НҮБХХ-ийн Цахим хөгжлийн бодлогоос боловсруулсан “Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ”-ний аргачлалыг ашиглан Монгол Улсын хиймэл оюуны өнөөгийн бэлэн байдлыг ерөнхий түвшнийг хиймэл оюуныг хэрэглэгч төр (3.2 оноо), хиймэл оюуныг идэвхжүүлэгч төр (3.4 оноо), хиймэл оюуны ёс зүй (2.4 оноо) гэсэн үндсэн гурван тулгуур чиглэлийг хамруулан үнэлсэн бөгөөд уг аргачлалаар “3 оноо” буюу “Тогтолцоо бүрэлдэх шат”-д байрлаж байна.

Зураг 6. Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ, тулгуур чиглэлээр



Их өгөгдөл: Дэлхий даяар өгөгдөл ихээр бий болж, үүнийг хадгалах багтаамж 2023 онд 10.1 зеттабайт байсан бол 2027 онд 21 зеттабайтад хүрч, жилд дунджаар 18.5 хувь өснө. Үүнийг даган цахилгааны хэрэглээ ихсэж, одоогийн эрчим хүчний сүлжээ үүнийг даах чадваргүй болоод байна. Монгол Улсын хувьд өгөгдлийг эргэлтэд оруулах зорилгоор Засгийн газраас холбогдох чиглэл, шийдвэрүүдийг гаргаад байгаа хэдий ч өгөгдлийн стандартын зөрүү, чанар муутай мэдээлэл, мэдээллийн системүүдийн уялдаа холбооны сул байдал, мөн хөдөө орон нутгийн дэд бүтцийн хязгаарлалт нь цахим өгөгдлийг бодлогын үр дүнтэй шийдвэр гаргалт болон төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд сөргөөр нөлөөлж байна. Цаашид өгөгдлийг олон улсын стандарттай нийцсэн зохицуулалтын орчинг бүрдүүлэх чиглэлд идэвхтэй ажиллаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан их өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, улмаар дижитал эдийн засгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Инновац, гарааны бизнес: Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг “Дэлхийн инновацийн индекс”-ээр өмнөх оноос 1 байр урагшилж, 2024 онд 133 улсаас 67 дугаарт тус тус эрэмбэлэгдсэн. Манай улс уг индексийн хүний нөөц, дэд бүтэц, бизнесийн орчны гэсэн дэд үзүүлэлтээр дундаж түвшинтэй байгаа ч зах зээлийн таатай нөхцөл байдлын дэд үзүүлэлт (зээл, хөрөнгө оруулалт, худалдаа)-ээр өмнөх оноос 5 байр ухарч, 106 дугаарт жагсаж байна. Энэ нь манай улсад инновац, нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын зохицуулалтын таатай орчин бүрдээгүй байгааг харуулж байна.

Монгол Улсад гарааны бизнесийн экосистем жилээс жилд өргөжин тэлж, бүтэц, төрөлжилтийн хувьд илүү тодорхой болж байна. Start байгууллагын судалгаагаар, экосистемийн зураглалд 227 технологид суурилсан гарааны бизнес, 10 инкубатор, хурдагсгуур, venture studio, 9 холбоо, ТББ, 8 төрийн байгууллага, 8 венчур хөрөнгө оруулагч, 3 олон улсын байгууллага тус тус дүрслэгдсэн байгаагаас дийлэнх нь инновац, өндөр технологийн чиглэлд төвлөрч буй нь ажиглагдаж байна. Тухайлбал,

финтек, даатгалын технологи, блокчэйн, кибер аюулгүй байдал, IoT, хууль tech, мета/AR/VR, proptech, healthtech зэрэг салбар давамгайлж байна.


Монгол Улсын гарааны бизнесийн өнөөгийн нөхцөл байдлыг олон улсын түвшинд авч үзвэл, Стартап-Блинкийн 2023 оны экосистемийн үнэлгээгээр дэлхийн 100 улсаас 79-р байр эзэлсэн нь (2020 оноос 7 байр урагшилсан), “Software Data” индексээр анх удаа 67-р байранд эрэмбэлэгдсэн нь мэдээллийн технологийн гарааны бизнесийн суурь хөгжлийн эхэндээ шатандаа байгааг харуулж байна.

Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ихэнх нь бусад улс орны энэ чиглэлийн компаниудтай харьцуулахад бүрэн төлөвшиж амжаагүй, бизнесийн орлого, хөрөнгө оруулалт, төрөөс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаагаас гарааны компани хэлбэртэй үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр асуудал нь санхүүжилт, хөрөнгө оруулалтын боломжоос ихээхэн хамаардаг боловч манай улсын хувьд хөрөнгө оруулалтын таатай нөхцөл, төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт дутмаг байгаагаас мэдээллийн технологийн гарааны компаниуд бусад улс орны хурдасгуур хөтөлбөрт хамрагдах, улмаар тухайн улсад үйлдвэрлэл эрхлэх, шилжин ажиллах эрсдэлийг дагуулж байна.

Монгол Улсын гарааны бизнес эрхлэгчид үндэсний экосистемийг хөгжиж байгаа гэж үздэг бөгөөд экосистемийг хөгжүүлэхэд боловсролтой ажиллах хүч (68%), эдийн засгийн тогтвортой орчин (59%), инновацын түвшин (41%), хүн амын худалдан авах чадвар (34%), багийн гишүүдийн хүрэлцээ (29%) зэрэг нь чухал хүчин зүйл хэмээн тодорхойлсон байна¹¹⁰.

Гарааны бизнесийг дэмжих санхүүгийн эх үүсвэр нь зөвхөн тухайн компанийн амжилтад нөлөөлөх бус, нийт эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлэх тул судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилт, хөрөнгө оруулалтын олон талт эх үүсвэрийг бий болгох шаардлагатай. (График 54-т харуулав.)

График 54. Гарааны бизнест төрөөс үзүүлэх шаардлагатай дэмжлэг



Эх сурвалж: (JICA, KITE, MMCG, 2022)

Тухайлбал, улсын төсвөөс гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалт хэлбэрээр дэмжлэг үзүүлэх нь чухал хөшүүрэг болох юм. Төрийн хөрөнгө оруулалт нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах итгэлцлийг нэмэгдүүлж, хамтарсан хөрөнгө оруулалт хийх орчныг бүрдүүлэх ба эрт үеийн өндөр эрсдэлтэй инновацын төслүүдийн хөрөнгө оруулалтын анхны шатанд “анхдагч хөрөнгө оруулагч” (anchor investor)-ийн үүрэг гүйцэтгэж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хуваалцана. Ингэснээр гарааны бизнесүүдийн өсөлт, хөгжилд шаардлагатай санхүүжилтийн хомсдолыг бууруулж, инновацын экосистемийн тогтвортой хөгжлийг хангах боломж бүрдэнэ.

¹¹⁰ Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулах судалгааны ажлын тайлан, 2025 он

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

4.1. МОНГОЛ УЛСЫН 2026-2030 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

“Монгол Улсын 2026–2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийг “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлтэй уялдуулан “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Засаглал, дижитал шилжилт”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлийн хүрээнд багцлан боловсрууллаа.

Энэ хүрээнд 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдсэн, хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн хөгжлийн төслүүдийг эрэмбэлж тусгалаа.

“Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн 66.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 87 төслийг тусгасан ба тэдгээрийг нийт 55.2 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төслүүдийн 44.8 хувь буюу 39 төслийг улс, орон нутгийн төсвөөр, 28.7 хувь буюу 25 төслийг гадаадын зээл, тусламжаар, 16.1 хувь буюу 14 төслийг шууд хөрөнгө оруулалтаар, 3.4 хувь буюу 3 төслийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 2.3 хувь буюу 2 төслийг Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасаар, 3.4 хувь буюу 3 төслийг холимог эх үүсвэрээр, 1.1 хувь буюу 1 төслийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх юм. Тухайлбал, зарим томоохон төслүүдийг дурдвал,

Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, соёлын салбарт нийт 4.6 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд боловсролын салбарт улсын хэмжээнд 108 сургууль, 95 цэцэрлэгийг, эрүүл мэндийн салбарт Зүрх судасны үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын төв-II, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгыг, шинжлэх ухаан, соёлын салбарт Байгалийн шинжлэх ухааны музей, Үндэсний урлагийн их театр, Хүүхдийн номын ордон, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг барьж байгуулна.

Боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн салбарт нийт 18.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, мөн экспортын тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах хүрээнд Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр зам болон авто замын холболтын төслүүдийг хэрэгжүүлнэ.

Эрчим хүчний салбарт 15.9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд Баянгийн 660 МВт-ын Дулааны Цахилгаан Станц, Тавантолгойн 450 МВт-ын Цахилгаан Станц, Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц, Дулааны V Цахилгаан Станцыг шинээр байгуулна.

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд 13.6 их наяд төгрөгийн 36 төслийг хэрэгжүүлнэ. Үүнд Туулын хурдны зам, Шинэ тойрог зам, Нийтийн тээврийн дүүжин зам, төмөр зам доогуурх авто замын нүхэн гарц төсөл, баруун, зүүн, хангай, төвийн бүсийг холбосон авто замын төслүүд багтана. Тухайлбал, Чойр-Мандалговь-Арвайхээр, Бор-Өндөр-Хэрлэн, Улиастай-Алтай, Ховд-Улаангом, Баянхонгор-Шаргалжуут, Өлгий-Цэнгэл, Төв аймгийн холболтын зэрэг 10 гаруй чиглэлийг шинээр хатуу хучилттай авто замаар холбоно.

Төрийн институцийн чадавх, гамшгийн эрсдэлийн удирдлага болон үндэсний аюулгүй байдлын хамгаалалтыг бэхжүүлэхэд нийт 1.98 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тус тус төлөвлөсөн.


Хүснэгт. “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийн санхүүжилтийн хуваарь, эх үүсвэрээр (сая төгрөг)

Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Санхүүжилтийн хуваарь						Шилжих	Нийт дүнд эзлэх хувь
			2026-2030	2026	2027	2028	2029	2030		
	100.00%	14.43%	82.89%	15.53%	21.65%	22.32%	13.67%	9.73%	2.68%	
Гадаад зээл	15,854,103.09	2,353,872.26	12,165,355.43	1,176,545.38	4,169,563.07	4,335,393.69	1,525,730.03	958,123.25	1,334,875.40	22.04%
Гадаад тусламж	996,246.22	34,800.00	887,606.26	196,556.97	246,664.49	224,864.49	176,286.12	43,234.19	73,839.96	1.61%
Улсын төсөв	8,717,557.82	993,807.38	7,452,960.17	1,024,502.61	1,984,807.21	1,692,716.62	1,403,641.37	1,347,292.36	270,790.27	13.50%
Орон нутгийн төсөв	3,347,955.84	500,000.00	2,847,955.84	1,321,314.01	763,320.91	763,320.91	-	-	-	5.16%
Улс, орон нутгийн төсөв	601,177.60	30,000.00	571,177.60	145,849.15	142,869.15	94,000.00	94,000.00	94,459.30	-	1.03%
Төр, хувийн хэвшлийн туншлал	4,254,705.93	1,222,500.46	3,032,205.46	1,189,614.01	930,295.73	912,295.73	-	-	-	5.49%
Шууд хөрөнгө оруулалт	26,880,329.25	4,426,265.80	22,454,043.46	4,480,730.24	5,322,422.93	5,967,474.91	3,995,216.65	2,688,198.72	-	40.68%
Зөвхөн газрын газраар, дотоод үнэт цаас	5,147,850.00	-	5,147,850.00	683,712.50	683,712.50	683,712.50	1,790,212.50	1,306,500.00	-	9.33%
Бусад эх үүсвэр	790,337.58	50,098.03	636,200.40	122,079.01	170,486.39	185,921.47	118,835.06	38,978.47	104,039.13	1.15%
Нийт дүн	66,590,263.33	9,611,363.93	55,195,354.62	10,340,903.98	14,414,142.38	14,859,700.33	9,103,921.74	6,476,666.29	1,783,544.78	100.00%

“Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн эхний жил болох 2026 онд хөрөнгө оруулалтын шинэ үе шат эхэлж, томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн суурь хөрөнгө оруулалтыг хийж эхэлнэ. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2027 онд 8.07 их наяд төгрөг, 2028 онд 7.59 их наяд төгрөг бөгөөд түүнээс газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл 2.39 их наяд төгрөг байна.

Монгол Улсын 2025 оны төсвийг Бүсчилсэн хөгжлийн бодлогыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг хийх бодлогыг баримталж боловсруулж, батлуулсан. Энэ хүрээнд аймгийн төвүүдийг авто замаар холбох төслүүдийг эхлүүлсэн бөгөөд үүнээс 12 төслийг 2027-2028 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн.

График 55. Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт дүн, улсын төсвийн хүрээнд олгох боломжит хэмжээ (их наяд төгрөг)



“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн үр дүнд “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан төслүүдийн үзүүлэх нөлөөлөл


Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлэх үр дүнд хөрөнгө оруулалтын 23 төсөл эерэг

нөлөөллийг үзүүлэхээр байна. Мөн хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах үр дүнд 9 төсөл, боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлэх үр дүнд 8 төсөл хувь нэмрээ оруулах юм.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үр дүнд 8 төсөл зэрэг нөлөөлөл үзүүлнэ.

Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулах чиглэлд тус бүр 5 төсөл хэрэгжихээр төлөвлөсөн бол боомтын зорчигч, ачаа тээврийн нэвтрэлтийг нэмэгдүүлэх, төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлэх чиглэлд тус бүр 3 төсөл хэрэгжих юм.

График 56. Монгол Улсын 2026-2030 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үр дүнгийн уялдаа



Стандартын шаардлага хангасан орчин бүхий ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлд 2 төсөл хэрэгжүүлнэ.

Нийт 87 төсөл нь хөгжлийн үр дүнд зэрэг нөлөө үзүүлэх бөгөөд тэдгээрийн дийлэнх нь дэд бүтэц, эрчим хүчний найдвартай байдал, боловсрол, эрүүд мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

МОНГОЛ УЛСЫН 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
1		2 дугаар хавсралтын 7.2.3 Үр дүн хэсгийн Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтыг сайжруулна гэснийг "Монгол Улсын Үндсэн хуулийн чандлан сахиулна" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 7.2.4 дэх хэсэгт "Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулна" гэж тусгав.
2		2 дугаар хавсралтын 7.2.3 Арга зам хэсгийн Монгол Улсын Үндсэн хуулийн чандлан сахиулах гэснийг "Үндсэн хуулийн цэцийн бие даасан гишүүний хараат бус байдлын баталгааг хангах" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Арга зам нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.
3		2 дугаар хавсралтын 7.2.3.1 Үр дүн хэсгийн Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулийн мэдлэгийг дээшлүүлнэ гэснийг "Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, шийдвэрийн үндэслэлийг чанаржуулна" гэж, Үндсэн хуулийг иргэдэд сурталчлан таниулах гэснийг "Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатыг тодорхой болгох, ажиллагааны болон судалгааны чанарыг сайжруулах, цахимжуулах" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
4		2 дугаар хавсралтын 7.2.3.2 Үр дүн хэсгийн Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг чанаржуулна гэснийг "Үндсэн хуулийн цэцэд итгэх иргэдийн итгэлийн нэмэгдүүлнэ" гэж, Арга зам хэсгийн Маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай харьцуулсан болон бусад судалгааны чанарыг сайжруулах гэснийг "Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна. Арга зам нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн зарчимтай нийцээгүй тул тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
5	Үндсэн хуулийн цэц 2025 оны 10.10-ны өдрийн 1/574 дугаартай албан бичиг	2 дугаар хавсралтын 7.2.3.3 Үр дүн хэсэгт "Үндсэн хуулийн дархлааг бэхжүүлнэ" гэж, Арга зам хэсэгт "Үндсэн хуулийг сурталчлан таниулах, иргэдийн Үндсэн хуулийн боловсролыг дээшлүүлэх" гэж нэмэх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.
6		3 дугаар хавсралтын 7.2.3 Үр дүн хэсгийн Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтыг сайжруулна гэснийг "Монгол Улсын Үндсэн хуулийн чандлан сахиулна" гэж, шалгуур үзүүлэлтийн Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гэснийг "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрлэлтийн түвшин" гэж, хэмжих нэгж тоо гэснийг "Хувь" гэж, суурь түвшин 219 гэснийг "77.9" гэж, зорилтот түвшин 2026-2030 "-" гэснийг "78, 79, 80, 81, 82" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 7.2.3 дахь хэсэгт "Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулна" гэж үр дүн хэсэгт "маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрлэлтийн түвшин" гэж хэмжих нэгж хэсэгт тус тус тусгав.
7		3 дугаар хавсралтын 7.2.3.1 Үр дүн хэсгийн Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулийн мэдлэгийг дээшлүүлнэ гэснийг "Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, шийдвэрийн үндэслэлийг чанаржуулна" гэж, Шалгуур үзүүлэлтийн Үндсэн хуулийн цэцэд иргэдийн хандсан тоо гэснийг "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах аргачлалын хэрэгжилт, хэмжих нэгж тоо гэснийн "хувь" гэж, зорилтот түвшин 231.00 гэснийг "0,100,100,100,100 гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 7.2.3.2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ" гэж үр дүн хэсэгт, "маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах аргачлалын хэрэгжилт" гэж шалгуур үзүүлэлт хэсэгт тус тус тусгав.
8		3 дугаар хавсралтын 7.2.3.1 шалгуур үзүүлэлтийн Үндсэн хуулийн цэцэд иргэдийн хандсан тоо гэснийг Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны цахимжуулалтын түвшин" гэж өөрчлөн хэмжих нэгж тоо гэснийн "хувь" гэж, зорилтот түвшин 10,20,30,40,50,60" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул шалгуур үзүүлэлтэд тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
9		3 дугаар хавсралтын 7.2.3.2 Үр дүн хэсгийн Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг чанаржуулна гэснийг "Үндсэн хуулийн цэцэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ" гэж, шалгуур үзүүлэлийн Харьцуулсан судалгааны тоо гэснийг "Шүүхийн индекс дэх Цэцийн талаарх үнэлгээ" гэж, хэмжих нэгж тоо гэснийг "хувь" гэж, суурь түвшин "-" гэснийг "59.03" гэж, зорилтот түвшин "-" гэснийг "61, 62, 63, 64, 65" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 7.2.3.2 дахь хэсэгт "59.03" гэж суурь түвшин хэсэгт, "61, 62, 63, 64, 65" гэж зорилтот түвшин хэсэгт тус тус тусгав.
10		3 дугаар хавсралтын 7.2.3.3 Үр дүн хэсэгт "Үндсэн хуулийн дархлааг бэхжүүлнэ" гэж, шалгуур үзүүлэлт хэсэгт "Үндсэн хуулийн боловсрол олгох хөтөлбөрийн хэрэгжилт" гэж, хэмжих нэгж "хувь" гэж, суурь түвшин "0" гэж, зорилтот түвшин "10, 20, 30, 40, 50" гэж нэмэх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн зарчимтай нийцээгүй байх тул тусгах боломжгүй байна.
11		2 дугаар хавсралтын 7.2.1 Үр хэсгийн Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ гэснийг "Иргэн төвтэй шүүхийг төлөвшүүлнэ" гэж, арга замын Шүүхийн үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх гэснийг "Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшинг нэмэгдүүлнэ" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудын дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.
12		2 дугаар хавсралтын 7.2.1.1 Үр дүн хэсгийн Иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг төлөвшүүлнэ гэснийг "Шүүхийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдал дээшилнэ" гэж, Арга замын Олон нийтийн оролцоог хангах гэснийг "Цахим шүүхийн үйлчилгээ нэвтэрнэ" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
13		2 дугаар хавсралтын 7.2.1.2 Салбар/ТЭЗ/Хөтөлбөрийн нэрийн 70701 Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах гэснийг "70702 Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа" гэж, Үр дүн хэсгийн Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана гэснийг "Иргэн тав тухтай орчинд үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ" гэж, Арга зам хэсгийн Шүүхийн цахим санг сайжруулах, тодорхой, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх гэснийг "Иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, шүүн таслах ажлын онцлогт тохирсон дэд бүтэцтэй болно" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.
14		2 дугаар хавсралтын 7.2.1.3 Үр дүн хэсгийн Шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангана гэснийг "Шүүхийн нээлттэй, ил тод байдал сайжирна" гэж, Арга зам хэсгийн Шүүгч, шүүхийн ажилтны хариуцлагыг нэмэгдүүлэх гэснийг "Иргэд шүүхийн талаар албан ёсны үнэн бодит мэдээлэл авах боломжоор хангагдана" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын уялдааны шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байх тул тусгах боломжгүй байна.
15	Шүүхийн ерөнхий зөвлөл 2025 оны 10.02- ны өдрийн 01/1574 дугаартай албан бичиг	2 дугаар хавсралтын 7.2.1.4 Үр дүн хэсгийн Сахилгын хэрэг шийдвэрлэлтийн чанарыг сайжруулна гэснийг "Шүүхийн үйлчилгээний соёл төлөвшинэ" гэж, Арга зам хэсгийн Хараат бус байдлыг нэмэгдүүлэх гэснийг "Харилцааны зэрэг хандла, ажил мэргэжлийн ур чадвар сайжирна" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй тул тусгах боломжгүй байна. Арга зам нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
16		3 дугаар хавсралтын 7.2.1.1 Шалгуур үзүүлэлт хэсгийн Иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, нээлттэй шүүхийн орчин бүрдсэн байдал гэснийг "Цахим шүүхийн үйлчилгээг ашигласан хүн, хуулийн этгээдийн эзлэх хувь" гэж, хэмжих нэгжийн хувь гэснийг "Оноо 1-100" гэж, зорилтот түвшин 26.2, 38.1, 50.0, 61.9, 73.8 гэснийг "8, 13, 18, 23, 28" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
17		3 дугаар хавсралтын 7.2.1.2 Шалгуур үзүүлэлт хэсгийн Хууль хэрэглээний нэгдмэл байдлын түвшин гэснийг "Шүүн таслах ажлын онцлогт тохирсон, стандарт барилга" гэж, шалгуур үзүүлэлт хувь гэснийг "Тоо" , суурь түвшин 2023 гэснийг "2025" , зорилтот түвшин 70, -, 73, -, 76 гэснийг "11, 16, 21, 26, 31" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
18		3 дугаар хавсралтын 7.2.1.3 Үр дүн хэсэгт "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай болно" гэж, Шалгуур үзүүлэлт хэсэгт "Шинээр авах тээврийн хэрэгслийн тоо" гэж, суурь түвшинг "28" гэж, зорилтот түвшинг "48, 68, 88, 108, 128" гэж тус тус нэмэх	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын үр дүнгийн уялдааны шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байх тул тусгах боломжгүй байна.
19		3 дугаар хавсралтын 7.2.1.4 Шалгуур үзүүлэлт хэсгийн Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгосон тохиолдлын эзлэх хувь гэснийг "Ажлаас халшрах шинжтэй ажилтны эзлэх хувь" гэж, суурь түвшин 14.8 гэснийг "19" гэж, зорилтот түвшин 14, 12.8, 11, 9, 7 гэснийг "18, 17, 16, 15, 14" гэж өөрчлөх. Мөн шалгуур үзүүлэлт хэсгийн 2-т "Сургалтад хамрагдсан ажилтны эзлэх хувь" гэж, суурь түвшинг "20" гэж, зорилтот түвшинг "25, 35, 50, 65, 75" гэж, шалгуур үзүүлэлтийн 3-т "Захирааны ажилтны тогтвор суурьшил" гэж, хэмжих нэгжийг "хувь" гэж, суурь түвшинг "50" гэж, зорилтот түвшинг "55, 60, 65, 70, 75" гэж тус тус нэмэх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Шалгуур үзүүлэлт нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10-д "Шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх" гэсэн зарчимтай нийцээгүй байх тул тусгах боломжгүй байна. Зорилтот түвшин нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д "Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх" гэсэн зарчимтай нийцээгүй байх тул тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
20	Шүүхийн сахилгын хороо	2 дугаар хавсралтын 7.2.1.4 Үр дүн хэсгийн Сахилгын хэрэг шийдвэрлэлтийн чанарыг сайжруулна гэснийг "Хариуцлагатай шүүхийг төлөвшүүлнэ" гэж, Арга зам хэсгийн Хараат бус байдлыг нэмэгдүүлэх гэснийг "Сахилгын зөрчил шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох" гэж тус тус өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна. Арга зам нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.
21		3 дугаар хавсралтын Үр дүн хэсгийн Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгосон тохиолдлын эзлэх хувь" гэснийг "Шүүхийн сахилгын хорооны шийдвэр" гэж, хэмжих нэгж хувь гэснийг "Тоо" гэж, суурь түвшин 14.8 гэснийг "137" гэж, зорилтот түвшин 14,12.8, 11, 9, 7 гэснийг "-" "Шүүхийн сахилгын хорооны шийдвэр" гэж тус тус өөрчлөх.	Саналыг тусгаагүй Тайлбар: Хөгжлийн бодлого , төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д "Судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх " гэсэн зарчимтай нийцээгүй байх тул тусгах боломжгүй байна.
22		3 дугаар хавсралтын 7.2.1.2 Хэмжих нэгжийн оноо гэснийг "Хувь" гэж, зорилтот түвшин "-" гэсний "2026-70, 2027 "-" , 2028-73, 2029 "-" , 2030-76" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 7.2.1.2 дахь хэсэгт "2026-70, 2027 "-", 2028-73, 2029 "-", 2030-76" гэж зорилтот түвшин хэсэгт тусгав.
23	Улсын дээд шүүх 2025 оны 10.03-ний өдрийн 05/3055 дугаартай албан бичиг	3 дугаар хавсралтын 7.2.1.2 Хөтөлбөрийн үр дүн хэсэгт "Шүүхийн ил тод байдлыг хангана" гэж, шалгуур үзүүлэлт хэсэгт "Шүүхийн нээлттэй ил тод байдлын түвшин" гэж, хэмжих нэгж "оноо" гэж, суурь он "2023" гэж, суурь түвшин "65,71" гэж, зорилтот түвшин "66, 66.50" гэж, мөн тус хэсэгт "Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн чадавхыг бэхжүүлэх" гэж, шалгуур үзүүлэлт хэсэгт "хэрэгжилт" гэж, хэмжих нэгж "оноо" гэж, суурь он "2024" гэж, суурь түвшин "30.00" гэж, зорилтот түвшин "50,80,100" гэж нэмэх.	Саналыг тусгаагүй Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг , хөгжлийн сайдын 2025 оын А /13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг , нийслэл , хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал "-ын тавдугаар хавсралтын үр дүнгийн уялдааны шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байх тул тусгах боломжгүй байна Шалгуур үзүүлэлт нь 1. Хөгжлийн бодлого , төлөвлөлт , түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10. "Шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх " гэсэн зарчимтай нийцээгүй байх тул тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
24	Улсын ерөнхий прокурор 2025 оны 10.07-ны өдрийн 02/4553 дугаартай албан бичиг	3 дугаар хавсралтын 7.2.2 Шалгуур үзүүлэлт хэсгийн Шүүхээс прокурорт буцаасан хэргийн эзлэх хувь гэснийг, суурь түвшинг, зорилтот түвшнийг мөрөөр хасах.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
25		2 дугаар хавсралтын 7.3.1 Үр дүн хэсгийн Төрийн албанд чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ гэснийг "Төрийн албанд чадварлаг хүний нөөцийг ажиллуулна" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
26		2 дугаар хавсралтын 7.3.1 Арга зам хэсгийн Үр чадвар, чадамжид суурилсан, сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлнэ гэснийг "Ур чадварт суурилсан томилгоог төлөвшүүлэх" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 7.3.1 дэх хэсэгт "Ур чадварт суурилсан томилгоог төлөвшүүлэх" гэж арга зам хэсэгт тусгав.
27		2 дугаар хавсралтын 7.3.1.1 Төрийн албан хаагчийн томилгооны зөрчлийг бууруулна гэснийг "Төрийн албан хаагчийн томилгооны зөрчлийн эрс бууруулж, цахим хяналтыг сайжруулна" гэж, чадамжид суурилсан сонгон шалгаруулалтыг бий болгох гэснийг "Чадамжид суурилсан томилгоог төлөвшүүлж, зөрчил гаргагчдад хариуцлага тооцох эрх зүйг шинэчлэнэ" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын үр дүнгийн уялдааны шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байх тул тусгах боломжгүй байна. Арга зам нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
28	Төрийн албаны зөвлөл 2025 оны 09.29-ний өдрийн 01/2041 дугаартай албан бичиг	2 дугаар хавсралтын 7.3.1.2 Үр дүн хэсгийн Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ гэснийг "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулж, сэтгэл ханамжид чанарын ахиц гаргана" гэж, Арга зам хэсгийн Хүний нөөцийн эдийн засаг, эрүүл мэндийн баталгааг хангах гэснийг "Нөлөөлөх хүчин зүйлсийг бодитоор илрүүлж, сэтгэл ханамж нэмэгдүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тогтоох, чанарыг сайжруулна" гэж өөрчлөх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна. Арга зам нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын үр дүнгийн уялдааны шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байх тул тусгах боломжгүй байна.
29		2 дугаар хавсралтын 7.3.1.2 Салбар/ТЭЗ/Хөтөлбөрийн нэр 70401 "Төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлнэ" гэж, Үр дүн хэсэгт "Ёс зүйн индексийг нэвтрүүлж, хяналт, хариуцлагыг сайжруулна" гэж, Арга зам хэсэгт "Ёс зүйн хяналт, ёс зүйн хороодын чадавхийг нэмэгдүүлнэ" гэж нэмэх.	Саналыг тусгаагүй. Тайлбар: Үр дүн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын дагуу асуудлыг шийдвэрлэх арга замын хувилбар боловсруулах сонголт хийхдээ хувилбаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байх тул тусгах боломжгүй байна. Арга зам нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын тавдугаар хавсралтын үр дүнгийн уялдааны шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байх тул тусгах боломжгүй байна.
30		3 дугаар хавсралтын 7.3.4 Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх гэсэн үр дүнгийн шалгуур үзүүлэлт Ёс зүйн үзүүлэлт гэснийг "Ёс зүйн индекс" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 7.3.4 дэх хэсэгт "Ёс зүйн индекс" гэж шалгуур үзүүлэлт хэсэгт тусгав.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
31		2 дугаар хавсралтын 7.3.4 Хэмжих нэгж хэсгийн хувь гэснийг "коэффициент" гэж, зорилтот түвшин T+15, T+20, T+25, T+35, T+40 гэснийг "T" гэж тус тус өөрчлөх.	Саналыг тусгаагүй Тайлбар: Хэмжих нэгж, зорилтот түвшин нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
32	Ёс зүйн хороо 2025 оны 10.03-ны өдрийн 1/207 дугаартай албан бичиг	2 дугаар хавсралтын 7.3.4.1 Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын үнэлгээ гэснийг "Төрийн албан хаагчийн ёс зүйн чадамжийн үнэлгээ" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 7.3.4.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагчийн ёс зүйн чадамжийн үнэлгээний дундаж" гэж арга зам хэсэгт тусгав.
33		3 дугаар хавсралт 7.3.4.1 Хэмжих нэгж хэсгийн хувь гэснийг "Хамрагдсан хувь" гэж өөрчлөх	Саналыг тусгаагүй Тайлбар: Хэмжих нэгж нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оын А/13 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
34		3 дугаар хавсралт 7.3.4.1 Зорилтот түвшин T+15, T+20, T+25, T+35, T+40 "T+10, T+20, T+30, T+40, T+50" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 7.3.4.1 дэх хэсэгт Зорилтот түвшин "T+10, T+20, T+30, T+40, T+50" гэж зорилтот түвшин хэсэгт тусгав.
35	Үндэсний аудитын газар 2025 оны 10.06-ны өдрийн 2888 дугаартай албан бичиг	2 дугаар хавсралтын 7.3.7.2 Үр дүн хэсгийн Төрийн аудитын мэдээллийн ил тод байдлыг сажруулна гэсний шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшнийг өмнө илгээсэн саналын дагуу өөрчлөх.	Саналыг тусгаагүй Тайлбар: Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин нь "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын дагуу үр дүнг илэрхийлэхгүй байх тул тусгах боломжгүй байна.
36	Сонгуулийн ерөнхий хороо 2025 оны 10.06-ны өдрийн 1/417 дугаартай албан бичиг	3 дугаар хавсралтын 7.5.1 Суурь түвшин 0.649 гэснийг 0.61 гэж, зорилтот түвшин 2026-2030 он (-) гэснийг "0.61, 0.62, 0.63, 0.63, 0.63" гэж өөрчлөх,	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 7.5.1 дэх хэсэгт "0.61, 0.62, 0.63, 0.63, 0.63" гэж зорилтот түвшин хэсэгт тусгав.
37		3 дугаар хавсралтын 7.5.1.1 Шалгуур үзүүлэлт санхүүгийн үйл ажиллагаа явуулсан Улс төрийн намын тайлан гэснийг "Сонгуулийн үйл ажиллагаа явуулсан улс төрийн намын тайлан" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: Үндсэн чиглэлийн дугаар хавсралтын 7.5.1.1 дэх хэсэгт "Сонгуулийн үйл ажиллагаа явуулсан улс төрийн намын тайлан" гэж шалгуур үзүүлэлтийн хэсэгт тусгав.
247		Үндэсний үйлдвэрлэлийг тогтвортой дэмжих, Үндэсний брендийг бий болгох, талаар үр дүнг тусгах	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 9.1.1.1 дэх хэсэгт "төрөөс үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах замаар бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүнд суртлыг бууруулна." Гэж агуулгаар тусгасан.

Улаанбаатар 2025 оны 10.06-ны өдөр

№	Байгууллага хэл бэлд байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
248		Маш олон дарамт, зөвшөөрөл хувийн хэвшлийн хөгжилд хортой нөлөөтэй байна. Эко системийг бий болгох.	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 9.1.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах замаар бизнесийн орчныг сайжруулна." Гэж агуулгаар тусгасан.
249	Туушин ХХК	Дэд бүтэц, терминал, логистикийн төв зэрэг томоохон ажил болон төслийг хувийн компаниудад илүү даатгах дэмжих талаар тусгах	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх хэсэгт "Гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар цахилгаан эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлнэ."; 5.7.1.1 дэх хэсэгт "Санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх замаар Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ." Гэж тусгасан.
250	Монгол Экспресс ХХК	Гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортын бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг багасгах зэрэг үйл ажиллагааг дэвшилтэт технологи ашиглан импортлож байгаа хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангасан эсэхийг нотолгоо гаргуулах.	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 9.4.2 дахь хэсэгт "Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах замаар Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ." Гэж агуулгаар тусгасан.
251	ЦИМЭ ХХК	Эрчим хүчний эх үүсвэрүүдийг барих талаар онцгой анхаарах	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 5.6 дахь хэсэгт "Олон төрөлт эх үүсвэрийг бий болгох замаар эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ." Гэж тусгасан.
252		Бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүнд сурталыг бууруулах	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 9.1.1.1 дэх хэсэгт "төрөөс үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах замаар бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүнд суртлыг бууруулна." Гэж агуулгаар тусгасан.
253	Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо	Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 9.1.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах замаар бизнесийн орчныг сайжруулна." Гэж агуулгаар тусгасан.
254		Бизнесийн орчныг сайжруулах талаар тусгах	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 9.1.4 дэх хэсэгт "Бизнесийн орчныг сайжруулна." гэж агуулгаар тусгасан.
255	МБОИЗ	Цэвдэг, мөнх цас, тэрбум мод хөтөлөрийн хүрээнд бүсчилсэн хяналт, шалгалт хийх бодлогыг зогсоох чиглэлд үйл ажиллагаа төлөвлөх.	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 6.3.1.1 дэх хэсэгт "Доройтсон ойг нөхөн сэргээж, ойжуулалт, ой хамгааллын ажлын үр дүн, чанарыг сайжруулна." гэж агуулгаар тусгасан.

№	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
256		Газрын доройтол – бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг түгээх, иргэн олон нийтийг мэдлэг мэдээллээр хангах.	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 6.3.1.5 дэх хэсэгт "Хөрсийг хамгаалж, нөхөн сэргээх." гэж агуулгаар тусгасан.
257	МАОЭНХ	Зөвхөн улс төрийн болон бодлого боловсруулах явцад бус бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг дэмжих.	Саналыг тусгасан. Тайлбар: 2 дугаар хавсралтын 4.2.2.1 дэх хэсэгт "Улс төрийн болон бодлого боловсруулах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ." гэж агуулгаар тусгасан.

—0000000—